



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2022 оны 10 дугаар сарын 06-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-6</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>7-138</i>
<hr/>	
<i>1. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанкнаас 2022.09.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<i>7-104</i>
<i>2. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/</i>	<i>104-138</i>

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
10 дугаар сарын 06-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 51.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адъяа, Х.Болорчулуун, Г.Ганболд, Х.Ганхуяг, Ж.Эрдэнэбат;
Тасалсан: Д.Ганбат;

Хоцорсон: Н.Алтанхуяг-13 минут, С.Амарсайхан-49 минут, С.Батболд-2 цаг 03 минут, Х.Булгантуяа-11 минут, Г.Дамдинням-34 минут, Т.Доржханд-57 минут, Ц.Мөнх-Оргил-17 минут, Д.Өнөрболор-2 цаг 11 минут, Г.Тэмүүлэн-10 минут, Д.Цогтбаатар-24 минут, Б.Чойжилсүрэн-23 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, С.Ганбаатар, Ц.Даваасүрэн нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ц.Даваасүрэн, С.Ганбаатар нар үг хэлэв.

Нэг. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанкнаас 2022.09.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Монголбанкны Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, мөн банкны Мөнгөний бодлогын газрын дарга Б.Баярдаваа, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин, Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын захирал Н.Ариунбат, Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Судалгаа, статистикийн газрын захирал Д.Даваасүх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн танилцуулгыг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан 11 цаг 50 минутаас хуралдааныг даргалав.

Танилцуулга болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат, С.Чинзориг, Ц.Даваасүрэн, Д.Тогтохсүрэн, Г.Амартүвшин, М.Оюунчимэг, Н.Алтанхуяг, Э.Батшугар, Ч.Ундрам, Х.Баделхан, Ц.Сандаг-Очир, С.Ганбаатар, Ц.Туваан, Ж.Батсуурь, Ц.Идэрбат, Б.Пүрэвдорж, Ц.Цэрэнпунцаг, Ж.Батжаргал, Н.Ганибал, Б.Баттөмөр, О.Цогтгэрэл, Д.Сарангэрэл, Н.Наранбаатар, Ж.Бат-

Эрдэнэ нарын тавьсан асуултад Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Монголбанкны Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, мөн банкны Мөнгөний бодлогын газрын дарга Б.Баярдаваа нар хариулж, тайлбар хийв.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 12 минут үргэлжилж, 13 цаг 12 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 11 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хуралдааныг даргалав.

Үдээс хойших хуралдаанаар “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Ж.Бат-Эрдэнэ, М.Оюунчимэг нар үг хэлэв.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Соёлын сайд Ч.Номин, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Д.Зүмбэрэлхам, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга С.Батбаатар, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга

Б.Отгонцэцэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Монгол Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Цогтбаатар, мөн газрын Хөрөнгө оруулалт, гүйцэтгэлийн албаны дарга Д.Чулуунбат, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасанням, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Д.Ариунболд, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Энхжавхлан, мөн газрын Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Төсвийн төслийн талаар илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат нар тус тус танилцуулав.

Илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Ё.Баатарбилэг, Х.Булгантуяа, С.Одонтуяа, Т.Доржханд, Ц.Сандаг-Очир, Ж.Бат-Эрдэнэ, О.Цогтгэрэл, Ц.Туваан, Н.Наранбаатар, Н.Алтанхуяг, Ш.Раднаасэд, Ж.Батсуурь, Б.Батгөмөр, Ч.Ундрам, Т.Энхтүвшин, Т.Аубакир, Г.Мөнхцэцэг, Н.Ганибал, Д.Бат-Эрдэнэ, Б.Энхбаяр, Г.Амартүвшин, Б.Жаргалмаа, Д.Сарангэрэл, Н.Энхболд, Ц.Мөнхцэцэг, М.Оюунчимэг, Д.Батлут, П.Анужин, Ж.Мөнхбат, Ж.Батжаргал, Ц.Идэрбат, Д.Тогтохсүрэн, С.Ганбаатар, С.Бямбацогт, Д.Цогтбаатар, Б.Энх-Амгалан нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн нарын урилгаар Увс аймгийн Тариалан, Түнхэл сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Ц.Мөнхцэцэг, Ц.Мөнх-Оргил нарын урилгаар Сүхбаатар дүүргийн 4, 20 дугаар хороодын иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Н.Ганибал нарын урилгаар Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын урилгаар Монгол Улсын Их сургуулийн номын сангийн албан хаагчид, Улсын Их Хурлын

гишүүн Ж.Эрдэнэбат, Ч.Ундрэм, Д.Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын цэцэрлэгийн багш, ажилчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын урилгаар Бүгд Найрамдах Солонгос Улсын Кёнгэ аймгийн Гуанжу, Ханам хотуудын худалдаа, аж үйлдвэрийн тэргүүлэгчдийн төлөөлөл, Үндэсний батлан хамгаалах их сургуулийн Гадаад харилцааны сургалтын төвийн багш, ажилчид, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчид, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Ж.Ганбаатар, Х.Ганхуяг нарын урилгаар Баянгол дүүргийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ц.Сандаг-Очир нарын урилгаар Орчлон ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Н.Энхболд, Ц.Туваан нарын урилгаар Төв аймгийн Зуунмод сумын сургууль, цэцэрлэгийн багш нарын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, Т.Доржханд, Г.Амартүвшин нарын урилгаар Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын 63 дугаар сургуулийн багш, ажилчид, Ахмадын хорооны дарга нар, Нийслэлийн ерөнхий боловсролын 52 дугаар сургуулийн ахлах ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын урилгаар Ховд аймгийн Үйлдвэрлэл, үйлчилгээний хоршоодын холбооны ахмадууд, Улсын Их Хурлын гишүүн Д.Бат-Эрдэнийн урилгаар Өмнөговь аймгийн Үйлдвэрлэл, үйлчилгээний хоршоодын холбооны ахмадууд Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 7 цаг 05 минут үргэлжилж, 76 гишүүнээс 70 гишүүн хүрэлцэн ирж, 92.1 хувийн ирцтэйгээр 18 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2022 оны 10 дугаарсарын 06-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

42 гишүүн хүрэлцэн ирж, 55.3 хувийн ирцтэй байна. Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 6-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

2.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төсөл,

3.“Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

4.“Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т заасны дагуу үг хэлэх горимын саналаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, нэмэх, дараалал өөрчлөх горимын санал гаргах бол өмнөх өдрийн 5 цагаас өмнө санал бичгээр ирүүлэх заалтын дагуу Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж, Цэрэнпилийн Даваасүрэн, Сайнхүүгийн Ганбаатар нараас тус тус ирүүлсэн албан бичгүүд ирүүлсэн байна. Ингээд албан бичгийн дагуу Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Гишүүдийнхээ энэ өглөөний амгаланг айлтгая.

Тэгэхээр би хамгийн сүүлд нь одоо дараалалд асуудал оруулах талаар бас ярина.

Хөдөө орон нутгаар 7 сарын 15-наас хойш 9 сарын 25 хүртэл ажиллаа. Энэ хугацаанд Ховд аймгийн иргэдийн гаргасан саналуудыг бас та бүхэнд хэлье.

Ховд аймгийн Цэцэг сумын иргэн Дамдинбазар, Ховд аймгийн Ховд сумын иргэн Хайсаа, Мөст сумын иргэн Баяст нар юмны үнэ тэнгэрт хадлаа, малын үнэ газарт уналаа, энэ талаар төр засаг тодорхой арга хэмжээ аваач ээ гэдэг саналыг хэлж байна. Алтай сумын Гантөмөр, Дарви сумын иргэн Батдэлгэр, Булган сумын иргэн Алтанцог нар арьс шир одоо газар хөсөр хаягдаж байна. Анхан шатны үйлдвэрийг одоо сүм бүрд барил барих талаар тодорхой арга хэмжээ авч өгөөч ээ гэж хүсэлтийг гаргаж байна. Мянгад сумын иргэн Намсрайжав гэдэг хүн Засгийн газар

хэт их PR-аар ажиллаж байна аа, хөрсөн дээр амьдрал дээр буусан шийдвэр ерөөсөө гарахгүй байна.

Тийм учраас хүмүүсийн амьдрал одоо хэцүүдэж байна гэдгийг хэлж байна. Алтай сумын Бодонч багийн иргэн Батаа гэдэг хүн буу байтугай хүрз бариад явахад хэцүү боллоо, Зөрчлийн хуулиар торгуулж байна аа, энэ Зөрчлийн хуулиа хурдан одоо эерэг ард түмэнд эерэг болгож өгөөч ээ гэсэн ийм хүсэлтийг тавьж байна.

Булган сумын Байтаг багийн иргэн Дүгэржав, Эрдэнэбүрэн сумын Баянгол багийн иргэн Чулуунхүү нар шүлхий өвчний вакцины талаар бас ялангуяа Оросын вакциныг оруулж ирэх талаар ажиллаач ээ гэж, Зэрэг сумын иргэн Гүвээ багийн Мөнхбат, Дөргөн сумын Цогбадрах нар өвөлжилт хүндрэх нь ээ.

Тийм учраас өвс тэжээлийн татдаг тээврийн асуудлыг бас тодорхой хэмжээгээр шатахууны үнэ дээр нь бас туслах талаар, мөн одоо гадаадаас орж ирж байгаа өвс тэжээлийн гаалийн татварыг НӨАТ-ыг чөлөөлөх талаар одоо ажиллаж өгөөрэй гэж хүсэлт тавьж байна.

Манхан сумын Баянгол багийн Биндэръяа гэдэг хүн хөнгөлөлттэй эмийн заримыг аймгийн төв орж бичүүлж байна захиалахын тулд, үзүүлэхийн тулд, авахын тулд одоо 3 удаа аймаг орж байна. Тэгээд тэр эм ээ одоо ингээд л 2 сарын хугацаанд л авдаг, тэгээд дахиад 2 сарын дараа дахин 3 удаа аймаг орох ийм нөхцөл байдал руу орох нь ээ.

Тийм учраас энэ тал дээр одоо арга хэмжээ аваач ээ, Цэцэг сумын иргэн Уламбаяр гэдэг хүн ерөөсөө энэ

хөнгөлөлттэй эмийн асуудлаар бол ерөөсөө энийгээ боль оо, энэ очер дараалал нь хүчрэгдэхээ болих юм байна. Тийм учраас ерөөсөө энэ нэг хөнгөлөлтийг нь аваад хаячих, тэгвэл хамаагүй дээр юм байна гэсэн ийм саналыг хэлж байна.

Мөст сумын иргэн Баянзүрх багийн иргэн Хүрлээ гуай статистик маш худлаа гаргаж байна. Манай Баянзүрх баг гар аргаар 8 тонн өвс бэлтгэсэн гэж ярьдаг, харамсалтай нь одоо манайхан тийм бэлтгэсэн нэг ч хүн байхгүй. Гэтэл дээр үеэсээ гардаг статистикаа хэвээр нь тоогоо өгдгөө болимоор байна гэдэг энэ зүйл ярьж байна. Хамгийн сүүлд нь Мөнххайрхан сумын Хаг багийн иргэн Мөнхтуул гэдэг хүн би 3 хүүхэдтэй, 3 хүүхдийнхээ одоо эрэгтэй хүүхэд тэр хүүхдийнхээ эрхээр хөлсөөр малаа өгөөд сумын төв рүү ордог. Сумын төв ороод одоо хүүхдээ харж байх хооронд 12 сарын 20-ноос 2 сарын 1 хүртэл одоо хүүхдийн амралтыг тавьдаг. Энэ амралт тавихаар бид нар ингээд суман дээр хий эргэсээр байгаад таарах юм.

Тийм учраас энэ хүүхдийн амралтыг өвөл одоо хот, хөдөөгөөр нь ялгаад өвөл одоо хүйтэн, түгжэрэлтэй утаатай үед нь тэр хотынхоо хүүхдийг амраагаад, харин одоо ид ажлын үеэр сумын хүүхдүүдийг 3 сарын 1-нээс 4 сарын 10 хүртэл амрааж өгөх талаар одоо ажиллаж өгөөч ээ гэдэг ийм одоо хүсэлтийг тавьж байна. Бас нэг Мөнххайрхан сумын Алаг багийн иргэн Отгонжаргал НӨАТ-ын татварыг одоо 5 хувь болгох талаар одоо гаргаж байгаа санаачилга чинь маш зөв байна. Ялангуяа энэ хөдөө алслагдмал бүс нутагт амьдарч байгаа ард

иргэдийн хувьд бол энэ маш тийм одоо барааны үнэ өсөхөд нөлөөлж байна.

Худалдаа үйлчилгээний шат болгон дээр авдаг энэ НӨАТ-ын татвар алслагдмал бүс нутагт амьдарч байгаа ард иргэдийн хувьд маш тийм хүнд нөхцөл рүү авчирч байна. Тийм учраас энэ талаар бас тодорхой арга хэмжээ аваач ээ гэдэг ийм одоо хүсэлтийг тавьж байна.

Алтай сумын иргэн Эрдэнэболд гэдэг хүн тэр 7 жилийг 5 жил болгох хуулийн төслөө маш яаралтай хэлэлцүүлж, батлуулж аваарай. Тэгээд энэ дээр бол маш их ард түмний хүлээлт байгаа шүү. Энэ талд одоо хоёргүй сэтгэлээр зүтгээрэй гэсэн ийм хүсэлтийг тавьж байна. Ингээд анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Пүрэвдорж гишүүн энэ тойргийн асуудал болон иргэдээс ирж байгаа санал гомдол, хүсэлтийг Өргөдлийн байнгын хороогоор хэлэлцдэг дэг журамтай байсан. Хуулийн өөрчлөлтийн дагуу хөөе, асуултад чинь хариулж байна, Пүрэвдорж гишүүн ээ, Пүрэвдорж гишүүн ээ.

Та бол нийт ард түмний хүсэл эрмэлзлийг төлөөлөх үүрэгтэй хүн бөгөөд энэ асуудлуудыг Байнгын хороод дээр иргэдийн өргөдөл гомдлыг ярихаар зохицуулсан байгаа. Ингээд Байнгын хороон дээр энэ асуудлуудыг ярьж байгаарай, чуулган дээр биш Байнгын хороон дээрээ холбогдох Байнгын хороон дээрээ Боловсролын хуулийн хэрэгжилтийг. Санал тавиад ярьж байгаа.

Ингээд дараагийн гишүүн бичгээ ирүүлсэн гишүүн, Цэрэнпилийн

Даваасүрэн гишүүн бичгээ ирүүлсэн байна.

Ц.Даваасүрэн: Та бүгдийнхээ энэ өдрийн амгаланг эрье ээ.

Өнгөрсөн 6 сард Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн заалт тайлбарласан ийм хууль бус үйлдэл гаргасан. Үүнтэй холбогдуулаад би Улсын Их Хуралд бол 2 асуудал тавьсан байгаа. Их Хурлаас томилогдсон тэр Одбаяр, Солонго, Баясгалан гэсэн гишүүдийг эргүүлэн татаач ээ. Мөн энэ хууль бус үйлдэлтэй холбогдуулаад би Улсын Их Хурлын гишүүний хувьд Цэцэд гомдол гаргасан байгаа. Эдгээр асуудлыг бол уг нь одоо Байнгын хороон дээр хэлэлцэх ёстой юм. Энэ долоо хоногийн хуваарьт л алга, ирэх долоо хоногийн хуваарьт одоо энийг хэлэлцэх гэж байна уу, яах гэж байна. Нэг тийш нь шийдэж өгөөч ээ гэж. Тэгээд ер нь бол энэ Улсын Их Хурлын зүгээс л энийг шийдэхээс өөр арга байхгүй.

Цэцийн энэ одоо гаргасан шийдвэр бол дахин сонгогдох боломжгүй гэж эмээсэн, жагсаалтын ард нуугдаж гишүүн болох гэсэн улс төрчдийн захиалга байсан. Үүнийг л одоо цэц болиулсан. Би одоо таны хариу өгөхгүй. Ингээд дараад байхаар бас нэг одоо захиалагч нь юм болов уу гэж хардахад хүрч байна. 6 сард та тойрогтоо очиж нэг сайн загнуулаад ирсэн. Тэрнээс 10 хоногийн дараа энэ Цэцийн шийдвэр гарсан. Тэгээд Баянхонгорчууд таныг 3, 4 удаа сонгосон байх. Үүний хариуд нь одоо тэр ард түмний сонгох эрхийг булааж авч байгаа ийм хууль бус үйлдлийг одоо дараа суугаад байж бас болохгүй ээ.

Г.Занданшатар: Горимын санал биш байна.

Ц.Даваасүрэн: Үгүй ээ, би дараалалд оруулж өгөөч гэж хэлж байна шүү дээ, энийг шийдвэрлэхгүй байгаа болохоор чинь би өөрт чинь хэлж байна шүү дээ.

Г.Занданшатар: Дэг зөрчиж байвал та Үндсэн хууль зөрчиж байна.

Ц.Даваасүрэн: Улс төрчдийн эмээлгэж байгаа ганц ташуур бол гишүүнээ сонгох байгаа. Хүнээ сонгож байгаа гийн хүчинд энэ улс орныхоо эрх ашгаас урвасан Оюу толгойг гадагшаа өгсөн нөхдүүдийг дахин сонгохгүй үлдээж чадаж байна шүү дээ. Нам сонгодог болох юм бол тэд энд торойгоод л сууж байна. Энэ одоо ганц ташуурыг нь хураагаад авчих юм бол энэ иргэд чинь бол эрх мэдэл, хөрөнгөтэй хүмүүсийн эрхшээлд нэг мөсөн орно оо. Энэ намын жагсаалтын ард хэн ч сонгогдож болно гэдгээс л би эмээгээд байгаа учраас энэ зүйлийг одоо шийдээч ээ гээд би хуулийн дагуу хүсэлт тавьсан.

Тэгэхээр энийг хэлэлцэх ёстой. Тэгэхээр энийг би хэлэлцэх жагсаалтад оруулж хэлэлцээч ээ л гэдэг асуудал одоо хэлэлцэх асуудалтай холбогдуулж л би үг хэлж байна. Тэгэхээр та одоо ингээд дарга болоод ирэхээрээ үг дааж чадахгүй болсон байна. Мөнхийн албан тушаалд очсон юм шиг ташуурсан байна. Үг дааж сур. Хэрвээ үнэхээр та одоо тэр өөрийгөө сонгосон иргэдэд хайртай дуртай.

Г.Занданшатар: Хуулиа дагаж мөрдөж ажиллахыг, хууль дээдэлж ажиллахыг өргөсөн тангарагтаа үнэнч байхыг сануулъя. Үндсэн хуулийн дагуу энэ өнөөдөр асуудал нэмэх, дараалал өөрчлөх, асуудлыг

хойшлуулах горимын санал гаргана. Улсын Их Хурлаар зөвхөн өргөн баригдсан хууль, тогтоолын төслийг хэлэлцдэг ээ.

Ингээд дараагийн гишүүн Сайнхүүгийн Ганбаатар гишүүн үг хэлнэ. Ганбаатар гишүүн түр хүлээж байгаарай. Хойшлуулж байгаа д дахиад хэлүүлъя.

Энэ Ганбат гишүүн сандал, ширээ булаацалдаж чуулган үймүүлэхээ больё. Өөрийн чинь энэ Туваан гишүүний суудал дээр сууя гэсэн хүсэлтийг Тогтохсүрэн дарга тавиад тэр Туваан гишүүн суудлаа тавьж өгөөд суусан байна. Тэгээд одоо битгий сандал ширээ булаацалдаж бай. Бүтэн 2 жил сандал, ширээ булаацалдаад чуулган үймүүлж байгаа Ганбат гишүүнд сануулга өглөө.

Одоо Сайнхүүгийн Ганбаатар гишүүнд үг хэлэх боломжийг олго. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Ингээд хэлэлцэх асуудлын жагсаалтад гүйцэтгэлийн аудитын тайланг оруулахыг би хүсэж байна. Аудитын сэдэв нь Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр. Их Хурлын дарга аа дахиад надад үг өгөх үү?

Г.Занданшатар: Ганбаатар гишүүн эхнээс нь үгээ хэлье.

С.Ганбаатар: Эхнээс нь үгээ хэлье ээ.

Эрхэм нөхөд өө, их чухал зүйл ярих гэж байна би. Монголын ард түмний өмнө хамгийн чухал асуудал бол ажлын байр бий болгох байгаа.

Ажлын байраа хадгалах явдал хамгийн чухал. Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцсэн хөдөлмөр эрхлэлтийн салбарт хэрэгжүүлсэн төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн гэдэг энэ гүйцэтгэлийн аудитын тайланг Их Хурлаар авч хэлэлцээч ээ. Энэ бүр маш чухал, ноцтой, тийм чухал тайланг Улсын Их Хурлын нүд чих болсон аудитын газар хийсэн байна. Энэ зүгээр Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцээд л одоо ингээд болоо. Энийг Улсын Их Хурлаар хэлэлцээч ээ. Энэ дээр гарсан хамгийн ноцтой дүгнэлт юу гэсэн үг вэ гэвэл Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ ажлаа хийхгүй байна л гэсэн байна.

Ерөнхий сайд Оюун-Эрдэнийн хамгийн чухал ажил бол энэ Засгийн газрын эрх баригчдын энэ 76 бидний хамгийн чухал ажил бол Монголчуудыг ажилтай байлгах, орлоготой байлгах, байгаа ажлын байрыг нь хадгалах, энэ тал дээрээ Монголын Засгийн газар, Монголын Улсын Их Хурал юу ч хийхгүй байна. Бүр гаргаад ирсэн тайлангий нь Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцдэг. Уг нь бол Эдийн засгийн байнгын хороо, Улсын Их Хурлаар хэлэлцээд Ерөнхий сайдын түвшинд энийг ярилцах ёстой зүйл. Энийгээ хэлэлцэх жагсаалтад оруулж өгөөч ээ гэдэг горимын саналыг би гаргаж байна. Энэ дээр 1.45-д заасан байгаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар төрийн байгууллагуудын чиг үүрэг харилцан уялдаагүй байна. Хөдөлмөр эрхлэлтийн талаар төрийн байгаа ууллагууд, тэр дунд яамдын уялдаа байхгүй байна. Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ энэ хувь хүн яриагүй ээ,

улс төржилт биш ээ, Солонгосын Ерөнхий сайд ажлаа сайн хийж байгаа учраас Монгол залуучууд Солонгос руу яваад байна Монголын Ерөнхий сайд, Монголын Ерөнхийлөгч нь мод тарихаас өөр ажил хийхгүй байгаа учраас Монгол залуучууд Солонгос яваад байна. Би мод тарихыг ерөөсөө эсэргүүцээгүй. Хамгийн гол нь энэний хажуугаар тэр сонгуулиар амласан ажлын байраа бий болгох талаар анхаараач ээ. Та нар боддоо, 6 жилийн өмнө Монгол Ардын нам эрх бариад Монгол хүн болгоны ногдох өрийг 30 саяд хүргэнэ ээ гэсэн бол би лав тэр хүнийг галзуу хүн байна гэж бодно. Өнөөдөр 30 саяд хүрчихсэн. 3 хүүхэдтэй нэг одоо өрх бол 150 сая төгрөгийн өртэй байна гэсэн үг. Бүр хувааж үзвэл арифметик дунджаар. Өнөөдөр инфляц 16.2 хувьд хүрлээ.

Өнөөдөр доллар 3500 гараад явчихлаа, одоо Ерөнхий сайд Оюун-Эрдэнийг огцор, энэ Засгийн газар, эрх баригчид ажлаа хийж чадахгүй байна гэдгийг ярих цаг болсон. Гол миний хэлэх гээд байгаа зүйл гэвэл энэ ажилгүйдэл, ядуурлыг гааруулсан энэ аудитын дүгнэлт та нар хардаа төсвөөс нэг ч төгрөг байхгүй шүү дээ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар төсвөөс нэг ч төгрөг байхгүй, гадаадын ажилчид Монгол хүний ажлыг булаасны төлөө төлбөр төлдөг, тэр төлбөрөөр Монгол хүнийг ажилтай байлгах 182 тэрбум төгрөг л байгаа. Өөр төсөвт мөнгө байхгүй. Хамгийн гол асуудал дээрээ бид мөнгө тавиагүй. Ийм арчаагүй асуудлыг аудит харин маш сайн дүгнэлт гаргасан байна.

Өнөөдөр хөдөлмөр эрхлэлтийн талаар Засгийн газар, Улсын Их Хурал хумсаа ч хөдөлгөхгүй байна. Харин Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн

яамны нуруун дээр аваачиж хаячхаад тэгээд л өөрсдөө нүүрс яах гэж гаргах гээд байгаа юм. Ажлын байртай болгох гэж л гарах гэж байгаа. Тэгэхлээр энэ асуудлыг хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулмаар байна.

Хоёрт нь миний хэлэх зүйл гэвэл хөдөлмөр эрхлэлтийн талаарх хууль тогтоомжуудаа хэрэгжилтийг эргээж харах цаг болсон. Энэ аудит дээр бас дүгнэлт нь гарсан байгаа. Энэ олон дүгнэлтүүдийг дэлгэрэнгүй би хэлэлцэх асуудлын жагсаалтад хэрвээ орвол ярилцмаар байна. Бид төлөвлөгөө гаргамаар байна.

Горимын санал гаргалаа, дэмжиж өгнө үү.

Г.Занданшатар: Хэлэлцэх асуудалтай холбогдуулж асуудал нэмэх, хойшлуулах, дараалал өөрчлөх талаар гаргаж байгаа саналыг горимын санал гэж нэрлэнэ. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу. Тэгэхээр цаашидаа гишүүд ийм горимын санал гаргах бол ядаж өргөн баригдсан хууль, тогтоолын төслөө өргөн барьчхаад, тэгээд энэ асуудлыг хэлэлцье, хойшлуулъя, нэмье. Энэ 7 хоногийн хуваарьт оруулаач гэж Байнгын хороондоо санал хүсэлтээ тавьчхаад Байнгын хорооноос ирүүлсэн санал хүсэлтүүдийн дагуу даргын дэргэдэх зөвлөлөөс хэлэлцэх асуудлын дараалал, товыг тогтоож байгаа. Тийм учраас тайлан бол хуулиар хэлэлцдэг, хугацаатай.

Тэгэхээр Ганбаатар гишүүний асуудлыг хугацааных нь дотор хэлэлцсэн эсэх, тэрийг Тамгын газар холбогдох Байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороо одоо төсөв

хэлэлцэхээр Төсвийн байнгын хороо авч үзэх шаардлагатай. Дэгийн хуулийн 112.6-д Байнгын хороо энэ хуулийн 112.2-т заасан тайлан, илтгэл, мэдээллийг хэлэлцээд, шаардлагатай гэж үзвэл холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулж холбогдох санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд танилцуулж болно гэж заасан.

Тэгэхээр энэ Байнгын хороон дээрээ тайланг сонсоод нэгдсэн хуралдаанд тогтоолын төсөл юм уу холбогдох арга хэмжээний төсөл боловсруулаад оруулж ирвэл нэгдсэн хуралдаан, чуулганаар хэлэлцэнэ. Байнгын хорооноос орж ирээгүй байна. Тийм учраас Байнгын хороон дээрээ энэ асуудлууд сайн ярьцааж бай, Дэгийн хуулиа сайн уншицгааж бай. Тэгээд Байнгын хороон дээрээ тэр асуудлаа Цэцийн асуудал байна уу, тогтоолын төслөө санаачлаад хэлэлцүүлээд, тэгээд нэгдсэн хуралдаанд оруулж ирэх ийм дэгтэй. Дэгээ барьж ажиллахыг хүсье.

Одоо дараагийн асуудалд орно оо.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ ээ.

Төслийн талаарх танилцуулгыг Монголбанкны Ерөнхийлөгч Бядрангийн Лхагвасүрэн танилцуулна.

Ажлын хэсгийг урьж байна.

Б.Лхагвасүрэн: Эрхэм хүндэт Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн бариад байгаа билээ. Дэлхий нийтийг хамарсан цар тахал, олон улсын зөрчилдөөн, нөхцөл байдлаас шалтгаалсан гадаад, дотоод үнийн өсөлт, эдийн засгийн хүндрэлийг төсөв, мөнгө, санхүүгийн бодлогыг уялдуулан хэрэгжүүлэх замаар даван туулах, Монгол Улсын эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр төрийн мөнгөний бодлогыг 2023 онд баримтлах үндсэн чиглэлийг боловсруулсан билээ. Гадаад орчны таагүй нөхцөл байдал нь Монгол Улсад шууд болон шууд бус замаар нөлөөлж, өнгөрсөн 2 жил гаруй хугацаанд эдийн засгийн идэвхжил сул байлаа. Төсөв, мөнгө, санхүүгийн бодлогын арга хэмжээ үр дүнгээ өгч, дотоод эрэлт эрчимжсэнээр эдийн засаг 2022 оны эхний хагас жилд өнгөрсөн оны мөн үеэс 1.9 хувиар тэлээд байна аа.

Тээвэр, уул уурхай, барилгын салбараас бусад бүх салбар өсөж, өрхийн хэрэглээ, хөрөнгө оруулалт үргэлжлэн сэргэснийг энд онцлохыг хүсэж байна.

Цаашид экспорт үргэлжлэн сэргэсэн тохиолдолд эдийн засаг энэ онд 3 хувь, ирэх онд 4-өөс 5 хувиар өсөх тооцоололтой байгаа. Монгол Улс төдийгүй дэлхий нийтийн инфляцад дотоодын эдийн засгийн идэвхжлээс гадна гадаад үнэ, эрчим хүчний үнэ, валютын ханш, тээвэр логистикийн хүндрэл хүчтэй нөлөөлөх боллоо. Манай улсын хувьд нийт инфляцын 60-70 хувь нь тээвэр болон гадаад үнэ, түүний шууд болон дам нөлөөгөөр бий болж байгаа ийм тооцоолол харуулж байна. Цаашид инфляцыг бага түвшинд бууруулах нь эдийн засгийн

тогтвортой өсөлтийг хангахад урьтаж суурь нөхцөл болох тул инфляцыг 2023 онд нэг оронтой тоонд дунд хугацаанд 6 нэмэх, хасах 2 нэгж хувийн интервал тогтворжуулахад мөнгөний бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ ээ.

Энэ зорилтыг хангах нь маш хэцүү хүнд хэдий ч тээвэр логистикийн сайн зохион байгуулалт, дотоод хүнсний бүтээгдэхүүний хангамжийг тасралтгүй байдал, экспортын орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр салбар бүрийн яам, агентлагийн үйл ажиллагаа том хувь нэмэртэй, экспортын орлогыг нэмэгдүүлэхгүйгээр эдийн засгийн аливаа хүндрэлийг давах, валютын ханшийг тогтворжуулах бололцоогүй гэдгийг мөн онцлохыг хүсэж байна. Энэ он гарснаас хойш бодлогын хүүг 6 нэгж хувиар нэмэгдүүлж, бодлогын тохиргоог хийсэн бөгөөд цаашид ч шинэ энэхүү дан ганц мөнгөний бодлогыг хатууруулах замаар асуудал, хүндрэлийг шийдвэрлэх гэж оролдох нь хувийн секторт илүү их гарз хохиролтой болох нь бол ойлгомжтой.

Иймд бусад бодлогын тохиргоо, үйл ажиллагааны зохион байгуулалт маш өндөр ач холбогдолтойг бас хэлэхийг хүсэж байна. Гадаад худалдааны тэнцэл Муудсан нь валютын цэвэр орох урсгалд нөлөөлж байна. Сүүлийн улирлуудад дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ өндөр түвшинд байсан боловч манай экспортын үнэ бодитойгоор одоо бас бага хэмжээндээ байсаар байлаа. Томоохон төсөл, бүтээн байгуулалтын дотоод эх үүсвэр, экспортын орлогоос санхүүжүүлж байгаа нь валютын орох урсгал дотоод зах зээлд орж ирэхгүй ийм байх нэг нөхцөл болж байна. Бензин,

шатахууны үнэ гэх мэт импортын үнийн өсөлт, импортын төлбөрийг нэмэгдүүлж, импортыг бол нэмэгдүүлсээр байна. Төсвийн өндөр зардал, хямралын дараах эдийн засгийн сэргэлт зэрэг нь худалдааны тэнцэлд сөргөөр нөлөөлж байгаа г бас онцлохыг хүсэж байна.

Төлбөрийн тэнцлийн тусгал болсон валютын орох, гарах урсгалын зөрүү нь эцэстээ хатуу мөнгөний бодлоготой зэрэгцэн банкны систем дэх эх үүсвэрийг бууруулж, улмаар зээлийн өсөлтийг сааруулж байгаа болно оо.

Цаашид дэд бүтцийн бүтээн байгуулалтууд нь худалдааг хөнгөвчлөхөд маш том эерэг нөлөө үзүүлэх хэдий ч логистикийн саатал БНХАУ-аас хэрэгжүүлж буй 0 ковид бодлого зэрэг гадаад хүчин зүйлсээс маш их хамаарч байгааг бол бас онцлон тэмдэглэе ээ.

Иймд юуны түрүүнд улсын санхүүгийн нөөцийг хамгаалахад онцгойлон анхаарч, хатуу төсөв, мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, хөгжлийн бодлогыг гадаад эх үүсвэрт тулгуурлан дотоод санхүүгийн чадавхтай нийцүүлэн хэрэгжүүлэх ийм шаардлага зүй ёсоор үүсээд байна аа.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төрөөс мөнгөний бодлогын талаарх 2023 онд баримтлах үндсэн чиглэлд төрийн эрх бүхий бусад байгаа ууллагуудтай хамтран хэрэгжүүлэхээр дараах асуудлыг бодлогын зорилт болгон тусгалаа.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлд гадаад төлбөрийн чадварыг сайжруулж, үүсээж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэрийг хангахад макро эдийн засгийн бодлогуудыг чиглүүлэхэд онцгойлон анхаарсан болно. Дунд, урт хугацаанд эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад аж үйлдвэрийн салбарын боловсруулалтыг гүнзгийрүүлж, импортыг орлох салбарыг хамгаалж, экспортыг дэмжих, эдийн засгийн төрөлжилтийг гүнзгийрүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг төсөв, мөнгөний бодлого, санхүүгийн зохицуулалтын хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай болно. Түүнчлэн логистикийн хүндрэлийг шийдвэрлэн хилийн гацааг арилгаснаар экспортын орлогыг нэмэгдүүлж, худалдааны эргэлтийг сайжруулж, тээврийн зардлыг бууруулан, үнэ ханишийн дарамтыг шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна. Гадаад орчны сөрөг нөлөөг зөөлрүүлж, эдийн засгийг дэмжих зайлиггүй хийх арга хэмжээ нь гадаад төлбөрийн чадварыг сайжруулж, гадаад санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх явдал билээ.

Дунд хугацаанд тогтвортой хөгжлийн нэн чухал зүйл болох уул уурхайн бус экспортыг дэмжих чиглэлээр гадаад худалдааны санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхийн зэрэгцээ тогтвортой ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлд үргэлжлүүлэн дэмжиж ажиллахаар мөнгөний бодлогод тусгасан болно. Эдгээр асуудлууд дэлхий нийтээр анхаарал хандуулж, онцлох дэлхий нийтээрээ бас анхаарал хандуулж байгаа г онцлох онцлох нь зүйтэй.

Мөнгө угаах, терроризмтой тэмцэх чиглэлээр үндэсний хөтөлбөрийг үндэсний хөтөлбөрийн хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлэх, санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад иргэд, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, түүнд шаардлагатай арга хэмжээнүүдийг эрчимжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ, ажлуудыг зорилт болгон тусгасан болно.

Цаашид үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэрийг хангахад макро эдийн засгийн бодлогуудыг чиглүүлэх нь чухал болж байна. Монголбанкны 2023 оны бодлого, үйл ажиллагааг инфляцыг зорилтот түвшинд эргүүлэн тогтворжуулах замаар эдийн засагт эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангах, тогтвортой өсөлтийн суурь нөхцөлийг бий болгоход дэмжлэг зүүлэхэд чиглүүлсэн билээ.

Эрхэм Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлийг баталж өгөхийг Та бүхнээс хүсэж байна.

Их баярлалаа.

Г.Занданшатар: Одоо төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамбын Цэрэнпунцаг.

Эдийн засгийн байнгын хорооны дарга танилцуулна аа.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ

Монголбанкнаас Төв банк Монголбанкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасны дагуу 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөлд хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2023 онд нэг оронтой тоонд, дунд хугацаанд 6 дээр нэмэх нь хасах нь 2 нэгж хувийн интервал тогтворжуулах зорилтыг хангахад чиглэсэн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд банкны хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын жишиг зарчимд нийцүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын арга барилд шилжих арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, Төв банк, олон нийттэй харилцах харилцааг олон улсын сайн туршилагад тулгуурлан өөрийн орны онцлогийг тусгасан хэлбэрээр боловсронгуй болгох, иргэдийн мэдээллийн тэгш бус байдлыг бууруулах, хүлээлтийг тогтворжуулах, улмаар бодлогын зорилтот үр дүнд хүрэх боломжийг нэмэгдүүлэх, төлбөрийн системийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, олон улсын шилдэг технологийг нутагшуулах, санхүүгийн үйлчилгээний инновацыг дэмжих, Цахим хөгжлийн багц хуультай уялдуулан мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, иргэдэд эдийн

засаг, санхүүгийн суурь мэдлэг олгох чиглэлээр тодорхой асуудлуудыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөжээ.

Геополитикийн эрсдэл өндөр байгаа хэвээр хадгалагдаж, БНХАУ-д 0 ковид бодлого цаашид үргэлжлүүлэхээр байгаа энэ үед Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, СЗХ хамтран гадаад орчны сөрөг нөлөөг зөөлрүүлж, эдийн засгийг дэмжих, гадаад төлбөрийн чадварыг сайжруулах, гадаад санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, тээвэр ложистикийн чадавхыг сайжруулах, үүсээд буй тээврийн хүндрэлийг шийдвэрлэх, уул уурхайн бус экспортыг хөгжүүлэх, нэвтрүүлэх, тогтвортой ногоон санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг олон чиглэлээр төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай үргэлжлүүлэн хамтран ажиллахаар төлөвлөсөн байна.

Цаашид нийгэм, эдийн засгийн бодлогын эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах, валютын дотогшилох урсгалыг нэмэгдүүлэх зорилт бүлэгт чиглэсэн халамжийн бодлого хэрэгжүүлэхээс гадна дунд, урт хугацааны тогтвортой хөгжлийн зорилттой нийцүүлэх, цаашид үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэрийг хангахад макро эдийн засгийн бодлогуудыг уялдуулан чиглүүлэх бодлого, арга хэмжээнүүдийг тусгасан байна.

Тогтоолын төслийг хуралдаанаар хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг Валютын нөөц багассан, хани тогтворгүй,

инфляцын түвшин өндөр байгаа үед дотооддоо шийдвэрлэх боломжтой асуудлууд дээр анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд өмнөх жилийн батлагдсан төсвөөс энэ жилийн төсвийн тэлсэн, төлбөрийн тэнцэл, гадаад бондын өр, төлбөрийн асуудал, гадаад нөөцөө хэрхэн удирдах талаар тодорхойгүй байгаа тул 2023 оны мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төсөл дэх хэрэгжих боломжгүй зорилтуудыг шинэчлэх шаардлагатай гэсэн санал гаргасан болно оо.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл, Чимэдийн Хүрэлбаатар, Баттогтохын Чойжилсүрэн нарын урилгаар Увс аймгийн Тариалан, Түргэн сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл

ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

Одоо Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Монголбанкны Ерөнхийлөгч Бядрангийн Лхагвасүрэн, СЗХ-ны дарга Дэмбэрэлдашийн Баярсайхан, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Баярсайханы Баярдаваа, Монголбанкны ерөнхий эдийн засагч Доожавын Ган Очир, Монголбанкны Нөөцийн удирдлага Санхүүгийн зах зээлийн газрын захирал Атарбаатарын Энхжин, Монголбанкны Бүтцийн өөрчлөлт бодлогын газрын захирал Найманжингийн Ариунбат, Монголбанкны Судалгаа статистикийн газрын захирал Дамдинжавын Даваасүх, СЗХ-ны Ажлын албаны дарга Түдэвийн Жамбаажамц, СЗХ-ны ББСБ-ын газрын дарга Бэгзийн Итгэлсүрэн.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Нэр тасаллаа.

Жамъянгийн Мөнхбат гишүүн.

Ж.Мөнхбат: Төрөөс мөнгөний талаар баримтлах тухай асуудлыг бид нар хэлэлцэж байна. Тэгэхээр Монгол банк, Засгийн газар 2-оос нэг нэг асуулт байна аа.

Өнөөдөр ам.долларын хани 3400, 3500 хүрээд ингээд талийж өгч

байна. 8 жилийн өмнө ам.доллар 1700 хүрч байхад би тухайн үедээ одоо сөрөг хүчний Улсын Их Хурал дахь сөрөг хүчний намын ЕНБД-аар ажиллаж байхдаа эрх баригчдад сануулж, энэ одоо ханшаа, энэ одоо инфляцаа, үнэ ханшаа одоо тогтвортой байлгаач ээ гэсэн одоо анхааруулга өгч улс төрийн ақц мэдэгдэл хийж байсан. 8 жилийн дараа тэр үеийн одоо ханшинаас 2 дахин нугалсан ийм ханштай болж байна. Тэгээд энэ нь одоо гол асуудал нь юунаас болж байгаа гэж энэ Монголбанк одоо дүгнэж байна аа? Дайны асуудлыг ярьж байгаа. Цар тахлын асуудал, Хятадын цар тахалтай холбоотой асуудал ярьж байгаа. Гол нэг асуудлаа ерөөсөө ярихгүй юм. Энэ экспортоо нэмэгдүүлэхийн тулд хил гаалиа нээх, энэ боомтынхоо үйл ажиллагааг сайжруулах тал дээр энэ Засгийн газраас ямар ажил, арга хэмжээ авч байна, Монголбанкнаас ямар бодлого, арга хэмжээ авч байгаа юм бэ? Энэ чинь одоо бүр арай дэндэж байгаа нөхцөл байдалд хүрч байна шүү. Цар тахалтай, эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаа, дайн байлдаантай байгаа нөхцөл байдлыг ойлгож байна. Гэхдээ энэ дээр одоо нэг дорвитой арга хэмжээ авахгүй бол энэ ханшийн асуудал энэ валютаа нэмэгдүүлэх асуудал дээр бол дорвитой арга хэмжээ авах цаг болсон байна.

Хоёрдугаарт, Засгийн газраас нэг зүйл асууя. Энэ мөнгөний хани, долларын хани өсөж, төгрөгийн хани суларч байна. Зөрөөд инфляц, өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдэж байна аа, энэ асуудал юутай холбоотой байна вэ?

Нөгөө нэг яриад байдаг нүүрсний чинь экспорт, байгаа алийн

баялгийн экспортын чинь борлуулалт ямар байгаа юм бэ? Энэний одоо түгээж дэлгэрүүлэх одоо энийг борлуулах асуудал дээр энэ хил, гааль, боомтын асуудал нэгдүгээр асуудал байдаг. Энэ дээр яаж анхаарч байгаа вэ? Улсын төсөв дээр энэ бодит байдлаар яаж хандаж энэ асуудлыг шийдье гэж оруулж ирж байгаа вэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ доллар, валютын ханшаа сайжруулахын тулд энэ худалдаалж байгаа байгаа алийн баялгууд чинь ерөөсөө доллар орж ирэхгүй байгаа гэдэг сурагтай байгаа д байх юм. Дандаа оптек гэрээгээр өмнө нь гэрээ хийсэн энэ төлбөрийн төлөөс нь одоо энэ нүүрс байгалийн баялгууд борлогдоод байгаа гэсэн байх. Энэ асуудал дээр нэг мэдээлэл өгөөч ээ. Энэ үнэхээр үнэн бол одоо яам ямар учраас ийм байдлаар бид нар баахан юмаа зараад борлуулаад байдаг. Тэгээд одоо валют нь орж ирдэггүй байдаг. Энэ асуудал дээр нэг тайлбар хийгээч ээ Засгийн газар.

Хоёрдугаарт, экспортыг нэмэгдүүлэх асуудал ерөөсөө ганцхан асуудал байгаа шүү дээ. Энэ хил боомтын л асуудал байгаа. Энэ хил боомтын асуудлыг сайжруулах асуудал дээр ямар ямар алхам хийж байна гэсэн ийм 2 зүйл дээр одоо хариулт авъя гэж бодож байна.

Тэгэхээр энэ долларын ханин ингэж талийж байгаа, инфляц өсөж байгаа энэ асуудал өөрөө эргээд хэн дээр ирж байна вэ гэхээр жирийн иргэд дээр аж ахуйн нэгжийн нуруун дээр л ирж байгаа юм. Энэ асуудал дээр Монголбанк яг ямар бодлого хэрэгжүүлэх гэж байгаа юм, Засгийн газар яг ямар бодлого хэрэгжүүлэх

гэж байгаа юм гэдгийг сонсмоор байна.

Г.Занданшатар: 83.
Монголбанкны ерөнхийлөгч
Бядрангийн Лхагвасүрэн.

Б.Лхагвасүрэн: Мөнхбат
гишүүний асуултад хариулья.

Төгрөг долларын эсрэг одоо өнгөрсөн онтой, жилийн өмнөхтэй харьцуулах юм бол 17 хувиар сулраад байна. Энэ сулрах бол ямар шалтгаан байна гэж асуултад хариулахад бол мэдээж гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл дээр бол энэ шалтгаанууд нь бол маш тодорхой харагдаж байгаа. Гадаад худалдааны хувьд бол экспорт бол өнгөрсөн оны мөн үеэсээ тодорхой хэмжээгээр өсөж байгаа ч гэсэн яг өнөөдрийн одоо импортоо нөхөх хэмжээгээр тэгж өндөр өсөж чадахгүй байна. Учир нь юу байна вэ гэхлээр одоо БНХАУ-ын тэр 0 ковид гээд хатуу хөл хорионы дэглэм үйлчилсэн хэвээр байгаа. Энэ нь өөрөө манай экспортыг хангалттай хэмжээнд гаргахад бол мэдээж тодорхой хэмжээний бэрхшээл учруулж байгаа юм. нөгөө талд нэлээн бас том нөлөө үзүүлж байгаа зүйл нь импорт байна. Импорт өнгөрсөн оны мөн үе 8 дугаар сартай харьцуулах юм бол энэ оны 8 дугаар сард 25 хувиар өсчхөөд байна.

Ингээд нэгэнт экспорт нь бага хэмжээнд гарч байгаа, импорт нь өндөр хэмжээнд өсөж байгаа учраас бол худалдааны тэнцэл болон төлбөрийн тэнцэл дээр маш их дарамтыг учруулж, худалдааны тэнцэл маань 8 сарын байдлаар 1.5 тэрбум долларын төлбөрийн тэнцэл маань 1.5 тэрбум долларын алдагдалтай гарсан. Энэ алдагдал

юунаас нөхөгдөх вэ гэхлээр Монгол Улсын валютын нөөцөөс л нэгэнт гадагш их төлбөр тооцсон учраас ингээд багасаад явж байгаа. Тэгэхлээр энэ нь бол хамгийн том нөлөө үзүүлж байгаа.

Өөр нэг шинэ зүйл бол юу байна вэ гэхлээр АНУ-ын доллар, ялангуяа АНУ-д байгаа инфляцын өндөр түвшин 9 хувь хүртэл хүрсэн өндөр түвшинтэй холбогдуулаад Америкийн төв банк бодлогын хүүгээ өсгөж байгаа. Бодлогын хүү өнөөдрийн байдлаар 3.25 болчихоод байна. Жилийн одоо энэ оны өмнө гэхэд бол зүгээр 0.25 шахуу байсан хүү өнөөдөр ингээд 3 нэгж хувиар ингээд өсчихсөн байгаа нь долларын эрэлтийг өсгөөд, одоо хөгжингүй буюу хөгжиж байгаа улсуудаас бол ингээд доллар гадагшлах урсгал, долларын эрэлт хэрэгцээ өндөр болсон. Тэгээд Монгол Улсын өнөөдрийн 17 хувиар суларчихсан байгаа, одоо сулралт маань Их Британийн фаунд одоо яг ижилхэн байгаа.

Их Британийн фаунд бол долларын эсрэг 17.9 хувь, Солонгосын вон гэхэд 19.1 хувь, Японы иен 25.2 хувь гээд ерөнхийдөө долларын хүү өссөнтэй холбогдуулаад бусад улсуудын мөнгөн тэмдэгт бол бас нэлээн ингэж байгаа ийм дэлхий нийтийн үзэгдэл явагдаж байгаа. Энэ үүднээсээ ерөнхийдөө бол ханиш ингээд сулрах дарамт нэлээн өндөр байгаа. Бидний зүгээс Төв банкны зүгээс бол Төв банкных мөнгөний бодлогыг бол хатууруулаад явж байна. Тэгээд сая 2 долоо хоногийн өмнө бодлогын хүүгээ 2 нэгж буюу 200 суурь нэгжээр өсгөж 12 хувьд хүргэсэн. Энэ маань өөрөө инфляц болон ханишны сулралт дээр бол тодорхой бодлогын тохируулга

хийх боломжтой гэж харж байгаа юм.

Г.Занданшатар: Засгийн газар Болдын Жавхлан сайд, Сангийн сайд.

Б.Жавхлан: Баярлалаа. Мөнхбат гишүүний асуултад хариулъя. Их чухал сэдэв хөндөж байна. Мөнгөний бодлогын дараа ирэх оны төсөв яригдана. Тэр үеэр энэ асуудлууд бас нэлээн дэлгэрэнгүй яригдах байх гэж ингэж бодож байна. Манай Засгийн газрын дэвшүүлж хэрэгжүүлж байгаа шинэ сэргэлтийн бодлогын нэг болох бондын сэргэлтийн бодлого ойрын тулгамдсан хамгийн чухал ийм хэсэг байгаа юм. Ингээд боомтын ажлуудыг бол нэг богино хугацаанд дунд, урт хугацаанд гэж салгаж харах хэрэгтэй. Богино хугацаанд бол бид ядаж ковидын өмнөх буюу 2019 онд гаргаж байсан тэр хэмжээндээ боомтоор нэвтрэн өнгөрүүлэх нь хамгаас чухал тулгамдсан ийм зорилт болж байгаа юм. Бид манай экспортын хамгийн том боомт болох Гашуун сухайт жишээ нь.

Гашуун сухайт дээр одоо жил гаруйн хугацаанд нэлээдгүй арга хэмжээ авлаа. Тэрний үр дүнд сүүлийн 6 сарын хугацаанд бид 2019 онд гарч байсан Нүүрс экспортын хэмжээндээ хүрч чадсан байгаа. Зарим өдрүүдэд бүр илүү ч гарч байгаа юм. Том тракуудаар 1350 тээврийн хэрэгсэл яг нүүрсний хэмжээгээр бол 150000 тонноос илүү хэмжээгээр өдөрт гарч байгаа юм. Ингээд явах юм бол сүүлийн хагас жилд эхний хагас жилийнхээ алдагдлыг бол нэлээн нөхнө. Бид нар энэ жил гаргана гэж байсан 18 сая тонноосоо давж биелэхээр ингэж харагдаж байгаа юм. Гашуун сухайт ийм байдалтай байна.

Тэгээд мөн том бүтээн байгуулалтуудын хувьд Гашуун сухайт хүртэлх төмөр зам ашиглалтад орсон. Замын-Үүд дээр мөн л одоо бид экспортын 12 цуваатай өдөртөө. Энийг удахгүй 16 болгож байгаа.

Ханги дээр одоо удахгүй мөн төмөр замаас Хангийн боомт хүртэл ашиглалтад орно. Хангиас цааши ачиж буулгаж одоо хил нэвтрүүлэх ийм терминал мөн одоо бүтээн байгуулалт нь эхэлсэн ингээд явж байна. Шивээ хүрэн бол мөн одоо өмнөх жилүүдээсээ нэвтрэн өнгөрүүлэх чадвар бол эрс нэмэгдэж байгаа. Тэнд чингэлэг тээврийн терминал одоо удахгүй ашиглалтад ороод нэвтрэн өнгөрүүлэх чадварууд бол нэмэгдэх учиртай. Булган боомт мөн одоо яг энэ хүнд үеүдэд одоо гаргалтын тоо нь буураагүй, тогтмол гарч байсан цөөхөн боомтуудын нэг байгаа.

Тэгэхээр боомтын нэвтрэн өнгөрүүлэх чадвар гэдэг бол зөвхөн одоо хилийн цэг дээрх бүтээн байгуулалтуудын ажил биш ээ. Энэ бол одоо маш олон яамдууд оролцож, Засгийн газрын маш олон бүтцүүд оролцож байж хамтарч ажиллаж байж эдийн засгийн урсгалыг нэмэгдүүлэх ийм боломжууд бүрддэг. Ялангуяа одоо боомт дээр гадаад харилцааны асуудал бас их чухал байдаг. Гадаад харилцааны асуудал. Хамгийн сүүлд Ерөнхий сайдын Бээжин хотод хийсэн ажлын айлчлалын үеэр маш олон жил одоо зогсонги байдалтай байсан хил нэвтрэх цэгүүдийн эцэслэн 2 тал эцсийн байдлаар дээд түвшиндээ тохирсон байгаа. Ингээд одоо бүтээн байгуулалтын ажлууд цаашидаа ямар нэг саадгүйгээр явах ийм шатанд орсон.

Тийм учраас одоо урд хилийн боомтуудын бүтээн байгуулалтын ажлууд өмнө нь одоо яг хилийн цэг дээр хийгдэж байсан гаалийн болон хилийн хяналтын бүтээн байгуулалтын ажлууд Хятадын буцалтгүй тусламжийн төслийн хүрээнд бол эхэлсэн явж байгаа. Зүгээр харамсалтай нь яг ковидын үед урдаас орж ирэх ажиллах хүч хязгаарлагдмал байснаас болж зогсонги байдалтай байгаа. Харин хилийн доторх хил хүртэлх дэд бүтцийн ажлууд бол харьцангуй одоо төлөвлөгөөт ажлынх хүрээнд л явж байгаа. Тийм ч учраас 2023 оныхоо төсвийг оруулж ирэхдээ одоо гаргах экспортынхоо биет хэмжээг одоо ковидын өмнөх буюу 2019 оныхоо түвшинд хүргэхээр зорьж ингэж төлөвлөж оруулж ирж байгаа юм.

Г.Занданшатар: Эхлээд зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар, Цэндийн Мөнх-Оргил, Цэрэнжамцын Мөнхцэцэг нарын урилгаар СБД-ийн 4 дүгээр хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн өмнөөс сайн сайхныг хүсэн ерөөе өө. Одоо Жамъянгийн Мөнхбат гишүүн тодруулж асууна.

Ж.Мөнхбат: Цар тахлаас болоод, дайнаас болоод, цар тахлын 0 зогсолтоос болоод энэ эдийн засаг хүнд байдалд орсон. Валютын хани өссөн гэдэг энэ тайлбарыг Монголбанк хийж байгаа. Энийг ойлгож байна. Гол нь яг энэний эсрэг ямар ямар дорвитой ажил алхам хийж байна. 1, 2, 3 гээд

хэлэхээр ийм ажлууд хэлээч ээ нэгдүгээрт.

Хоёрдугаарт Засгийн газрын боомтын үйл ажиллагаа, хүчин чадлыг сайжруулахтай, ачаа тээврийн эргэлтийг нэмэгдүүлэхтэй холбоотой, хэвийн болохтой холбоотой хийж байгаа ажил алхмуудыг бол ойлгож байна аа. Гол нь энэ одоо гадагш нь гаргаж байгаа энэ байгалийн баялаг энэ нүүрсний экспорт чинь доллар орж ирэхгүй байгаа юм биш үү? Энэ дээр Хүрэлбаатар сайд нэг тайлбар өгөөч ээ. Оптек гэрээ гэдэг юм одоо янз янзын ил далд гэрээгээр борлуулсан нүүрс тэр байгалийн баялгийн чинь мөнгө, доллар, валют нь орж ирэхгүй байгаа учраас энэ валютын нөөц чинь нэмэгдэхгүй, ханиш нь бас ингээд алдагдах нөхцөл байдал болоод байгаа юм биш үү гэсэн энэ байдал дээр бас.

Г.Занданшатар: 83
Монголбанк.

Б.Лхагвасүрэн: Мөнхбат гишүүний асуултад нэмж тодруулж хариулъя. Төв банкны тухай хуулиар бол одоо Төв банканд бол мөнгөний бодлогын арга хэрэгслүүд гээд байдаг. Энэ арга хэрэгслийнхээ хүрээнд бол оны эхнээс хойш бол нэг шат дараатай арга хэмжээг аваад явж байгаа. Бодлогын хүү өсгөж байна гэдэг нь нэг талдаа мэдээж одоо санхүүгийн энэ орчныг нөхцөлийг чангаруулж байгаа хэдий ч нөгөө талд төгрөгийн өгөөжийг бас нэмэгдүүлж байгаа ийм зүйл байгаа. Одоо тэгээд өнөөдөр банкны системээр бол хадгаламжийн хүү бол тодорхой хэмжээгээр өсөж байна. Ялангуяа энэ төгрөгийн худалдан авах чадварыг нэмэгдүүлэх үүднээсээ ийм хандлага бол ингээд үргэлжлээд явж байгаа. Тэгээд өгөөж бол өсөж байгаа гэж

харж байна. Өөр нэг зүйл нь гэвэл Ковидын тухай хуулиар тодорхой хэмжээнд бас энэ санхүүжилт, ялангуяа эдийн засаг дээр ирж байгаа энэ бодит баримт дээр нь хөнгөлөлттэй байх үүднээсээ тодорхой хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр гаргах тал дээр нь бодлогын ийм арга хэмжээнүүд бол үргэлжлүүлээд хэрэгжүүлээд явж байгаа.

Г.Занданшатар: Хүрэлбаатар сайд.

Ч.Хүрэлбаатар: Мөнхбат гишүүний асуултад хариулъя. Статистикийн тоо мэдээ үзэхээр экспорт өсөөд байдаг. Яг энэ хэмжээндээ нийцсэн валют орж ирж байна уу гээд үзэхээр тэр хэмжээнийх нь валют орж ирэхгүй байгаа юм. Тухайлбал зөвхөн одоо Эрдэнэс Тавантолгой компанийн экспортолсон нүүрсийг аваад үзэх юм бол би 9 сарын тоо мэдээ хэлж байгаа. Ингэхэд бол нийтдээ 1.8 тэрбум америк долларын нүүрс гарсан гэдэг статистик мэдээ байгаа. Гэхдээ бодитоор орж ирсэн мөнгөнийх нь хэмжээг бол нэг 500-аас 600 сая долларын дотор байгаа юм. Ингээд үзэхээр 1.8 тэрбум америк долларын нүүрс одоо гарлаа гэдэг статистиктай мөртөө одоо 600 сая доллар ороод ирлээ гэхээр чинь 3 дахин бага хэмжээний мөнгө орж ирсэн. Энэ нь яагаад энэ байна вэ гээд үзэхээр хэд хэдэн үндсэн 4 шалтгаан байгаа юм.

Г.Занданшатар: Хүрэлбаатар сайд гүйцээж хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Зөрөө байгаа шалтгаан үндсэндээ 4 байгаа юм. Нэгдүгээрт нь нөгөө оптек гэрээнүүд оптек гэрээгээр нүүрс гарсан тохиолдолд бол төлбөр нь орж

ирэхгүй байгаа. Урьдчилж нүүрсээ зарчихсан нүүрсүүд гарч байгаа. Энэ дотор 2 төрлийнх байгаа. Урд өмнийн оны нүүрснүүд бас гарч байгаа юм байна лээ. Одоо жишээлбэл бол 2018, 2019, 2020, 2021 оны гэрээгээр нүүрсүүд нь гарч байгаа юм байна лээ. Урьдчилаад борлуулагдчихсан, энэнтэй холбоотой.

Дараа нь гааль одоо экспортынхоо хэмжээг яаж бүртгэдэг вэ гэхээр жишиг үнээр нь шууд үржээд тавьчихдаг. Гэтэл жишиг үнэ яг бодитой орж ирж байгаа компанийн хооронд үнийн зөрөө байгаад байгаа нь тухайлбал одоо тэр жишиг үнэ, бодит борлуулалтын үнэ хоёрын зөрөө одоо ам, үнэ хоёрын хоорондын зөрөөнүүд байгаа д байгаа юм. Үүнтэй холбогдуулаад Засгийн газар сүүлийн бараг гурван 7 хоног орчим ажиллаж байгаад өчигдөр тогтоол гаргасан. Үндсэндээ энэ бүх зүйлүүдийг одоо бууруулахаар. Тухайлбал гарч байгаа оптик гэрээгээр гарч байгаа нүүрс урьдчилж төлбөр нь хийгдсэн нүүрс, одоо мөнгөө өгөх нүүрс зэргийг тээвэрлэлтийг зөв зохион байгуулж, мөнгө долларын урсгалыг нэмэгдүүлэх ийм чиглэл өгөгдөөд үндсэндээ сүүлийн 10 гаруй хоног ажиллаж байгаа. Валютын нөөц бол та бүгд бүгдээрээ мэдэж байгаа. Нэлээд бууж байсан бол одоо 2.8 тэрбум америк доллар буюу эргээд жоохон тийм өсөх хандлагатай орчихсон байж байгаа. Тэгэхээр бид нар цаашидаа энэ арга хэмжээнүүдээ нэлээн сайн үргэлжлүүлээд авах юм бол бас боломж байна л гэж харагдаж байгаа.

Тэгэхээр Мөнхбат гишүүний одоо асуусан асуултад бол зөрөөнүүд байгаад байна, энийг одоо цэгцлэх ажлууд хийгдэж, аль болохоор

доллароо төрүүлж, илүү орж ирэх урсгалыг нь бодож холбогдох зохицуулалтыг хийж байна. Үүнээс гадна нүүрсний гэрээ болгоныг уурхайн амнаас гарсан нь олборлогдоод олборлогдож эхэлснээс хил гарах хүртэлх хугацаанд хийгдэх тэр нүүрс тээвэрлэлтийн бүх үйл ажиллагаануудыг бүгдийг нь цахимжуулж, бүртгэлжүүлж явбал бидэнд маш ойлгомжтой болгох ийм боломж бүрдэж байгаа. Гэрээ нь цахимжаагүй нүүрсийг бол хилээр гаргахгүй. Дугаар бүртгэлтэй эзэнтэй улстай ямар компанийн ямар чанартай нүүрс гарч байгааг бүгдийг нь бүртгэж ингэх бүрэн боломжтой болж байгаа юм. Үүнээс гадна ам үнэ, хил, үнэ хоёрын хоорондын ялгаа байгаа. Хил үнээр хийгдчих юм бол тухайлбал зүгээр жишээ авч байгаа шүү. Ийм тохиолдлууд байсан юм байна лээ. Ам үнэ 71 доллар байхад хил үнэ нь 129 доллар. Тэгээд энэ хоёрын хоорондын зөрөө 58 доллар байгаа. Тэгэхээр Эрдэнэс Тавантолгойн дансанд бол ам үнээр бодоход нэг тонн тутамд 71 доллар орж ирдэг. Хэрвээ гэрээ нь хил үнээр байсан бол 129 доллар буюу 58 доллароор илүү хэмжээний мөнгө бол Монголд орж ирэх ийм боломжтой. Тэгээд Си зөвшөөрлийг нь аж ахуйн нэгжүүдийг олгох байхаар эрхийг нь тийшээ шилжүүлж байгаа. Ингэснээрээ үндсэндээ илүү хэмжээний валют Монголд орж ирэх ийм боломж нь бол бүрдэж байгаа. Бас тэнд байгаа янз бүрийн одоо асуудлууд цэгцлэгдэх бас боломжтой гэж үзэж байгаа. Энэ чиглэлээр Засгийн газар нэлээд бас ажиллаад эхэлсэн байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн асууна.

С.Чинзориг: Мөнгөний бодлого ярьж байна. Бид 2022 оны мөнгөний бодлого яриад баталсан. Тэгээд 2022 оны төрөөс одоо мөнгөний талаар баримтлах бодлогын бичиг баримтын биелэлт хангалтгүй байна л даа. Иргэдийн амьжиргаа чинь маш хүндэрчихлээ. Ажил эрхлэлтийн байдал маш хүндэрчихлээ, орлогын байдал одоо маш хүндэрчихлээ. Оны эхэнд валютын хани 2850 орчим байсан санагдаж байна. Одоо хорь гаруй хувиар өсчихлөө. 3 мянга 300 гараад явчихсан байна. Валютын ханиийг тогтворжуулна гээд Монголбанк маань долларын интервенц хийгээд гадаад валютынхаа 40 гаруй хувийг энэ интервенци хийхэд зарцуулсан байна. Би бол тэгж ойлгож байгаа юм. Тэгээд яагаад одоо гадаад валютынх 40 гаруй хувийг интервенц хийгээд валютын ханиийг тогтворжуулна гээд ийм бодлого явуулаад байгаа атлаа энэ долларын хани чинь тогтворжихгүй ингээд оны эхнийхээ түвшинээс 20 гаруй хувиар өсчихдөг юм бэ. Энд одоо та бүхэн ямар бодитой дүгнэлт хийж байна вэ?

Хоёрдугаарт, Монгол Улс чинь валютын 2 ханитай болчихлоо шүү дээ. Албан хани, албан бус хани гээд. Монголбанк албан хани гээд зарладаг. Найман шарга дээр албан бус хани зарладаг. Өнөөдрийн байдлаар бол Монголбанкны зарласан хани найман шарга дээр албан бусаар одоо зарагдаж байгаа хани хоёрын хооронд ч бараг 150 орчим төгрөгийн зөрөө байна шүү дээ Лхагвасүрэн дарга аа. Тэгээд энэ одоо зөрөөг яаж арилгах юм бэ? Ер нь цаашидаа Монгол Улс ингээд 2 удаа валютын ханитай яваад байх юм уу, үгүй бол одоо тэр хууль тогтоомждоо өөрчлөлт ороод энэ гадаад валютын одоо арилжаа

эрхэлдэг энэ байгууллагуудынхаа тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлыг цэгцлэх, боловсронгуй болгох үйл ажиллагааг нь бас хумих, хязгаарлах ийм чиглэлээр арга хэмжээ авахгүй юу? Тэгэхгүй бол ингээд Монгол Улс чинь Монголбанкны зарласан хани, ченжийн найман шарга зах дээр борлуулах гэж байгаа хани гээд тэгээд 2 ханитай. Энэ чинь бас 3 дахь удаагаа ийм үзэгдэл болж байна шүү дээ. Асар зөрөөтэй. Гурав дахь асуудал нь Хүрэлбаатар сайд, Засгийн газар, Лхагвасүрэн Ерөнхийлөгч 2 хариулж өгөөч. Их Хурлаас чинь энэ хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн, гурил, түүш, шатахуун, махны үнийг тогтворжуулна, нөөц бүрдүүлнэ гээд бүр хууль баталж өгсөн шүү дээ, тусгай хууль. Тэгээд энэ хууль маань одоо яагаад хэрэгжихгүй байгаа юм бэ? Засгийн газар энэ ажлаа яаж зохион байгуулж байгаа юм? Монголбанк тэр хөнгөлөлттэй санхүүгийн эх үүсвэр гаргаж өгнө гэсэн, тэрийг нь гаргаж өгсөн юм уу? Одоо энэ гурилын үнэ чинь килограмм тутамд 400 төгрөгөөр нэмэгдээд 20 гаруй, 30 орчим хувиар бол гурилын үнэ чинь нэмэгдчихээд байна шүү дээ. Тийм Их хурлаас нь тодорхой хэмжээгээр нөөц бүрдүүлэх, үнэ тогтворжуулах хууль батлаад өгсөн. Энэ одоо хууль маань үр дүнд хүрэхгүй байгаа юм уу, цаашидаа одоо яах юм бэ? Ингээд юмныхаа үнийг одоо алдчих юм уу гээд. Энэ дээр Монголбанк, Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам, Хөдөө аж ахуйн яамнаас юу дуулдаж байгаа юм. Цаашидаа Монголбанк, Засгийн газар экспортын орлогыг яаж одоо нэмэгдүүлэх бодлого баримтлах гэж байгаа юм бэ. Монголбанкнаас өгсөн энэ мөнгөний бодлогын чинь бичиг баримтыг нь харахаар уул уурхайн бус салбарын бүтээгдэхүүний орлого,

экспортын орлогод эзлэх хувь нь 2000 оны эхээр 40 гаруй хувь байсан байна.

Өнөөдөр бол долоохон хувь болоод буурчихсан байна шүү дээ. Тэгээд бид нар энэ уул уурхайгаас бусад салбаруудад экспортын орлогод эзлэх хувь хэмжээг нь нэмэгдүүлэх энэ валютынх нөөцийг нэмэгдүүлэх талаар ямар арга хэмжээ авах юм.

Г.Занданшатар: 83.
Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя.

Б.Лхагвасүрэн: Чинзориг гишүүний асуултад хариулъя. Тийм. Монголбанк яг энэ ханишин дээр бол интервенц хийе гэж ийм бодлого одоо ийм арга хэмжээ авдаггүй. Монголбанк бол долоо хоногтоо 2 удаа дуудлага худалдааг зохион байгуулдаг. Дуудлага худалдааны зорилго нь банкны харилцагчдын гадаад төлбөр тооцоог саадгүй явуулах үүднээсээ банкнууд бол манай харилцагчдаас ийм валютаар ийм улс орнууд руу ийм бүтээгдэхүүнийг худалдаж авах зайлшгүй шаардлага байна. Энэ үүднээсээ эх үүсвэрийг одоо бидэнд олгож өгнө үү гэдэг хүсэлтээ тавиад явдаг. Өмнөх жилүүдэд ч гэсэн яг л ийм хэлбэрээр ингээд явж ирсэн. Түрүүн би Мөнхбат гишүүний асуултад хариулж байхдаа хэлсэн. Импорт бол одоо өнгөрсөн оны мөн үеийнхээс 25 хувиар өсчихсөн байна. Энэ өсөх шалтгаанууд нь бол хэдийгээр импортоор авч байгаа тэр бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ өсөөгүй ч гэсэн үнэ бол өссөн. Үнэ юунаас болж өссөн бэ гэхлээр олон улсад бол одоо ОУВС, Дэлхийн банк, бүх л улс орнууд бол яг л ижилхэн л тайлбар хэлж байгаа. Энэ ковидын хүнд нөхцөл байдал, тэр тэвээр ложистик, одоо нийлүүлэлтийн

сүлжээний доголдоос болоод барааны хомсдол үүсэж үнэ өссөн байна.

Дээр нь хамгийн гол зүйл нь бол тэр нефтийн бүтээгдэхүүн буюу одоо тээврийн зардалд хамгийн гол байр суурь эзэлдэг, шатахуун туслах материалын үнэ өссөн учраас юмны үнэ өсчихсөн. Энүүгээр дамжаад импортын маань төлбөр тооцооны хэмжээ нэмэгдээд ингээд явж байгаа. Энд нь тааруулж, ингээд тодорхой хэмжээгээр бол мэдээж нөөцөөсөө ингээд валют гаргаад явж байгаа. Тэгээд валютын нөөц маань өөрөө ингээд одоо импортын 4 сар орчмын хэрэгцээтэй ингээд нэлээн тийм анхаарал хандуулах түвшинд хүрсэн учраас бидний хувьд бол яг бүх хэрэгцээтэй тэр валютыг нийлүүлж чадахгүй байгаа. Энэ утгаараа ер нь 7 хоногтоо бол тодорхой хэмжээний валют нийлүүлж болохоос биш яг 100 хувь тэр харилцагчийн хүсэлтийг бол биелүүлэхээр валютыг банкнуудад өгөхгүй байгаа. Энүүгээрээ бол мэдээж, ингээд хани цааи ингээд нэлээн өсөөд ирсэн. Банкан дээр байгаа энэ төлбөр тооцоо бол дандаа бэлэн бусаар явдаг. Харилцагч бол өөрөө сургалтын төлбөр байдаг юм уу? Тодорхой бараа бүтээгдэхүүний төлбөрийг шилжүүлэхээр бол бүгд бэлэн бусаар явж байгаа. Харин банк бусын зах зээл дээр бэлэн валютын хэрэгцээ шаардлага гэдгээрээ тэндээ бэлнээр явагддаг валютын арилжаа явагддаг. Тэгэхлээр бэлэн болон бэлэн бусын хооронд иймэрхүү зөрүү байж байгаа. Ийм нэлээн та түрүүн бас хэлсэн. Энэ 2 дахь, 3 дахь удаагаа ч юм уу, ингээд Монгол Улсын түүхэнд ингээд явж байгаа. Ер нь бол яг л энэ гадаад худалдааны тэнцэл, төлбөрийн тэнцлийн төвөгтэй энэ нөхцөл байдлын үед бол ийм ханишны зөрүү бол ажиглагддаг.

Тэгэхдээ бүх юм хэвийн болоод ирэхлээрээ буцаад энэ зөрүү бол өөрөө арилчихдаг ийм байгаа. Хүнсний бүтээгдэхүүний хувьд бол одоо тэр Улсын Их Хурлаас хаврын чуулганаар баталсан зарим нэр төрлийн бараа бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэх, хомсдолыг арилгах. Тэгээд үнийг тогтвортой байлгах талаар хууль гарсан байгаа. Энэ хуульд бол нефтийн бүтээгдэхүүн, гурил, мах гээд 3 бүтээгдэхүүн орсон. Мэдээж гурил, махны хувьд бол энийг Монголбанкны эх үүсвэрээр биш, арилжааны банкин дээр байгаа тодорхой эх үүсвэрийг ашиглахаар ийм хуулийн зохицуулалттай. Нефтийн бүтээгдэхүүний хувьд бол Монголбанкны репо арилжаагаар хийхээр явж байгаа. Тэгээд нефтийн бүтээгдэхүүний хувьд бол одоо бидний Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас авсан мэдээллээр бол бүх төрлийн шатахуун дээр бол 30-45 хоногийн нөөц бол хангалттай нөөц ингээд бүрдээд үнэ бол тогтвортой байгаа гэсэн ийм мэдээлэл байгаа.

Гурил, махны хувьд бол одоо энэ оны үр тариа хураан авалтаас бол нийтдээ 100-аад тэрбум төгрөгийн санхүүжилтийг гурилын үйлдвэрүүдэд өгөөд, энэ нь өөрөө тариалан эрхлэгчдээс бол гурилыг нь худалдаж авах эх үүсвэрийг бүрдүүлэхээр байгаа. Банкнуудтайгаа бол яриад тохирсон. Банкнуудаас бол 100 тэрбум төгрөгийн ийм санхүүжилтийг олгоно.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь, Наянтайн Ганибал нарын урилгаар Сүхбаатар аймгийн

Мөнххаан сумын ЗДТГ-ын ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд эрүүл энх, сайн сайхныг гишүүдийн нэрийн өмнөөс хүргэе.

Чимэдийн Хүрэлбаатар сайд,
Эдийн засаг, хөгжлийн сайд.

Ч.Хүрэлбаатар: Чинзориг гишүүний асуултад хариулъя.

Үнэ тогтворжуулах хууль батлаад үнэ тогтворжихгүй ээ гэдгийг бид нар яг тухайн хууль хэлэлцэж байхад бол нэлээн сайн ярьж байсан. Ер нь тэгээд дэлхий даяар үнэ өсөөд дэлхийн улс орнууд одоо ямар бодлого руугаа шилжээд эхэлж байна вэ гэвэл ямар ч хамаагүй үнэ цэнээр инфляц л буулгая гэдэг ийм бодлогын юм руу бол бүгд шилжчихлээ шүү дээ. Ямар ч одоо ямар ч үнэ цэнээр хамаагүй инфляцыг буулгах бодлогыг явуулъя гэдэг. Энэ нь үндсэндээ бол эдийн засгаа тогтворжуулъя гэдэг гол бодлого явж байгаа. Тэгэхээр ер нь яг ний нуугүй хэлэхэд хууль батлаад үнэ тогтворжуулчих юм бол амьдрал дээр бол хэзээ ч байхгүй. Тэрийг бид нар бол мэдэх ёстой гэдгээ хэлье. Харин саяын тэр Лхагвасүрэн Ерөнхийлөгчийн хэлсэн дээр зүгээр үргэлжлүүлээд хэлэхэд хэлэх гэж байгаад дутуу орхичихлоо гэж ойлголоо.

Зээл олгоод энэ хуулийг хэлэлцэж байх үед бол яригдсан зүйл мах бол угаас энэ жил өвөл хүндэрнэ гээд хүмүүс нэлээд нядална. Тэгэхээр энэ хуультай хуульгүйгээр махны үнэ бууна гэдгийг бол тэр үедээ яригдаж байсан. Яригдаж байсан гурилын үнэд бол энэ удаагийн энэ арга хэмжээнүүд чинь Монголбанкны олгож байгаа зээл

энэ тэрээ бол үр дүн гарахгүй ээ гэдгийг бас хэлж байсан. Үр дүн нь харин ирэх жил гарах юм байна гэдгийг тухайн үедээ бол ярьж байсан гэдгийг би бас хэлмээр байна. Яг хэлэлцүүлгийн явцад тийм зүйл яригдаж байсан шүү. Тэгэхээр бид нар яг тэр хэлэлцүүлгийн үед яригдаж байсан үр дүн өнөөдөр яг хэвээрээ л байгаа.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн, тодруулж асууя.

С.Чинзориг: Бодлогын хүүгээ Монголбанк 12 хувь болголоо л доо. Бодлогын хүү болох нэмэх чинь бол яах вэ мөнгөний нийлүүлэлтийг бас багасгаж байгаа инфляцыг одоо буулгахад бас нэг хөшүүрэг болох байх. Гэхдээ нөгөө талдаа энэ аж ахуйн нэгж байгууллагууд иргэдийн нуруун дээр маш асар их, ачаалал ирнэ шүү дээ гэж бол ойлгож байгаа юм. Бодлогын хүү 12 хувь болчихлоор арилжааны банкнуудын чинь зээл доод тал нь одоо 17 хувь болж очиж таарна шүү дээ. 5 хувиар одоо нэмэгдэж байж л зээл гарвал гарна. Энэ одоо ямар хугацаанд одоо үргэлжлэх юм бэ? Ер нь бол энэ арилжааны банкнууд чинь энэ хэрэглээний зээлийг чинь хэт одоо хумьчхаад байгаа юм биш үү? Бодлогын хүү нэмэхээр энэ чинь үндсэндээ аж ахуйн нэгж байгууллагууд, иргэд маань л бүсээ чангалж байж энэ хүндрэлийг чинь давах л тийм нөхцөл рүү орчихлоо шүү дээ Лхагвасүрэн Ерөнхийлөгч өө. Энэ тэгээд ямар хугацаанд одоо үргэлжлэх юм бэ?

Г.Занданшатар: Лхагвасүрэн Ерөнхийлөгч 83.

Б.Лхагвасүрэн: Чинзориг гишүүний асуултад тодруулъя. Тэгээд бодлогын хүү 12 хувь хүргэж байгаа нь бол ерөнхийдөө Монголбанкнаас бол 2 зүйлийг хүлээж байна. Нэгдүгээрт бол мэдээж инфляц. Инфляц бол 8 сард 14.4 хувь, 9 сарын урьдчилсан тоо гарч байна, 13.5 хувь гээд. Тэгэхлээр ерөнхийдөө сүүлийн 2, 3 сард ингээд инфляц өөрөө буураад эхэлж байгаа учраас бол хэзээ бодлогын хүү өөрөө бодитой түвшинд хүрнэ гэдэг буюу одоо инфляц 12 хувь руу орж ирэхэд бодлогын хүү цааш өсгөх бас тийм зайлигүй шаардлага үүсэхгүй болно. Энэ утгаараа ямар ч байсан макроогоо түвшинээ тогтвортой байлгах үүднээсээ энэ бодлогын хүүгийн эхний зорилго нь бол энэ байгаа.

Хоёр дахь нь бол одоо таны асууж байгаа бодлогын хүүг чангаруулснаараа санхүүжилтийн орчин нэлээн хатуурна. Мэдээж бодит сектор дээрээ зээл олдохгүй байх. Зээлийн зардал өндөр байх гээд нэлээн хүндрэлтэй зүйлүүд гарах учраас аль болохоор богино хугацаанд бид нар зорилтынхоо түвшинд хүрч чадах юм бол эргээд одоо сулруулах боломж нь тэндээс гарч ирнэ.

Г.Занданшатар: Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Энэ эдийн засгийг тогтворжуулах, энэ инфляцыг богино хугацаанд бууруулах ханшийг бас богино хугацаанд тогтворжуулах л нэг тийм шуурхай арга хэмжээ авмаар байна л даа Ерөнхийлөгчөө.

Би бол таны тэр хэлээд байгаа үгэнд бол итгэхгүй байна. Хани бол суларчхаад байна гэж байна. Шулуухан хэлэхэд бол энэ чинь аж ахуйн нэгж байгууллагууд, иргэд бүсээ

чангалж байж л энэ хани чинь суларч байгаа шүү. Зээл олдохгүй байна. Юмны чинь үнэ одоо өсөөд байна. Тэгэхээр энэ одоо хани инфляцын бууралт чинь асар өндөр үнээр энэ аж ахуйн нэгж байгууллагууд ч үйл ажиллагаагаа зогсоож байж, хаалгаа барьж байж иргэд маань бүсээ одоо маш чангаруулж бүсэлж байж л ийм, жаахан сулралт бол ажиглагдаж байгаа шүү. Энийг та нар нэг их одоо өөрсдийнхөө үр дүнд сайн арга хэмжээ аваад сулруулчхаж байгаа юм шиг ингээд та тайвшруулаад яриад байж болохгүй ээ. Бодит үнэнийг нь бол иргэдэд энэ аж ахуйн нэгж байгууллагууд бол бас ойлгож байх хэрэгтэй шүү дээ.

Г.Занданшатар: Үг хэллээ. Одоо Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Ер нь валютын хани, валютын нөөцийн асуудал бол үнэхээр хүнд болсон байна аа. Зүгээр ер нь хатуу хэлбэл бараг дампуурлын ирмэг дээр байгаад байна. Үнэхээр урд талаас экспортын орлого чинь тодорхой хэмжээгээр одоо ковидоор ч байдаг юм уу хязгаарлагдвал тэгээд л элгээрээ газар хэвтэх гээд байна шүү дээ. 100 хувь шахуу бид нар экспортын нэг л эх үүсвэрээс хамаарч байна. Нэг орноос л хамаарч байна. Тэгээд бид нар энэ талаар олон л удаа ярьж байсан л даа. Ер нь эдийн засгаа солонгоруулъя гээд хэдэн жил ч ярьчихав. Солонгорч байгаа юм байхгүй. Танай банк мөнгө, зээлийн бодлогоороо энийг дэмжиж байгаа юм байхгүй. 10 их наядын хөтөлбөр гээд нэг попорсон хөтөлбөр Засгийн газар нь ерөнхийдөө бас нэг жоохон нэг тийм попрох маягаар ажиллаад байхаар энэ экспортын орлого нэмэгдүүлэх чиглэлд ерөөсөө ахиц дэвшил гарахгүй байна шүү дээ.

Тэгээд Хятадад ямар нэгэн юм болоход манайд шууд хатгаа авахаар байна шүү, ханиахаар.

Тэгээд энийг ер нь одоо та нар цаашидаа яаж дэмжих юм бэ гэж экспортын орлогоо дэмжье гээд Хөгжлийн банк байгуулсан. Нөгөө бизнес эрхлэгчид нь мөнгө нь олдохгүй болчихсон. Нөгөө улс төрчид нь хуваагаад цохьчихсон. Манай зарим дарга сайд нар сонгуулийнхаа менежерүүдийг аваачиж тавьж байгаад тэгээд хусаад хаячихсан. Одоо энэ Хөгжлийн банкны асуудал, тэгээд үндсэндээ тэгээд чимээгүй болж байгаа юм шиг байгаа юм. Энэний мөнгийг төлөх баталгааг Засгийн газарт одоо гаргаж өгөх гэж байна шүү дээ, баталгааг. Үг нь энэ зээл авсан нөхдүүд чинь энийгээ төлөх ёстой байхгүй юу. Гэтэл өнөөдөр төр баталгаа гаргаж энэ зээлийг төлөх тухай эргэж байна шүү дээ.

Ер нь нэг зүйл дээр одоо бид анхаарахгүй бол болохгүй нь ээ. Энэ өрийн асуудал. 2012 оноос өмнө бол 2 тэрбум долларын өртэй байсан юм. Дараа нь Алтанхуягийн Засгийн газрын үед 3 тэрбумаар нэмэгдсэн. Тав болсон. Дараа нь одоо манай Хүрэлбаатар Сангийн сайд байх үед ахиад 3 тэрбумаар нэмэгдээд 8 тэрбум болсон. Одоо ахиад тэрбум гаруйгаар нэмэгдчихээд явж байна шүү дээ. Тэгээд дээр нь юанийн свопын 2.6 байна уу? Энийгээ нэмчих юм бол энэ чинь 12 гурван тэрбум долларын Засгийн газар нь өртэй болчихоод байна шүү дээ. Энийг одоо яаж төлөх юм бэ?

Тэгээд би одоо энэ мөнгө зээл, төсвийн бодлогыг харахаар дахиад зээл авах тухай яриад байгаа байхгүй юу? Үгүй ээ, нөгөө зээл авахгүй,

ажиллаж чадна гэж яриад байсан үг чинь одоо хаачихсан юм.

Яагаад дахиад зээл авах тухай яриад байгаа юм. Одоо зээл авч чадахгүй ээ. Авлаа ч маш өндөр хүүтэй авна. Аваад ч, төлж чадахгүй болно. Хойд хормойгоороо урд хормойгоо нөхсөөр байгаа одоо хойд хормой чинь дуусаж байгаа байхгүй юу? Тийм учраас энэ өрийн асуудал, энэ зээлийн асуудал дээр Монголбанк энэ мөнгөний бодлогын хүрээнд ямар төлөвлөлт хийж байгаа юм бэ? Засгийн газар чинь одоо баахан баталгаа гаргая гэгчихсэн байна шүү дээ. Тэгээд ингээд өр зээлээ нэмээд өнөөдрийг аргалж өнгөрөөгөөд хойч үедээ өр үлдээх гэж байгаа бол энэ бол гамшиг шүү. Одоо бид нар урд талд нэг л крантаа нэг удаа хаахад бид нар гадаад төлбөрийн чадваргүй болчих гээд байна шүү дээ. Энэ компаниудын валютын дансанд нь мөнгө байгаа мөртөө хүссэн хэмжээгээрээ гадаад төлбөр тооцоогоо хийж чадахгүй байгаад байна шүү дээ. Тэгээд энэ чинь үндсэндээ дампуурч эхэлж байгаагийн шинж шүү дээ.

Тэгээд энэ талаар ер нь та нар одоо цаашидаа ямар арга хэмжээ зээл аваад л байх юм уу? Энэ тал дээр нэг Төв банкны байр суурийг би бас сонсмоор байна.

Г.Занданшатар: 83.
Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Даваасүрэн гишүүний асуултад хариулъя.

Тийм, ерөнхийдөө бол Монгол Улсын гадаад өртэй холбоотой асуудал бол маш хүнд нөхцөлд байгаа. Тантай бол санал нэг байна. Сая ОУВС-ийн одоо дүрмийн 4 дүгээр

заалтын дагуу баг ирж ажиллаад явсан. Бас ирсэн ажлынхаа тайланг бол бас олон нийтэд бол хүргэгчихсэн байгаа. Ер нь бол Монголбанкны ч тэр, олон улсын байгууллагуудын ч тэр байр суурь бол ер нь их ойролцоо байгаа. Ялангуяа 2023, 2024 онд бол одоо өртэй холбоотой, өрийн эргэн төлөлттэй холбоотой маш том дарамттай ийм жилүүд энэ ойрын хугацаанд бол байгаа. 2025, 2026 он гэх юм бол ерөнхийдөө энэ дарамтууд бол алга болохоор хамгийн том одоо өр төлөлттэй хэсэг нь бол энэ 2023, 2024 он. Тэгэхээр яг энэ өрийг бол яаж зөв удирдаж явах вэ гэдэг удирдлагын асуудал нь бол өнөөдөр бол нэг номерын асуудал болчихоод байгаа юм.

Тэгээд төв банкны зүгээс бол мэдээж бид хэд бол хэрвээ энийгээ одоо өөрийнхөө валютын нөөцөөр төлөх юм бол хангалттай нөөц бол өнөөдөр бидэнд бол байхгүй. Тэр утгаар бол валютынхаа нөөцийг бол аль болохоор ариг гамтай байлгах, нөөцөө аль болохоор буулгахгүй байх талаар бол нэг номер бол бодлогоо болгочихсон явж байна.

Дараагийнх нь асуудал нь бол хэрвээ өрийг бол дахин санхүүжүүлэх маягаар ингээд бүтцийн өөрчлөлт хийгээд явах юм бол мэдээж олон улсын нээлттэй зах зээл дээр гарахад нь Монгол Улсын одоо зээлжих зэрэглэл өөрөө тогтвортой байх ёстой. Тэр хөндлөнгийн үнэлгээний байгууллагуудын үнэлгээний дүгнэлт болон тэдний гаргаж байгаа одоо Монгол Улсыг яаж ямар харж байгаа тэр одоо ирээдүйд байх хандлагыг нь гаргасан дүнгүүд нь бол маш чухал. Тэгээд энэ оны хувьд бол 7, 8 сард бол Стандарт пуэрс, Пийч гээд 2 агентлаг ирж үнэлгээгээ өгсөн. 2 үнэлгээ маань өөрөө манай Ковидын өмнөх

үнэлгээтэй бол хэвээрээ гарсан, буурсан, одоо бууруулсан зүйл бол байхгүй. Одоо Мудиз бол үнэлгээгээ удахгүй гаргах гэж байна.

Тэгэхлээр ерөнхийдөө үнэлгээ бол хэвийн түвшиндээ гарах юм бол ямар ч байсан олон улсын зах зээлд гарах өөрчлөлт урьдчилсан маягийн одоо нөхцөлүүдийг бол бид нар ингээд хангаад явж байгаа. Энэ өнцгөөсөө бол одоо өрөө 2023 онд төлөх өрийг бол яаж санхүүжүүлэх вэ гэдэг асуудлыг бол бэлтгэл ажил талаас нь бол ингээд хангаад явж байна. Нөгөө талаасаа бол одоо мөнгөний бодлогыг хатууруулж байна гэдэг маань одоо макро тогтвортой байдал, ялангуяа тэр өр тавихгүйгээр шинээр өр үүсгэхгүй байх тал руу нь л хийж байгаа ийм хатуу бодлогын арга хэмжээ. Энэ бол одоо Монголбанкны өнөөдрийн бодлого юм.

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн тодруулж асууя.

Ц.Даваасүрэн: Би нөгөө эдийн засгаа солонгоруулж, экспортын орлогыг бий болгох гэхлээр мөнгө, зээлийн бодлого явахгүй байна гэдэг талаар бас асуугаад байгаа шүү дээ. Ямар төслүүд Засгийн газартай хамтарч байгаа юм байна уу гэж. Энэ зээлийг ахиад зээл аваад хайгаад байсан бол өрийн дүн чинь өсөхгүй байх байсан байхгүй юу. Өсөхгүй байх байсан шүү дээ. Нэг тэрбумын зээлийг нэг тэрбумаар хаагаад байвал хэвээрээ л байгаа. Зээлээсээ зээл төлөх зээл аваад байгаа мөртөө ахиад нэмж зээл аваад байгаа учраас энэ өрийн чинь дүн өнөөдөр ингээд талийчихлаа шүү дээ. Одоо 2023, 2024 он. Төлбөрийн чадваргүй болчих гээд байна шүү дээ чи тэрийг ойлгож байна уу? Лхагвасүрэн. Компанийн дансанд

мөнгө байгаа мөртөө тэр хэмжээгээрээ зарцуулж чадахгүй болчихоод байна шүү дээ энэ компаниуд чинь. Одоо айл өрх рүү орж эхэлнэ. Зарим айл өнөөдөр хүүхдийнхээ сургалтын төлбөрийг гадаад төлөх гэхээр асуудал үүсэж эхэлж байна гэж ярьж байна шүү дээ. Тэгээд энэ чинь одоо юу болоод байна аа? Энэ талаар та нар ер нь цаашдаа ямар арга хэмжээ, экспортын орлогыг нэмэгдүүлэх чиглэл дээр энэ эдийн засгаа солонгоруулах чиглэл дээр олон жилийн арга хэмжээ авахгүй бол өнөө маргааш хийчихдэг ажил энэ чинь биш байхгүй юу?

Г.Занданшатар: 83.
Монголбанк Лхагвасүрэн.

Б.Лхагвасүрэн: Даваасүрэн гишүүний асуултад тодруулъя.

Тийм. Монголбанкны хувьд бол энэ 2023 онд бол Хятадын ардын банкны своп байгаа 1.7 тэрбум доллартой тэнцэх. Бидний хувьд бол мэдээж энийг цааш нь дахиад 3 жилээр сунгах хүсэлтээ бол тавьчихсан. Тэгээд 6 сарын өмнөөс ингээд уулзалтууд хийгээд явдаг учраас бол дөнгөж он гараад бид нар уулзалт хийгээд цаашаа явна. Ерөнхийдөө бол цааш сунгахаар бол зарчмын хувьд бол энэ оны 2 сард Монгол Улсын Ерөнхий сайдын айлчлалын үеэр асуудал хөндөгдөөд хамтарсан мэдэгдэл дээрээ бол энэ талаар тусгачихсан байж байгаа. Экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр бол энэ 2022 онд бол Монголбанк бол нэг салбар дээр туршилт хийсэн. Ялангуяа ноолуурын салбар дээр яаж ноолуурыг бол одоо 10000 тонн жилдээ гарч ирдэг ноолуурыг яаж нэмүү өртөг бүтээгч маягаар илүү цааш нь нэмүү өртөг шингээх талаар боловсруулах вэ

гэдэг тал руу нь туршилт нэлээн амжилттай болсон. 1 сараас худалдаж авсан ноолуур маань одоо тодорхой аж ахуйн нэгжүүдээр дамжаад 3, 4 сар гэхэд бол олон улсын зах зээл.../минут дуусав/.

Г.Занданшатар: Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Тодорхой экспортын орлого бүрдэх төслүүд. Одоо жишээлбэл төмрийг. Төмрийн хүдрийг боловсруулаад хайли хийж байгаа юм байна лээ шүү дээ. Одоо тэрийг ган болох ч байдаг юм уу? Тэгэх юм бол бид нар барилгын арматурыг хэмнэхэд 200 доллар, арьс ширний үйлдвэрийн Дарханы зогсоолыг та нар санхүүжүүлчих л дээ. Тэгэх юм бол дахиад 200 доллар гэх мэтийн төслүүд дээр яагаад та нар дэмжиж болохгүй байна гэж. Зүгээр яах вэ, Монголбанк бол нэг попрохгүй л байгаа юм. Засгийн газар бол зүгээр попорч ажиллаад байгаа байхгүй юу. Та нар тэгээд энэ бодитой нэг жоохон ажил хийхэд нь туслаад. Тэр арьс ширний үйлдвэр төмрийг боловсруулах. Дан боловсруулах, энэ чиглэлд нь жоохон анхаараад өгчхөөч дээ. Тэгэх юм бол 500 сая доллар адаглаад хэмнэх боломжууд байгаад байна шүү дээ. Энэ байдлаар импортыг орлох бүтээгдэхүүнүүд, экспортыг дэмжих юман дээр Засгийн газартайгаа сайн яриад, валютын урсгалыг багасгах энэ юм руугаа анхаар. Барилгын салбарыг одоо дэмжиж болохгүй ээ.

Тэгэх юм бол хамаг юм чинь тийшээ урсана шүү. Энэ байрны бүх дотоод засал чинь дандаа валютаар явж байгаа. Тийм учраас энэ мэтийн юмнуудаа бодит.

Г.Занданшатар: Экспортын төсөл дээр юм байгаа юм уу гэж. 83. Монгол банк.

Б.Лхагвасүрэн: Тэгээд энэ мөнгөний бодлоготой хамт өргөн барьсан Засгийн газар болон төрийн бусад байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлэх ажил дотор экспортын чиглэлийн үйл ажиллагааг дэмжих, хамтран зохион байгуулахаар заалт орсон байгаа. Тэгэхлээр энэ дээрээ ингээд хамтраад яах вэ цаг хугацааны хувьд өнөөдөр өөрөө инфляц өндөр, ханшийн дарамттай байгаа учраас бол мөнгөний бодлогоо хатууруулж байгаа нөхцөлд нэг газраа нэг гараараа хатууруулаад нөгөө гараараа мөнгө гаргах нь өөрөө бодлогын хувьд нийцэхгүй байгаа учраас бол энэ хугацаанд ийм байгаа. Ирэх оноос эдийн засгийн макро түвшин маань тогтвортой болоод эхлэх юм бол гарах боломж байгаа гэж харж байгаа. Хөгжлийн банк маань өөрөө бас нэлээн олон төлбөрөө төлөөд эхэлсэн.

Саяхнаас бол одоо өчигдөр Сангийн сайд бас хэлж байсан. 2023 оноос эхлээд шинээр зээл гаргах үйл ажиллаг эхэлнэ гээд л тэгэхлээр энэ дээр нь, ялангуяа экспортын чиглэлийн энэ тал руу нь хамтарч ажиллахад бол Төв банкны зүгээс бол хамт оролцоно л гэж бодож байна.

Г.Занданшатар: Одоо Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Тэгэхээр 2023 оны мөнгөний бодлого ярьж байна л даа. Тэгэхээр өнгөрсөн жил бол үнэхээр хүнд жил байлаа. Нэг талаас ковидын нөхцөл байдал, нөгөө талаас дайны нөхцөл байдалтай холбоотойгоор макро эдийн засаг,

ялангуяа мөнгөний бодлогод бол маш хүнд жил болж байна. Үйлдвэрлэгч биш Монгол орны хувьд ч гэсэн энэ хүнд нь тусаж байгаа. Тухайлбал инфляц их өндөр байгаа, инфляцаа дагаад өргөн хэрэглээний барааны үнэ өсөж байгаа. Валютын нөөц эрс багасаж байгаа, цаашидаа Монгол Улсын зээлжих зэрэглэлийн асуудал ч яригдахыг үгүйсгэхгүй байдал руу явж байгаа юм.

Тийм учраас бол энэ макро эдийн засгийн бодлого буюу мөнгөний бодлого дээр бол гишүүд нэлээд байр сууриа илэрхийлж ярьж байх шиг байна. Нөхцөл байдал бол хүнд байгаа гэдгийг бүгд ойлгож байгаа. Гэхдээ Монгол банк, Засгийн газар тодорхой хэд хэдэн арга хэмжээнүүд авч хэрэгжүүлэхгүй байгаа л гэж би надад санагдаад байгаа юм. Валютын гадагшлах урсгалыг яаж тогтоон барих вэ гэдэг асуудал маш том асуудал. Валютынхаа нийлүүлэлтийг яаж нэмэгдүүлэх вэ гэдэг том асуудал. Би ганцхан интервенцээр л яваад байна уу даа л гэж л хардах гээд байгаа юм.

Ийм учраас би энэ валюттай холбоотой нэг хэдэн одоо мөнгөний бодлоготой холбоотой нэг хэдэн зүйлийг тодруулж асууя гэж бодож байна.

Нэгдүгээрт, бид нар валютын гадагшлах урсгалыг багасгах асуудал хамгийн том асуудал. Ирэх онд бид нар энэ мөнгөний валютын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр экспортоо нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой том арга хэмжээ авахгүй л бол бид нар эдийн засаг маш хүндэрнэ. Нөхцөл байдал бүр хүндэрнэ. Төлбөрийн чадварын хувьд хүндэрч эхэлнэ. Сая ч

Даваасүрэн гишүүн нэлээд хэд хэдэн гишүүн ярьж байна.

Тийм учраас нэгдүгээрт, валютын гадагшилж байгаа хамгийн том асуудал бол нефтийн бүтээгдэхүүний асуудал байгаа. Энэ дээр Монголбанк, Засгийн газар манай Хүрэлбаатар сайд эд нар Ганбаатар сайд эд нар ярьж байгаа юм байна уу? Нефтийн бүтээгдэхүүнийг доллароор авахтай холбоотой асуудал байна.

Хоёрдугаарт, манай импортын бараг 90 орчим хувь нь Бүгд найрамдах Хятад улстай хийгддэг импорт. Гэтэл энэ улстай доллароос өөр валютаар худалдаа хийхтэй холбоотой асуудал яригдаж байгаа юмнууд байна уу? Энэ мэтчилэнгээр бид нар энэ валютын гадагшилж байгаа урсгалаа яаж зогсоох вэ, багасгах вэ гэдэг чиглэлээр тодорхой арга хэмжээ би авахгүй байна гэж би хэлэх гээд байна.

Өнөөдөр бүр зарим нэгэн аж ахуйн нэгжүүд, ялангуяа зарим нэгэн барилгын компаниуд төлбөр тооцоогоо валютаар авна гээд байж байгаа байхгүй юу. Энийг хаах хянах, зохицуулах чиглэлээр Монголбанкнаас хийж хэрэгжүүлж байгаа юм байна уу. Би мөнгөний гадагшлах урсгалтай холбоотой ийм асуудлыг нэгдүгээрт нь асууя гэж бодож байна.

Хоёрдугаарт нь, нийлүүлэлтийг нэмэгдүүлэхтэй холбоотой түрүүн хэд хэдэн гишүүн асуусан. Хүрэлбаатар сайд хариулах болов уу гэж би бодож байгаа юм.

Бид экспортын орлоготой орлогыг л нэмэгдүүлэх ёстой. Гэхдээ сүүлийн үед экспортын орлого дээр гарч байгаа нэг хамгийн том алдаа бол энэ оптек гэрээ байгаа юм. Зүгээр

миний сонссоноор бол энэ оны эхнээс хойш л манай Сангийн яамныхан, Эдийн засгийн яамныхан өдөр шөнөгүй л яриад л байгаа. Гэтэл харамсалтай нь гадагшаа нүүрс зөөгөөд л байгаа, орж байгаа валют хомсхон байна гэж байгаа юм. Тэгээд энийг болиулах, цаашидаа энэ уул уурхайн бүтээгдэхүүний ил тод байдлыг хангах, валютынхаа нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр ер нь ямар арга хэмжээ авч хэрэгжүүлье гэж төлөвлөж байгаа юм бэ 2023 онд.

Гуравдугаарт нь Лхагвасүрэн Ерөнхийлөгчөөс асууж байгаа юм. Яг өнөөдрийн байдлаар манай валютын бодит нөөц яг хэд байна вэ гэсэн ийм 3 асуултыг асууя.

Г.Занданшатар: 83.

Монголбанк Тогтохсүрэн даргын асуултад хариулъя. Төв банк бол хуулиараа одоо мөнгөний бодлогыг хэрэгжүүлдэг. Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх арга хэрэгсэлтэй цөөхөн арга хэрэгсэлтэй. Шууд одоо экспортолдог аж ахуйн нэгжтэй юм уу, шууд импортолдог аж ахуйн нэгжтэй шууд ингээд харьцдаггүй. Бид бол мөнгөний бодлогын арга хэрэгсэл, одоо хэрэгжүүлж байгаа арга хэрэгслээрээ дам нөлөөгөөр ингээд энд нь нөлөөлөд ингээд явдаг л ийм л институц байгаа. Тэгээд яг таны асуултад яг тодорхой хариулъя гэх юм бол импортыг бол багасгах талаар одоо шууд тариф ч гэдэг юм уу, гааль, худалдааны тариф нөхцөлийг хатууруулах ийм юмыг бол Монголбанк биш, Засгийн газар хэрэгжүүлдэг байгаа. Бидний зүгээс бол яг одоо импортын өнөөдөр одоо өндөр байгаа импортын нэлээн томоохон хэсэг нь бол одоо тансаг хэрэглээний бараа буюу тэр автомашин, архи тамхи ч гэдэг юм уу,

ийм олон зүйлүүд дээр бол маш их одоо төлбөр тооцоо хийгдэж байгаа. Өнгөрсөн оны мөн үеийнхээсээ ч өсчихсөн байгаа. Зүгээр би машин дээр дурдах юм бол 2021 онд бол 400 гаруй сая долларын автомашин Монгол Улс импортолсон. Тэгэхэд одоо 8 сарын статистикаар автомашины импортын хэмжээ 400 сая давчихсан явж байгаа юм.

Нэг жилийн хэмжээнээсээ ч давчихсан. Одоо өшөө оны төгсгөл хүртэл дахиад нэг улирал байхад ингээд ийм байж байгаа. Тэгэхлээр төв банкны зүгээс бол энэ дээр бол ямар зүйл хийх боломжтой гэхлээр хэрэглээний зээл гэж үзээд хэрэглээний зээлийн одоо өр орлогын харьцаа гэдэг нэг үзүүлэлт байгаа.

Дээр нь одоо машины лизингийн зээлийг бол 30 сар гэдгээр хязгаар тогтоож байгаа юм. Тэгэхлээр энэ маань өөрөө нөхцөлийг нь хатууруулж байна гэдэг маань худалдан авалтыг нь багасгах тал руугаа л ийм арга хэмжээ болоод явж байгаа .

Тэгэхлээр энэ талруугаа бол Монголбанк бол ингээд хийгээд явж байгаа. Экспорт тал дээрээ бол мэдээж экспортыг нэмэгдүүлэх тал руу нь, ялангуяа экспортыг төрөлжүүлэх өнөөдөр нийт экспортын 94 хувь нь бол зөвхөн уул уурхай байна. Зургаахан хувь нь л одоо бусад салбар байна. Тэгэхлээр яаж ноос ноолуур, мах, арьс шир одоо илүү их нэмүү өртөг шингэчихсэн, үйлдвэрлэлийн технологи шат ахисан, ийм маягаар экспортлох вэ гэдэг чиглэлээр 2023 онд бол тодорхой арга хэмжээг авахаар ийм заалтуудыг оруулж өгсөн байгаа. Нөөцийн хувьд бол одоо 2 тэрбум 790 сая доллар. Сая энэ 9 сарын 30-ны байдлаар гарсан.

Ингээд яг энэ хандлагыг нь харах юм бол оны эхнээс буурч байсан нөөц маань анх удаагаа энэ 9 сард буцаж өсөж ингээж гарч ирж байгаа.

10 сард ингээд тэгэхлээр бол ерөнхийдөө нөгөө экспорт, төлбөрийн тэнцэл, худалдааны баланс дээр эерэг одоо хандлага гарч ирж байна. Тэгээд одоо Засгийн газар одоо нүүрсний экспорт дээрээ тодорхой арга хэмжээ аваад явах юм бол, хэрвээ оны төгсгөл хүртэл бол бид нүүрсээ одоо 2019 он буюу ковидын өмнөх түвшинд хүргэж, 30-36 сая тонн руу хүргэж чадах юм бол гадаад худалдааны тэнцэл дээр бүр нэлээн томоохон эерэг үр дүн гарна гэж харж байгаа юм.

Г.Занданшатар: Хүрэлбаатар сайд.

Ч.Хүрэлбаатар: Энэ экспорттой холбоотой ийм бодлого бол авч хэрэгжүүлж байгаа. Яг өнөөдрийн нөхцөл байдалд үүсчихсэн байдлыг аваад үзэхээр оптик гэрээгээр гарч байгаа нүүрс урьдчилаад төлбөрийг нь авчихсан нүүрс, урд онуудад өмнө нь гэрээ нь хийгдчихсэн мөртөө гарч амжаагүй нүүрс, 2022 ондоо гэрээ нь хийгдээд, одоо гарах гэж байгаа нүүрс гээд энэ бүгдийнх нь хооронд нь уялдаа пропорц нь бүгд алдагдчихсан байж байгаа. Тэгэхээр их хэмжээний нүүрс гараад байдаг мөртөө одоо оптикээр гарч байгаа, эсвэл одоо урьдчилгаа төлбөрийг нь авчихсан нүүрс их хэмжээгээр гараад байгаа тохиолдолд бол доллар орж ирэхгүй шүү дээ. Энэ цаана нь аж ахуйн нэгжүүдийн одоо буруу ч гэж юу байх вэ. Тэгэхээр ерөөсөө энэ дээрээ бас жоохон зохицуулалт хийж явахгүй бол үнэхээр болохгүй болчихоод байна гэж үзээд Засгийн газрын зүгээс шинээр янз бүрийн одоо оптик гэрээ

хийх, урьдчилж зарах энэ бүгдийг нь одоо зогсооёо гэж байгаа юм.

Тийм шийдвэр өчигдөр Засгийн газар дээрээ яриад үндсэндээ одоо шийдчихсэн байж байгаа. Тэгэхээр ер нь оптик гэрээнүүд бол ерөнхийдөө хяналтад орчих байх гэж бодож байгаа. Мөн одоо урьдчилж хийх, янз бүрийн гэрээ байгууллагуудыг мөн ялгаагүй хорьж байгаа. Үүнээс гадна урьд өмнө байгуулагдчихсан байсан нүүрс борлуулах гэрээ зэргийг бол бүгдийг нь ил тод болгох, цахим бүртгэлд оруулж бүртгүүлэх түүнийхээ дагуу гэрээний нөхцөлүүдийг одоо цахимд оруулах, гаргах гээд л ийм зүйл явж байгаа. Тэгэхээр бид нарын хувьд бол энэ валютын нөөцөө нэмэгдүүлэх, гадаад худалдааны бодлого дээрээ бас нэлээн бодолтой хандахгүй бол зүгээр л гаргаж л байвал сайн гэсэн агуулгаар биш гарахдаа бид нар бас чанартай, илүү их хэмжээний доллар нутагтаа оруулж ирсэн, Монгол Улсынхаа нутаг дэвсгэр дээр төгрөгөөр хийх гүйлгээ арилжааны хуулийнхаа дагуу явагддаг. Үүний цаана бас бодитой үр дүнгүүд нь гардаг байх тал дээрээ нэлээд анхаарах нь зөв юм байна л гэж үзэж байна. Холбогдох зохицуулалтуудыг хийгээд явж байгаа. Үнэхээр бас тулчихсан байгаа учраас бид нар бас энэ арга хэмжээнүүдийг авахаас ч өөр аргагүй. Хугацаа алдах тусам энэ нь одоо сөрөг үр дагавартай, Тийм учраас бас төрийн байгууллагууд, Монголбанк эд нар бол хоорондоо яриагаа нийлүүлж үйл ажиллагаагаа нэг болгож явж байгаа гэдгийг би хэлмээр байна.

Ялангуяа экспорт, экспорттой холбоотой төлбөрүүд дээр.

Г.Занданишатар:

Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн МАН-ын бүлгийн дарга тодруулж асууна.

Д.Тогтохсүрэн: Нэг зүйлийг тодруулъя. Хүрэлбаатар сайд хариулах юм болов уу. Энэ импорт дээр нефтийн бүтээгдэхүүний төлбөртэй холбоотой асуудал байгаа юм. Мааш их хэмжээний доллар гадагшилж байна. Дээр нь бусад импортууд гаднаас орж ирж байгаа. Энэ дээр яг одоо ирэх 2023 онд шинээр гаргаж байгаа ямар том бодлого байна вэ? Бид нар хамгийн гол нь энэ импортод бол доллар гадагшлах урсгалаа багасгах чиглэлээр л онцгой анхаарах ёстой гэдэг ийм л байр суурь байгаа юм.

Г.Занданишатар: Зочид эхлээд танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар, Цэндийн Мөнх оргил, Цэрэнжамцын Мөнхцэцэг нарын урилгаар СБД-ийн 20 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе өө. Одоо Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар асуултад хариулна.

Ч.Хүрэлбаатар: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Үнэхээр энэ төлбөрийн тэнцэл дээрээс төлбөрийн баланс дээрээс харахаар хаанаа бид нар яг аль гарч байгаа чиглэл дээрээ бид нар одоо доллароо алдаад байна уу, валют алдаад байна уу гэдгийг нэлээд аваад үзсэн. Ингээд үзэхээр нийт одоо хасахтай байгаа гүйлгээнүүдийг нь бараг жаргаад, 60 гаруй хувь нь ОХУ-тай нефт бүтээгдэхүүн дээр хийгдэж байгаа

худалдаан дээр байж байгаа. Тэгэхээр энэ дээр одоо своп одоо хэлцэл хийгээд явбал илүү одоо амар байх болов уу гэдэг зүйлүүдийг нэлээд ярилцаж байгаа. Яг одоо тодорхой шийдчихсэн, гэрээ хэлцэл хийгээд үр дүнд бол хүрчихсэн ийм зүйл бол байхгүй байгаа. Хятад, БНХАУ-тай хийгдэх нэг свопыг бол энэ 2023 ондоо хугацаа нь дуусна. Гэхдээ одоо урьд өмнө одоо яригдаж байсан мэдээллээр бол нэлээд нааштай хандлагатай байхаар ийм урьдчилж ярилцсан гэдэг ийм мэдээлэл бол байгаа. Тэгээд энэ чиглэлээр бас цаашаа ярья.

Г.Занданишатар: Одоо эрхэм гишүүн Ганибалын Амартүвшин.

Г.Амартүвшин: Баярлалаа. Мэдээж хэрэг одоо төсөв болон мөнгөний бодлого хэлэлцэж байгаа үед хани гэдэг сэдэв бол номер нэг сэдэв болоод явж байна л даа. Тэгэхдээ яг ингээд нарийн харахад бол яалт ч үгүй 2 жил ковидын үед бидний одоо бол Засгийн газрын хэрэгжүүлсэн арга хэмжээ, их хэмжээний бэлэн мөнгө тараасан, хөнгөлөлт үзүүлсэн төсөв тэлсэн энэ арга хэмжээний үр дагавар нь яг энэ ханшийн сулрал байна л даа. Тэгэхээр Монголбанк мөнгөний бодлогоо чангаруулсан бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн. Гэхдээ энэ бол цаг хугацааны хувьд бол жсоохон цаг алдсан гэж харагдаж байна.

Хоёрдугаарт, тийм болохоор одоо цаашид мөнгөний бодлого дээр, бодлогын хүү дээр ямар өөрчлөлт гарах вэ. Хүлээлт бол бодлогын хүү үргэлжлээд одоо өснө гэсэн тийм хүлээлт байгаа. Арилжааны банкнууд яагаад зээл гаргахгүй байна гэхлээр хүү өснө гэсэн л тийм хүлээлттэй байгаа. Инфляц 14 хувьтай байхад бодлогын хүү 12 хувь гэдэг чинь бодит

хүү нь бол хасах 2-той байна л гэсэн үг шүү дээ.

Тэгэхлээр төгрөгийн өөрийн өгөөж нь ийм байхад бол хани сулрахаас өөр аргагүй.

Хоёрдугаарт төлбөрийн тэнцэл одоо энэ оны 7 сарын байдлаар бол хүнсний бүтээгдэхүүний импортоор 600 гаруй сая доллар зарцуулсан байна. Суудлын автомашины худалдан авалт 400 сая доллар, барилгын материал мөн л одоо бараг 600 сая доллар бид нар одоо 450 сая доллароор гадаадад аялж жуулчилсан байна л даа. Тэгэхлээр ийм хэмжээний доллар гадагшилж байгаа тохиолдолд Монголбанкны гадаад валютын нөөц буурахаас өөр аргагүй байхгүй юу.

Тэгэхлээр Монголбанк цаашид энэ төлбөрийн тэнцэл дээр ямар бодлого хэрэгжүүлнэ гэж бодож байна аа? Энэ талаар бас хариулж өгөөч ээ?

Хоёрдугаарт арилжааны банкнуудын IPO хийх гэж байхад хойшлуулсан хугацаа байгаа юм. Яагаад гэвэл одоо активын чанарын үнэлгээ AQR хийх ёстой гэсэн. Тэр AQR маань тэгээд юу болсон бэ? Энэ AQR-ийн тэр арилжааны банкнуудын том арилжааны банкнуудын активын чанарын үнэлгээний дүн одоо хэзээ гарах юм? Ил тод олон нийтэд энийг мэдээлэх юм уу? Энийг бас мэдэх хэрэгтэй шүү дээ. Зарим банкууд нь IPO хийх гээд одоо очерлоод зогсож байгаа. Тэгэхлээр энэ мэдээллийг бас авмаар байна. Моргежийн ипотекийн хөтөлбөр чинь үргэлжилж байгаа юу? Одоо 6 хувийн ипотека маань гарч байгаа юу, үгүй юу. Гадуур болохоороо зээл ерөөсөө гарахгүй байна л гээд байна. Миний ойлгож байгаагаар бол

мөнгөний бодлого дээр Монголбанк үргэлжлүүлээд авч явахаар ярьж байх шиг байна л даа. Тэгэхлээр МИК нь одоо байхгүй болчихсон гэсэн үг юм уу? Энийг нэг тодруулж өгөөч ээ, Ер нь бол ипотекийн 6 хувь чинь манай мөнгөний бодлогын эсрэг явж байгаа шүү дээ. Өөрөөр хэлбэл бодлогын хүү чинь 14 байхад 6 хувиар бид нар их хэмжээний мөнгийг барилгын салбарт оруулж байгаа. Барилгын салбарын хөрөнгө оруулалтын 70 хувь нь ерөөсөө импортод гараад явчихдаг. Тэгэхээр энэ бол бас мөнгөний бодлогын эсрэг явж байгаа бас нэг хөтөлбөр гэдгийг ойлгох хэрэгтэй байх. Эцэст нь төгрөгийн дэвсгэрт одоо шинэ дэвсгэрт 50 мянгатын дэвсгэрт гаргана гэж бичсэн байна лээ л дээ. Яг 50000-т биш, ямар ч байсан шинэ дэвсгэрт гаргана ингээд яах вэ нийт мөнгөний нийлүүлэлт өөрчлөгдөхгүй гэвэл энэ бол нэг их инфляц болон бусад юунд бол нөлөөлөхгүй байх. Гэхдээ бас нэг үр дагавар нь юу вэ гэхлээр нэгдүгээрт төгрөгийн инфляц болон ханшийн сулралын хүлээлт нь илүү сөрөг болно оо.

Хоёрдугаарт, далд эдийн засгийн одоо дэмжих тийм арга хэмжээ болох юм биш биз. Энэ дээр бас жоохон анхаармаар байна л даа. Ер нь бол яах вэ манай мөнгөний эргэлтийн 96 хувь нь болохоор цахимаар одоо юу гэдэг юм бэлэн бусаар явдаг. 4 хувь нь л одоо бэлнээр явдаг болохоор харьцангуй бага байна байх. Гэхдээ Ерөнхийлөгчийн.

Г.Занданшатар: 83.
Монголбанкны Ерөнхийлөгч
Лхагвасүрэн.

Б.Лхагвасүрэн: Амартүвшин
гишүүний асуултад хариулья.

Тэгээд бодлогын хүү одоо оны эхнээс хойш ингээд 6 нэгж хувиар бараг 2 дахин өсчхөөд 12 хувьд хүрчихсэн байна. Хүүг цааш нь өсөх үү гэдэг дээр бол мэдээж, яг одоо бол нэлээн олон юмнаас хамаарна л гэж Төв төв банк бол үзэж байгаа.

Нэгдүгээрт, эдийн засгийн идэвхжил, эдийн засаг хир их идэвхтэй ковидын дараах одоо идэвхжил эрэлт хир их өндөр байх юм. Тэр өндөр байх нь өөрөө хир одоо удирдлагатай байх вэ гэдэг дээрээс нэлээн хамаарах гэж байгаа.

Хоёрдугаарт бол мэдээж инфляц, ханиш эдгээрээс нэлээн хамаарна. Ханиш, инфляц маань өөрөө юунаас хамаарч байна вэ гэхлээр, бас нөгөө гадаад худалдааны тэнцэл буюу манай экспорт хир идэвхтэй байж, доллар хэр урсаж орж ирэхээс ингээд нөөц яаж өсөж явахаас ингээд хамаарч байгаа учраас бол зүгээр Төв банкны зүгээс бол мэдээж одоо сүүлийн 2 сард инфляц ингээд буурч байгаа энэ хандлага цааш үргэлжлээд явах юм бол мэдээж одоо саяын таны дурдаж байгаа тэр бодит хүүний зөрүү бол одоо нарийсаад бүр ингээд нийлэх буюу одоо бодит хүү өөрөө бий болох ийм зүйл. Одоо бол хасах хүүтэй явж байгаа. Одоо ингээд бодит хүүтэй болчих юм бол эргээд хүүгээ цааш нь чангаруулах гэдэг дээр бол мэдээж нэлээн бодолцох ийм зүйлүүд гарч ирэх байх. Тэгэхлээр бидний хувьд бол одоо энэ ойртож байгаа гэдэг утгаараа бол, хүү бол өөрөө саяын л хэлж байгаа экспортоос бол нэлээн хамаарна.

Эдийн засгийн идэвхжилээс бол нэлээд хамаарах юм байгаа юм. Тэгээд шууд төлбөрийн тэнцэлтэй нь ингээд уялдуулаад үзэх юм бол төлбөрийн

тэнцэл бол одоо 8 сарын сүүлийн байдлаар 1.5 тэрбум долларын алдагдалтай байгаа. Оны төгсгөл рүү бол одоо энэ нэмэгдэх хандлага нь бол байж л байгаа. Тэгэхдээ гол зүйл нь бол одоо Засгийн газраас хэрэгжүүлж байгаа зарим арга хэмжээний үр дүнд бол тодорхой хэмжээний төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах ийм нөхцөл байдал үүсэх үүсэж магадгүй гэж төв банкны зүгээс бас тооцоолж байна. Ялангуяа тэр нүүрсийг аман дээрээс нь биш хил дээрээс зараад эхлэх юм бол ялангуяа тэр тээврийн үйлчилгээн дээр байгаа 4 зуугаад сая долларын алдагдал бол өөрөө энэ хэмжээгээр хумигдах бас боломж гарч ирэх болов уу гэж нэгдүгээрт харж байгаа. Ер нь бол дэлхий нийт дээр байгаа энэ нефтийн үнийн бүтээгдэхүүний үнэ бол өөрөө нэлээн өндөр хэмжээнд бас байж байна. Энэ үнэ маань өөрөө цаашаа буурах хандлага бол бас их төвөгтэй байгаа.

Дээр нь одоо ингээд нефтийн үнэ тогтоодог байгууллагууд бол үнээ хэвээр нь хадгалахын төлөө дандаа арга хэмжээ аваад байгаа учраас бол бидний хувьд бол импорт энэ хэмжээгээрээ гарсаар байх юм байна л гэж л төсөөлж байгаа. Тэгэхлээр төлбөрийн тэнцлийн алдагдлаа яаж одоо багасгах вэ гэдэг дээр бол мэдээж Төв банк бол шууд ийм бодлогоор ийм хэрэгслээр ингэж багасгана гэж шууд оролцох зүйл байхгүй. Гадаад худалдаа маань экспорт импортоороо дамжиж байгаа. Үйлчилгээ маань өөрөө бас л одоо үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудын салбарын ийм үйл ажиллагаанууд байгаа. Мөн Оюутолгойтой холбоотой далд уурхайн бүтээн байгуулалтын ажил үргэлжилсэн хэвээр байх учраас төлбөрийн тэнцэл дээр бол алдагдал

бол хэвээрээ нэг хэсэгтээ байх юм байна л гэж л харж байгаа.

Гурав дахь асуудлын хувьд бол активын чанарын үнэлгээг бол 6 сарын сүүлээс 8 сарын эхэн хүртэл хийж дуусгасан. Активын чанарын үнэлгээний дүн бол гарсан. Үнэлгээний байгууллагаар хийсэн байгаа. Үнэлгээний дүнг ч гэсэн Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл дээрээ бид хэд хэд ярьсан. ОУВС-ийн бас энэ газар дээр хийсэн ажлын хэсэгтээ ч гэсэн тодорхой хэмжээгээр хуваалцсан байгаа. Мөн сэтгүүлчидтэй уулзах уулзалт дээр энэ хөндсөн асуудлаар нь бол тодорхой хариултыг өгөөд ингээд явж байгаа. Тэгээд 5 том банкан дээр активын чанарын үнэлгээ хийгээд багахан хэмжээний одоо богинохон хугацаанд удирдаж болохоор өөрийн хөрөнгө нь дутагдсан ийм зүйл гарсан. Тэгэхээр ерөнхийдөө энэ ондоо багтаагаад тэр тодорхой хэмжээний өөрийн хөрөнгийн дутагдал бол арилаад явах л боломжтой гэж харж байгаа.

Өөрийн хөрөнгө дээр нь зохистой харьцаан дээр нь тодорхой өөрчлөлт ороогүй ийм банкнууд дээр бол одоо IPO хийх асуудал нь бол нээлттэй.

Г.Занданишатар: Ганибалын Амартүвшин гишүүн тодруулж асууна.

Г.Амартүвшин: Мэдээж хэрэг Монголбанк шууд төлбөрийн тэнцэл дээрээ бол одоо ямар нэгэн шууд нөлөө байхгүй гэдэг нь ойлгомжтой. Гэхдээ одоо жишээлбэл хэрэглээтэй холбоотой, гадагшилж байгаа валютын урсгал дээр бас тодорхой хэмжээний арга хэмжээ авах боломж байна гэж харж байна л даа.

Жишээлбэл хэрэглээний зээл, автомашины лизинг. Одоо хэрэглэсэн хуучин автомашины импорт яагаад ийм эрчимтэй яваад байгаа одоо хүртэл гэхээр санхүүжилт нь хангалттай бэлэн байгаад байна л даа. Санхүүжилт байгаа тохиолдолд, өөрөөр хэлбэл авто машины лизинг байгаа тохиолдолд бол энэ импортын хэмжээ нь бол буурахгүй шүү дээ. Тэгэхлээр энэ дээр арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллагууд дээр ямар нэгэн тийм одоо шалгуурыг нь чангаруулах арга хэмжээ авах уу, үгүй юу?

Нэмээд тэр мөнгөний төгрөгийн шинэ дэвсгэртийн талаар.

Г.Занданишатар: 83
Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Г.Амартүвшин: Амартүвшин гишүүний асуултад тодруулъя.

Тэгэхлээр Монголбанкны хувьд бол тэр автомашины лизингийн хугацааг нь 30 сар болгоод багасгачихсан байгаа. Одоо бид тэний хувьд бол өр орлогын харьцаа гэдгээр нь бас нэг шинэ заалт оруулж ирж байгаа. Тэгэхээр энэнийхээ хүрээнд бол орлого нь хангалттай хүн л энэ автомашины хэрэглээний зээл авч болохоор энэ заалтыг хийж өгч байгаа учраас бол зээлийн энэ гаргалт дээр бол тодорхой хэмжээний хязгаарууд орж ирэх байх гэж харж байгаа.

Мөнгөн дэвсгэртийн хувьд бол яг таны түрүүчийн хэлж байгаа шиг нийт гүйлгээнд байгаа мөнгөний дөрөвхөн хувь нь бол одоо бэлэн мөнгө байгаа. Бусад улсуудын жишгээр бол 10 хувь байдаг. Тэгэхлээр бол Монгол Улсад бол нэлээн тийм дижитал цахим хувьсгал бол их амжилттай

хэрэгжээд явж байгаа нь бол банк санхүүгийн салбар дээр харагдаж байгаа. Хамгийн гол нь бол бид нар Төв банкны зүгээс судалгаа хийж байгаа. Монгол Улсад бол гүйлгээнд байгаа 11 дэвсгэрт байдаг 11 дэвсгэрт маань өөрөө Улсын Их Хуралд бол хэчнээн дэвсгэрт байх, ямар хэмжээтэй байх нь Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал. Өмнө нь ингээд 93 онд анх гарахад 11 дэвсгэрт гарсан учраас бол.

Г.Занданшатар: Одоо Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Өнөөдөр бид нар Төрөөс мөнгөний бодлогыг ингээд хэлэлцэж байна, бас төсөв удахгүй орж ирнэ. Тэгэхээр мөнгөний бодлого, төсвийн бодлого 2-ыг маш зөв тохиргоо хийж байж л бид өнөөдөр яриад байгаа энэ өндөр инфляц энэ долларын ханшийн огцом өсөлтийг бол тодорхой хэмжээнд бас барьж чадах байх. Гэхдээ өнөөдөр орж ирж байгаа энэ мөнгөний бодлогын баримт бичгийг төрөөс баримтлах мөнгөний бодлогын баримт бичгээс харахад нүүрсний экспортыг л ингээд 36 сая тонноор нь гаргаад явчихвал нэг тодорхой хэмжээгээр бодлогын хүүгээ ч бууруулаад инфляцыг нэг оронтой тоон дээр авааччих эдийн засгийг нэг 4.5 хувийн өсөлт дээр авчирчих бололцоо байна гээд ганц нүүрс яриад л байна л даа. Тэгсэн хэрнээ нүүрс нь өөрөө бас хэд нь гарч байгаа, хэд нь гарахгүй байгаа юм, ямар хэмжээний ашиг олж байгаа нь ч тодорхой статистик тоо баримт нь байхгүй гэдгээ сая Эдийн засгийн хөгжлийн сайд нь бас яриад байна л даа.

Тэгэхээр нүүрсний экспортыг бид өнөөдөр ярьж байна. Тэгвэл зэсийн экспорт дээр бид ямар бодлого барьж байгаа юм. Сая жишээлбэл, энэ 6 сард

бараг 20 хувиар доод цэгтээ хүртэл уналаа шүү дээ зэсийн үнэ. 8230 ам.доллар болсон. Өмнөх жилийн 4 сард бол 10000 гаруй ам.доллар байж байсан. Цаашидаа бас буурах, өсөх энэ тэр нь бол та нар бас судалгаа хийж байгаа байх. Тэгэхээр алт, зэсийн экспорт дээр та нар ямар бодлого барьж, эндээс хэдий хэмжээний ашиг бас олох бололцоо байгаа гэж бодож байна. Эндээс төлбөрийн тэнцэл дээр бас эерэг нөлөө үзүүлэх дүр зураг харагдаж байна уу. Ер нь төлбөрийн тэнцлийг бид нар тодорхой хэмжээнд ингээд сайжруулчихвал өнөөдөр яриад байгаа асуудлаа шийдчихнэ гээд байна л даа. Тэгэхээр одоо эндээс харахад төлбөрийн тэнцэл дээр яг үнэхээр сайжрах бодит дүр зургийг та нар нь нэрлээдхээч. Ганцхан нүүрсний экспорт биш тэгээд энэ дээр бас бодит мэдээллийг өгөх нь чухал байна.

Хоёр дахь миний одоо гол асуух гэж байгаа зүйл Ган-Очир эдийн засагчаас би асууя гэж бодож байна. Өнөөдөр ингээд бодлогын хүүгээ бид 12 хувьд хүргээд хатуу мөнгөний бодлого явуулна гэдэг чинь өөрөө зээл хумьж байна. Зээл хумьж байна гэдэг чинь зах зээл рүү гарч байгаа мөнгө хумигдаж байна гэсэн үг. Энэ хумигдаж байна гэж байгаа чинь ажлын байр хумигдаж байгаа. Энэ нь өөрөө эргээд ажилгүйдэл, ядууралд нөлөөлөх бас нэг үндэс болж байгаа. Монголбанк маань өөрөө төрийн мөнгөний бодлого дээр энэ ажлын байрыг нэмэгдүүлэх, ажлын байрыг хангах, хадгалах гол үүрэгтэй бас нэг үүрэг нь.

Тэгэхээр би энэ дээр юу ярих, ярих гээд байна гэхээр бас Нэгдсэн Үндэсний байгууллагаас одоо 2000 оны үед бас хэрэгжүүлж байсан нөгөө Майкро финанс гээд яриад байгаа.

2000 оны эхээр манай Хас банк жишээлбэл энэ бичил жижиг, дунд бизнес эрхлэгчдэд ус агаар шиг хэрэгтэй байсан санхүүжилтийг олгосноор маш амжилттай хэрэгжсэн энэ төсөл. Олон хүн ажлын байртай болсон. Өнөөдөр ч жишээ нь бэст шүүс гээд маш гоё арьсаар хийж байгаа монгол гутал. Экспортод хүртэл яг тэр бичил бизнесээс өнөөдөр ингээд өндийж босоод экспорт гаргаж байгаа шүү дээ. Тэгэхээр бид нар бас энэ мөнгөний бодлогоо ярилцаж байгаа энэ үед яг энэ амжилттай хэрэгжиж бодит жишээ болж чадсан Хас банк байна, Хаан банк байна, ямар үнэхээр амжилт гаргаж байлаа. Бүр олон улсын түвшинд энэ чинь Монгол Улсын ийм банк, бичил, жижиг, дунд бизнесээр ийм амжилт гаргалаа гээд бусад улсад жишээ хүртэл болоод явж байсан. Энэ хэмжээгээр тэр үед ажилгүйдэл, ядуурал буурч байсан. Статистик тоон ч хүртэл байгаа. Огцом шүү дээ, бүр. Тэгтэл одоо бид нарын гол ингээж шаардлагатай байгаа зүйл энэ итгэлцлийн зээл байгаад байгаа юм.

Тэгээд Улсын Их Хурлын даргын зүгээс бас энэ Монголбанкны яг салбарын хүмүүстэй уулзаад энэ дээр маш нарийн тооцоо судалгаа гаргаад бас энэ иргэд рүүгээ чиглэсэн орлоготой байлгах, ажилтай байлгах чиглэл дээр бодит ажил хийх үүрэг чиглэл бас өгч байсан. Тэгэхээр энэ бодлогын баримт бичиг та бүхэн маань боловсруулж байна уу? Энэ итгэлцлийн зээлийг энэ макро финансыг хэрэгжүүлэх 2023 оноос бололцоо, дүр зураг байна уу? Энэ өөрөө өнөөдөр маш чухал байна, түрүүн бас Ганбаатар гишүүн хэлээд байгаа тэр хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр гаргасан ажлын байрыг хадгалах, хамгаалах 10 их наядын

хөтөлбөр үр дүнд огт хүрээгүй байна гэдэг дүгнэлтийг гүйцэтгэлийн аудит гаргасан байсан. Энийг сая Нийгмийн бодлогын байнгын хороон дээр ярьсан л даа. Ямар ч тооцоо судалгаа байхгүй. Хэдэн хүн ажлын байртай болсон нь тодорхойгүй. Зүгээр түр хугацаагаар сургалтад хамрагдсан гэсэн тооцоонууд байгаад байгаа юм. Гэтэл өнөөдөр иргэд маань ажлын байрыг хүсэж байна, эсвэл ажлын байр гэхэд ажлаа зөв үнэлүүлэхийг хүсэж байна. Орлоготой байхыг хүсэж байна, өндөр инфляц байна, тэгээд энэ.

Г.Занданшатар: 83.
Монголбанкны Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Оюунчимэг
гишүүний асуултад хариулья.

Тэгээд мэдээж макро эдийн засгийг тогтворжуулах үүднээсээ бүх л бодлогууд бол хоорондоо нийцтэй уялдан байж байж бол үр дүн маш амжилттай гарна. Мөнгөний бодлогын хувьд бол одоо бид төлөвийг хатууруулаад л, ингээд л маш хатуу хэлбэрээр явж байгаа. Одоо бодлогын хүү маань 2 дахин өсөөд 12 хувьд хүрчихсэн. Энэ нь өөрөө одоо мэдээж шинээр гарч байгаа эх үүсвэр, зээлийн зардлаараа дамжаад, нөгөө бодит сектор руугаа очиж байгаа учраас дарамтыг маш их нэмэгдүүлж байгаа. Энэ дарамтаар дамжаад импортлох гэж байгаа тодорхой бүтээгдэхүүн импортлох гэж байгаа ийм компаниуд буюу тэдгээрт л одоо энэ нь өөрөө тохиргоо хэлбэрээр л очиж байгаа л даа. Тэр нь импортыг багасгаж экспорт талд худалдааны тэнцэл талдаа л нэмэх, орон зайг нь илүү болгох л ийм л бодлого байгаа.

Тэгэхээр мэдээж мөнгөний бодлого хатуу байгаа юм чинь төсвийн бодлого энэ чиг рүү нь бас хатуу, аль болохоор бага зардалтай байвал бидний одоо чармайж байгаа үр дүн бол илүү ойрхон болно л гэж л Төв банкны зүгээс бол харж байгаа. Худалдааны тэнцэл, төлбөрийн тэнцэл дээрээ мэдээж одоо сайжруулах тал руу нь бол бүх л тооцоо судалгааг бол хийж байгаа. Хэдийгээр одоо зэсийг экспортолдог 2 аж ахуйн нэгж байгаа. Оюутолгой, Эрдэнэт үйлдвэр гээд хоёулангийнх нь хүчин чадал бол тодорхой хязгаартай. Энэ хязгаарынхаа үр дүнд бол мэдээж гарна. Обьём одоо тоо хэмжээнийхээ хувьд бол яг л ийм хэмжээгээр гарна. Мэдээж дэлхийн зах зээл дээр зэсийн үнийн дээш доошоо хөдөлгөөн бол Монгол Улсад таатай байх уу, эс үгүй бол таагүй байх уу гэдэг нь хамаарна. Тэгээд ойрын хугацаанд бол ерөнхийдөө энэ түүхий эдийн үнэ бол өөрөө тодорхой хэмжээнд өндөр түвшинд байгаа гэдгээрээ тодорхой хэмжээний орлого орж ирнэ гэж харж байгаа. Монгол Улсын хувьд бол зэсийн баяжмалаас бол одоо өнгөрсөн онд 2 тэрбум, 500-г бол олсон. Энэ жилийн хувьд бол бидний төсөөлөл 2 тэрбум 300 гэж төсөөлчихсөн байж байгаа. Тэгэхлээр 2 тэрбум 300 бол орж ирэх боломжтой гэж харж байгаа.

Алтны хувьд бол өнгөрсөн онд бол бас 20 гаруй тонн алтыг экспортолж байсан. Нийт дүнгээр бол тэрбум орчим доллар бол орж ирдэг. Бидний хувьд ч гэсэн дээ, энэ онд бол бас 20 тэрбум руугаа хүрнэ байх. Тэгэхлээр тэрбум орчим доллар бол орж ирнэ. 20 тэрбум тушаагддаг, тэгээд экспортоор бол тэр 20 тонн тушаагддаг. Тэгээд тэрбум доллар бол олж ирнэ гэж харж байгаа.

Өнөөдрийн байдлаар бол 10 тэрбум долларыг бол худалдан авчихсан байна. Тэгэхлээр бол энэнээс хойш бол дахиад цаашаа, дахиад 5 тонн алт бол худалдаж аваад л энэ хэмжээний орлогоо бол бүтэн төвлөрүүлж чадна гэж харж байгаа юм.

Г.Занданшатар: Жамбалын Ганбаатар сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Оюунчимэг гишүүн бас зөв зүйтэй зүйл хөндлөө. Нүүрсний экспортын хувьд бол та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Ер нь уурхайнуудын хүчин чадал бол бараг яах вэ, ер нь бол хамгийн багадаа гэж хэлэхэд бол нэг 60 сая тонн гаргах хүчин чадалтай. Зүгээр яах вэ бид нар тээвэрлэлт болоод хил гаалийнхаа асуудал гээд Хятад улсын цар тахалтай холбоотой барьж байгаа бодлогоос шалтгаалаад энэ 36 сая тонн гэдэг зүйл гарч ирж байгаа. Энийг бол та бүхэн сайн мэдэж байгаа. Цаашидаа энийгээ нэмэгдүүлэх талаар Эдийн засгийн хөгжлийн яам, Хэрэг эрхлэх газар бас ажиллаж байгаа юм байна лээ. Тэгэхдээ энэ бол нэмэгдэх байх гэж бодож байна. Зэсийн баяжмалын хувьд бол ер нь Уул уурхайн яамнаас өгсөн санал бол 1.4 сая тонн энэ бол ер нь дундаж үнэ нь бол 8400 доллар гэж одоо төлөвлөж байгаа. Энэ зэсийн үнэ бол цаашидаа зүгээр Уул уурхайн яамнаас юу гэж үзэж байгаа вэ гэхлээр эрэлттэй бол нийлүүлэлт нь бол гүйцэхгүй байгаа. Дэлхийг ярьж байгаа юм. Тэгэхлээр зэсийн үнийг цаашаа бол өсөх өндөр магадлалтай гэж харж байгаа. Уул уурхайд Оюутолгойн далд уурхай ашиглалтад орсон тохиолдолд экспортын хэмжээ бол нэмэгдэнэ. 1.5 сая тонн хүртэл бол нэмэгдэнэ.

Цагаан суваргын хувьд бол 350 тонноор бол нэмэгдэнэ.

Энэ тохиолдолд бол манай экспорт, бас зэсийн хувьд бол бараг 2 сая тоннд хүрэх магадлалтай. Тэгэхдээ яах вэ Оюутолгой дээр бол одоо гаргаж байгаа экспортын тодорхой хувь нь Монголбанканд орж ирдэг. Энэ бол одоо бас гэрээтэй ийм зүйл байгаа. Энийг бол их олон жил ярьсан учраас дэлгэрэнгүй яриад бол яах вэ. Алтны хувьд бол ер нь ноднин бол 20 тонн байсан бол энэ жил нь 17 тонн болж буурсан. Ирэх жилүүдэд алтны хувьд бол бас буурах магадлалтай байгаа. Тийм учраас Монгол Улс алтны хувьд бас хайгуулаа нэмэгдүүлэх шаардлагатай байгаа гэдгийг танд хэлье ээ.

Баярлалаа.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууна. Дараа нь Монголбанкны Ерөнхийлөгч хариулна.

М.Оюунчимэг: Тэр бичил жижиг, дунд бизнесийг дэмжих санхүүжилттэй холбоотой Миний асуултад Ган-Очир зөвлөхөө маш тодорхой хариулаад өгөөрэй.

Өнөөдөр иргэдэд ус агаар шиг хэрэгтэй байна шүү. Бичил бизнес эрхэлж байгаа хүмүүсдээ эдийн засгийн нөгөө 10 их наядын хөтөлбөр тодорхой хэмжээгээр одоо хэд нь үлдээд, хэдэд нь энийг гаргах гэж байгаа гээд энэ дээр бид нар маш тодорхой хариулт авахыг хүсэж байна. Сая Ганбаатар сайд энэ Цагаан суваргын орд ашиглалтад орчихлоо гэхчэв үү? Орчихсон явж байгаа юм уу? Тэгэхээр 2023 оны төсөөлөл тэгээд төлбөрийн тэнцэл, валютын

нөөц бүрдүүлэх дээр аль нь яг Оюутолгойгоос бид хэдийн хэмжээгээр Эрдэнэт үйлдвэр маань ийм хэмжээгээр алтан дээр одоо яг алт хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа алтаар Засгийн газар эрх зүйн орчны хувьд юм уу, ийм бодит юмнуудыг бид бас энэ төсөвтэйгөө уяад зохицуулалт хийх шаардлагатай байгаа гэсэн яг тийм тооцоо судалгаа та нар маань хийсэн байгаа юу? Тэгээд энэ хоёртоо хариулт авъя. Баярлалаа.

Т.Аюурсайхан: 85. Дугаар микрофон дээр Монголбанк хариулъя.

Дараа нь Ганбаатар сайд бэлдэж байгаарай.

Д.Ган-Очир: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Тэр бодлогын хүү өсөж байгаатай холбогдуулаад мэдээж санхүүгийн нөөц дээр зардлууд үүснэ.

Аж ахуйн нэгж дээр болон ажил эрхлэлт дээр тодорхой хэмжээний сөрөг үр дагавар байж болзошгүй гэж байгаа боловч бодлогын хүүгийн тохиргоог хийх зайлигүй шаардлага бол эдийн засаг дээр байгаа. Ялангуяа өнөөдрийн инфляцын их зорилт түвшинд оруулж ирэх, валютын ханшын тогтвортой байдлыг богино хугацаанд хангах гэдэг зорилтын хүрээнд бол бодлогын өсгөх шаардлага байгаа. Зүгээр олон улсын байгууллагууд Монголын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал дээр бол эдийн засгийг нь тогтворжуулах зорилтыг бол яалт ч үгүй энэ төсвийн бодлого, тэр дундаа бол таны сая хөндөж байгаа энэ ажлын байрыг хамгаалах, иргэдийн орлогыг хамгаалах гэдэг энэ зорилт дээр бол энэ төсвийн бодлого дээр хийх түүний бүтцийг нь

оновчтой болгох гэдэг зөвлөгөө бол байгаа. Энэ утгаар бол энэ итгэлийн зээлийн хуулийн төсөл гээд 2019 онд Монголбанкны тухайн үеийн удирдлага бол бас манлайлаад хийсэн хуулийн төсөл байгаа.

Г.Занданшатар: 1 минут нэмээд өгчих 85 дээр.

Д.Ган-Очир: Энэ хуулийн төсөлдөө бол Монголбанкны одоогийн бид бүхний байр суурь бол яг адил. Санхүүжилтийн хувьд бол мэдээж энэ бол яг л төсөв, төсвийн тусгай сангуудаас бол тодорхой эх үүсвэрийг бол энэ зээлийн санхүүжилт дээр бол байршуулах ёстой. Тэгээд мэдээж төрийн банкнууд гэдэг юм уу, төрийн тусгай сангууд бол үйл ажиллагааг эрхлэн явна. Үйл ажиллагааг эхлээд харуулаад чадсаны дараа бол олон улсын бусад байгууллага, санхүүгийн байгууллагуудаас нэмэлт эх үүсвэрийг бол тусламж байдлаар гэдэг юм уу, зээл хэлбэрээр хөнгөлөлттэй зээл хэлбэрээр авч оруулаад бол явах бололцоотой гэсэн ийм хуулийн төсөл байгаа. Үүн дээр ч гэсэн бид бүхэн санал нэг байгаа. Тэгэхээр энэ бол төсвийн зардлынхаа бүтэц дээр энэ хэлбэрийн санхүүжилтийг тодорхой тавиад явах ёстой төрийн бодлого байна гэдгээр бол асуудлыг харж байгаа.

Т.Аюурсайхан: Жамбалын Ганбаатар сайд хариулъя.

Ж.Ганбаатар: Оюунчимэг гишүүний тодруулгад хариулъя. Ер нь энэ 2022 оны 1.4 гэдэг бол 560 мянга нь бол Эрдэнэтийн одоо баяжмал үлдсэн нь Оюутолгойн баяжмал гэж одоо ойлгож болно. Цагаан суваргын хувьд би зүгээр ирээдүйн төсөөлөл хэлсэн шүү гэдгийг танд хэлье ээ. 2023 онд

бол Цагаан суваргын хувьд 1.4 гэдэгт ороогүй байгаа гэдгийг хэлье.

Баярлалаа.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг асуулт асууна.

Н.Алтанхуяг: Би төгсгөл рүү нь асуулт асуучихъя.

Энэ бодлого ер нь биш байна даа. Манай жаран хэдээ. Энэнээс болоод энэ юм явахгүй байна. Мэдээж хүндрэл бэрхшээл бол байгаа. Дэлхий даяараа ч байж байна. Гэтэл уулаасаа хүндрэл бэрхшээлтэй тэмцэнэ, зохицуулна гэж л энэ Их хурал, засаг, Монголбанк байдаг байлгүй дээ. Гэтэл одоо орж ирээд ярьж байгаа юмыг нь сонсохоор Хятад буруутай, эсвэл Орос буруутай тэр нөхдүүд валютаар бензинийг зараад байгаа юм, эсвэл энэ Хятад одоо тээвэр гацаагаад байгаа юм гэсэн нэг ийм л юм яриад л, тэгээд л нэг ингээд л үүргэлигээгээд л. Тэгээд энэ жаран хэд нь байх ч үгүй юм байна энд. Тэгээд хүн байгаа юм уу?

Тэгээд одоо яаж ингэж ард түмний ахуй амьдралыг энэ улс орны хөгжлийг ярих юм бэ? Хэн ч үгүй хоосон танхим дотор Монголбанкны хэдэн хүн суучихсан. Одоо энэ Лхагвасүрэн захирал бид нар их олон жил бас ингээд хамт явж байна. Та нарыг загнаад ч нэмэргүй байхгүй юу? Үгүй ээ, энэ төсвийнхөө бодлогыг уялдуулаач дээ. Одоо өнөөдөр хар аа энийг баахан ярьж ярьчхаад одоо энэний хойноос Сангийн сайд нь орж ирээд ирэх жилийн төсөв ярина, тэр төсөв нь наад мөнгөний бодлогыг чинь хуцваа гэж хэлсэн төсөв орж ирж байна лээ. Үгүй ээ, тэгээд ингэж болох юм уу? Энэ чинь нэг л улс шүү дээ, бид

нар. Энэ төсвийн үр ашиггүй хөрөнгө оруулалт, элдэв юмыг зогсоогоод өг, энэ тойргийнхоо мөнгийг болиод өг гээд би бас зөндөө л хэллээ шүү дээ. Бодлого чинь зөв байх ёстой байхгүй юу. Бодлого буруу учраас ийм байна. Энэ инфляц юмны үнийн өсөлтийг бол та нар зогсоож чадахгүй юм байна. Бид нарын үед хийсэн юмыг шүүмжилж байснаа хууль батлангуут нь үнийн өсөлтийг хазаарлах хууль батлангуут нь болчихно оо гэсэн. Одоо тэр Хөгжлийн сайд чинь сая хэлж байна шүү дээ. Хууль батлаад тэр тогтдоггүй юм гэж. Бодлого чинь хаана байгаа юм бэ?

Энэ Ардын нам дотроо бодлогоо зохицуулж, энэ улс орноо, энэ ард түмнээ гэсэн бодол сэтгэлтэй юм хийхгүй бол энэ улс дампуурлаа шүү дээ. Энэ хээл хахууль гэдэг юм чинь энэ нэг тээвэр ложистикийн бүх салбарт бол хэрээс хэтэрлээ л дээ. Тэгээд л нэг их гоё гоё юм ярих юм энд орж ирэхээрээ. Одоо ингээд алаад өгнө, маргааш тэгээд гоё болгоод өгье. Үгүй ээ, хэчнээн жил хүлээж байна аа, та нарыг энэ улс орныг гайгүй болгоод өгөөч гэж энэ ард түмэн. Одоо бүр туйлдлаа шүү дээ. Юмны үнийн өсөлт бол хэрээс хэтэрлээ, Энэ валютын ханшин дээр би нэг хэлэх гээд байгаа юм. Энэ төсвийн бодлоготой яаж уялдаад байгаа юм гэхээр та нар сонс л доо, барилгын материал гэхэд 600 сая доллароор худалдаад авч байна шүү дээ. Хэрэгтэй хэрэггүй барилга битгий барь гээд байгаа юм шүү дээ. Ялангуяа төсвийн мөнгөөр авто машин худалдаж авч байна 400 сая доллароор. Үгүй ээ, тэгээд нөгөө муу шинэчлэлийн Засгийн газрын үед хийсэн, босгосон нэг хэдэн үйлдвэрүүдээ дудамдаач дээ. Үгүй ээ, тэр захирлуудтай нь уулзаад яриаач ээ, ямар зовлон бэрхшээл байгаа юм?

Хоорондоо хэрэлдэнгүүтээ цементээ гаднаас оруулж ирдэг болгочих юм яаж байгаа юм бэ? Энэ чинь 300 гаруй сая доллар байхгүй юу? Барилгын материалын үйлдвэрлэлийг дотооддоо хийдгийг дэмжье гээд зөндөө юм хийсэн. Одоо тэд нар нь үүд хаалгаа барьцааж байх шиг байна. Бодлогоо нэгтгэхгүй Хөгжлийн сайд нь тэр LRT гэдэг юм хэрэггүй гэсэн. Хотын дарга нь тэрийг чинь бид нар мөнгө олоод барина. Үгүй ээ, энэ нэг улс юм уу хэдэн улс юм. Хаана байна та нарын нөгөө нэг хүчээ нэгтгээд Монгол Улсыг хөгжүүлээд алаад өгнө гэсэн чинь хаана байна?

Бодлого чинь ерөөсөө нэгдэж өгөхгүй байна, би бодитой жишээ хэлж байна шүү дээ. Тийм учраас энэ дээр бодлогоо гаргаад энэ ард иргэддээ үнэнээ хэлээч. Их хурал дээр орж ирэхээр л юм сайхан болно л гэж ярих юм. Үгүй ээ, гараад л гудамжинд гараад.

Т.Аюурсайхан: Алтанхуяг гишүүнд 1 минут нэмж өгье.

Н.Алтанхуяг: Тэгээд бодлогоо нэгтгээд өг л дөө. Хүчээ нэгтгэнэ гээд л дөвчигнөцгөөгөөд байсан юм. Бодлогоо нэгтгээч. Улс орноо, ард түмнээ бодооч, одоо ажиллаач. Ажлаа хийгээч ээ хуралдаа орж ирээч ээ. Үгүй ээ, жаран хэдэн хүн байдаг биз дээ энэ чинь. Цемент 3 үйлдвэр боссон юм, гурвууланг нь ингээд амыг нь бариад зогсоож байх шиг байна. Арматурын төмөр гэж нэг зээл авсан. Хүмүүсийг нь шоронд хийгээд тэгээд ерөнхийдөө дуусгаж байх шиг байна. Сүүлдээ арматурын үйлдвэр барина гэж Алтанхуяг гэдэг нөхөр Засгийн газрын тогтоол гаргасан гээд буруутаад дуусах юм шиг байна. Ийм тэнэг юмаа больцгоо. Ноос ноолуур,

арьс шир, өчнөөн үйлдвэр бид дэмжсэн шүү дээ. Наад валютын ханиш гэдэг юм чинь нь өнөө маргаашийн асуудал биш байхгүй юу.

Харин Монголбанк засагтайгаа хамтраад тэр экспортыг дэмжих бодлогоо гарга л даа, дунд хугацаанд, урт хугацаанд. Байхгүй шүү дээ одоо тэр бодлого чинь алга болчихсон. Тийм учраас энэ дээрээ анхаараач ээ.

Би нэг ганцхан асуулттай.

Т.Аюурсайхан: *1 минут нэмж өгье, Алтанхуяг гишүүнд. Асуултаа асуу.*

Н.Алтанхуяг: *Ямар асуулт байна вэ гэхээр байна шүү дээ, энэ байгалийн чинь баялгаас жаахан доллар олно гээд бүгд л одоо харж байгаа нь зөв үү. Байгалийн чинь баялгийг зөөдөг юу алга, тээвэр ложистик алга, нэгдүгээрт.*

Хоёрдугаарт Хятад улс буруутай биш, Монголын Засгийн газар унхиагүйдээ буруутай. Юунд вэ гэхээр Эрээн дээр ирчихсэн бараа Улаанбаатарт орж ирээд эзнийхээ гар дээр очиход 30-45 хоног зарцуулж байна шүү дээ. Энд бас Хятад буруутай юм уу, яагаад энэ тээвэр ложистикийнхоо асуудлыг шийдэхгүй байгаа юм? Одоо тэр хэн мэддэг юм, тэр хүнийг нь дуудаад нэг надад нэг хариулт өгөөдөх. Надад юу яах вэ энэ ард түмэнд хариулт өгөөдөх. Тэгээд вагон дээрээ бөөн зодоон, бөөн хээл хахууль, вагоных нь үнэ өсчихсөн. Ороод ирэхээр гаалийнх нь хээл хахууль нэхдэг. Тээврийнх нь хээл хахууль нэмдэг. Ингээд энэ юмны чинь энэ өсөлт дээр хээл хахууль өгч байгаагийн үнэ нэмэгдчихээд байгаа байхгүй юу.

Манай Засгийн газрын хувьд энэ Замын-Үүд дээр бараа.

Т.Аюурсайхан: *Зочин танилцуулъя аа.*

Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамын урилгаар МУИС-ийн номын сангийн ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Монголбанк хариулья 83 дээр Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Хариулт хариулт зөндөө асуулт асуусан шүү дээ тээ, мөнгөний бодлогоо төсвийн бодлоготойгоо уялдуулж чадаж байна уу, тэгээд тээвэр ложистик, валютын одоо асуудал гээд зөндөө суусан шүү дээ.

Б.Лхагвасүрэн: *Алтанхуяг гишүүний асуултад хариулья. Тэгээд ерөнхийдөө мөнгөний бодлого хатуурч байгаа. Тэр утгаар төсвийн бодлого бас алдагдалгүй, зардал нь бага түвшинд орж ирэх юм бол мэдээж бодлогын нийцэлтэй байдал нь бол хангагдана. Тэр утгаараа инфляц ч гэдэг юм уу валютын ханшийг тогтворжуулах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад тул богино хугацаанд хангах ийм үр дүнд авчирна. төв банк бол одоо төлбөрийн тэнцэл, гадаад худалдааны тэнцлийг ашигтай гаргах тал руу нь одоо бодлогын санал гэдэг юм уу, одоо тийм зүйлүүдийг гаргаж, одоо Сангийн яаманд бол бас тодорхой хэмжээнд хүүргүүлдэг.*

Дээр нь Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл дээрээ бол бас нээлттэй нэлээн ярьж явдаг. Тэр утгаар импортыг бууруулах чиглэлээр одоо зарим нэг бараа бүтээгдэхүүний импортын татвар, тарифын бодлого ямаршүү байвал зүгээр вэ гэдэг дээр саналаа бол хэлээд явж байгаа. Яг тээвэр ложистикийн хувьд бол тээвэр ложистик бол зардал өссөн байдал бол одоо дэлхий нийтийн бас хэмжээнд яригдаж байгаа. Ковидын өмнөх үеэсээ бол бараг 2000 долларт байсан контейнерын тээврийн зардал өнөөдөр 10000-ыг даваад, одоо ингээд буцаад 7000 руу ороод явж байна, анхных бүр өндөр 5, 6 дахин өсчихсөн байснаас бол тодорхой хэмжээгээр 30, 40 хувиар буураад явж байгаа ч гэсэн бас л ковидын өмнөх нөхцөлөөсөө 4 дахин өндөр ийм хэмжээний зардалтай байгаа. Энэ нь өөрөө импортын бараа бүтээгдэхүүний зардлаар дамжиж цуг орж ирээд өнөөдрийн инфляцын манай инфляцын бараг 60-70 хувийг бол бас тодорхойлоод явж байгаа.

Тэгэхдээ ерөнхийдөө хандлага буураад явж байгаа гэдэг утгаараа бол хэсэг хугацааны дараа бол ковидынхоо өмнөх түвшинд бол хүрэх байх гэж Төв банкны зүгээс бол төсөөлж байгаа.

Т.Аюурсайхан: 83 дээр Лхагвасүрэн Ерөнхийлөгч гүйцээж хариулъя. Төсвийн зардал бол 20 их наяд буюу манай ДНБ-ий 36 хувьтай тэнцүү байгаа. Төв банкны зүгээс бол одоо тооцоо судалгаа хийгээд явахад бол, хэрвээ улсын төсөв одоо ковидын өмнөх нөхцөл буюу одоо ДНБ-ний 30 хувиас доогуур байх юм бол мөнгөний бодлогод бол маш сайн дэмжлэг болно гэдэг талаас нь харж байгаа.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батшугар асуулт асууна.

Э.Батиугар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Нийлүүлэлтийн инфляц нийт инфляцын 68 хувийг эзэлж байна. Тэгэхээр Монголбанк үүн дээр ямар арга хэмжээ авах тийм төлөвлөгөө байгаа вэ? Энэ төлөвлөгөө нь тэгээд зорилтот инфляц болох нэмэх, хасах 2. 6 дээр нэмэх, хасах 2 дээр нь хангалттай хүрч чадах уу? нэгдэх асуудал.

Хоёр дахь нь бол ирэх жил шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Засгийн газраас том том төсөл хөтөлбөр хэрэгжиж эхэлнэ. Энэ хэрэгжилт дээр Монголбанк бодлогоо уялдуулсан уу? Яагаад гэвэл энэ төслүүдэд дийлэнх нь бол импортын гаднаас импорт авах тоног төхөөрөмж авах тийм төслүүд байгаа юм. Өнгөрсөн тав дахь өдөр гадаадын хэвлэл мэдээллээс болоод Монгол Улсын гадаад бондын зардал 20 хувьд хүрсэн. Энэ нь бол ирэх жил бондын эргэн санхүүжилт болох рефрэнцинг хийхэд одоо ямар нөлөө өгөх вэ? Та бүхэн яг энэ дээр бас тодорхой хэмжээний бодлого гаргаж чадсан уу? Монголбанк юу гэдэг юм одоо нөөц төлөвлөгөө гэж байдаг уу ийм эрсдэлтэй үед. Контентэнчки план гэж явдаг шүү дээ, байгаа юу гэж асуумаар байна?

Дөрөвт нь бол бид нар гадаад валютыг Монгол Улсад оруулж ирэх бодлого явуулна гэж байна. Гэхдээ яг өнөөдрийн байдлаар бол дэд бүтэц нь бас бүрэн бүрдээгүй байна Юу гэсэн үг вэ гэвэл өнөөдрийн байдлаар арилжааны ганц ч банк шууд ам.долларын клиринг крос фондын банкттай холбоо байхгүй байна. Тэгэхээр Монголбанкны зүгээс

арилжааны банкнуудаа дэмжих гэж энэ кроссфондинг долларын клиринг хийдэг банкнуудтай ямар харилцаа, тогтолцоо үүсэхэд нь одоо дэмжиж өгч байна аа? Энэ бол яалт ч үгүй одоо дэд бүтцийн асуудал бол одоо энэ доллар Монголд авчрах, мөн Монгол Улсын төлбөр тооцоог шууд доллароор хийхэд нь бол том дэм болно гэж хэлье. Тав дахь нь бол сая 5 сарын 1-нээс тоон гарын үсгийн хууль хэрэгжиж эхэлсэн. Банкны салбар, ялангуяа арилжааны банкууд энийг хангалттай нэвтрүүлж чадаж байна уу? Монгол Улсын иргэн одоо тоон гарын үсгээрээ банканд дээр очоод өөрийгөө таниулаад тэгээд санхүүгийн үйлчилгээг бүрэн авах тийм бололцоо нээгдсэн үү, өнөөдрийн хувьд.

Баярлалаа.

Т.Аюурсайхан: 83 дээр Лхагвасүрэн ерөнхийлөгч хариулъя. 83 дугаар микрофон өгөөрэй.

Б.Лхагвасүрэн: Батшугар гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр одоо инфляц 8 сард 14.4 сард бол 13.5 руу орж ирж байгаа гэсэн ийм урьдчилсан мэдээлэл байна. Тэгэхлээр инфляцын маань бараг 60-70 хувь нь өөрөө одоо импортоор дамжиж эс үгүй бол импорт, тээвэр ложистикийн бас зардлаар дамжиж орж ирсэн. Нэлээн нийлүүлэлтийн шинжтэй ийм инфляц байгаа. Мэдээж нийлүүлэлтийн шинжтэй инфляцад мөнгөний бодлогоор бол шууд нөлөөлүүлж, нөлөөлж болж чадахгүй. Гэхдээ бол хүлээлтийг буюу цааш инфляц даамжрахгүй байх талаас нь одоо эрэлт талаас нь мөнгөний бодлогыг хатууруулж ингээд явж байна. Бодлогын хүү маань 12 болж байгаа нь өөрөө тэр 2 дахь шатны

буюу эдийн засгийн сэргэлт, эрэлтээр дамжиж орж ирэх, инфляцыг л цааш нь өсгөхгүй байх ийм л зорилгоор явж байгаа дунд хугацааны бодлого байгаа. Тэгэхлээр бидний хувьд бол өнөөдөр мөнгөний бодлого маань өөрөө дунд хугацаанд инфляцыг 6 нэмэх хасах, 2 буюу энэ зорилтот түвшинд авч ирнэ гэсэн ийм л зорилгоор зорилт тавиад явж байгаа зүйл.

Инфляц бол 2023 онд нэг оронтой тоонд орно. 2024 онд энэ 6 хувийн түвшинд маань зорилтот түвшинд маань ирж чадна гэдэг ийм төсөөлөл, тооцоолол, судалгаагаар одоо мөнгөний бодлогоо өнөөдрийн бас 2023 онд хэрэгжүүлэх мөнгөний бодлогынхоо үндсэн чиглэлийг боловсруулсан байгаа.

Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд бол мэдээж томоохон бүтээн байгуулалтууд хийгдэнэ. Энэ 2022 онд ч гэсэн түрүүчийн дэд бүтцийн буюу төмөр зам, нефтийн хоолой, боомтын бүтээн байгуулалт гээд томоохон бас төсөл, шинэ сэргэлтийн бодлогоор бол томоохон төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Эдгээр төсөл хөтөлбөрүүдийг голдуу, дандаа төсвийн хөрөнгө оруулалтын зардлаа төсвөөр санхүүжилтээр, мөн төрийн өмчтэй компаниудын экспортын орлогоор ингээд санхүүжүүлээд явж байгаа. Энэ нь өөрөө гадаад худалдааны гадаад худалдаагаар дамжиж бэлэн валют урсаж орж ирэх энд маань нэлээн бас төвөг учруулж байна.

Дээр нь өөрөө ингээд төсвийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлж байгаа учраас Төв банкны нөөцөөс бол тодорхой хэмжээний санхүүжилтийг гарч яваад, энэ нь өөрөө Монгол Улсын валютын нөөцийг бол тодорхой

хэмжээнд ингээд буулгаад ингээд явж байгаа. Тэгэхээр энэ утгаар 2023 онд шинэ сэргэлтийн энэ бодлогыг явуулахдаа ямар санхүүжилтээр ашиглавал зүйтэй вэ гэдэг талаас нь бол Төв банк бол тодорхой санал санал хүргүүлж байгаа. Энэ нь юу вэ гэхлээр энэ нэг төслийг төслийн санхүүжилт хэлбэрээр буюу дэд бүтцэд хийж байгаа энэ санхүүжилтийг нь гаднаас импортоор орж ирж байгаа тэр бараа материал, одоо төмөр зам, рейлс төмөр байдаг юм уу, бусад тоног төхөөрөмжийг төсөл хэлбэрээр гаднаас босгосон мөнгөөрөө санхүүжүүлээд явах юм бол дотоодын энэ худалдаагаар дамжиж орж ирсэн экспортын орлого маань өөрөө нөөц дээрээ үлдээд нөөцийг нэмэгдүүлэх ханшийг тогтвортой байлгахад нэмэртэй юм аа. Тэгэхгүй зөвхөн нөөцөө ашиглаад явах юм бол энэ нь өөрөө нөөц дээрээ дарамт болоод макро эдийн засгийн тогтвортой байдалд төвөгтэй байна гэдэг талаас нь бол Төв банкны зүгээс бол санал хэлж байгаа.

Бонд ялангуяа Монгол Улсын энэ олон улсын санхүүгийн зах зээл дээр гарсан бондын одоо өгөөж сая нэлээн хөдөлсөн. Өгөөжийн мөрөө бол хөтлөөд нэлээн одоо өндөр хэмжээнд бол оччихсон байгаа. Нэлээн тогтвортой байсан зүйл. Энэ нь өөрөө бол тодорхой хэмжээний бас нэг гаднын хэвлэл дээр гарсан мэдээлэл болон бас тодорхой хэмжээнд Монголын энэ бонд үнэт цаасан дээр арилжаа хийдэг, бас брокер диллерийн компаниудын оролцоо байна гэж Төв банкны зүгээс бол хөндлөнгөөс бол ажиглаж байгаа. Мэдээж бондын өгөөжийг бол цааш нь одоо ингээд зах зээлийнх нь тогтворжуулах талаас нь Төв банк болон Засгийн газартай бид

хэд уулзсан, арилжааны банкнуудтайгаа уулзсан.

Т.Аюурсайхан: Батшугар гишүүд микрофон нэмж өгье. Нэмээд тодруулаад асуучих.

Э.Батшугар: Үргэлжлүүлээд нөгөө нэг фемент систем дээр нөгөө гадаадын долларын клиринг хийдэг банкнуудтай холбоо, арилжааны банкнуудтай холбоо тогтоогоод Төв банкнаас ямар байдлаар тусалж байгаа вэ? Энэ бол би түрүүн хэлсэн. Гадаад валютын төлбөр тооцоон дээр маш их том, зэрэг нөлөө авчирна.

Дээрээс нь нөгөө тоон гарын үсгийн хэрэглээ хэр зэрэг банкны салбарт хэрэгжиж байгаа вэ? Өнөөдөр одоо ямар нэгэн иргэн заавал цахим үнэмлэхээ очихгүйгээр тоон гарын үсгээ авчхаад, тэгээд өөрийгөө таниулаад банкны үйлчилгээ авах тийм бололцоо нь байна уу?

Т.Аюурсайхан: 83 дээр Лхагвасүрэн ерөнхийлөгч гүйцээж хариул.

Б.Лхагвасүрэн: Батшугар гишүүний асуултад нэмээд хариулъя. Тэгэхлээр бол Монгол Улсын гадаад, дотоод импортоор бид нар гадаад худалдаа арилжаа хийхдээ голцуу доллароор төлбөр тооцоо явж байгаа. Яагаад гэвэл нөгөө 2 түншийн хооронд хийж байгаа нөгөө төлбөрийн баримт буюу инвойс нь өөрөө дандаа доллароор хэрэгждэг учраас Монгол Улсын гадаад төлбөр тооцоо бол голдуу доллароор хийгдээд явж байгаа. Тэгээд доллар гэдэг бол өөрөө АНУ-ын үндэсний валют, долларын клиринг хийдэг банкнууд нь голцуу Америкийн банкнууд байдаг. Хэдийгээр гуравдагч орны буюу Солонгос, Сингапур, Их

Британи гэдэг Европын холбооны бас бусад улсуудад байдаг хэдий ч голцуу долларын клиринг бол Америкийн банкнуудаар явдаг гэдэг утгаараа Америкийн банкнуудад Монголын банкнуудын харилцах дансыг нээх талаар бол нэлээн ажил зохион байгуулж байгаа. Америкийн сангийн яамтай Их Британийн Сангийн яамтай харилцаад тодорхой хэмжээний энэ одоо дэмжсэн захидлуудыг авсан. Энэ хүрээндээ манай эхний банк Худалдаа хөгжлийн банк маань Америкийн банк, Нью Йоркын банк дээр өөрийнхөө харилцах дансыг нээж байна.

Тэгэхлээр ингээд асуудал цаашаагаа ингээд.

Б.Лхагвасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам асуулт асууна.

Ч.Ундрам: Өнгөрсөн тав дахийн оройноос Монгол Улсын Засгийн газрын бондын үнэ огцом унасан. Өгөөж нь 35 хувьд хүрсэн. Ийм мэдээ одоо олон улсын орчинд яваад эхэлсэн. 35 хувь гэдэг чинь одоо дефолт дампуурлын рейкт шүү дээ. Тэгэхээр олон улсын түвшинд яагаад ийм гэнэтийн шок үүсэв ээ. Та бол яах вэ, нөгөө зээлжих зэрэглэл энэ тэр гээд хэлэх байх л даа. Тэгээд таны одоо ярьж байгаа хэлж байгаа юм, олон улсын зах зээлийн мэдээ 2 чинь зөрөөд байна. Гадаад валютын албан нөөц цэвэр дүнгээрээ 400 сая доллар л байна. Тэгэхээр энэ жил дараа жил нийлээд нэг тэрбум доллар төлнө. Тэгээд энэ өрийг хүү багатай дахин санхүүжүүлж чадах уу гэдэг нэг асуулт байна.

Хоёрдугаарт төлбөрийн тэнцлийн алдагдалд хүнсний импорт

одоо 600 сая доллароор нөлөөлж байгаа. Тэгээд банкнууд чинь ерөөсөө зээл гаргахгүй. Манай энэ одоо Сэлэнгэ аймгийн газар тариалангийн хүнсний салбарынхан өөрсдөө дотооддоо хүнсээ үйлдвэрлэе ээ гээд ажил хийх гээд байдаг. Зээл гардаггүй. Тэгэхээр энэ дээр ямар арга хэмжээ авах юм бэ?

Гуравт өнгөрсөн жил яг мөнгөний бодлогын үндсэн чиглэл хэлэлцэх үеэр би танаас асууж байсан. Ипотекийн зээлийн хүү, зээлийн хэмжээ, барилгын үнийн талаар олон улсын найт пранк индекс болон Монголын орон сууцны үнийн өсөлтийн тухай би танаас асууж байсан. Та юу гэж хариулсан бэ гэхээр орон сууцны үнийн өсөлт хэвийн хэмжээнд байгаа. Цаашид ч хэвийн буюу одоо Төв банк хянаад явна гэж хариулсан. Энэ жил энэ Тэнхлэг зуучаас гаргасан судалгаагаар орон сууцны үнэ 19 хувь өссөн. Энэ бол инфляц чинь 14.4 гэхээр инфляцаас өндөр байгаа. Тэгээд нөгөө төлбөрийн тэнцлийн алдагдлыг бий болгоход энэ барилгын салбар ч хамгийн их нөлөөлж байна. Тэгэхээр таны өнгөрсөн хугацаанд хийсэн бодлогын тохируулгууд чинь цагаа олсон, зөв байсан гэж та бодож байна уу?

Дээрээс нь Засгийн газар маань нөгөө хөдөө орон нутаг руу шилжиж суурьшсан хүмүүст 3 хувийн ипотекийн одоо зээл олгоно оо гээд яриад байдаг би тэгээд бүр ерөөсөө ойлгохгүй. Энэ нь яг хэрэгжих юм бол хэдэн төгрөг одоо бас энүүгээр гарах юм бол? Энэнтэй холбоотой тайлбаруудыг мөн хэзээнээс авмаар байна?

Т.Аюурсайхан: Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя.

Б.Лхагвасүрэн: Ундрам гишүүний асуултад хариулъя. Тэгээд энд ерөнхийдөө блүүмбергт гарсан. Блүүмбергийн сэтгүүлчийн мэдээллээс үндэслээд энэ Монгол Улсын үнэт цаасны бондуудын өгөөжийн мөр бол гэнэт огцом ингээд хөдөлсөн, савласан байгаа. Тэр Блүүмбергийн сурвалжлагчийн мэдээлэл дотор ингээд банкнууд тодорхой хэмжээний ийм хязгаартайгаар одоо ингээд валютыг өгч байгаа нь капитал контролын хэлбэр мөн байх шиг байна гэсэн маягаар ярьсан. Тухайн нэг арилжааны банкны эдийн засагчтай ярьсан ярианыхаа тэр юуг л тавьсан байна лээ.

Энэнээс нь хамаараад Монгол Улс одоо энэ валютын орох, гарах урсгал дээрээ контрол буюу хяналт тавьж байгаа юм байна, капитал контрол тавьж байгаа юм байна гэсэн маягаар олон улсад мессеж болж очсон байх гэж бидний хувьд бол төсөөлж байгаа. Тэр утгаараа бол ерөнхийдөө одоо өгөөжийн муруй, ийм өндөр тавина гэдэг маань Монгол Улсын одоо бонд, үнэт цаасыг эзэмшиж байгаа этгээд зах дээрээ би ийм 35 хувиар хямдруулаад энийгээ зарахад бэлэн байна гэж тавьснаас л ядаж байгаа. Тэгэхээр хэрвээ худалдаж авч байгаа талаас нь одоо авна гэдэг санал ороод явах юм бол мэдээж одоо бидний таны хөндөж байгаа тэр дефолт буюу хэн ч авахгүй юм байна, угаас ингээд үнэ цэнгүй болох юм байна гэдэг зүйл бол мэдээж гарахгүй. Тэр утгаараа бол худалдаж авах саналууд орж ирээд явах юм бол эргээд хэвийн байдалд орох байх. Мэдээж Монгол Улсын хувьд ч гэсэн дээ, ийм капитал контрол гэдэг юмыг бол одоо хүртэл байдаггүй. Орж ирж байгаа валют дээр ч, ямар ч хяналт байхгүй, эргээд гарахдаа ч гэсэн

хязгаар хяналт гэдэг байдаггүй учраас бол ийм зүйл бол байхгүй. Тэгэхлээр энэ бол эргээд хэвийн байдалд орох байх гэж бидний зүгээс бол харж байгаа. Монгол Улсын валютын нөөц нийт нийлбэр дүнгээрээ 2 тэрбум 796 сая доллар гэж сая 9 сарын 30-ны манай статистик гарсан.

Тэр утгаараа бол одоо энэ маань өөрөө 4 сарын импортын хэрэгцээг хангах ийм хэмжээний нөөц гэдэг утгаараа бол ерөнхийдөө валютын нөөц бол бас тогтвортой хэмжээнд, бүр тийм аюулын түвшин хүртлээ буураагүй. Энэнээс сая 9 сард бол сүүлийн энэ оноос хойших анх удаагаа сарын дүнгээрээ нэмэгдсэн байдлаар гарсан гэдэг утгаар хандлага эргээд сайжраад явах юм бол бид ковидын өмнөх түвшин рүүгээ эргээд очих юм бол өр төлбөрийн асуудлуудыг мэдээж тодорхой хэмжээнд шийдээд явах боломжтой гэж харж байгаа.

Хүнсний импортыг хүнсийг орлуулах талаар бол Хүнс, хөдөө аж ахуйн яамтай, ялангуяа ногоо, хүнсний ногоо, тариалан эрхлэгчдэд тодорхой зээлийг бол олгосон. Тэр газар тариалангийн эрхлэгчдэд бол энэ 8 сарын байдлаар 70 тэрбум төгрөгийн зээлийг 449 ийм аж ахуйн нэгж, иргэдэд олгоод явж байгаа. Тэгэхлээр тодорхой хэмжээнд зээл гараад явж байгаа. Мэдээж зээлийн эрэлт хэрэгцээ өндөр байгаа. Тэрний нь хүссэн хэмжээнд нь бол хангаж чадахгүй зүйл байгаа. Тэгээд энийг аль болохоор нэмэгдүүлэх, хүртээмжтэй байх талаас нь тодорхой бодлогыг хэрэгжүүлэхээр бас Хүнс, хөдөө аж ахуйн яамтай хамтраад ажиллаж байгаа Төв банкны зүгээс. Өнгөрсөн онд бол үл хөдлөх хөрөнгийн үнэ 17 хувиар, энэ онд 19 хувиар ингээд өсөөд явж байгаа.

Гол нь энэ үнэ өсөхөд зардлын өртөг, өртөг зардлын нөлөө байгаа. Ялангуяа барилгын материалын үнэ өсөж ирсэн учраас одоо үнэ бол ингээд өсөөд явж байгаа гэж байгаа. Тэгэхдээ тэр Төв банкны зүгээс ч гэсэн бид нар бол ялангуяа энэ ипотекийн зээлийг бол ирэх 2023 оноос бол зогсоох гэж байгаа. Яагаад гэвэл өнөөдөр ипотекийн зээлийг ковидын хуулийн дагуу бид нар өнөөдөр олгоод явж байгаа. Олгож байгаа эх үүсвэр маань эргэн төлөлтөөсөө ингээд санхүүжигдээд явж байгаа. Энэ утгаараа бол одоо ипотекийн зээлийн хөтөлбөр маань өөрөө одоо өөрөө өөрийгөө санхүүжүүлээд ингээд явах ийм хэмжээнд бол орчихсон. Тэр утгаараа мэдээж ирэх 2023 оноос Төв банк хуулийн дагуу олгож болохгүй. Тэгэхлээр Засгийн газрын нэг агентлаг, аж ахуйн нэгжээр дамжаад энэ хөтөлбөр маань цааш хэрэгжээд явах боломжтой гэж Төв банк харж байгаа.

Б.Лхагвасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Хавдесламын Баделхан асуулт асууна.

Х.Баделхан: Баярлалаа. Яах вэ өнөөдөр дэлхий дахинд бол нөхцөл байдал маш хүнд байгаа л даа, эдийн засаг ч хүнд байгаа. Ер нь иргэдийн амьдралд ч гэсэн бараа товарын үнэ өсөөд хүнд байгаа гэдгээ ойлгож байгаа. Монголбанкнаас бол мөнгөний хатуу бодлого явуулж, бодлогын хүүгээ нэмсэн.

Арилжааны банкнууд бол зээлийн хүүг нь нэмээд одоо зээл өгч чадахгүй байгаа хүнд байдалтай байгаа гэдгийг бид нар ойлгож байгаа. Ер нь манай улс хөгжихгүй байгаа гол нэг шалтгаан бол ер нь энэ арилжааны

банкнуудын зээлийн хүү бол маш их өндөр байгаа. Яах вэ, энэ 2000 онтой харьцуулахад буусан юм байна л даа. 2000 онд зээлийн хүү нь 34 хувь байснаа, энэ онд 14 хувь хүртлээ ингээд буусан бас амжилт байгаа юм. Гэхдээ бусад улс орнуудтай харьцуулахад зээлийн хүү бол их өндөр, энэ өндөр хүүтэй зээл аваад тэгээд аж ахуй явуулаад орлого олно гэсэн байдал маш хүнд, ер нь цаашидаа эндээс гарах ямар арга байдаг юм бэ?

Ер нь жил болгон мөнгөний бодлого ярилцсан үед энэ асуудал бас яригддаг. Ер нь гаднын банк оруулж болохгүй юу. Бид нар 1990 оноос хойш ер нь зах зээлийн нээлттэй, эдийн засгийн харилцаанд шилжсэн. Одоо зах зээлийн харилцаанд шилжсэн бусад орнууд бол гаднын хүү багатай банк оруулж ирээд зээл олгож байгаа.

Нэг биш олон банк оруулж байгаа улс орнууд байна. Тийм учраас манайх яагаад ингээд гаднын банк оруулж ирж болдоггүй юм бэ. Ер нь жил болгон яригддаг, гэхдээ үр дүн гардаггүй. Энэ тал дээр Монголбанк цаашидаа ямар бодлого барьж байгаа юм бэ гэсэн нэг асуулт байна.

Хоёр дахь нь бол бид өнөөдөр валютын орлого дутаад өдөр болгон валютын ханш өсөж байгаа. Гэтэл энэ Оюутолгойн орлогын данс яагаад Монголд байдаггүй юм бэ, ер нь. Оюутолгойн орлого яагаад Монголоор дамжаад явдаггүй юм бэ. Энэ чинь бас жил болгон яриад тэгээд л шийдэгдэхгүй ингээд л яваад байгаа. Энэ чинь хамтарсан компани. Монгол орны Монгол Улсын газрын баялгаа гаргаж байгаа орсон орлого нь яагаад Монголоор дамждаггүй юм. Монгол Улс энэ компанийн дотоод үйл ажиллагаанд яагаад хяналт тавих

боломжгүй байгаа юм бэ. Энэ асуудал дээр бас нэг хариулт авмаар байна.

Гурав дахь нь бол энэ долларын хани бол өдөр болгон өсөөд байгаа. Тэгтэл банк бус санхүүгийн байгууллага Найман шарга дээр ер нь энэ ББСБ-д тэр нэг хяналт тавьдаг тийм юу байгаа юу? Ер нь өдөр болгон өөрсдөө мэдээд нэмээд хасаад явж л байгаа л даа, яах вэ. Гэхдээ тодорхой хэмжээний хяналт, тооцоо байдаг болов уу. Ер нь энэ тал дээр цаашидаа ямар бодлого барьж байгаа юм бэ? Энэ чигээрээ ер нь долларын хани өдөр болгонд өсөөд байх юм. Хэзээ хэд хүрээд тогтох юм бэ гэсэн хэдэн асуулт байна аа.

Баярлалаа.

Т.Аюурсайхан: 83 дээр
Лхагвасүрэн Ерөнхийлөгч харуулъя.

Б.Лхагвасүрэн: *Баделхан гишүүний асуултад хариулъя. Би Улсын Их Хурлаас зээлийн хүү бууруулах стратегийг баталсан байгаа. Энэ хүрээнд бол зээлийн хүүг бууруулах, ялангуяа эх үүсвэрийн хүүг бол нэлээн огцом бууруулж ингээж ирсэн. Тэр бодлогын хүч үр дүнгээр зээлийн хүү бүр жилийн 14 хувь хүртлээ бол ингээд багассан байж байсан. Тэгээд мэдээж энэ гадаад орчны таагүй нөхцөл байдалд бол эргээд одоо бодлогын хүүгээ чангаруулж, хүний нөхцөл хүндрэхээс ийм аргагүй байдалд хүрсэн учраас бол эргээд ингээд бодлогын хүүгээ чангаруулаад ингээд явж байгаа. Мэдээж одоо гадаад нөхцөл байдал хэвийн байдалд орж, дотоод эдийн засаг сэргээд эхлэх юм бол эргээд хүүн дээр бол буурах боломж нь нээлттэй байгаа.*

Гадаадын банктэй холбоотой асуудлаар бол өнөөдрийн үйлчилж байгаа Банкны тухай хуулиар бол хувийн өмчтэй гаднын арилжааны банк өөрөө Монгол Улсад бие даасан салбар байгуулах бүрэн боломжтой. Яах вэ, Банкны тухай хуулийн зохицуулалтын дагуу бол эхлээд төлөөлөгчийнхөө газрыг нээж, тодорхой хугацаа болсны дараа ингээд салбар нээгээд явдаг. Монгол Улсад бол өнөөдрийг хүртэл бол 6 банкны төлөөлөгчийн газар байсан боловч ингээд 3 нь гараад явчихлаа буцаад. Одоо өнөөдөр БНХАУ-ын 2 банкны төлөөлөгчийн газар, Японы нэг банкны төлөөлөгчийн газар л байна. Тэгэхдээ хувийн секторын банк гэдэг үүднээсээ бол одоо Японы банк нь бол мэдээж салбар нээж ажиллуулах боломж нь нээлттэй байгаа. Тэгэхдээ өнөөдрийг хүртэл бол Монгол банканд салбар нээе гэж ганц ч банк бол хандаж ирээгүй. Бидний хувьд бол хуулийнх нь дагуу, ингээд зохицуулалтынх нь дагуу ингээд шалгаад зөвшөөрөл өгөхөд бэлэн байгаа.

Хэрвээ төрийн өмчтэй банк байх юм бол мэдээж тусгай бас хуулийн зохицуулалттай. Тэр нь эхлээд мэдээж Засгийн газраас зөвшөөрлөө аваад ийм орж ирэх ийм зохицуулалт байдаг. Тэгэхлээр хувийн өмчтэй банк бол нээлттэй байгаа.

Өнөөдөр ямар нэг хувийн банк, гаднын банкны салбар, төлөөлөгчийн газар дахиж Монгол Улсад нээе гэсэн ийм л санал одоохондоо ирээгүй байна. ББСБ-ын хувьд бол Санхүүгийн зохицуулах хороо болж байгаа. Оюутолгойтой холбоотойгоор анх бол Оюутолгойн данс бол Монголын банкнууд дээр байсан. Монголын банкнуудаар дамжиж болохоор байсан. Дараа нь бол Дубайн гэрээ

гэдгээрээ энэ Монголын банкаар дамжих албагүй байдаг гэдгээрээ ингээд одоо Оюутолгойн орлого Монголын банкаар дамжихгүй байгаа. Яг тэр анхны гэрээний үед бол Английн стандарт чартер гэдэг банк бол Монголд ирж төлөөлөгчийн газраа нээгээд Монголд салбар нээх гээд ингээд байж байсан боловч энэ гэрээний дараа ийм шаардлагагүй болсон гэдгээрээ Монголоос гараад явсан.

Т.Аюурсайхан: 80 дээр Санхүүгийн зохицуулах хороо Баярсайхан дарга нэмээд хариулчих.

Д.Баярсайхан: Гишүүний асуултад тодруулъя. Яг одоогоор бол 38 ББСБ, гадаад валютын арилжааг дангаар эрхэлж байгаа. Үүний 31 нь Найман шарга дээр үйл ажиллагаа явуулж байна. Яг одоогийн хууль эрх зүйн хүрээнд бол алив ханшийг шууд хязгаарлах юм уу, тогтоох нь Санхүүгийн зохицуулах хороонд одоо байхгүй байгаа. Яг энэ мөчид одоо Улсын Их Хурал дээр банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг нэмэлт, өөрчлөлт хэлбэрээр өргөн бариад хэлэлцэх эсэх нь шийдэгдээд явж байгаа. Тэр дотор бол ажлын хэсэг байгуулагдчихсан байгаа. Энэ хүрээнд бол бид нар банк бус санхүүгийн байгууллагуудыг ээ 3 ангилаад, дээрээс нь зээлийн үйл ажиллаг явуулдаг хөрөнгө оруулалтын факторыг ингэж 3 ангилж байгаа. Гадаад валютын арилжаа эрхэлдэг банк бус санхүүгийн байгууллагуудын ББСБ гэдэг энэ гарчгийг нь аваад зүгээр валют солих цэг хэлбэрээр тусгаж өгч байгаа. Энэ валют солих цэг хэлбэрээр тусгах юм бол тодорхой хязгаарлалтуудыг тавих тодорхой бүсүүдэд ялангуяа одоо нисэх онгоцны буудал байдаг юм уу, жуулчид байдаг

юм уу, ийм байдлаар байршуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих хэлбэрээр бол зохион байгуулаад явж байгаа гэдгийг бас хэлье ээ гэж бодож байна.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Би асуулт гэхээсээ илүүтэйгээр санал хэлчихье ээ гэж бодож байна. Би Монголбанкны удирдлага бүрэн бүрэлдэхүүнээрээ ер нь огцрох болзлоо хангасан л гэж үзэж байгаа юм. Монголбанкны үндсэн чиг үүрэг юу юм бэ гэж. Мөнгөний бодлого, инфляц, валютын хани төгрөгийн ханшийн сулрал, валютын нөөц, зээлийн бодлого, гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл гээд энэ бүх үндсэн үзүүлэлтүүд ямар байгаа билээ. Тодорхой хугацаа өнгөрлөө. Монголбанкны удирдлага бол Улсын Их Хурлаас томилогддог. Тэгээд өнөөдөр манай Эдийн засгийн сайд бол хэдхэн сарын өмнө бас энэ асуудлыг хөндөж байсан. Хэрвээ энэ асуудал орж ирвэл миний хувьд хувь гишүүнийхээ хувьд 2 гараа өргөөд дэмжихэд бэлэн байна. Яагаад гэхээр та бүхний авч хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагаа энэ одоо гишүүдийн асуусан асуултад чуулганы танхимд зүгээр нэг аргалаад өнгөрөөд хариулах биш, ард иргэдийн амьдрал, энэ гадаа, тэр малчны хотонд, тэр тариаланчийн талбай дээр, тэр худалдагчийн, лангуун дээр, дугаар хорооны иргэний хашаа, айлд ярьж байгаагаас чинь эсрэгээрээ байна. Наалдахгүй байна.

Өдрөөс өдөрт бараа бүтээгдэхүүний үнэ хани чинь өсөж байна. Энэ валютын хани чинь баригдахаа болилоо. Тэгээд яах юм

гээд энэ улс орон ингээд яриад суусаар байгаад ингээд бүр дампууралд оруулах юм уу, энийг нь хүлээх юм уу? Тийм учраас хийж чадахгүй бол хийж чаддаг улсуудад нь өгөх ёстой л гэж би хувьдаа хэлж байгаа юм. Энэ хариуцлагын арга хэмжээг нь тооцох цаг нь болсон байна гэж би хувьдаа үзэж байгаа юм. Тэгээд өнөөдөр одоо Монголбанкны ханиш Найман шаргын ханиш гээд 150 төгрөгийн зөрүүтэй ханишууд үүсчихсэн. Магадгүй Монголбанкныхан өөрсдөө оролцоод, цаана нь бас энэ давхар мөнгө угаах асуудал явагддаг юм биш биз дээ. Энэ дээр тэр хууль хяналтын байгууллага, цагдаа, тагнуул, АТГ-ыг ажиллуулбал яасан юм. Ийм 30 хувийн ашигтай бизнес гэж юу байгаа юм. Монголбанкнаас доллар аваад үндсэндээ Найман шарга дээр аваачиж зараад байна шүү дээ. Тэгээд энийг мэдэж байгаа хэрнээ мэдээгүй юм шиг ингээд царайлаад суугаад ингээд валютын нөөц хомсдолд орчихсон гээд ингээд байж байдаг.

Гурав дахь санал асуулт юм даа. Нэр бүхий банкнууд IPO босгох компанийн хэлбэрт шилжих энэ асуудал ямар шатанд яваа бэ? Энэ ондоо багтаж хийгдэж дуусах уу? Энэ иргэдийн дотор бас хүлээлт байгаа юм байна лээ. Нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжих асуудал. Энэний бэлтгэл ажил хир хангагдсан бэ? Хавар орж ирээд цаг хугацаа аваад ингээд бэлтгэл хангагдаагүй байна гээд хугацаа хойшлуулж байсныг санаж байна. Одоо энэ асуудлууд ямар шатанд яваа вэ гэдэг ийм асуулт асууя?

Баярлалаа.

Т.Аюурсайхан: Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулна.

Б.Лхагвасүрэн: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Монголбанк бол одоо түрүүн би бас гишүүний асуултад хариулж байхад хэлж байсан. 7 хоногтоо 2 удаа дуудлага худалдаа хийдэг. Дуудлага худалдааны зорилго маань харилцагчийн төлбөр тооцоо, гадагшаа хийж байгаа төлбөр тооцоог л тасралтгүй хэвийн явуулах ийм зорилгоор л хийдэг. Дуудлага худалдаа маань ингээд явагдаад, бид нар бол араас нь хяналтаа тавьдаг. Монголбанкнаас авсан валютыг яг тэр харилцагчийн төлбөр тооцоонд гадагш нь одоо төлбөр тооцоондоо ашиглаад явуулж байна уу, үгүй байна уу? Хэрвээ эвгүй байвал одоо тэр валют нь үлдсэн үү, үлдээгүй юу? Хэрвээ үлдсэн бол одоо ямар хэмжээнд яаж үлдсэн гээд тэгээд өгсөн энэ бүх мэдээллээ одоо Монгол Улсад байгаа хууль хяналтын байгууллага бүгдэд нь бол өгч байгаа. Тагнуулын ерөнхий газарт өгдөг, Цагдаагийн ерөнхий газрын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх тэр албанд нь бүгдэд нь энэ мэдээллийг өгдөг. Тэр банканд ийм ханшаар ийм хэмжээний доллар нийлүүлсэн гээд. Тэгэхлээр мэдээж энэ дээр нь бол хууль хяналтын байгууллага хяналтаа тавиад явдаг байх гэж бодож байна. Тэгэхлээр бол энэ дээр ямар нэг зүйл байхгүй.

Мэдээж зарим нэг банкнууд өөрийнхөө одоо дотоод арга хэмжээнийхээ хүрээнд бол хязгаарлалтууд хийгээд явж байгаа юм байна лээ. Тэр хязгаарлалтынхаа хүрээнд бол ямар хүмүүст өгч байгаагаа бол бас тэр мөнгө угаах терроризмтой тэнцэх хуулийн дагуу ямар зорилгоор, хэн хэчнээн хэмжээний доллар авсан бэ гэдгийг бол

бас мэдээлдэг. Энэ мэдээлэл бол бас ингээд том биг дата гэдэг шиг ингээд мэдээллийг Монголбанк бас хүлээж аваад сууж байгаа. Тэгээд мэдээж хууль хяналтын байгууллага бол хэрвээ энийг ингээд шалгаад явах юм бол Монголбанкны зүгээс бүх мэдээллээр хангахад бас бэлэн байгаа.

Хоёр дахь асуудлын хувьд бол тэр банк бол түрүүчийн Төрийн банк бол IPO гээд зарлаад ингээд явж байна, амжилттай явж байгаа. Монголбанкнаас энэ ондоо багтааж IPO хийхэд бэлэн байна гэсэн өөр 2 банк бол Монголбанкаас зөвшөөрөл авсан. Голомт банк, Хаан банк. Одоо эцсийн зөвшөөрөл нь бол Санхүүгийн зохицуулах хорооноос гаргадаг учраас ингээд энэ ондоо багтаад гарах байх гэж найдаж байгаа. Өөр 2 банк бол арай хараахан хүсэлтээ ирүүлээгүй. Хас банк, Худалдаа хөгжлийн банк төв банкны зүгээс ч гэсэн энэ хөрөнгийн бирж дээр байгаа өдөр тутмын гүйлгээнийх нь тэнцвэртэй байдал, хөрөнгө босгож байгаа байдлыг нь харгалзаад, ер нь бол зөвшөөрлөө мэдээж өгнө. Тэгэхдээ энэ ондоо биш, ирэх оны эхээр зөвшөөрлөө авхуулбал хөрөнгийнхөө бирж хөрөнгө оруулагчдын худалдаж авахтай зэрэгцээд байхгүйгээр энэ байдал нь бол хангагдах байх гэдэг үүднээсээ ирэх ондоо энэ 2 банк нь гаргаад явбал илүү зохистой байх гэж харж байгаа.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар асуулт асууна.

С.Ганбаатар: Талархалтай сайн мэдээнээс эхэлье ээ. Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах энэ үндсэн чиглэл үндсэндээ бараг сурах бичиг шиг ном шиг юм орж ирсэн. Би 2 өдөр бүтэн өдөр уншлаа.

Асуудалд бол яг нарийн яривал бас хариуцлагатай ач холбогдол өгч хандаж байна гэж би үзэж байна. Урьд нь 2012-2016 онд бол зүгээр 10 хуудас цаас орж ирдэг байсан. Энэ бол сайн зүйл.

Муу зүйл нь юу вэ гэвэл доллар 3500 төгрөгт хүрчихлээ. Монголбанкны үндсэн үүрэг бол төгрөгийн худалдан авах чадварыг тогтвортой, доод түвшинд барина гэсэн үндсэн үүргээ гүйцэтгэх ёстой доллар 3500 хүрчихлээ. Энэ дээр харин ганцхан Монгол банкныг буруутгаад байж болохгүй ээ. Урд хөл бүдэрвэл хойд хөлийг гуядна аа, ташиурдана гэдэг шиг эрх баригчид хүч түрж 2 жил юу ч сонсохгүй, ямар ч ажил хэргийн дибет явуулахгүй, дандаа магтуулж, дандаа сенсацаар явсаар байгаад ийм гүн хавцалд уначихлаа. Ямар муухай магтаалд дуртай улсууд вэ? Танай дарга нар чинь. Ерөнхий сайд Оюу-Эрдэнэ энэ дээр хар толгойгоороо хариуцна. Сайд нар ч биш, бид сайд нарыг ч томилдоггүй тавьдаггүй. Оюун-Эрдэнийг бол Улсын Их Хурал тавьсан. Тэгээд энэ дээр ганцхан мөнгөний бодлого биш шүү дээ. Энэ долларын 3500 гэдэг чинь төсвийн бодлого. Та нар бодлоо сүүлийн 3 жилд 10 их наядаар төсвийн алдагдалтай баталлаа. Өнөөдөр бид өөрсдөөс нь зөвшөөрөл авахгүйгээр хойч үеэсээ мөнгийг нь дээрэмддэг улс төр, улс төрчид Улсын Их Хурал. 10 их наяд. Энэ жилийн 2.4-ийг оролцуулаад 10 их наяд, бүх гэр хорооллынхны 200 мянган айлыг орон сууцанд оруулах мөнгө.

Тэгэхлээр найр хийж байгаагаа зогсоогоод энэ асуудал дээрээ хандах цаг болсон, ашиггүй сая нэг баян баян сайд нар томиллоо, бас бэлэг дэмбэрэлтэй юм даа энэ олигарх сайд

нар Монголыг баяжуулах болов уу гэсэн сахил хүртээд шал дордов гэдэг шиг юм болчихлоо.

Миний нэгдүгээр асуулт төгрөгийн худалдан авах чадвар доройтсон, гадаад валютын төгрөгтэй харьцах хани аймшигтайгаар өсчихсөн байгаа энэ цаг үед 45 дугаар хуудсан дээр нэг зүйл бичсэн байна лээ шүү. Монголбанк бодлогын хүүгээрээ инфляцыг удирдаж боломжгүй болсноо үндсэндээ зөвшөөрсөн тийм мэдэгдэл байлаа. Би та нарт цаг бага байна, уншиж өгч болно шүү.

Бодлогын хүүгийн зохицуулалтаар инфляцыг бид одоо хязгаарлаж чадахгүй гэдгээ бичсэн байна. Тэгэхлээр тэгээд инфляцыг одоо цэгэн голчтой интервал хэлбэрээр инфляцыг сонгон авч бид ажиглана. Тогтвортой түвшинд байлгана гэж байна. 6 хувь дээр нэмэх, хасах 2 хувь. Гэтэл өнөөдөр инфляц танай энэ мэдээн дээр байгаа шүү. 16 хувь хүрчихлээ. Яаж энэ чинь 6 хувь руу оруулах гэж байгаа одоо 16 хувь байна. Бүхэл бүтэн 10 хувийг яаж та нар аргалах вэ? Ямар инфляцтай тэнцэх гаргалгаа түрүүнээс хойш яриад байна. Ерөнхий сайд, Засгийн газрын түвшинд ярих цаг болсон. Энэ аргачлалаа хэлээч.

Хоёрдугаарт, асуулт хүмүүсийн цалин хөлс та нарын бидний хамтын унхиагүй байдлаас болоод цалин тэтгэвэр 30-40 хувь, 36 хувь гээд тэр сонин дээр судлаачид бичсэн байна лээ. 30-40 хувь тэтгэврийн хүмүүсийн мөнгө карманд нь байхдаа хулгайлагдчихлаа. Цалин кармандаа байхдаа хулгайлагдчихлаа. Тэр Америкт байдаг юм даа коли кола гээд. Амьжиргааны өртөгтэй уялдуулж

цалин нэмэх асуудал биш шүү дээ, тэтгэвэр нэмэх асуудал биш. Байсан түвшинд нь хүрэх гэдэг тийм аргачлал байдаг. Энэ тухай та нар санал байгаа юу? Энэ Засгийн газар дээр холбогдох сайдууд нь энэ.

Т.Аюурсайхан: 83 дээр Монголбанк хариулъя.

Б.Лхагвасүрэн: Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Цэгэн буюу бас тодорхой коридорын хүрээнд инфляцыг зорилтот түвшинд хүрэх, энэ бол олон улсын олон төв банкнуудын авч хэрэгжүүлж байгаа, одоо яг хэрэглэж байгаа л хэрэгсэл л дээ, АНУ-ын Төв банк бол 2 хувь, Европын төв банк 2 хувь, тэгээд л Английн төв банк 2 хувь ч гэдэг юм уу, ингээд яг ингээд нэг зорилтыг бүр цэгэн нарийвчлаад аваад бидний хувьд бол мэдээж тодорхой коридор, бас уян хатан маягаар явж байгаа. Энэ бол одоо сүүлийн 30 жилийн одоо Төв банкнуудын Монгол Улсын төв банкны одоо ингээд бодлогынхоо арга хэрэгсэл, зорилгоо ингээд маш нарийлаад хөгжлийн бас тодорхой шат шатаар ингээд ахиад явсан нэг ийм арга хэмжээний үр дүн байгаа юм тэгэхлээр одоо энэнээсээ хэрвээ ингээд 6 нэмэх хасах хоёроосоо өөр болгоод өнөөдрийнхөө инфляцыг харж байгаад ирэх жил одоо дунд хугацаанд тийм байлгана гээд яах юм бол?

Ухарсан л зүйл болох юм, тэгэхлээр бид хэд аль болохоор энэ зорилгоосоо ухрахгүй 6 нэмэх хасах 2 лууг хүрэх нь тодорхой, хугацааны одоо дараа гэдгээрээ ингээд энэ бодлогоо ингээд баримтлаад явж байгаа. Тэгээд мөнгөний бодлогынхоо үндсэн чиглэл дотор бичсэн байгаа,

2023 онд бол инфляцыг нэг орон тоо тоонд оруулж, 2024 онд яг энэ зорилтот түвшиндээ хүргэнэ ээ, энэ зорилгоо барьж, мөнгөний бодлогынхоо бодлогын арга хэрэгслийг арга хэмжээг авч хэрэгжүүлээд явна гэдгээрээ л ингээд явж байгаа хэдийгээр өнөөдөр АНУ-д инфляц 9 хувь, Англид 10 хувь даваад явчихсан байгаа ч гэсэн тухайн улсын төв банкнууд бол энэ зорилгынхоо түвшинд хүргэх нь зорилгоо бол зорилго хэвээрээ хадгална, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээгээ энэнийгээ аль болохоор хурдан хүргэх ийм хэмжээнд л мөнгөний бодлогыг хатууруулна гэдгээрээ ингээд явж байгаа тэгээд АНУ-ын одоо бодлогын хүү маш богино жилийн дотор ингээд 0.25-аас 3.25 болоод, тэгээд 3 нэгж хувиар ингээд өсөөд явчихсан, маш хатуурч байна. Энэ нь өөрөө, долларыг бол маш одоо бас үнэ цэнтэй буюу бас бусад валютуудын эсрэг чангаруулж байгаа. Монгол Улсын төгрөг бол яг өнөөдрийн байдлаар бол Английн паунд, Их Британийн Паунд, одоо Солонгосын вон ч гэдэг юм уу, эд нартай адилхан 17 хувиар ингээд суларчихсан явж байна. Японы иен бол одоо нэгхэн улирлын дотор бүр 22 хувиар ингээд суларчихсан явж байгаа.

Хэдийгээр ханиш бол ингээд суларч байгаа нь худалдан авах чадвар алдаж байгаа хэдий ч гэсэн нэг талдаа, нөгөө талдаа бол макро эдийн засгийн тохиргооны одоо хэрэгсэл байдаг. Импорт бол энэ ташуур болгохоор багасгахаар импортлогч нарт бол байнга л зардал өсөж байгаа ийм зүйл учраас импортыг багасгах ийм нөлөө үзүүлнэ. Экспортлогч нарт урамшуулал болдог. Гаргасан, одоо доллар тутамд энэ ханшийн зөрүүгээрээ бол бас нэмэлт орлого олж байдаг учраас бол гадаад

худалдаандаа бол энэ өөрөө тохируулгын бас хэрэгсэл болоод явдаг. Тэгэхлээр энэ өнцгөөсөө бол мэдээж Монгол Улсын өнөөдрийн энэ байдал маань өөрөө бодлогоороо ч тэр, бас нөгөө зах зээлийнхээ тохиргоогоор орж, тэгэхээр ингээд хамтдаа ингээд хавсраад явж байгаа. Төсөвтэй холбоотой таны гаргаж байгаа саналд бол мэдээж одоо 2 бодлогын нийцтэй байдал нь үр дүнд л бол хүргэнэ. Тэгэхээр нэг талдаа ингээд тэлэлттэй юм уу, ингээд нээлттэй явах нь нөгөө талд хатуу байх юм бол хатуу мэдээж бодлогын үр дүнд нь бол мэдээж үр дүн гарахгүй байх тал руугаа байгаа.

Тэгээд мэдээж төсвийн тэлэлт бол инфляц ханиш дээр тодорхой бас дарамт авчрах нь ойлгомжтой. Яагаад гэвэл одоо хэрэглээний сагсны 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн үйлчилгээний бараа 50-иас илүү хувь нь 200-гаад нь бол одоо дандаа импортын бараа бүтээгдэхүүн байдаг. Энэ утгаар бол одоо хэрэглээн дээр очиж байгаа төгрөг тутам дээр доллар болж гарна л гэсэн зүйл байгаа. Нийт 50 хувь нь бол доллар болж гарна. Мэдээж бас хөрөнгө оруулалтын та бас яг хөндөж байгаа тэр бүтээн байгуулалт ялангуяа барилгын салбар дээр.

Т.Аюурсайхан: Ганбаатар гишүүн нэг минут өгье. Асуултаа тодруулъя.

С.Ганбаатар: Би тодруулж асуулт аваагүй зүйл нь нөгөө коли кола л гэж яриад байдаг юм даа. Тэр одоо сая төгрөгийн орлоготой хүн 300-аас 400 мянган төгрөгөө эрх баригчдын буруугаас болоод хулгайлуулаад алга болчихлоо. Би цалин нэм гэж хэлээгүй, орлого нэм гэж хэлээгүй. Энэ алга

болсон 300. 400-г хэзээ нь яаж нөхөж өгөх вэ гэж асуусан. Энэ дээр би хариулт авъя.

Хоёр дугаар миний асуулт. Тэр та нар хариулах болов уу гэж би горьдож байсан. Нөгөө мартсанаас мал мэндүү гэдэг шиг нөгөө Оюутолгойн 2 тэрбум орчим доллар манайхаар дамжиж байна уу, хэд нь дамжиж байна, яагаад дамжуулахгүй байгаа юм бэ? Энэ талаар.

Гурав дугаар миний асуулт. Энэ банкнууд чинь мөнгөө гаргах больчихлоо. Нөгөө Английн эдийн засагч хэлдэг, банк ухах, банк ажиллуулах 2 чинь ер нь адилхан юм биш үү гэж дуу алдаж байсан. Тэрэн шиг энэ ёс суртахуунгүй мөнгө гаргахгүй байгаа, ажлаа хийхгүй байгаа эх орон ч биш, энэ хүнд үед шингэний дутагдалд орчихсон, эдийн засгийг зовоож байгаа банк.

Т.Аюурсайхан: 83 дээр гүйцээж хариулъя.

Б.Лхагвасүрэн: Ганбаатар гишүүний асуултад тодруулъя.

Ерөнхийдөө ирэх ирэх оны төсөв дотор бол цалингийн тодорхой хэмжээний нэмэгдэл байгаа гэж Монголбанкны зүгээс харж байгаа. Тэгэхлээр бол тодорхой хэмжээний, бас орлогын энэ тасалдаж байгаа одоо буурч байгаа хэсэг дээр бол тодорхой хэмжээгээр нэмэгдэх юм байна гэдгээрээ харж байна. Оюутолгойн одоо орлого, ер нь бол Монголын банкаар Монгол банкаар дамждаггүй. Энэ нь өөрөө нөгөө Засгийн газартай байгуулсан гэрээгээрээ ингээд зохицуулагдаад явж байгаа гэж Монгол банкны зүгээс харж байгаа.

Оюутолгойн уурхайн бүтээн байгуулалтын хүрээнд жилдээ бол 1.4 орчим тэрбум долларын одоо урсгал зардлаа нөхөх хэмжээний доллар орж ирээд төгрөгөөр энд зарцуулагдаад явдаг. Гэхдээ ирэх онд ч гэсэн одоо 1.4-1.7 тэрбум доллар орж ирнэ гэдгээрээ төсөөллийг бид нар бол ирэх оны төсөөлөл дотор хийгээд явж байгаа.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан асуулт асууна.

Ц.Туваан: Мөнгөний бодлого орж ирсэн. Тэгээд бид хэд батлаад явдаг, тэгээд энэ дээр хэрэгждэг зүйлүүд байдаг л байх, хэрэгждэггүй зүйлүүд зөндөө байдаг. Инфляцаас авхуулаад Монгол банкиг иргэд бид бүхэн бүгдээрээ яадаг вэ гэхлээр энэ Монгол Улсын мөнгөний бодлогыг барьдаг, инфляцыг барьдаг, валютын ханшийг барьдаг, валютын нөөцийг хадгалдаг банкнууд болон пүүс компаниуд бол энэ зээлийн эх үүсвэр талд нь бол дэмжлэг үзүүлдэг. Ер нь жоохон том утгаар хэлбэл энэ юмны үнэний тогтвортой байдлыг хангадаг, ийм л одоо хэдэн функцтэй гээд боддог, горьддог. Сүүлийн үеүдэд бол энэ бодлогын хүүг нэмэгдүүлэх, заримдаа хасах гэдэг нэг ийм л зүйлээс өөр нэг их одоо бодлого бас сайн гарахгүй байгаа.

Энийг бас хэлэх ёстой байх гэж бодож байна. Инфляцыг бид нар 14, 16 гээд яриад байгаа шал худлаа. Инфляц бол зүгээр доод тал нь 20 бол гарчихсан. Авдаг юмныхаа ханшаар л бодоод үзье хэдүүлээ. Инфляц тооцож байгаа тэр сагсанд орж байгаа барааныхаа бага савласан үнэтэйнүүдийг нь түүж аваад л инфляцаа бодчихож байгаа байх.

Инфляц чинь өөрөө чимээгүй хулгайч шүү дээ. Хүний карма хотыг чимээгүй л хулгайлчихдаг. Зуухан төгрөгөөр авч чаддаг байсан юмаа бид нар 130, 140 төгрөгөөр авдаг л болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ дээр одоо бодлогоо илүү чамбайруулж барьж байгаа юу? Энэ дээр ямар одоо бодлого явах гэж байна аа? Дахиад л нөгөө 6 нэмэх, хасах хоёроо л биччихсэн байна. Валютын ханиш дээр бол тавиад тууцан. Нэг дахин сүүлийн одоо бараг багахан цөөхөн жилийн дотор нэг дахин тавиад тууцан. Энэ дээр та хэд энэ ханишийн өсөлтөө ер нь ирэх саруудад одоо нэг ирэх оны 2023 оны 1 сарын 1 гэхэд ер нь яана хэд байна гэж багцаа ер нь харж байгаа юм. Тийм төлөв байна уу. Валютын нөөцийг яг одоо хэлээдхээч, Засгийн газрын гишүүд, иргэд, албаны хүмүүс өөр өөр тоо хэлээд байгаа юм. Энийг яг эцсийн байдлаар нэг хэдэн төгрөг байгаа гадаад валютын нөөц гээд хэлээдэх.

Энэ Монголбанкны өөрийн одоо Төв банкны гадаад өр нэмэгдчихсэн. Бараг 500 орчим сая доллароор нэмэгдчихсэн. Тэгээд энэ яагаад нэмэгдэв гээд харсан чинь энэ зээлийн өсөлттэй холбоотой гээд тавьчихсан байна лээ. Би бол худлаа гэж харж байгаа юм. Зээл чинь байхгүй болоод удаж байна шүү дээ. Зээл өгөхөө болиод бүр сүүлдээ одоо энэ зээлийн хүү нэмэгдээд банк бусууд ч зээл өгөхөө больж эхэлж байна. Зарим иргэд маань ярьдаг байсан. Ялангуяа энэ одоо хөдөөгийн малчид маань ярьдаг байсан. Бид нар ер нь амьдрал хүнд байна шүү, энэ зээр зээл 2-оор л амьдарч байна гээд. Зээрийг нь одоо мэдэхгүй, зээл нь бол нүхэндээ шургаад алга болчихсон. Эдийн засгийн цусны эргэлт, энэ мөнгөний урсгал зээл чинь ерөөсөө байхгүй болчихсон.

Тэгэхээр энэ дээр ер нь ямар одоо бодлого явж байгаа юм бэ? Ингээд бодлогын хүүгээ нэмчхээд банкнууд чинь зээлээ гаргахгүй болоод банк бусууд зээлээ гаргаххаа болиод ингээд эдийн засаг чинь мөнгө эргэхээ болиод ингээд яаж өсөлт янз бүрийн юмыг харж байгаа юм бэ гэдэг асуудал. Энэ дээр нэг одоо бодлого юм хэлж өгөөч ээ. Одоо гадуур ажиллаж байгаад ядуучуудын эгнээнд орчихдог. Бизнес эрхэлж байгаад дампуурчхаж байгаа газрууд зөндөө байна шүү дээ. Энэ төв банканд хамаагүй юм уу. Хуучин энэ Ардчилсан намын үед бол явж байсан энэ инфляцыг нэг хувь руу оруулаад үнэ тогтворжуулах хөтөлбөр гээд батлаад явж байхад яаж муулж, яаж одоо ярьж байлаа. Хэдэн төсөвтэй боллоо гээд. Тэр үед чинь тэгээд л бас.

Т.Аюурсайхан: Туваан гишүүнд нэг минут өгье.

Ц.Туваан: Үр дүнд хүрч л байсан байна шүү дээ.

Хоёрдугаарт энэний дараа тэр төсөв орж ирэх байх, тэгээд төсөв дээр тэр Монголбанкнаас энэ Засгийн газартай энэ төсвөө яаж одоо хамтатгаж, яаж боловсруулж орж ирсэн юм. Энэ одоо улс орон юм чинь хүндрэл байгаа ч гэсэн энэ хүнсний хангамж гээд нэг юм байгаа юм. Хүнсний хангамж дээр 1.7 их наяд тавьчихсан байна лээ. Энэ жил нэг 220-иод тэрбум төгрөг тавьчихсан байна лээ. Энэ дээр толгойгоо ажиллуулаад засагтайгаа хамтраад энэ мөнгөн дүнг ядаж 400, 500 тэрбум руу явуулж болдоггүй юм уу? Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар гараад ирчихсэн бэлэн Их Хурал батлаад өгчихсөн юман дээр бас хамтарч ажиллаад энэ төсвийг

нэмэгдүүлэх тал дээр бас бодлого явуулж болдоггүй юм уу гэсэн нэг ийм хэдэн асуултад хариулт авъя.

Т.Аюурсайхан: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жаргалтулгын Эрдэнэбат, Чинбатын Ундром, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн багш, ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

83 дээр Лхагвасүрэн
Ерөнхийлөгч хариулна.

Б.Лхагвасүрэн: Туваан гишүүний асуултад хариулъя.

Тийм, одоо энэ инфляцын түвшнийг бол Монголбанк өөрөө тооцдоггүй, гэхдээ өөрөө зорилт болгочоод өөрөө тооцох юм бол нөгөө нийцтэй байдалтай одоо асуудалтай учраас тэгээд Үндэсний статистикийн хороо бол 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг ингээд сагс болгож аваад дундаж үнийн өөрчлөлтөөр нь ингээд гаргаад явж байгаа. Тэгэхлээр мэдээж зарим бараан дээр бол нэлээн том өөрчлөлт байгаа. Зарим бараан дээр нь бага өөрчлөлт байгаа гээд ингээд зүйлүүд байгаа. Яах вэ, тэр утгаар дундаж нь бол ингээд өнөөдөр 9 сард 13.5 гээд ингээд явж байна. Ханишийн хувьд бол мэдээж Төв банк бол одоо 1 сард хаништай тийм байна, 2023 онд тийм байна гээд хэлээд явах нь бол бас зохисгүй байдаг. Яагаад гэвэл нөгөө хүлээлт байдаг. Тэгээд хүлээлт нь өөрөө өнөөдрийн хүлээлт нь өсөх үү,

буурах уу гэдэг хүлээлтээр явдаг учраас бол одоо ингээд өсөх байх. Тэгэх байх гээд буурах байх гээд хэлчихвэл тэгээд л тэр хүлээлтээрээ ингээд яваад байдаг учраас бол ер нь бол Төв банкны зүгээс бол харж байгаа нь бол яг өнөөдрийн одоо энэ гадаад орчны нөхцөл байдлаас хамаараад бүх юмаа л тооцоо судалгаагаа хийж байгаа. Экспорт бол мэдээж нэмэх, бүрэн боломж бол байгаа.

Яагаад одоо хойд хөрш буюу ингээд хойшоо нэг зах руу гарч байгаа тэр гарч байгаа, тээвэр ложистикийн асуудал байна гэж яригдаад байгаа. Түрүүн Ганбаатар сайд бас хэлж байсан. Монгол Улсын одоо энэ уул уурхайн компаниудын хувьд бол хүчин чадалаар бүрэн зуун хувь дайчлаад ажиллах юм бол 60 сая тонн хүртэл одоо нүүрс экспортлох хүчин боломжтой гэж байгаа. Тэгэхдээ нүүрс нь бол байна, гаргаж ирэх хүчин чадал нь бол байна, урагшаа зөөгөөд гаргаж байгаа нь өнөөдөртөө бол ингээд яг өнөөдрийн байдлаар бол 18, 19 сая тоннд хүрсэн гэсэн. 2019 онд бол 36 сая тонн байсан. Тэр утгаар одоо ингээд л зөөж байгаа тээвэр ложистикийн энэ асуудал маань л өнөөдөр ийм байгаа учраас бол энэ дээрээ л асуудал байгаа. Тэгээд энэнээсээ экспортын орлого нь бол буураад явж байна.

Импорт дээрээ ч гэсэн дээ яагаад бас гадаад хүчин зүйл байна гэхлээр Орос Украйны холбоотой энэ олон улсын нөхцөл байдал нь өөрөө энерги эрчим хүчний үнэ буюу одоо энэ бензин шатахууны үнийг бол маш их өсөх 60 хувиар ингээд өсгөчихсөн. Тэгээд нэгэнт Монгол Улс өөрөө дотооддоо үйлдвэрлэдэггүй. Бүгдийг нь импортоор авдаг гэдэг утгаараа бол одоо худалдан авч байгаа импорт

маань өөрөө ингээд заавал нэмж мөнгө төлж, илүү их доллар төлж ингэж авч байгаа гэдгээрээ худалдааны төлбөрийн тэнцэл маань ингээд алдагдалтай гараад явж байгаа. Тэгээд энэ маань өөрөө нөөц дээр дарамт болж байна. Нөөц маань одоо яг 9 сарын 30-ны хамгийн сүүлийн статистикаар бол 2 тэрбум 979 сая доллар гэж гарсан. Энэ маань өөрөө Монгол Улсын өнөөдрийн ингээд нөөц байгаа. Мэдээж 2 тэрбум 797 доллар. Энэ маань өөрөө буурсаар байж байсан бол 9 сард анх удаагаа өссөн. Тэгэхлээр бол одоо саяын нүүрсний экспорттой холбоотой ч тэр нэлээн энэ байдал тогтворжиж байгаа гэж одоо эерэг талаас нь харах юм бол ямар ч байсан буурч байсан хандлага маань одоо ингээд тогтворжсон гэж хэлж болохоор. Одоо ингээд өсөлттэй гарсан. Цаашидаа энэ хандлага маань хэвээрээ үргэлжлээд байх юм бол Монгол Улсын валютын нөөц өсөөд явах боломж нь бас нээлттэй байгаа.

Зээлийн хувьд бол одоо яг энэ оны хувьд бол зээл яг сарын байдлаар 14 хувийн өсөлттэй гарсан байна, өнгөрсөн оноос хойшоо 14 хувиар өссөн. Тэгэхлээр бол зээл бол бүр зогсчихсон ингээд хаалттай зүйл бол байхгүй. Банкнууд бол тодорхой хэмжээний зээл олгоод явж байгаа. Тэгэхдээ нэгдүгээр улиралд бүр 25 хувийн өсөлттэй байсантай харьцуулах юм бол мэдээж буурсан. Энэ хэмжээгээр бол мэдээж зээлийн олголт бол буураа явж байна гэж харж болно.

Ерөнхийдөө бол одоо энэ банкны AQR хийгдсэн, одоо IPO хийгдэж байгаа гээд тэгээд энэ ондоо энэ давхацсан үйл явдалтай холбогдуулаад бол банкнууд бол зээл гаргалт дээрээ нэлээн болгоомжтой байгаа.

Тэгэхлээр энэ бол одоо ингээд хэвийн байдалд ороод явахад бол асуудал биш байх гэж харж байгаа.

Т.Аюурсайхан: Туваан гишүүнд микрофон өгье. Тодруулъя.

Ц.Туваан: 2 зүйлийг тодруулчихъя. Энэ төв банкны өр байгаа шүү дээ. Энэ дээр чинь ер нь яг одоо хугацаа юм байдаг юм уу? Тэгээд зээл нэг их нэмэгдсэн юм байхгүй ээ, нэмэгдээгүй байхад яагаад энэ чинь ингээд нэмэгдээд байгаа юм?

Хоёрдугаарт, Улсын Их Хурал шийдвэр гаргаад өгсөн. Инфляцыг чинь өдөөдөг 1, 2, 3 номерын бүтээгдэхүүн дээр чинь 500 гаран тэрбум төгрөг хууль баталж байгаад батлаад өгчихсөн. Махны үнэ, гурилын үнэ, бензиний үнэ, барилгын материалын үнэ шүү дээ. Тэгээд энд энэ нөгөө баталсан хууль дээр одоо Монголбанкнаас энэ чиглэлд тэр 500 тавиад тэрбум төгрөг ч билүү энэ дээр одоо арга хэмжээ авсан юм уу? Юм яг гарчихсан юм уу? Яг мэдээлэл байвал өгөөдхөөч. Энэ чинь инфляцыг уг нь буулгах ёстой. Тэгээд юмны үнэ нь нэмэгдээд байдаг. Та хэд бууж байна гэж яриад байдаг 2 чинь л зөрөөд байна даа. Энэ дээр хариулт авна.

Т.Аюурсайхан: 83 дээр гүйцээж хариулъя.

Б.Лхагвасүрэн: Монголбанкны гадаад өр гэдэг дээр 2 тэрбум 200 сая байгаа. 1.7 тэрбум доллар нь бол Хятадын ардын банкны своп. Энэ ингээд хойшлуулахаар ингээд яригдаад явж байгаа. Энэ бол нэлээн олон жил ингээд байж байгаа өр. Сүүлд бол таван зуун сая доллароор нэмэгдэхэд бол мэдээж Монголбанкны дансан

дээр бол зээл гэдэг бүртгэгдсэн зүйл нь бол ОУВС ч гэдэг юм уу, Азийн хөгжлийн банкнаас тодорхой энэ нөгөө төсвийн дэмжлэг маягаар тэгээд энэ нөөцийг бас тодорхой хэмжээнд дэмжлэг үзүүлэх зорилгоор орж ирсэн мөнгийг бол Засгийн газрын нэрээр орж ирж байгаа ч гэсэн ингээд Монгол банкна дээр үүрэн хэлбэрээр ингээд бүртгэгдээд явдаг. Бас алтны урьдчилгаа хэлбэрээр Монголбанк санхүүжилт өгдөг. Энүүгээр бол алтаа худалдаж аваад танайд зарна гэдгээрээ бас тодорхой багахан хэмжээний долларыг бол бас ингээд зээлээр дамжуулан олгох маягаар зээл аваад явдаг. Энэ бүртгэгдэж байгаа.

Манай арилжааны банкууд бас тодорхой хэмжээний төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр урт хугацааны.

Т.Аюурсайхан: 83 дээр 1 минутын нэмээд өгье. Гүйцээгээд хариулчих.

Б.Лхагвасүрэн: Арилжааны банкууд маань ногоон хөгжил ч гэдэг юм уу жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, бас технологийн тодорхой хэмжээний зээлүүдийг жижиг, дунд үйлдвэрт олгохоор гаднын банк санхүүгийн байгууллагаас зээл авдаг. Тэрийгээ бол Монгол банктэй своп хэлцлээр төгрөгт шилжүүлээд ингээд зээлээ олгоод явдаг. Тэр своп хэлцлээр орж ирж байгаа тэр гадаад валютын эх үүсвэр нь Монгол банкна дээр бас зээл хэлбэрээр бүртгэгддэг. Энэ нь ингээд бүгдээрээ нийлбэр дүнгээрээ, ингээд 500 сая доллар.

Үнэ тогтворжуулах хуулийн хүрээнд бол одоо Улсын Их Хурлаас хавар батлахдаа энэ ялангуяа гурил, махны энэ үнийн тогтвортой байлгах санхүүжилтийг арилжааны банкны эх

үүсвэрээр олгоно оо, энэ дээр бол Монголбанкны эх үүсвэрээр мөнгөний нийлүүлэлт хийхгүй шүү гэдгээрээ хууль батлагдсан учраас арилжааны банкнаас эх үүсвэр нь олгогдоод явж байгаа. Тодорхой хэмжээгээр бол санхүүжилт хийгдсэн. Одоо махан дээр бол 74 тэрбум төгрөгийн зээл гарсан байгаа. Хаврын нөгөө тариа хүнсний ногоо тариалалт дээр бас.

Б.Лхагвасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь асуулт асууна.

Ж.Батсуурь: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Тэгэхлээр энэ 11 сарын 15 хүртэл Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл, мөн одоо 2023 оны төсвийн талаар нэлээд ярилцах байх. Хууль нь ч угаас тийм.

Өнөөдөр одоо төрөөс мөнгөний бодлогын талаар одоо энэ чухал баримт бичиг орж ирэхэд энийг батлах гэж байгаа энэ гишүүд чинь энэ зааланд байхгүй байна шүү дээ. Ингээд хоосон танхимд яриад ямар хүмүүсээр батлуулах юм бэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт батлагдлаа гэх гээд энэ чинь 2023 оныхоо төсөвтэй уялдаж байгаа юм уу? Жишээ нь энэ та бүхний оруулж байгаа энэ батлуулах гэж байгаа мөнгөний бодлого дээр инфляцыг 6 нэмэх, хасах 2 болгоно гэж байгаа юм. Барах юм уу, барахгүй бол яах юм? Одоогийн байдлаар инфляцын түвшин 14.4 байна гэсэн статистикийг та бүхэн бид нарт ирүүлсэн. Тэгэхлээр эдийн засаг хүнд байна, нөхцөл байдал, валютын нөөц, гадаад дотоод нөхцөл гэж ингэж ярьж байж энэ одоо инфляцын түвшинг 6 хувь руу оруулж

чадах юм уу? Чадахгүй бол Монголбанк яах юм? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт та бүхэн энэ мөнгөний бодлогодоо мөнгөний хатуу бодлогыг хэрэгжүүлнэ, ингээж байж эдийн засгийг сэргээнэ гэсэн байгаа юм. Нэгдүгээрт, хатуу бодлогодоо долларын ханшийг яг хэдээр барина гэж тооцож байгаа юм яг одоо ирэх он жилд яг хэдээр барих юм?

Хэрвээ долларын ханшаа алдаад инфляцын түвшинээ алдвал төсөв тодотгох уу? 2023 оны төсвийг та бүхэн тодотгоно гэж бодож байна уу? Тодотгохгүй гэж бодож байна уу? Тодотговол хэд тодотгоно гэж бодож байна? Мөнгөний бодлогын хатуу бодлогыг хэрэгжүүлнэ гэж сая Монголбанкны Ерөнхийлөгч хэлж байна. Хэрвээ хатуу бодлого хэрэгжүүлэе гэж байгаа бол төсвийг алдагдалгүй батлах ёстой биз дээ? Тэгэхэд орж ирж байгаа төсөв 1.5 их наядын алдагдалтай орж ирж байгаа юм. Ингээд жил болгон 1-2 их наядын алдагдалтай төсөв батлаад байхлаар нөгөө Монгол Улсын өр чинь улам л нэмэгдээд байхгүй юу? Энэний зөрүүг хаанаас нөхөх вэ? Хэрвээ инфляцын түвшингээ барьж чадахгүй долларын ханш алдвал энэ алдагдал ихсэх үү, багасах уу? Тийм болохоор Монголбанкны барьж байгаа бодлого чинь төсвийн бодлоготойгоо оруулж ирж байгаа бодлоготойгоо уялдахгүй байгаа юм биш үү? Хэрвээ уялдахгүй бол одоо ямар сайн бөгөөд муу үр дүн хүлээж байгаа вэ гэсэн ийм тодорхой хэдэн асуултад хариулт аваад тэгээд би дараа нь тодруулъя гэж бодож байна. Баярлалаа.

Т.Аюурсайхан: 83 дээр Монголбанк хариулъя.

Б.Лхагвасүрэн: Батсуурь гишүүний асуултад хариулъя. Тийм инфляцын түвшинг 6 нэмэх, хасах 2 хувь гэдэг бол нэлээн бас л хэцүү, төвөгтэй зорилт. Тэгэхдээ эцсийн эцэст бол ийм л зорилгыг л зорьж явж байж л Монголбанкны үйл ажиллагаа үр дүнтэй болно. Тэгэхлээр бол одоо чадахгүй юм байна гээд арай өөртөө тавьдаг амархан тоо тавьдаг, тийм байвал одоо мөнгөний бодлогын өөрийнх нь үнэ цэн, нэр хүндийн асуудал хүртэл яригдах учраас бол бидний хувьд бол одоо 2023 онд нэг оронтой тоонд оруулна, 2024 онд яг 6 нэмэх, хасах 2 гэдэг зорилтын түвшиндээ хүргэнэ ээ гэж нэлээн ийм нарийн тодорхой тусгаж оруулсан байгаа.

Тэгэхлээр бол ирэх онд бол инфляц бол нэг оронтой тооны орчинд байлгаад тогтворжуулаад, 2024 онд бол яг нэмэх, хасах 2-той 6 гэдэг ийм цэгийн оношилсон түвшиндээ хүргэж чадна гэж тооцоо судалгаагаа хийсэн. Мэдээж тооцоо судалгаа хийхдээ бол зөвхөн өөрсдийнхөө мөнгөний бодлого, өөрсдийнхөө тоон дээр хийхгүй. Төсөв ямар хэмжээнд тэлж явах юм. Төсвийн орлого нь хэр хэмжээнд байх юм. Зарлага нь хэр хэмжээнд байх юм. Энэ нь өөрөө төсөв өөрийнхөө бодлогоор дамжаад эдийн засаг дээр хэр одоо тэлэлт авчрах юм. Ханш дээр ямар дарамт учруулах юм. Инфляц дээр бас ямар хэмжээнд одоо хөөрөгдөх ч гэдэг юм уу, ямар зүйл болох вэ гэдгээрээ л бүх тооцоо судалгаагаа хийж байгаа. Тэгээд яг л одоо бидний хувьд бол мэдээж төсвийн одоо энэ нарийн тоо боловсруулж байгаа үед нь бол энийг авч чадахгүй учраас бол одоо Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль энэ бүх хуулийн

хүрээнд бүх параметруудээ үзэж байгаад энэ хэмжээнд төсөв бол тэлэлттэй гарч магадгүй юм байна. Энэ хэмжээний ийм төсвийн одоо тэлэлтээр дамжиж эдийн засаг руу мөнгө ороход ийм хэмжээний бодлого барьж байж л одоо бидний инфляцын түвшингийн зорилт хангагдах юм байна гэдгээрээ л тооцоо судалгаагаа хийж байгаа. Тэгээд ямар ч байсан төсвийн алдагдлыг бол одоо таны хэлж байгаа хэмжээнд 2.5 хувийн ийм алдагдалтай байх болов уу.

Энэ хэмжээнд л гэж тооцоо судалгаагаа хийсэн. Тэгэхлээр бол мөнгөний бодлого тэгээд л ингээд хатуурч байгаа. Хэрвээ төсвийн бодлого өөрөө хатуу байсан бол, мэдээж мөнгөний бодлогод бол тодорхой орон зай гарах учраас бол хатуу бодлого маань ч гэсэн өөрөө бас тогтвортой маягийн, эс үгүй бол арай зөөлхөн, ялангуяа зээл, санхүүгийн салбараар дамжаад бодит эдийн засаг руугаа зээл хэлбэрээр гарах хэлбэр лүү нь илүү бас нийлүүлэлт шинжтэй нөлөө үзүүлэхээр ингэж бодлого бол бас гарах л боломж нь байгаа. Тэгэхдээ мэдээж гадаад нөхцөл байдал, энэ Орос, Украйны олон улсын нөхцөл байдал, бас одоо 0 ковид гээд энэ нөхцөл байдал хэзээ хил нээгдэх нь тодорхойгүй байгаа энэ үед бол бүх л юм муугаар нь төсөөлж, тэгээд энэ хатуу бодлогыг л оруулж ирсэн. Тэгээд хатуу бодлого маань өөрөө мэдээж санхүүгийн салбараар дамжаад зээл олголт дээр нэлээн бас саармагжуулах зүйл гарна. Хүүгээрээ дамжаад зардлыг нь өсгөхөөр бас нэлээн зүйлүүд л мэдээж түвэгтэй зүйлүүд гарах учраас гэхдээ энэ нь өөрөө эргээд макро эдийн засгийн тогтвортой байдал, инфляцыг богино хугацаанд зорилтын түвшинд оруулахаар л ийм зүйл болно оо л гэж

өнцгөөсөө энэ мөнгөний бодлогыг боловсруулсан байгаа.

Ирэх оны төсөв тодотгох уу гэдэг дээр бол одоо Төв банкны зүгээс бол мэдээж шууд хэлэхэд бол хэцүү. Энэ төсөв бол одоо Сангийн яам боловсруулаад өргөн бариад Улсын Их Хурал батлаад явах учраас зүгээр ирэх оны төсвийн орлого тал нь өөрөө хэр байх вэ? Орлого нь үнэхээр энэ төсөөлсөн хэмжээгээр орж ирэх юм бол мэдээж тодотгох зүйл гарахгүй байх боломжтой. Хэрвээ орлого өөрөө тодорхой хэмжээгээр тасалдах юм бол мэдээж тодотгохоос өөр аргагүй болох байх л гэж бодож байна. Төсвийн алдагдлыг нөхөхийн тулд мэдээж Засгийн газар дотооддоо юм уу, гадагшаа үнэт цаас гаргаж, хаа нэг газраас санхүүжилт авч л нөхөх болно. Тэгэхлээр бол мэдээж гадагшаа бонд босгох уу, эс үгүй бол дотоодоосоо үнэт цаас гаргаж өгөх үү гэдэг нь бол бас Засгийн газар тодорхой шийдлээ оруулж ирэх байх.

Т.Аюурсайхан: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболорын урилгаар БНСУ-ын Кёнгэ аймгийн Гуанжу хот, Ханам хотын худалдаа аж үйлдвэрийн тэргүүлэгч тэргүүтэй төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцуулж байна. Танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Батсуурь гишүүн тодруулна.

Ж.Батсуурь: Тэгээд тодруулъя, үгүй ээ, дуусаагүй асуугаагүй эхлэн долларын ханиш сонссон чинь ганцхан тоо тэгээд л асуу дор ханшийг яг хэдэн

төрөх юм Үгүй ээ, үгүй эхнийхээ асуултыг авч байж л хариулах ёстой л доо тэгэхлээр нөхцөл байдал бол энэ төсвийн бодлого, мөнгөний бодлого, төсвийн бодлого 2 чинь цогц бодлого байх ёстой шүү дээ. Ерөөсөө нэг зоосны 2 тал, тэгээд мөнгөний бодлого нь болонгуут хатуу бодлого явуулна. Одоо инфляцыг нэг оронтой тоо буюу 6 дугаар байр нь долларын ханиш та хэлсэнгүй. Одоо энэ асуулт дээр хэлэх ёстой байх. Монголын ард түмний өмнө.

Т.Аюурсайхан: 83 дугаар микрофон өгөөрэй. Яагаад тасарчхав. Батсуурь гишүүнд Монголбанкны бодлого, төсвийн бодлого 2 бол цогц бодлого байх ёстой. Монголбанкны оруулж ирж байгаа мөнгөний бодлого дээр инфляц нэг оронтой тоонд барина, долларын ханишийг хэлсэнгүй, долларын ханишийг одоо та хэлэх ёстой, 23 онд одоо Монголын ард түмэн яг долларын хэд гэдэг тоон дээр дээд хязгаараар байх вэ гэдгээ бид нар мэдэх ёстой. Гэтэл та бүхний оруулж батлуулчих гэж байгаа мөнгөний бодлогын чинь эсрэг төсөл, төсвийн төсөл өргөн баригдчихаад байна шүү дээ. Хатуу бодлого явуулна гэдэг чинь та бүхэн одоо бодлогын хүүгээ бууруулна гэсэн үг. Бодлогын хүү бууруулахаар эдийн засаг царцана гэсэн үг арилжааны банкууд зээл олгох боломжгүй. Зээл олгохгүй болгонгуут хүмүүс хадгаламж татна, ингээд одоо нөгөө үхлийн гурвалжин гэдэг шиг эдийн засаг зарцана, эдийн засаг зарцаад ирэхлээр татвар төлөх аж ахуйн нэгж байхгүй болоод ирнэ, татвар төлөх аж ахуйн нэгж байхгүй болоод ирэхлээр орлого гарахгүй бол орлого орохгүй болгодгоор төсвийн алдагдал чинь улам нэмэгдэнэ.

Ингээд хэлэнгүүт инфляц чинь нэг оронтой тоонд орж чадахгүй ээ, долларын ханиш алдана аа, ингэхлээр хэдийгээр бид нар ингэж төсөөлж байна гэсэн байдлаар асуудалд хандах биш Монголын ард түмний хувь заяаг шийдэх гэж байгаа. Ирэх оны төсөвт бодит тоонуудыг бодит ханишийг бодит инфляцыг бодит төсвийг оруулах тал дээр хатуу, бодлогоо хэрэгжүүлээч ээ, та нар бодлогоо батлуулна гээд байж байхад батлах Их Хурлын гишүүд чинь энэ танхимд байхгүй байна. Жаран хоёрын бүлгээс чинь тав гаруйхан хүн байна. Нэг хоёрхон хүн байна. Баталсан хойно нь хэрэгжүүлэгч Засгийн газраас чинь нэг ширхэг ч юм байхгүй байна. Ингэхлээр ирэх онд ер нь одоо Монголын эдийн засаг ямар байх төлөвтэй байна вэ гэдгийг Монголбанк өөрөө харж чадахгүй байгаа юм биш үү? Та нарын үгийг сонсохгүй гээд байгаа юм биш үү? Та нарын үгийг сонсохгүй бол инфляц 2 оронтой тоо.

Т.Аюурсайхан: 83 дээр хариулъя.

Б.Лхагвасүрэн: Батсуурь гишүүний асуултад тодруулж хариулъя. Тийм ханишийн хувьд бол ерөнхийдөө ханишийг Төв банк бол одоо ингээд хүлээлтийг удирддаг гэдэг утгаар зарлаад явах юм бол тэр одоо 2023 оны эцэст ч юм уу, 2023 оны дунд 2023 оны эхэнд ч гэдэг юм уу, ийм байна гээд хэлэх юм бол өнөөдөр, маргааш, өнөөдөр ингээд л энэ хэлсний дараа шууд гараад л тэр ханиш руугаа шууд тэмүүлээд явдаг тийм олон улсын өмнө нь байсан туршлага юмнууд байгаа учраас Төв банк бол хэзээ ч одоо тэгээд бид нар тийм байна гэж хүлээж шууд зарладаггүй. Тэр утгаараа бол ханиш бол өөрөө бас гадаад худалдааны тэнцэл, төлбөрийн

тэнцлийн л одоо тусгал. Одоо үнэ үнэ үнэ гэх юм уу? Тэгэхлээр хэрвээ Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл ашигтай гараад л, төлбөрийн тэнцэл ашигтай гараад л. Ингээд явах юм бол төгрөг бол ингээд л чангараад л явах боломжтой. Манай өмнөх жилүүдийн туршилагуудад ч гэсэн тийм юм гарч байсан төгрөг бол бас огцом чангарч байсан үе байна.

Т.Аюурсайхан: Батсуурь гишүүнд нэг минут нэмж өгье. Монголбанк нь өөрөө одоо валютын ханшийнхаа баримжааг нууж болохгүй л дээ. Жишээ нь улсын төсвийг тооцоход гаднаас орж ирэх барааг гадагшаа гарах барааг үгүй бол цементийн үнийг ч гэдэг юм уу, арматурын үнийг ч гэдэг юм уу ойролцоогоор ойролцоогоор валютын ханшийг төд байна гэж нэг ийм төсөв гарсан байгаа шүү дээ. Тэр ханшийг асуугаад байгаа юм. Тэр ханшийн асуудал тэрнээс мэдээж хани чангарвал сайжраад л явах байх, төсвийн алдагдалтай болоод хөрөнгө оруулалтын тооцоонууд бүгд нураад л явах байх. Тэгэхлээр би таныг юу гэдэг юм ирэх оны төсвийг бодсон аргачлалд аргачлал долларын ханшийг хэдээр тооцож одоо энэ аргачлал хийгдсэн бэ гэсэн асуултыг асуугаад байгаа юм.

Т.Аюурсайхан: 83 гүйцээгээд хариулчихъя. 1 минут.

Б.Лхагвасүрэн: Төв банкны зүгээс бол одоо ингээд ер нь онолынхоо хувьд одоо инфляц ямар байна, хани суларна гэдэг нь хоорондоо яг л энэ инфляц, хани 2 бол төслүүд их явдаг л даа. Тэгэхлээр бол одоо бодит утгаар төгрөг өөрөө чанга байна уу, нэрлэсэн утгаар чанга байна уу гэдэг нь бол одоо инфляцынх хаана нь байна гэдгээсээ л хамаарч байгаа юм. Тэгээд

манай бас худалдааны түншүүдийн нөлөөлөл эд нар ордог. Тэгэхээр бидний хувьд мэдээж инфляцынхаа түвшинээс илүү гарч сулрахгүй байх. Мэдээж төгрөг өөрөө одоо бидний ирэх онд инфляцынх нэг оронтой түвшиндээ оруулаад ирнэ гэж харж байгаа өнцгөөрөө харах юм бол мэдээж гял төс янз янзаар л тооцоо судалгаа хийж болно. Бидний хувьд бол яг өргөн барьсан төсвийнхөө бүх нарийн тоог Монголбанканд бол өгөөгүй байгаа. Тэгээд бидний хувьд бол одоо ингээд аваад тэр ямар суурь төсөөлөл нь яаж гарсныг бол бас тэндээс хараад хэлж болох боломжтой. Тэгээд яах вэ Монголд одоо 13 цаг болсон байна.

Үдээс өмнөх нэгдсэн хуралдааныг завсарлуулж байна.

ЗАВСАРЛАГА

10.15 цаг

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 06-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Одоо Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч байгаа. Ажлын хэсгийг оруулъя. Ажлын хэсэг орно. Дараа нь Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн асуулт асууна. Цэрэнпунцаг гишүүн сая уулзалтад хамт байж байгаад одоо орж ирнэ. Үг хэлнэ. Яараад яах вэ гэж. Ажлын хэсгийг оруулъя. Монголбанк, Монголбанкны Ерөнхийлөгч яагаад 2 цагт байхгүй хүлээлгээд байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууна.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Өнөөдөр инфляц 14 хувьтай гэсэн мэдээ байгаа. Тэгээд мөнгөний бодлогын зорилтод бол нэг орон тоо руу оруулна гэсэн том зорилт байгаа. Энэ 14.4 хувь руу оруулахад нөлөөлсөн гол зүйл бол дайн байлдаан, цар тахал гэсэн ийм хүчин зүйлүүд гол нөлөө үзүүлж байна. Хил, гааль, тэгээд ирэх 2023 онд өнөөдрийн энэ хүнд байдал оруулсан нөхцөл байдал арилна гэдэг дээр бид нар өнөөдөр хэн ч хэлж мэдэхгүй ийм л нөхцөлд ажиллаж, амьдарч байгаа. Тэгэхээр байдал энэнээсээ дээрдэхгүй байвал энэ мөнгөний бодлого цаашидаа ер нь яг ямархуу байдалтай байх юм бэ? Энэ нөөц төлөвлөгөө “Б” хувилбар гэж байгаа юу гэж нэгдүгээрт асуумаар байгаа юм.

Хоёрдугаарт би нэг тодорхой асуултууд асууна. Тэгээд та бол энэ дээр нэлээн тийм тодорхой хариулаарай гэж хэлэх байна. Яагаад гэвэл таны хэлсэн ярьсан зүйлүүд иргэд олон нийтээс их асуугддаг ийм зүйлүүд бас байгаа юм.

Нэгдүгээрт, дотоодын аж ахуй нэгжүүд томоохон мега

төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрүүдийг өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкнууд гаргаж чадахгүй байна. Тийм ч учраас Монгол Улс Хөгжлийн банк гэж улс төр банкгийг байгуулаад гадна дотноос оруулсан бондоо тийш нь оруулаад томоохон төслүүдийг хэрэгжүүлэх гэж үзээд өнөөдөр ямархуу байдалтай байгаа билээ. Улс орноороо хэцүү байдалд орж байгаа юм. Тэгэхээр яг энэ мега төслүүдийг хэрэгжүүлэх боломжтой томоохон гаднын банкнуудыг оруулж ирэх бололцоо ер нь байгаа юу?

2023 оны төлөвлөгөөнд энэ талын ямар зүйл заалтууд байгаа вэ? Ер нь алсын хараа ямар чигтэй байгаа вэ гэдэг нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт, ипотекийн зээл ирэх жил бол мөнгөний бодлогыг улам чангална ингээд банкнаас зээл гарах хумигдана гэсэн ийм л дүр зураг анзаарагдаж байгаа. Гэтэл орон нутагт ажиллах залуучуудад ипотекийн зээлийн 6 хувийг 3 хувь болгоно. Урьдчилгаа 30 хувийнх нь жаран хувийг нь төр хариуцна гэсэн ийм зүйл байгаа. Орон нутагт бол энэ нэлээн хүлээлттэй байгаа ийм зүйл.

Дараагийнх нь Монголбанкны зээлийн мэдээллийн сан гэж нэг айхтар юм байгаа юм. Тэнд тухайн хүн бизнесийн асуудлаас болоод хар жагсаалт гэж яриад байдаг тэрэнд ороход бол бараг насан туршид арилдаггүй, тэр хүнд бизнесийн асар их дарамтыг учруулдаг, саад учруулдаг, тэгээд энэ жагсаалтыг бас зээлийн хэмжээ, түүх юмнаас нь шалтгаалаад тодорхой хэмжээнд арилдаг, хугацаатай байлгах тийм бололцоо байна уу, үгүй юу? Тэгээд энэ

чинь их хэцүү юм байна лээ шүү. Сум хөгжүүлэх сан, жижиг дунд бизнесийг дэмжих сан гээд улсын хэмжээнд 300-аад тэрбум төгрөг тарчихсан. Энийгээ хамж авахад зээлийн мэдээллийн сан дээр ямар ч тэмдэглэл байдаггүй. Гэтэл зүгээр үүрэн холбооныхоо төлбөрийг төлөөгүй хүний мэдээлэл энэ дээр ирээд тэр хүнд тээг учруулаад байдаг.

Тэгэхээр Монголбанкны энэ явуулж байгаа үйл ажиллагаа яг энэ хар жагсаалттай холбоотой юман дээр эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлүүдэд бас нэг жоохон уян хатан болгох бололцоо байна уу, үгүй юу? гэж бас асууж байгаа юм.

Дараагийнх нь, иргэдээс маш их асуугаад байдаг нэг зүйл бол энэ зээлийн хураамж гэж нэг зүйл. Зээлийн хураамж олон улсын жишигт байдаг л гээд байдаг. Олон улсын жишиг гээд бас жоохон судлаад үзэхээр зээлийн хүү багатай байдаг улсуудад бол зээлийн хураамж бас байдаг юм байна. Манайх шиг ийм өндөр зээлийн хүүтэй, хадгаламжийн хүү ч бас өндөр явдаг байх. Ийм улсуудад зээлийн хураамж гэж байх уу? Энэ банкнаас гаргаж байгаа үйл ажиллагааны зардал бүгд хүүндээ шингээд явж болдоггүй юм уу? Тэтгэврийн хөгшин зээл авсан ч нэг хувийг нь шууд хураагаад авчихдаг ийм зүйлийг Монголбанк ер нь дэмжиж байгаа юу? Энийг зогсоох ямар нэгэн зүйл байна уу, үгүй юу?

Дараагийнх нь энэ ББСБ-тай холбоотой арилжааны банкнууд зээл гаргахгүй хэрнээ ямар нэгэн байдлаар доороо ББСБ-тай болдог. Тэндээсээ зээлээ гаргадаг гэдэг ийм хардлага бизнес эрхлэгчдийн дунд маш их байна.../минут дуусав/

Г.Занданшатар: 83.
Монголбанк.

Б.Лхагвасүрэн: Идэрбат гишүүний асуултад хариулъя.Инфляц өнөөдөр 8 сард 14.4, 9 сард 13.5 ч юм уу доошоо ороод, тэгэхдээ энэ бол өөрөө Монголбанкны зорилтот түвшнээс их өндөр байгаа. Тэгэхдээ энэ инфляцын хамгийн гол хэсэг тэр 60-70 хувь нь одоо гадаадаас орж ирж байгаа бараа бүтээгдэхүүний инфляц, тэрийг наашаа тээвэрлэж авчирч байгаа тээврийн зардлын өсөлтөөрөө тодорхойлогдож байгаа. Тэгэхлээр хэрвээ энэ инфляц доошоо орохгүй бол яах вэ? Энэ нөлөөнүүд нь хэвээрээ байвал яах вэ? гэдэг асуулт нь болохоор ерөнхийдөө дэлхийн ихэнх улсууд ер нь өөрийн энэ инфляц бол дээд түвшиндээ хүрч байна. 9 хувь, 10 хувьд оччихсон. Энэнээс нь саармагжиж байна. Цааш өсөж байгаа нь эргээд буурах ийм хандлага байна. Тэгэхээр энэнээс цааш тэр импортын бидний авч байгаа бараа бүтээгдэхүүн цаашаа нэмэгдэх тэр боломж нь бол бас байхгүй болж байна уу гэдэг ийм төсөөлөл бас байна. Нэгдүгээрт,

Хоёрдугаарт, нөгөө тээврийн зардал маань өөрөө КОВИД-ын өмнөхөөсөө 6 дахин өсөөд нэг контейнер 2000 доллароор ирдэг. Монголд ирдэг контейнер өөрөө 12000 доллар болчихоод одоо эргээд 7000, 8000 доллар болж бууж байгаа юм. Тэгэхлээр мэдээж энэ хандлагаар буугаад яваад байх юм бол хуучин КОВИД-ын өмнөх буюу тэр 2000 долларынхоо түвшинд оччихвол манай энэ инфляц дотор байгаа тэр том тээврийн зардал нь бас агшаад алга болох боломжтой.

Нөгөө талаар бас мөнгөний бодлого ингээд хатуураад явахлаар эдийн засаг дээр байгаа эрэлтийг дарж өгч байгаа. 100 бүтээгдэхүүн хийдэг газар 200 хийнэ, 150-ийг хийнэ гэж томрох гэж байх, одоо тэр хүсэлтийг нь 100-гаар л байсан нь зөв гэдгээрээ дарж өгч байгаа нь өөрөө эргээд цаашаа эрэлтээрээ өдөөгдөх тэр хэсгийг нь дараад өгчхөж байгаа юм. Тэр утгаар инфляцыг бол доош нь бууруулах боломж байна гэж Төв банкны зүгээс хараад тэгээд 2023 онд нэг оронтой тоонд нь оруулж чадаад 2024 онд бол 6 хувийнх зорилт түвшинд хүргэнэ гэж төсөөлж байгаа.

2 дахь асуултын хувьд бол мэдээж Монгол Улсад бол Засгийн газрын шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд ч тэр өшөө ингээд томоохон төсөл хөтөлбөрүүд хэрэгжихдээ дандаа дотоодоосоо санхүүжигдээд яваад байгаа арилжааны банкнуудаас санхүүжүүлэх юм уу, эс үгүй бол улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэсгээр санхүүжигдээд, зарим нь бол энэ улсын үйлдвэрийн газрууд өөрсдийнхөө экспортын орлогоор санхүүжигдээд явахлаар манай Монголын дотоод дахь төлбөрийн тэнцэл, худалдааны тэнцэл, дээр нь энэ нөөц дээр дарамт түлчхаж байгаа юм. Яагаад гэвэл мөнгө нь орж ирэхгүй зөрөөд бартер маягийн бараа орж ирээд байхаар импорт нь томроод байдаг, экспортынх нь орлого нь орж ирэхгүй, бэлэн мөнгөөр орж ирэхгүй болохоор ийм асуудал үүсэж байгаа учраас энэ томоохон төсөл хөтөлбөрүүдийг аль болохоор төслийн санхүүжилт маягаар гадаад улс орнуудад хэрэгждэг, угаасаа гадна талд хөрөнгөө босгоод ирж бариад төсөл, дэд бүтцээ байгуулчихаад бид бүтцийнхээ, дараа нь орох орлогоор нь

хөрөнгө оруулалт нөхөж, санхүүжүүлээд төлбөрөө төлөөд явдаг, энд олон улсад байдаг тэр сайн жишгийг нь л авчирч өгвөл зөв гэж хараад, тэгэхгүй бол өнөөдөр манай эдийн засаг өөрөө энэ томоохон бүтээн байгуулалт өөрөө дийлж санхүүжүүлж чадахгүй. Өнөөдрийн энэ төвөгтэй байдал маань ерөнхийдөө бас энэнтэй холбоотой байна гэж Төв банкны зүгээс харж байгаа. Мэдээж зөвхөн гаднаас мөнгө босгох битгий хэл гаднын арилжааны банкнууд ирээд манайд үйл ажиллагаа явуулбал мэдээж бас сайн.

Өнөөдөр 12 дотоодын банк үйл ажиллагаа явуулж байна. Бүгдээрээ Монголын банкнууд, гаднын банк нэг ч байхгүй. Тэгэхлээр өрсөлдөөн бий болгох талаас ч гэсэн сайн. Тэгээд Төв банкны тухай хуулиар бол ерөнхийдөө нээлттэй. Хувийн арилжааны банк бол орж ирж болно. Өмнө нь ч гэсэн Монголд бас тодорхой ганц нэг тооны арилжааны банк ажиллаж байсан түүх бас туршилага байгаа. Оросын банк бол ирээд үйл ажиллагаа явуулж байсан салбар нь тэгэхлээр Төв банкны зүгээс бол хориглоод оруулахгүй гээд хориглож байгаа зүйл саад болж байгаа зүйл байхгүй. Гол нь одоо тэндээс бол эрэлт хэрэгцээ, хүсэлтээ тавьсан зүйл байхгүй байгаа юм. Өнөөдөр.../минут дуусав/

Г.Занданшатар: Зочид танилцуулъя Үндэсний Батлан Хамгаалахын Их сургуулийн Гадаад харилцааны сургалтын төвийн багш, ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлага, хөдөлмөрийн өндөр амжилт, сайн сайхныг Улсын Их Хурлын гишүүдийн нэр өмнөөс хүсэн ерөөе.

Цагаанхүүгийн Идэрбат
гишүүн тодруулж асууна. 1 минут.

Ц.Идэрбат: Би 5 асуултынхаа 2-ыг авлаа. Тэгээд хугацаа бас хүрэхгүй байх шиг байна. Тэгэхээр та үлдсэн 3 асуултад нь хариулаад өгөөч ээ л гэж.

Г.Занданшатар: Лхагвасүрэн Ерөнхийлөгч товч, тодорхой асуултуудад бүрэн хариулъя. 83.

Б.Лхагвасүрэн: Засгийн газрын шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Улаанбаатар, орон нутгийн хоорондох ялгааг арилгах үүднээсээ орон нутагт ипотекийн зээлийг арай хөнгөлөлттэй хэлбэрээр олгохоор тодорхой төсөл явж байгаа юм байна лээ. Тэр нь болохлоор 6 хувийн ипотекийн зээлийг орон нутагт 3 хувиар гаргах, 3 жилийн хугацаатай гаргах, тэгэхлээр 3 хувийн 6 хувийн хүүгийн хөнгөлөлт нь 3 хувь байна. Тэгэхлээр эхний 3 жилдээ 3 хувиар очиж болно гээд. Урьдчилгаа төлбөр нь 30 хувь байгааг, 10 хувийг нь зээлийн батлан даалтын сангаар гаргуулаад 20 хувиар байхаар ийм хөнгөлөлттэй зээлийн төсөл явж байгаа. Энэний тооцоо судалгааг нь хийх юм бол орон нутагт байгаа орон сууцны хэмжээг 2 дахин нэмэгдсэн гэдгээр нь арай томруулж аваад үзэхэд улсын төсөв дээр 5 жилийн хугацаанд 80-аад тэрбум төгрөгийн л хүүний татаасын ийм зарлага байхаар тооцоо байгаа юм.

Тэгэхлээр энэ бол өөрөө ажиллаж болохоор, ялангуяа орон нутагт ипотекийн зээл илүү хотоос илүү нөхцөлтэйгөөр байхад энэ боломж нь тэнд гарахаар ийм... /минут дуусав/

Г.Занданшатар:
Цагаанхүүгийн Идэрбат гишүүн тодруулж асууя. 1 минут.

Ц.Идэрбат: Надад тэр ББСБ гэж яригдаад байгаа шүү дээ. Дараагийнх нь тэр зээлийн мэдээллийн сан гэж. Би тэрэн дээр бүр яриад байгаа шүү дээ. Үүрэн холбооны утасны төлбөрөө төлөөгүй хэрэглэгчийг ороод байгаа хэрнээ сум хөгжүүлэх сангаас зээл аваад алга болчихсон нөхдүүдийн мэдээлэл тэр дээр байхгүйгээс болоод улсын хэмжээнд 300-гаад тэрбум төгрөг очоод үнэхээр юм хийх хүн нь зээлээ авъя гэхээр эхний авсан хүмүүс нь төлөхгүй байдаг, тэр хүмүүсийг төлүүлэх хөшүүрэг бол ердөө дараагийн бизнесээ явуулахад зээл дээр мэдээлэл байх ёстой болж байна, Тэгэхээр үүрэн холбооных байгаад байдаг төрийн мөнгөнийх байхгүй байгаад байдаг. Энэ олон жил яригдаж байгаа асуудал байхгүй юу.

Г.Занданшатар: 83.
Монголбанкны Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Гишүүний асуултад дахиад тодруулъя. ББСБ-ын банкттай холбоотой гэдэг мэдээлэл бол Монгол банканд байхгүй. Бид хэд бол арилжааны банкны эзэн, холбогдох этгээдийн, хувь хүн талаас нь холбогдох хамаатан садан, холбогдох этгээд гээд бүх талаас нь бол мэдээллээ авдаг. Энэ дотор бол банк болон банк бус санхүүгийн байгууллага хамтад байгаа гэсэн мэдээлэл байхгүй байгаа. Тэгэхлээр бол ББСБ-аар дамжуулж зээл хүү хүүлж байна гэдэг мэдээлэл бол ерөнхийдөө бол жсоохон ташаа мэдээлэл байх гэж Төв банк үзэж байгаа.

Зээлийн мэдээллийн сангийн тухай хуулиар зээлийн мэдээлэл хувь хүний зээлтэй холбоотой мэдээлэл 10 жил хадгалагддаг, 10-аас дээш жил бол өөрөө устгагдах ёстой. Мөн зээлийн мэдээллийн сангийн ил гардаг мэдээлэл нь 6 жилээр байдаг, тэгэхлээр бол энэ 6 жилээс дээш мэдээлэл нь бол зарим үед харагдаад, зарим үед харагдахгүй байхаар зохицуулалт байгаа. Өөр нэг зүйл нь гэвэл Монгол банкн дээр байгаа зээлийн мэдээллийн сан бол бид нар банкнуудаас авсан зээлийн мэдээллээ авдаг, дээр нь тэр харилцаа холбооны компани... /минут дуусав/

Г.Занданшатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн алга байна. Одоо Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Гадуур бол банкнууд зээл олгохгүй байна. Энэ яасан. Оны эхнээс хойш л ерт үнэлгээнд, шалгуур хангахын тулд банкнууд зээлээ өгөхгүй, зохист харьцааг хэвийн болгохын тулд л явсан л даа. Тэгээд энэ ийм учраас зээл олгохгүй гэж явж байсан. Одоо тэгээд ерт-ийн шалгалт дуусчихсан. Тэгээд зээл өгөхгүй хэвээрээ л байж байгаа. Энэ нь юунаас шалтгаалж байна вэ гэхлээр Ковидын хуультай холбогдож гарсан Монголбанкны журмуудтай холбоотой гэж би үзээд байгаа юм. Одоо банкнууд зээл өгөхгүй. Гадуур яаж байна гэхээр банк бус санхүү бол бусад байгууллагууд, хувь хүн, машинаа тавьчих, нэрээ шилжүүлчих 50 сая төгрөгийн зээл ав 5 хувийн хүүтэй гээд л ингээд л явж байна. 6 хувийн хүүтэй гээд л. Тэгэхээр энэ Ковидын хууль дээр бас нэг хэд хэдэн заалтууд орсон. Тэр нь харилцах, хадгаламжийн хүү төлөхгүй байх ийм заалтууд орсон.

Тэрэнтэй холбоотойгоор Монголбанкны тэр банкнуудын шалгуур үзүүлэлтийг нэлээн өндөр тавьсантай холбоотойгоор зах зээл рүү ерөөсөө мөнгө орохгүй байна. Ингэхийн тулд 2, 3 ажлыг хийх хэрэгтэй ба одоо жишээ нь яаж байна гэхлээр сүүлийн үед 600 сая доллар 6 сарын хугацаанд төгрөгийн харилцах хадгаламжаас шууд валютын хадгаламж болоод явчихлаа шүү дээ.

Тэгээд энэ нь юунаас шалтгаалж байна вэ гэхээр нөгөө харилцахад хүү төлөхгүй байгаагаас болоод л ингээд ийм зүйл рүү яваад байгаа юм. Тэгэхдээ нэг зүйлийг бас ард иргэдэд анхааруулахад Ковидын хуулиар, хэрвээ төгрөгийн хадгаламжид бол төр баталгаа өгнө, харин долларын хадгаламжид бол баталгаа өгөхөө больчихсон шүү дээ. Хэрвээ аль нэг банк асуудал гарах юм бол тэр долларын хадгаламжтай хүмүүс бүгдээрээ хохироод үлдэнэ гэсэн үг байхгүй юу. Тийм учраас энэ валют руу шилжүүлэх нь бол иргэдийн хувьд эрсдэлтэй шүү гэдгийг бас нэгдүгээрт хэлсэн нь зүй зүйтэй байх гэж бодож байна.

Тэгээд бодлогын хүүг өндөр тавиад явж байгаа тохиолдолд тэр Ковидын хууль дагасан журмууд дагасан тэр банкнуудын зохист харьцааг жоохон сул л даа, суллахгүй болохоор зах зээл рүү мөнгө орохгүй ийм нөхцөл байдал руу ороод байна шүү дээ. Мөнгөний ийм хэтэрхий их хатуу бодлого чинь одоо маш том эрсдэл рүү аваачих гэж байна. Энэ өвөлжилт хүндрэх гэж байна, малчид малаа зарж чадахгүй байна, банкнууд махны компаниуд зээл олгохгүй болохоор үйлдвэрүүд мөнгөгүй, үйлдвэрүүд мөнгөгүй байхаар ченжүүд мөнгөгүй, ченжүүд мөнгөгүй

болохоор малчдаас мал авдаг хүн байхгүй болчихоод байна.

Тэгээд энэ олон 91 сая толгой малыг энэ өвөл өвөлжилт хүндрэх юм бол тэгээд сүйрүүлээд дуусах уу? Тийм учраас энийг яаралтай худалдаж авах тэр эх үүсвэрийг гаргах зайлшгүй шаардлага байгаад байна. Тийм учраас тэр зохист харьцааг багасгаж байж, багасгах юм бол 3-4 их наяд төгрөг дахиад зах зээл рүү орох ийм боломж чинь нэмэгдэнэ. Тийм тооцоолол нь ч бас над дээр байж байгаа.

Өнөөдрийн бас нэг чухал зүйл бол энэ валютын гадаад урсгал асар их нэмэгдэж байгаатай холбоотой. Энэ дээр ялангуяа Жавхлан сайд бараг тэр Дэд ерөнхийлөгч байж байхдаа төгрөг рублийн своп хэлэлцээрийг бараг хийгээд дуусаад гарын үсэг зурахад бэлэн болчихсон байсан байхгүй юу? Тэрнийг одоо энэ геополитикийн нөхцөл байдалтай холбогдуулаад яаралтай гарын үсэг зураад ашиглалтад оруулах хэрэгтэй. Өнөөдөр Оросууд орж ирж байна. Рубль зарж байна. Банкнууд тэр рублиа яахаа мэдэхгүй сууж байна. Тэгээд дээрээс нь Оростой худалдаа хийдэг Хятадууд, Герман, Энэтхэг энэ тэр гээд олон орнууд бүгдээрээ рублиар худалдаа хийж байна. Тэгээд тэнд байгаа рублийн тэр эх үүсвэрийг хямд өртгөөр аваад буцаагаад энэ своп хэлэлцээр хийчих юм бол нэг тэрбум доллар шатахууны төлбөрт гарч байгаа. Тэгээд Оросыг спиртээр шахах тэр бодлого явж байна. Энэ хооронд нь тэр төгрөг рублийн своп хэлэлцээрийг хийх юм бол та нарын төлбөрийн нөхцөл.

Г.Занданшатар: 83.

Б.Лхагвасүрэн: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя.

Тийм еqr-ийн үр дүн дууссан арилжааны банкнууд, түрүүчийн банк нь Төрийн банк IPO хийж байна, дараа нь Хаан, Голомт гээд 2 банк бол зөвшөөрлөө бас авчихсан байгаа. Тэгээд энэ ондоо багтаагаад IPO хийх байх гэж хүлээж байгаа. Яах вэ, арилжааны банкнууд өнөөдөр зээл гаргахгүй байгаа бас хэд хэдэн шалтгаан байна гэж төв банкны зүгээс харж байна. Таны бас хэлж байгаа тэр Ковидын хуультай холбоотой хөнгөлөлт, чөлөөлөлт бол энэ 2022 оны 3 сарын 31-нээр дууссан байгаа. 2020 оноос анх Ковидын хүнд нөхцөл дээр аль болохоор зээлийг хугацааг нь сунгаж байх, зээлийн хүүг бас багасгах энэ олон хөнгөлөлт чөлөөлөлтүүдийн арга хэмжээ бол энэ 2022 оны 3 сарын 31-нээр дууссан. Тэгээд эргээд хэвийн, нөгөө хатуу нөхцөл рүүгээ нэг талаар бас ороод байна.

Хоёрдугаарт нь гэвэл Төв банкны мөнгөний бодлого хатуурч байгаа бодлогын хүү өндөрсөөд явж байгаа учраас бол мэдээж бас нөхцөл байдал бол төвөгтэй байгаа. Тэгээд яах вэ, одоо зээл гаргах тал руу нь Төв банк бодлого явуулаач гэхээр Төв банкны хувьд бол төвөгтэй 2 зүйл болчихоод байгаа юм.

Нэг нь нэг гараараа мөнгөний бодлого хатууруулж чангалчхаад нөгөө гараар бас сул тавихлаар нөгөө бодлогын нийцтэй байдлаа алдах гээд. Тэгэхлээр ер нь бол энэ 2023 оны төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэл дотор нэг ийм заалтыг Засгийн газартай хамт хэрэгжүүлэхээр ялангуяа тэр уул уурхайн бус экспортын салбарыг дэмжих, яг эдийн

засгийг илүү их солонгоруулах маягаар экспортод чиглэсэн үйлдвэрүүдийн ахисан түвшний боловсруулалт хийдэг. Энэ тал руу нь бодлого явуулна гэдгээрээ Төв банкны энэ банканд тавьж байгаа зохистой харьцааны үзүүлэлт дотор, ялангуяа тэр экспортын чиглэлтэй үйлдвэрүүдэд олгож байгаа зээл, санхүүжилт дээр нь илүү их боломжтой нөхцөлүүдийг тавихаар бид нар судлаад тооцооллоо хийгээд явж байгаа. Тэгэхлээр бол ерөнхийдөө яг тэр экспортын чиглэлийн үйлдвэрлэлүүд рүү нь бол тодорхой бас хөнгөлөлт чөлөөлөлт гаргах боломж нь байгаа гэж. Рублийн своптой хэлэхлээр Монгол Улс, ОХУ-тай хийдэг, гадаад худалдаа бол өөрөө Монгол талд маш ашиггүй, бид нар 2 тэрбум долларын бараа Оросоос худалдаж авдаг мөртөө манай экспорт бол 100 сая доллароор хэмжигддэг, маш харьцангуй.

Тэгэхлээр бидний хувьд бол рублээр Орос руу бараагаа зарж чадахгүй учраас рублийн орлого байхгүй, рублийн орлого байхгүй байна гэдэг нь рублээр төлбөр тооцоо хийх боломж байхгүй нэг зүйл байна.

Хоёрт нь угаас олон улс бол свопын сүлжээгээр төлбөр тооцоогоо хийдэг. Тэнд бол рублээр явдаггүй, голдуу нөгөө доллар, еврогоор ингээд төлбөр тооцоо явдаг учраас эргээд рубль нь Монголд орж ирсэн ч гэсэн, энийг бол банкны тэр сүлжээгээр явуулах боломж байхгүй. Бэлнээрээ л энд үлддэг. Тэгээд Оросын банк энд байхгүй учраас бол буцаад л тэрийг нь нөгөө мөнгийг нь зөөж бараа шиг нь зөөж гаргаж, данс очиж зузаатгах л ийм л болж байгаа юм.

Тэгэхлээр энэ утгаар бол яг рублиэр бол төлбөр тооцоо хийх бол

маш төвөгтэй. Дээр нь Орос, Украйны энэ нөхцөл байдалтай холбоотойгоор олон улсууд бол Оросын эсрэг хориг арга хэмжээ авч тавьж байгаа. Ялангуяа тэгээд рублийг төлбөр тооцоогоор хийж байна гээд Монгол Улс яах юм бол эргээд тэр хориг сааданд нь давхар хамрагдах ийм эрсдэл бол байгаа. Тэр утгаараа бол аль болохоор рублиэр своп хийхгүй, хийх ч угаас нөхцөл нь байхгүй. Худалдаан дээрээ ийм их алдагдалтай учраас нөгөө талаар бол тэр рублийг шилжүүлэх сүлжээ бас төлбөр тооцооны систем, бүтэц бол байхгүй байгаа. Тэгэхлээр бол энэ дээрээ бас рублээр төлбөр тооцоо хийх боломж ер нь л бага байх. Тийм.../минут дуусав/

Г.Занданшатар: Пүрэвдорж гишүүн асуулт асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр яг энэ геополитикийн өнөөдрийн энэ нөхцөл байдал дотор бол Монгол Улс 2 хөрш тэгээд дээрээс нь далайд гарцгүй гэдэг энэ нөхцөл байдлаар яалт ч үгүй бид бүхэн шатахуун нефтийн бүтээгдэхүүнээ Оросоос авч байгаа. Энэ тохиолдолд ер бид бүхэн энэ геополитикийнхоо нөхцөл байдлыг давагдашгүй хүчин зүйл гэж үзээд бас тодорхой хэмжээгээр энэ своп хийх төгрөг, рублийн своп хийх ийм боломж чинь өнөөдөр л гарч ирж байгаа байхгүй юу даа.

Тийм учраас энэ дээр гадаад харилцаан дээр алдана гэж айхгүйгээр энэ төгрөг рублийнхээ своп хэлэлцээрийг үргэлжлүүлээ. Энэ дээр бол нэг тийм алдаа гарахгүй. Гадаад хэргийн яам мөн түүнчлэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөл энэ одоо асуудлаа ярьж байгаад энэ дээрээ

Г.Занданшатар: Хариулах уу?
83.

Б.Лхагвасүрэн: 6 сард Монгол Улсын Сангийн сайд, ОХУ-ын Санкт Петербург хотод болсон эдийн засгийн чуулганд оролцсон. Оролцохдоо ОХУ-ын Сангийн сайд болон ОХУ-ын Төв банкны ерөнхийлөгч нартай уулзаж энэ төгрөг, рублийн свопын талаар ярилцсан байна лээ. Тэгээд ОХУ-ын Төв банкны хувьд бол гадаад худалдааны ийм зөрүүтэй тэмцэл байгаа учраас рублээр бол своп хийх нэгдүгээрт нөхцөл бол хангагдаагүй байна гэж нэг хариулсан байсан.

Хоёрдугаарт нь бол мэдээж төгрөг, рублийн своп гэдэг чинь бидний хувьд бол шатахуун авах гэж рублийг нь авна, зөрүүлээд оронд төгрөг өгөх болно. Тэгэхлээр ОХУ-д бол нэгэнт Монгол Улсаас 100 сая доллар хүрэхгүй ийм бараа бүтээгдэхүүн худалдаж авч байгаа тохиолдолд танай төгрөгөөр бид одоо юу худалдаж авах вэ гэдэг талаар бас тодорхой тийм төлөвлөсөн зүйл байхгүй гэдэг утгаар бол ерөнхийдөө энэ удаа бол төгрөг, рублийн своп хийх нь бол зохимжгүй юм байна.

Г.Занданшатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн. Эдийн засгийн байнгын хороон дарга.

Ц.Цэрэнпунцаг: Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвасүрэнгээс 2,3 асуулт асууя.

Бид нар Монголбанкны энэ хуулиараа, хуульд Монголбанкны хамгийн гол хийх ёстой үүрэг бол энэ төгрөгийн үнэ цэнийг хадгалах энэ бол хамгийн гол ажил нь. Тэгэхээр өнөөдөр эндээ хаагүй л байна. Энэ бүгд мэдээж

байна, бүгд л ярьж байгаа. Энэ төгрөгийн хани суларч байна аа, худалдан авах энэ чадамж муудаж байна гээд. Ингээд юмны үнэ өсөөд байна гээд ингээд инфляц гэдэг юмны тухай яриад байна.

Тэгэхээр зэрэг бид нар яах вэ энэ инфляцыг буулгах тал дээр бол одоо нэг, 2 жил, 3 жил дунд хугацаа, урт хугацаанд бид нар Монголбанкны явуулж байгаа бодлогыг бол зөв гэж харж байгаа юм. Тэгэхдээ өнөөдөр яг тулчихсан, бид нар энд жилийн төсвөө ярьж байна. Энийг жилд бид нар хэрэгжүүлэх мөнгөнийхөө бодлогыг ярьж байна. Гэхдээ яг 1 жилийн дотор бол бид нарт энэ үнийн өсөлт, үнийн өсөлтийн гол шалтгаан бол хани, төгрөгийн хани, энэ бусад валютын эсрэг суларч байгаа.

Ялангуяа долларын эсрэг суларч байгаа энэний их нөлөө бол гол нөлөө үзүүлж байгаа. Тэгэхээр зэрэг энэ богино хугацаандаа Монголбанкнаас яг барьж байгаа төгрөг инфляцаа буулгахад барьж байгаа гол бодлого яг ямар бодлого барьж байгаа юм? Жишээлбэл, 3 сарын дараа, 6 сарын дараа, 9 сарын дараа, 2023 оны өдийд 10 сард гэхэд яг улирал улирлаар 3, 3 сараар бол ийм ийм арга хэмжээ байна, үр дүн нь бол 3 сарын дотор ингэж ингэж гарч ирнэ гээд ийм төлөвлөсөн, бодож харж байгаа үр дүнгээ харж, тооцож харж байгаа ямар ямар арга хэмжээ байгаа юм? Ийм арга хэмжээний үр дүнд 3 сарын дараа, 6 сарын дараа үр нөлөө ингэж гарч ирнэ гэж тэр нарийвчилж тооцсон ямар арга хэмжээнүүд байгаа юм, үр дүнг нь юу гэж тооцож байгаа юм, ямар үзүүлэлтүүд байна? Нэгд.

Хоёрдугаарт, энэ дунд бол би хамгийн түрүүнд энэ богино хугацаанд хэрэгжүүлж, үр дүн нь гарахаар энэ валютын ханш суларч байгаа гол шалтгаан болж байгаа бид нарын валютын нөөц багасаж байгаа. Энэ эрсдэлээс гарах арга хэмжээнүүд дунд бол энэ экспортоос орж ирэх орлогоо даруйхан нэмэх л хэрэгтэй байгаа тийм ээ. Яг энэ чиглэл дээрээ валютынхаа орлогыг энэ сар, дараагийн сар, дараагийн улирлуудад яаж нэмэх гэж байна?

Хоёрдугаарт энэ алтны асуудал. Алт хөтөлбөрийн асуудал яригдаж байна. Бид нар хамгийн богино хугацаанд үр дүн нь гарахаар ажиллавал энэ алт хөтөлбөрөө сэргээх, алт хөтөлбөр дээр онцгой анхаарч ажиллах хэрэгтэй гээд ялангуяа хөрөнгө бизнес, хөрөнгө оруулагчид, бизнесийнхэн бол их санал бодлоо ярьж байгаа юм байна лээ. Тэгэхлээр энэ тал дээр яг ямар ажлууд хийж байна?

Алт хөтөлбөртэй холбоотой. Алт хөтөлбөрийн хэд дэх нь ч явж байгаа юм тийм ээ.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт бол одоо бид нарт ус агаар мэт хэрэгтэй байна. Энэ тал дээр яг ямар ямар одоо бодлого ажлууд хийх юм. Энэ мөнгөний бодлого дотор яг юу гэж орсон юм?

Мөн гадаадын шууд хөрөнгө оруулалтыг бид нар хуулийг нь.../минут дуусав/

Г.Занданшатар: Одоо зочид танилцуулъя.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Орон нутгийн

өмчийн газрын албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхний ажилд өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе. Улсын Их Хурлын гишүүдийн өмнөөс.

Асуулт, хариулт үргэлжилж байгаа Цэрэнпунцаг гишүүний асуултад Лхагвасүрэн ерөнхийлөгч 83.

Б.Лхагвасүрэн: Цэрэнпунцаг гишүүний асуултад хариулъя.

Тийм, ерөнхийдөө ийм нийлүүлэлтийн шинжтэй инфляц явж байгаа нөхцөлд бол мөнгөний бодлогоор шууд нөлөөлөх боломж бол их хомс байдаг. Тэр утгаар бас мөнгөний бодлогын авч байгаа арга хэмжээ маань өөрөө тодорхой хугацааны дараа үр дүн нь гарч ирдэг.

Ер нь Монгол Улсын өмнөх жишиг тооцоо судалгаанаас харахад ерөнхийдөө мөнгөний бодлогын өнөөдөр чангаруулж байгаа арга хэмжээ бол хамгийн багадаа 6 сар, ойролцоогоор бол 1 жил, жил хагасын дараа бодитой үр дүн нь гардаг гэж үзэж байгаа. Тэгэхлээр мөнгөний бодлогыг бол өнгөрсөн намраас эхлээд чангаруулаад эхэлсэн. Тэгээд мөнгөний бодлогын хүүг бол энэ оны эхнээс эхлээд өсгөөд явж байгаа. Тэгэхлээр өнөөдрийн инфляц ерөнхийдөө дээшээ өсөлт нь зогссон саармагжаад зарим саруудад буурч байгаа юм маань өөрөө мөнгөний бодлогын, бас түрүүчийн үр дүн нөлөө гарч ирж байна уу гэж харж байгаа.

Хоёрдугаарт гэвэл мөнгөний бодлого маань өөрөө энэ хүүгээрээ дамжихад шууд бус замаар нөлөөлдөг, ялангуяа шууд бус зам гэдэг маань гишүүдийн бас хөндөөд байгаа зээл

олдохгүй байна, багассан байна, хүү өсчихсөн байна гэдгээрээ тайлбарлагдаж байгаа юм маань өөрөө эдийн засгийн нөгөө эрэл талыг л намдааж байгаа. Одоо багасгаж байгаа гэсэн утгаар ингээд нөлөөлж байгаа юм.

Тэгэхлээр энэ утгаар эдийн засгийн өөрийнх нь идэвх нь жоохон сулрах нь эргээд нөгөө инфляцыг цааш нь өдөөх, энэ нөхцөл нь буурч байгаа гэдэг өнцгөөсөө хараад мөнгөний бодлогыг хатууруулж байгаа нь зөвхөн хүүгээр дамжихгүй, заавал байлгах нөөц өшөө олон арга хэрэгслүүд байгаа. Тэгэхээр заавал болих нөөцийн хэмжээ бол бас өндөр түвшинд байж байгаа. Төгрөг дээр 12, доллар дээрээ 18 хувь хувьтай байгаа.

Тэгэхээр эдгээр зүйл нь аль болохоор банкин дээр нь л мөнгийг нь барьж, эдийн засаг руу орж, мөн эдийн засаг, эдийн засагт мөнгө нь өөрөө элбэгшээд ихдэхээрээ л инфляцыг өдөөдөг ийм л гол шалтгаан байдаг. Тэгэхлээр энийг нь бага байлгах үүднээсээ л энэ мөнгөний хатуу бодлого л яваад байгаа л даа. Тэгээд экспорт талд бол мэдээж Монголбанк шууд өөрөө оролцох боломж байхгүй, гэхдээ мэдээж экспортлогч ААН-үүдээс долларыг нь бол шууд худалдаж авдаг, тэгээд нөөц хэлбэрээр барьдаг, нөөцөөрөө дамжуулж ханиш нь бол тодорхой хэмжээгээр нөлөөлөхөөр оролддог гэдэг бодлогынхоо хувьд бол одоо өөрөө бид нар нөөцөө сайн нэмэгдүүлээд, аль болохоор экспортын чиглэлийн үйлдвэр, ААН-үүдэд зориулсан мөнгөний бодлогыг явуулахаар энэ 2023 оныхоо мөнгөний бодлогод л тусгачихсан байж байгаа.

Тэр Улсын Их Хурлын тогтоолын төслөөр Засгийн газар,

ТББ-тай хамт хэрэгжүүлэх ийм заалт бол байж байгаа. Одоо Засгийн газрын Алт-2 хөтөлбөр байгаа. Алт-2 хөтөлбөрийн хүрээнд бол яах вэ Монголбанк бас дэмжээд явж байгаа. Энэ жилдээ тушаах алтан дээр нь бол урьдчилгаа хэлбэрээр мөнгө олгоод энэ жил тушаасан алтыг нь тэр урьдчилгааных нь төлбөрт авч байгаа. Нэлээн тийм үндсэн уурхай буюу бүтээн байгуулалттай, уул уурхайд бол 3 жилийн хугацаатай, бас хөнгөлөлттэй хүүтэй, ийм репо санхүүжилтийг бол олгоод явж байгаа. Гадаадын ишүүд хөрөнгө оруулалт бол ерөнхийдөө сүүлийн хэдэн жил маш багасчихсан. Өнөөдөр Монгол Улсад орж ирж байгаа хамгийн том, ер нь л ганц хөрөнгө оруулалт нь бол Оюутолгой байгаа. Одоо нийт тэрбум гаруй доллар орж ирдгийн дийлэнх нь Оюутолгой, бусад салбарт бол 100-200 сая долларын л хөрөнгө оруулалт орж ирээд, өнөөдөр бол гаднын хөрөнгө оруулалт Монгол руу орох урсгал бол бага байна.

Тэгэхдээ гадаад нөхцөл байдал бол хамгийн гол шалтгаан болж байгаа. Хамгийн хүнд нь гэвэл АНУ-ын хүү өндөр болсон 3 нэгж хувиар өсчихсөн байгаа. Одоо бүр дэлхий даяар байгаа энэ валютын нөөц бол Америк руу ингээд буцааж урсаж байгаа ийм нөхцөлд бол мэдээж их төвөгтэй. Гэхдээ Монголбанк бол Засгийн газартай хамтраад энэ рейтинг тогтоодог, зэрэглэл тогтоодог байгууллагад бол Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдал, ирээдүйн хандлагаа сайн тайлбарлаад явж байгаа учраас өнөөдөр рейтинг тогтоодог байгууллагууд бол Ковидын өмнөх нөхцөлөөрөө Монгол Улсын зээлжих зэрэглэлийг хэвээр нь хадгалаад явж байгаа. Энэ нь өөрөө

гаднын шууд хөрөнгө оруулалтыг орж ирэхэд бол.../минут дуусав/

Г.Занданишатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн тодруулж асууя.

Ц.Цэрэнпунцаг: Лхагвасүрэн Ерөнхийлөгч өө, ер нь ойлгож байгаа л даа. Мөнгөний бодлогоо чангаруулахаас өөрцгүй, тийм ээ. Энэ чангаруулж байгаа нь бол цаана нь эдийн засаг хумих чиглэл рүү явж байгаа. Энэ бол одоо гарц байхгүй, одоо ямар ч өөр гарцгүй болоод явж байгаа. Тэгэхдээ бид нар валютынхаа нөөцийг нэмэх тал дээр л Монголбанк хамгийн гол нь анхаарч ажилламаар байна. Тэгэхээр энэ валютын нөөцтэй холбоотой тоо энэ алт хөтөлбөр дээрээ анхаарах хэрэгтэй байна. Энэний санхүүжилтийг яаж босгох вэ? Цаанаас алтаар урьдчилж оптикоор зараад тэндээс нь доллароор эх үүсвэрийг оруулж ирж энэ алтных компаниудыг үйл ажиллагааг нь явуулах гарцыг нь нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажилламаар байна. Одоо санал хэлчихье.

Хоёрдугаарт, ер нь экспортын чиглэлд үйл ажиллагаа явуулж байгаа. Ер нь уул уурхайн бус бүтээгдэхүүн гаргаж байгаа энэ салбарууд дээрээ бас анхаарч ажилламаар байна. Энэ дээр бас Монголбанк мөнгөний бодлогоо энд чиглүүлмээр байна. Энэ дээр бас... /минут дуусав/

Г.Занданишатар: 83. Монгол банк.

Б.Лхагвасүрэн: Цэрэнпунцаг гишүүний асуултад зарим нэг тодруулга тоо хэлэх юм бол Монголбанк бол алтны урьдчилгаа хэлбэрээр 100 сая доллар бол гаднын

алт худалдан авагчаас оруулж ирээд энийгээ бол дотоодын алт олборлогч компаниуд руу ингээд дамжуулан зээлдүүлэх маягаар гаргаад явж байгаа. Одоо алт олборлогч ААН-үүд энэ 2022 оны байдлаар 74 тэрбум төгрөгийн урьдчилгаа санхүүжилт авчихсан явж байгаа юм. Өнөөдөр бас Худалдаа аж үйлдвэрийн танхимтай Монголбанк ийм санамж бичиг зурах гэрээ санамж бичиг зурахаар байгаа. Энэ санамж бичиг маань өөрөө экспортод чиглэсэн ААН-үүдийн тэр нийлүүлэлтийн сүлжээг яаж дэмжих вэ, худалдааны санхүүжилт хэлбэрээр экспортын гаргаж байгаа ААН-үүдэд худалдааны санхүүжилтийн үйлчилгээг яаж үзүүлэх вэ, дотоодын банкнууд болон гаднын нөгөө даатгалын байгууллагууд дээр хамтарч хийхээр ийм ажил хийхээр төлөвлөөд явж байгаа. Тэгээд өнөөдөр санамж бичиг зурахаар ийм төлөвлөгөө байгаа юм.

Г.Занданишатар: Тэр бол миний хэлж байгаа уул уурхайн бус арьс шир боловсруулдаг, ноос ноолуур боловсруулдаг, хүнсний бүтээгдэхүүн экспортолдог компаниуд хамрагдах юм.

Г.Занданишатар: Эдийн засгийн байнгын хороон дээр энийг хэлэлцэхдээ сайн хэлэлцээрэй.

Жигжидийн Батжаргал
гишүүн.

Ж.Батжаргал: Мөнгөний бодлогоо бид ярьж байна. Олон олон асуудлууд дээр бас жоохон төвөгтэй юмнууд байгаа. Бид хэд инфляцаа нийлүүлэлтээс хамааралтай инфляц гэж ярьцаагаад байгаа. Тэгээд үүнд нөлөөлөхөд мөнгөний бодлогоор нөлөө үзүүлэхэд нэлээн түвэгтэй, үр дүн нь

жоохон аажуу гардаг юм гэж ярьцаагаад байгаа юм. Тэгсэн хэрнээ бид мөнгөний бодлогоо чангатгаад байгаа улс шүү дээ. Тэгэхээр нөгөө талд нийлүүлэлтээ нэмэгдүүлье гэхээр зэрэг бодит эдийн засаг руугаа нийлүүлдэг мөнгөнийхөө хэмжээг нэмэгдүүлж байж л эдийн засгийн чинь идэвхжил, сэргэлт нэмэгдмээр юм, уг нь би тэгж л бодох юм. Тэгэхээр тэрийгээ өөрсдөө улам агшаагаад атгачихаар зэрэг энэний чинь өөрийнх нь энэ инфляцыг чинь байх хугацаа уртасчих юм биш үү? Энийг ер нь юу гэж бодоцгоогоод байна вэ? Нэг.

Хоёрдугаарт, ер нь инфляцыг бид 6 дээр $+2$ гэж ярьж байна. Тоо тавьж болно. Энэ бол болдог зүйл. Гэхдээ үүнийг хангахын тулд бид мөнгөний бодлогоороо дамжуулж яг ийм арга хэмжээнүүд авна. Төсвийн бодлогоороо дамжуулж яг ийм арга хэмжээ авна. Бусад нөлөөлөх хүчин зүйлүүдээр дамжуулж ийм арга хэмжээ авна. Энэний үр дүнд ийм юм гарна гэдэг яг тов тодорхой тийм төлөвлөлтүүд чинь хоорондоо уялдсан юм байна уу гэдэг асуудал байгаад байгаа юм. Энийг харахгүйгээр бид болохгүй гэж.

Дараагийн нэг асуудал энэ валютын нөөц, валютын хани, төлбөр тооцооны тэнцлийн асуудал өөрөө бид нарын энэ орж ирж байгаа орлогоос хамааралтай. Гэтэл орж ирж байгаа орлого маань бас улирлын эдийн засагтай, улс орон.

Дээр нь бид нарын харж байгаа зүйлээс хамааралгүйгээр энэ орлогыг чинь саатуулаад байгаа зүйлүүд байна. Дандаа энэ төрийн өмчтэй том компаниуд өөр дээрээ янз бүрийн үйл ажиллагаанууд явуулаад, урьдчилсан байдлаар борлуулалт хийдэг,

тодорхой бүтээгдэхүүнээр хөрөнгө оруулалт хийдэг, ийм гэрээ хэлцлүүд хийгээд гадаад худалдааг харахаар зэрэг боломжийн харагдаад байдаг. Тэнцлээ харахаар зэрэг алдагдалтай гарч ирээд байгаа явдал чинь яг энүүгээр л тов тодорхой харагдаж байгаа шүү дээ. Тэгэхээр үүнийг яаж зохицуулья гэж бодоцгоогоод байна. Би энэ жилийн тэр бараг 2 тэрбум орчим долларын саатлын асуудал чинь бол үүнтэйгээ яг холбоотой юм байна гэж хараад байгаа. Тэгээд бид улирлын эдийн засагт оны төгсгөлд байх валютын нөөц, дараагийн орлого орж иртэл хугацаанд бид нарын зарцуулах зүйлсээ харахаар зэрэг бид магад ч үгүй оны эхний хагас жил дээр одоогийн энэ оруулж ирээд байгаа импортын зарим зүйлсийг дам дамаан энэ хугацаанд тэвчиж болохоор тийм зүйлсийг нь хязгаарлалтын арга хэмжээний шийдлийг нь эрх бүхий байгууллагаар нь гаргуулж байж сая наад валютын чинь хани, тэгээд төгрөгийн чинь өөрийнх нь ханишийн сулралыг хамгаалж гарах ийм бололцоо байгаад байгаа шүү. Тэр 400 сая долларын автомашины импортыг ядаж эхний хагас жилд хязгаарлалтыг хийж байж бид үүнийгээ зөв зохистой ашиглах болов уу гэж би бодоод байгаа юм. Энэ мэтчилэнгээр тэвчиж болмоор байгаа импортуудыг яаж Засгийн газар хязгаарлах юм бэ?

Нэгэнт л мөнгөний бодлого ярьж, энэ улс орны эдийн засгийн сэргэлтийг бий болгож, инфляцыг бууруулж, амьжиргааг нь зохистой түвшинд авч явна л гэж мөнгө төсвийнхөө бодлогоор ярьцааж байгаа бол тоо тавьчхаад суугаад баймгүй байна л даа. Авч хэрэгжүүлдэг арга хэмжээнүүдээ цаг алдалгүй авч хэрэгжүүлэх ийм л шаардлагатай үүн дээр ямар бодлогын

арга хэмжээ авах гээд байгаа юм бэ. Ямар шийдэл гаргах юм. Дагуулж орж ирсэн дам дамаан төсөв дагаж орж ирсэн хуулиудыг чинь харахаар зэрэг яг тэрэнтэй нийцчихсэн ийм төдийлөн харагдаж өгөхгүй байгаа. Тийм учраас би энэ эдийн засгийн.../минут дуусав/

Г.Занданишатар: 81. Баярдаваа. Баярсайханы Баярдаваа. Түр хүлээж байгаарай.

Эхлээд зочдоо танилцуулчихъя. Улсын Их Хурлын Дэд дарга Салдангийн Одонтуяа, Монгол Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар, Хассуурийн Ганхуяг нарын урилгаар БГД-ийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн өмнөөс эрүүл энх, ажлын амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

Одоо Баярдаваа хариулна. 81.

Б.Баярдаваа: Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Та эдийн засагт үүссэн нөхцөл байдлыг бол маш тодорхой дүгнэж байна.

Нэгдүгээрт, нийлүүлэлтийн гаралтай шалтгаантай инфляц байгаа боловч мөнгөний бодлогыг хатууруулаад байгаа нь эргээд бас эдийн засагт сөрөг нөлөөтэй байна гэж та дүгнэж байгаа. Үүнтэй бүрэн санал нэг байна. Нийлүүлэлтийн шалтгааныг үүсгээд байгаа гол хүчин зүйл бол нэг талаас энэ тээвэр логистикийн асуудлууд, гадаад талд үнэ өсөөд байгаа. Европ дээр өсөж байгаа асуудлууд, нөгөө аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг улс орнуудын инфляц

үндсэндээ 10 хувь хүрчихсэн байгаа учраас энэ Монгол Улс руу импортлогдож орж ирж байгаа юм.

Хоёрдугаарт, валютын хани дээр үүсэж байгаа дарамт өөрөө энэ валют таны түрүүний хэлсэн тэр хоёр тэрбум доллар, одоо тухайлбал тэр орох, гарах урсгалын зөрүүн дээрээс үүдсэн энэ хүндрэл нь валютын хани, төгрөгийн хани сулрах ийм хүчин зүйл үүсгээд, энэ нь бас импортын барааны үнийг хөөрөгдүүлсэн ийм байдалтай бол нөлөөлөөд байгаа. Энэ үед бид нар бас одоогийн 2022 оны эхнээс авч байгаа мөнгөний бодлогын арга хэмжээнүүдийн үр дүн, энэ оны сүүлийн хагас, ирэх жил, ирэх жилийн дунд хүртэл бол энэ үр дүнгүүд бол улам эрчимжиж, үр нөлөө нь гарна.

Тэгэхээр үүний үр нөлөө яаж гарах вэ гэхээр зэрэг бас тодорхой хэмжээнд энэ импортын таны хэлээд байгаа тэр төлбөр тооцоо тэвчиж болох зүйлүүдийг тэвчихийн тулд бид нар хэд хэдэн зүйл дээр анхаарах ёстой. Нэгдүгээрт, энэ эдийн засгийн хүлээгдэж байгаа нөхцөл байдал хүнд байна, гадаад, дотоод орчин тодорхойгүй байна гэж байгаа. Энийг олон нийтэд зөв ойлгуулж мэдээлэх, бизнес эрхлэгчид хөрөнгө оруулалтаа зөв төлөвлөх, эрсдэлд орохгүй байх талаас нь ажиллах ёстой байгаа.

Хоёрдугаарт нь бас их хэмжээний суудлын автомашин, цахилгаан бараа бүтээгдэхүүн гээд энэ зүйлс бол өнгөрсөн оны эхний 8 сарын сараас импортын хэмжээ нь 1.2 тэрбум доллароор нэмэгдсэний тал хувь нь бол зөвхөн энэ 2 бараа бүтээгдэхүүнтэй холбоотой байгаа. Тэгэхээр тодорхой хэмжээний энэ эрэлтийг хумихын тулд зах зээл дээр

байгаа бэлэн мөнгийг бол бас зөв зохистой удирдах, ийм мөнгөний бодлого чиглэх нь бол зайлиггүй болчихоод байгаа юм.

Нөгөө талаас эдийн засаг дээр энэ эрэлтийг үүсгээд байгаа тэвчиж болох энэ төсвийн хөрөнгө оруулалтын зардлуудыг бас тодорхой хэмжээнд тэвчиж байж бид нар энэ хүнд нөхцөл байдлаас гарна. Тэгэхгүй бол энэ гадаад, дотоод орчин ийм тодорхой бус байгаа үед яг нөхцөл байдал хэвийн юм шиг цааш явах юм бол эдийн засаг, валютын нөөцөөр дамжуулаад инфляцын энэ зүйлээр дамжуулаад их хүнд байдалд орох ийм зүйл ажиглагдаж байна.

Нөгөө талд нь Засгийн газартай хамтарч хэрэгжүүлэх мөнгөний бодлогыг тогтоолын төсөл дээр 8 зүйл заалт тусгасан байгаа. Энэний эхний 4 заалт нь бол үндсэндээ энэ гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэх, төлбөрийн тэнцлийг засах үндэсний төгрөгийн ханшийн суларч байгаа энэ дарамтыг зөөлрүүлэх чиглэл рүү ийм арга хэмжээнүүд тусгагдсан. Үндсэндээ 3 нь бол экспортыг нэмэгдүүлэх, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхтэй холбоотой нэг заалт нь бол энэ тээвэр логистик дээр үүссэн хүндрэлүүдийг шийдэх талаар үүссэн нөхцөл байдлыг үнэлсэн, шийдэх арга замыг нь бол тусгасан ийм заалтыг энэ мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн ном дээр тусгаж өгсөн байгаа. 3 экспортыг нэмэгдүүлэхтэй холбоотой заалтын нэг нь бол энэ уул уурхайн биш, энэ экспортын салбарыг хөгжүүлэхийн тулд Монголбанкнаас илүүтэйгээр Засгийн газрын бодлого, үйл ажиллагааг бас их чухал байна гэдгийг тодорхой хэлж байгаа.

Монголбанк, банкнуудтай нийлээд СЗХ-той хамтраад энэ санхүүжилтийн бүтээгдэхүүнийг нь тодорхой болгох, санхүүгийн зах зээлийг энэ чиглэл рүү чиглүүлэх, эдийн засаг дээр байгаа бэлэн санхүүгийн нөөцүүдийг ийш нь дайчлах, ийм санхүүгийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх чиглэл рүү бол ирэх жилд жилд бол анхаарал хандуулъя гэсэн ийм зорилтыг тусгасан байгаа. Энэ нь мэдээж улс орны энэ боловсруулах салбарын үйлдвэрийг нэг шат ахиулах, үүгээрээ валют олдог байх, энэ арга хэмжээг дунд хугацаанд үр дүнтэй хүргэхэд ийм суурь нөхцөл болно.

Уул уурхайн бус салбарыг хөгжүүлэхэд анхаарах ёстой зүйлүүдийг бас өнгөрсөн жил төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлд тусгасан. Энэний хүрээнд санхүүжилтээс гадна өөр бизнесийн орчны талаар юу юу шийдэх ёстой талаар бизнес эрхлэгчид юу гэж харж байгааг бас тодорхой энэ ном дээр бол заагаад өгчихсөн байгаа. Энэ чиглэл рүү Засгийн газрын зүгээс бас бодлого үйл ажиллагаанд тусгаж хөгжлийн төлөвлөгөөндөө бас тусгаж ажиллаасай гэж бол хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн тодруулна.

Ж.Батжаргал: Энэ үндсэн чиглэл баталж байгаа Их Хурлын тогтоол дээр саяын таны ярьдаг тэр эхний 4 заалт дээр, тэр тусмаа тэр гадаад худалдаа, тээвэр логистикийн хүндрэлийг арилгахад чиглэсэн, одоо хамтарч хэрэгжүүлэх арга хэмжээ тусчхаад байгаа юм. Энийг хангахын тулд ер нь яг тухайлсан ямар арга хэмжээнүүд авч хэрэгжүүлэх вэ гэдэг асуудал өөрөө их чухал болоод байгаа

юм. Энэ рүү бас ямархуу байдлаар дэмжлэг гарах вэ гэдэг асуудал байгаад байгаа юм.

Дараагийн нэг асуудал нь тэр 4 дэх заалт буюу уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх, экспорт, гадаад худалдааг дэмжсэн санхүүгийн үйлчилгээ бий болгох тухай асуудал яригдаад байгаа юм. Энэ рүү чиглэсэн яг тов тодорхой бодлогын чиглэлтэй бүтээгдэхүүнүүд гэж энэ санхүү зээлийн ямар үйл явц байна. Би одоо санаж байна 230 тэрбум төгрөг мах, гурилын ханган нийлүүлэлт дээр шийдэл гаргасан тэрний үр дүн үгүй.../минут дуусав/

Г.Занданшатар: Баярсайханы Баярдаваа. 81.

Б.Баярдаваа: Батжаргал гишүүний асуултад тодруулахад нэгдүгээрт нь тэр уул уурхайн бус экспортыг дэмжихийн тулд маш олон бизнесийн орчныг бизнесийн орчныг сайжруулахад чиглэсэн маш олон арга хэмжээнүүд авах хэрэгтэй байгаа. Энэ дээр хамгийн түрүүнд нь тээвэр логистик зөвшөөрөл, лиценз, гарал үүслийн гэрчилгээ энэ бүх юмыг хөнгөн шуурхай болгох, зардал чирэгдэл багатай болгох Монгол Улсаас, тухайлбал одоо юу гэдэг юм экспортлохын тулд 28 төрлийн баримт бичиг бүрдүүлэх 4, 5 байгууллага дээр ингэж давхардсан тоогоороо гарч байгаа. Энийг жишээлбэл цөөлөх, цахимжуулах ийм асуудал чухал байгаа нөгөө талд нь санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгохын тулд үл хөдлөх хөрөнгөөс гадна гэрээ факторинг, батлан даалт, борлуулалтын гэрээ гэх мэтчилэн ийм зүйлс нь банкн дээр барьцаа болж чаддаг ийм хууль эрх зүйн тогтолцоог бий болгох ёстой.

Энэ чиглэл рүү нь бодлогоор банкнуудыг ингэж дэмжихийн тулд зохицуулагч байгууллагын Монгол банк, СЗХ-ны хөшүүргийн арга хэмжээнүүд бас чухал байгаа. Энэ зүйлүүдийг бол хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаа.

Г.Занданшатар: Баярдаваа гүйцээгээд хариулчих.

Уул уурхайн яам энийгээ хариулна биз. Бас тэгээд тэр Куази физикал активити явуулаад байгаа гэж байна шүү дээ. Аж ахуйн нэгжүүд тэр чинь ямар байна. Ил тод байдал энэ тэр гээд төрийн өмчийн компаниуд энэ тэр чинь яаж нөлөөлж байгаа юм энэ тэр гээд тодорхой асуулт асуусан шүү дээ.

Б.Баярдаваа: Сүүлийн үед 2019 оноос хойш хэрэгжүүлж байгаа Монгол Улсын урт хугацаа, дунд хугацааны бодлогод чухал ач холбогдолтой том төслүүд байгаа. Тухайлах юм бол 3 ширхэг төмөр зам, экспортод чиглэсэн авто замын ийм том төслүүд. Энэ төслүүд бол дүнгээрээ их том ойролцоогоор тооцох юм бол энэ 4 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтын тухай ярьж байгаа. Тэгэхээр энэ гадаад санхүүжилтээс биш дотоодоосоо хийхээр зэрэг түүнийг нь дотоодын одоо төрийн өмчит аж ахуйн нэгжүүд бусад одоо эх сурвалжаас энэ санхүүжилтийг гаргахаар эцэстээ тусгал нь хаана ирж тусаж байна вэ гэхээр Монгол Улсын гадаад валютын нөөц дээр орж ирж байгаа экспортын урсгал замаасаа тэр төслийн санхүүжилт рүү одоо бартер импортын төлбөр болж явахад нөлөөлж байгаа юм. Тэгэхээр энэний үр нөлөө нь валютын нөөц, валютын

ханишаар дамжиж дотоод эдийн засгийн нөхцөл байдал бол ингээж нөлөө үзүүлээд байгаа нь их төвөгтэй байгаад байгаа юм.

Тэгэхээр Монголбанкны Ерөнхийлөгч түрүүн асуултад хариулахад эдгээр төслүүдийг дотоод эдийн засагт сөрөг нөлөө, үр дагавар багатай байлгахад хэрэгжүүлэхийн тулд төслийн санхүүжилт, тухайн төслөөс орж ирж байгаа валютын орлоготой эх үүсвэрийг уясан байдлаар ингээж явуулбал дотоод эдийн засагт үр нөлөө багатай байна гэж хэлж байгаа. Яг энэ цаг хугацаанд төсвөөс хэрэгжүүлж байгаа бусад зардлууд бас хэвийн үргэлжилж байгаа энэ үед тэгээд валютын урсгал энэ татарчихсан байгаа үед бол энэ арга хэмжээнүүд бүр илүү их хүндрэлтэй нөхцөл байдлыг бол үүсгээд байгаа юм.

Тэгэхээр зэрэг энэ төсвийн нэгдмэл байдлыг хангах, төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн шинж чанартай үйл ажиллагааг төсвөөс гадуур хэрэгжүүлэх ийм үйл ажиллагааг нэгдсэн байдлаар шийдэж, ил тод ингээж явах нь цаашдаа бол илүү үр дүнтэй байх байх гэсэн ийм зүйлийг харуулж байгаа.

Нөгөө талд таны асуултад би түрүүн хариулж чадаагүй тээвэр логистиктой холбоотой маш олон хүндрэлтэй асуудлууд бол өнгөрсөн жилүүдэд үүссэн энэ ковидын үед. Харьцангуй нэг талаас шат дараатайгаар ийм хүндрэлтэй нөхцөл байдал үүсэж байгаа нь хилийн цаана Тяньжин дээр үүссэн контейнерын түгжрэлийг нь арилгаад нааш нь зөөхөөр Эрээн хот дээр Эрээн хотоос арилгахаар Замын-Үүд дээр, Замын-Үүд дээр арилгахаар зэрэг

Улаанбаатар хотын терминалууд дээр контейнерууд ингээд задрахгүй ийм нөхцөл байдал руу орчихсон ийм зүйлүүд ажиглагдаж байсан. Сүүлийн үед бол бас мэдээллүүдийг харахад бол нэлээд гайгүй энэ сулраад зохион байгуулалт бол сайжраад явж байгаа нь бол харагдаж байгаа юм. Энийг илүү хурдан шуурхай, үр дүнтэй болгохын тулд тээвэр зуучлагчдын холбоо, тээвэрлэгчид, энэ бизнес эрхэлж байгаа хүмүүсээс гарч ирж байгаа нэг тодорхой санал бол нэгдүгээрт цахимжуулах ёстой.

Хоёрдугаарт нь энэ тээвэр логистикийн нэгдсэн мэдээллийн систем одоо гаалийн материал бүрдүүлэхээс авхуулаад ийм нэгдсэн байдлаар зохион байгуулах нь бол шат шатны хүнд суртлыг багасгах, илүү хөнгөвчлөх, энэ нь улмаар контейнер задраагүйгээс болоод зам дээр түрээс дээр төлж байгаа энэ төлбөрүүдийг бол багасгах замаар эцэстээ бизнесийн үйл ажиллагааны зардлыг хөнгөвчлөх ийм үр дүнг бол авчирна гэсэн ийм зүйлүүдийг хэлж байгаа.

Энийг бас энэ тодорхой судалгааг нь хийгээд саналыг нь бас энэ төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн ном дээр бас тусгаж оруулсан байгаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулна. Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайхан, Цэндийн Сандаг-Очир нарын урилгаар “Оргил” сургуулийн ахлах ангийн сурагчид болон багш, ажилчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэр өмнөөс сурлагын өндөр амжилт хүсэн ерөөе.

Асуулт, хариултын цаг явж байгаа. Одоо ойролцоогоор цагийн дараа асуулт, хариултын цаг дуусах тул гишүүд цагийн дараа чуулганы танхимд цуглаарай. Өрөөндөө зурагтаар үзээд сууж байгаа. Асуулт, хариултыг танхимд сууж байгаа гишүүд. Ингээд Наянтайн Ганибал гишүүн асуулт асууна.

Н.Ганибал: Ер нь бараг ихэнх асуултад хариултаа авчихлаа.

Тэгэхдээ тодотгох ганц нэг асуудал байна. Ер нь сүүлийн 5 жилийн экспортын бүтцийг харахад уул уурхайн бүтээгдэхүүн бол Монгол Улсын экспортын 91 хувь байна. Ноос, ноолуур, мах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүд 6.5 хувь, 1 хувь нь бэлэн бүтээгдэхүүн буюу эцсийн бүтээгдэхүүн болсон хувцас, ноолуур, ноолууран бүтээгдэхүүн гээд эзэлдэг юм байна. Бид нар өнөөдөр мөнгөний бодлого ч тэр төсөв ярихад зөвхөн нүүрсний асуудал болон зэсийн асуудал дээрээ маш их анхаарал хандуулдаг. Үүнээс гадна мэдээж өнөө алт гээд сая Цэрэнпунцаг гишүүн тодорхой асуулаа. Тэгээд хариултыг ч авч байна. Алтны асуудал байна. Цаашилаад гадаадын хөрөнгө оруулалтын асуудал, ноос ноолуур гээд ингээд хэдхэн бүтээгдэхүүн бид нарын экспортыг бүрдүүлж байгаа.

Мэдээж одоо гадаадын хөрөнгө оруулалтыг бол сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газар маш амжилттайгаар оруулж ирэхгүй байх үйл ажиллагаануудыг хийсэн. Энийгээ бүгдээрээ мэдэж байгаа. Одоо ч эргээд бусад улс орнуудын мөнгөний бодлогын чангарч байгаатай холбогдуулаад бид 1-2 жил болоод гадаадын хөрөнгө оруулалт орж ирэх

тал дээр бол бас ер нь нэг хүлээлт байхгүй болчихлоо.

Цаашилаад бидэнд бас зайлишгүй хийх ёстой нэг асуудал байгаа юм. Энэ мах гэдэг бүтээгдэхүүн дээр зөвхөн дотоодын хэрэгцээг хангах, инфляцад нөлөөллийг нь багасгах, энэ үнийг тогтворжуулах гээд энэ бодлогыг бид нар 30 жил бараг барьчихлаа. Энэ өөрөө уг нь бид нарын одоо экспортод гаргах бүтээгдэхүүний уул уурхайн бүтээгдэхүүний дараах хамгийн том бүтээгдэхүүн байгаад байгаа юм.

Өнөөдрийн нөөц бололцоогоо бид нар тооцоолоод үзэх юм бол энгийн математикаар 200-аас 300 мянган тонн махыг бид нар экспортод гаргах ийм боломж байгаа. Харамсалтай нь энэ дээр өнөөдөр Засгийн газар маань ямар нэгэн оролдлого хийхгүй байгаа нь харагдаад байгаа юм.

Нүүрсэн дээр бол тэр боомтын үйл ажиллагаанд нэвтрэх чадвар, тэр ямар ч хамаагүй аргаар чингэлэг тээврээр хүртэл одоо нүүрсээ гаргаад ингээд болоод байдаг. Махан дээр Засгийн газрын гаргаж байгаа энэ бодлогууд үнэхээр сул байна. Ямар нэгэн оролдлого хийхгүй байна.

Энэ дээр бас саяын алт гэдэг хөтөлбөртэй адилхнаар манай Монголбанкныхан маань ямар нэгэн одоо бодлого шийдвэр бас гарах талаас нь өнөөдөр бид нар, бас энэ гаргаж байгаа чиглэл дээрээ ч гэсэн тодорхой тусгах хэрэгтэй байгаа юм. Ямар нэгэн хууль гаргаад байвал бүтэхгүй гэдгээ бол өнгөрсөн жил бид нар Их Хурлын тогтоол гаргасан. Тэрний үр дүн гэж нэг ч байхгүй. Энэ өөрөө бодит үйл ажиллагаануудыг хийх нь бол Засгийн газрын үүрэг мөн л

дөө. Харамсалтай нь Засгийн газар маань энэ ажлыг бүр хийхгүй, зөвхөн махны үнийг хямдхан байгаад нь алга ташаад ингээд суугаад байх юм.

Өнөөдөр малчин хүн үр хүүхдийнхээ их, дээд сургуулийн сургалтын төлбөрийг 1, 2 эр үхрээр төлдөг байсан бол 4 эр үхрээр төлдөг болчихлоо. Сард 2 төлөг зараад гурил, будаагаа авдаг байсан бол одоо 4 битгий хэл 5 төлөг зараад ч гурил будаагаа авч чадахгүй хэмжээнд хүрчихлээ. Нөгөө гол орлого олдог, өдөр тутмын л орлого олдог, бүтээгдэхүүнийх нь үнэ нь унаад байдаг, худалдан авдаг бүтээгдэхүүнүүд нь өсөөд байдаг, тэгсэн мөртөө Монгол Улс мах борлуулах, нийлүүлэх экспортын нөөц боломж байгаад байдаг юм. Энэ дээр Засгийн газрын бодлого дэндүү их дутагдаж байгаа. Ямар нэгэн хэлцэл хийсэнгүй, хийсэн хэлцлийг нь.../минут дуусав/

Г.Занданшатар: 83.

Б.Лхагвасүрэн: Ганибал гишүүний асуултад хариулъя.

Тийм, ер нь бол Монгол Улсын экспортын одоо 94 хувь нь бол уул уурхайн бүтээгдэхүүн, 6-хан хувь нь бол одоо мал аж ахуй, аж үйлдвэр, газар тариалангийн ийм бүтээгдэхүүн болсон байгаа. Тэгэхлээр бол одоо мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн гэхлээр түүхийгээрээ шахуу гарч байгаа ноолуур, ноос, малын өлөн гэдэс, арьс шир гээд энэ бол нэг 300 сая долларын хэмжээнд арай жоохон боловсруулсан, хүнсний бүтээгдэхүүн гэхэд бол 5 саяын хэмжээнд л. Ноолууран бүтээгдэхүүн, одоо пальто ч юм уу, цамц болчихсон хэлбэрээрээ 15 сая гээд маш бага хэмжээтэй байгаа.

Тэгээд энийг яаж нэмэгдүүлэх вэ гэдэг дээр бол тодорхой хэмжээний саналыг оруулъя гэдгээрээ энэ жил 2023 онд баримтлах төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэл дотор Засгийн газартай хамт хэрэгжүүлэхээр тэр заалтыг оруулсан.

Ерөнхий яах вэ, зүгээр заалт нь бол ерөнхий байгаа боловч яг дэлгэрэнгүй танилцуулга бол нэлээн их байгаа. Нэлээн дэлгэрэнгүй танилцуулгатай явж байгаа. Тэгээд аль болохоор экспортлогч тал мах байна уу, ноос ноолуураа илүү боловсруулаад гаргах байна уу. Ямар ч байсан уул уурхайн бус салбарын экспортыг нэмэгдүүлэх зорилгоор Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтарч ажиллахаар одоо тухайн танхимын доор бол маш олон бас салбарын холбоод байдаг юм байна лээ. Тэр холбоодоор нь дамжаад нарийн ширийн мэдээллийг нь авч, бүх боломжоор нь тусалж дэмжих талаар, ялангуяа санхүүжилтээр нь дэмжих талаар бол хамтарч ажиллахаар төлөвлөчихсөн байгаа.

Тэгээд энэ 10 сарын сүүлээр Худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголбанкны Судалгаа статистикийн газар, хүрээлэн хамтраад экспортлогчдын ийм уулзалтыг зохион байгуулна. Өнөөдөр бас Худалдаа аж үйлдвэрийн танхимтай мэдээлэл солилцож хамтран ажиллахаар санамж бичиг зурахаар төлөвлөж байгаа. Тэгэхлээр бол тодорхой, яг бүр зорилготой тийм арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд явж байгаа.

Г.Занданшатар: Наянтайн Ганибал гишүүн.

Н.Ганибал: Бид нарын авч хэрэгжүүлж байгаа олон арга хэмжээг нь 30 жил авлаа л даа. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлнэ гээд л экспортын бүтээгдэхүүнийг дэмжсэн гээд л бага хүүтэй зээл гаргадаг. Тэгээд нөгөөдөх нь эргээд албан тушаалтнууд, эрх мэдэлтнүүд, тэр авлигач ингээд ингээд өнөөдрийн энэ салбарууд гаргаж байгаа үр дүнгүүд чинь ингээд алдагдаад байгаа юм биш үү?

Энэ дээр бас ер нь олон нийтэд нээлттэй бүх хүмүүс хамрагдах боломжтой ийм л тэр зээлийн бодлогуудыг, зорилтот бодлогуудыг явуулахгүй бол энэ дээр зөвхөн одоо нэг удаа гал унтраасан арга хэмжээ хийдэг. Тэрнийх нь очих ёстой хүндээ очдоггүй нэг ийм зээлүүд гаргасаар байгаад өнөөдрийг хүрчихлээ л дээ. Тэгээд энэ дээр бас та бүхэн хамгийн гол нь нийтэд сайн гаргах тал дээрээ анхаарч ажиллаарай гэж хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Санал хэлчихлээ. Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Мөнгөний бодлого бол яах вэ? Эдийн засагт нийлүүлж байгаа мөнгөөр дамжуулаад, тэрийг зохицуулах гэж байгаа замаар инфляц үйлдвэрлэл, ажил үйлчилгээг дэмжих л ийм л бодлого л доо. Яг төсвийн бодлоготойгоо яаж одоо уялдах вэ? Юу юугаар уялдуулав? Энийг Монголбанкныхан маш тодорхой хэлмээр байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт бол юу гэхээр зэрэг энэ төв банк бол ажил эрхлэлт болон инфляцын зорилтыг тэнцүү хангаж ажиллах ийм шаардлага байгаа юм.

Тэр нөгөө ярьдаг шүү дээ нөгөө гибрид мөнгөний бодлого гэж тийм ээ. Тэгээд энэ бодлого маань одоо та нар 2023 онд юу гэж харж байна? Ийм зүйлийг асуух гэж байгаа юм.

Дараагийн асуулт бол юу вэ гэхээр энэ хүлээлт их байгаа. Та Монголбанкны Ерөнхийлөгчийн хувьд 2023 онд энэ инфляц ямар байх вэ? Одоо энэ ханиш ямар байх вэ? Энийг тодорхой хэлээч. Өөрөөр хэлбэл энэ хүлээлтээр дамжуулж эдийн засгийг бас удирддаг, өөрөөр хэлбэл зохиомол, хомсдолоос сэргийлдэг их олон ач холбогдолтой шүү дээ. Тийм ээ. Тийм учраас энэ бол их чухал байх болно гэдгийг одоо хэлье.

Энд эдийн засгийн 3 үзүүлэлт байгаа. Өсөлт манайд байхгүй, эдийн засгийн өсөлт байхгүй, инфляц өндөр. Ханишаа ингээд тавиад туучихсан байгаа.

Энэ үед бол мөнгөний бодлогыг маш их оновчтой тодорхойлоход их төвөгтэй л дээ. Энийг одоо зовлонг бол ойлгож байгаа. Тийм учраас бол хатуу мөнгөний бодлого явуулна. Тэгэхдээ тухайн үед нь тохируулгууд хийгээд явах нь зүйтэй гэсэн ийм зүйлийг би хэлэх гэж байгаа юм. Яах вэ одоо 10 дотор байх юм байна. 9.9 дотор байх юм байна. Энэ жилийн инфляцын хувь хэмжээ ингэж ойлгож байгаа юм. Дунд хугацаанд бол нэг 6 дээр +2 ингээд явах юм байна. Энэ яах вэ дээ өнөөдрийн энэ алдаа дутагдлууд бол яах вэ бид нарын энэ 30 жилийн нэг бодлогын алдаа л одоо өнөөдөр ингэж гарч ирж байгаа юм байна л даа.

Энэ мөнгөний бодлогыг чинь одоо бид нар 4 дэх удаагаа чангаруулчихаад байгаа юм. Одоо 12 болчихсон байгаа шүү дээ, тийм ээ.

Тэгэхээр энэ бол одоо яг өнөөдөр 12 болгосноос эдийн засаг гарч ирж байгаа нөлөөллүүд юу байна? 2022 оныг дуустал одоо та нар юу гэж бодож байна? Энэ дээрээ байх юм уу, Нэмэгдэх үү? Энийг юу гэж төсөөлж байна? Энийг бас нэг асуучихъя гэж бодож байгаа.

Энэ валютын нөөц 2.5 тэрбум доллар байгаа миний тооцож байгаагаар бол одоо дахиад нэг 2 тэрбум доллар дутна энийг яаж шийдье гэж байгаа юм бэ? Энийг одоо юу гэж бодож байна? Энэ банкууд бол том хадгаламж эзэмшигчдийнхээ хувьцааг, юуг хадгаламжийг бол доллар болгоод байгаа. Таны үгэнд ч гарч байсан. 300 сая доллартой тэнцэх хэмжээний Монгол төгрөгийг доллар болгочихсон байгаа. Энэ чинь бол энэ долларын эрэлтийг бол өдөөж байна. Энийг одоо ер нь цаашид яах юм бэ? Энийг юу гэж бодож байгаа вэ? Энэ манайд яах вэ бүхий л үзүүлэлтүүд муу байгаа юм л даа. Энэ ганц нэг гайгүй явж байгаа нь энэ хөрөнгийн зах зээл байгаа юм.

Би Баярсайхан даргаас асуух гэж байгаа юм. Санхүүгийн зах зээлд хөрөнгийн захыг нь эзлэх хувийн хэмжээ бол 15 болж Монголын түүхэнд байхгүй маш сайн үзүүлэлтүүд гарч ирж байгаа. Он дуустал бол дахиад одоо 8.5 орчим хувиар өсөх боломж байна гэж үзэж байгаа юм. Ингээд өсөөд байгаа юм бидэнд бол нөгөө эцсийн эцэст үр өгөөж нь юу байгаа юм бэ? Одоо өөрөөр хэлбэл татвараар дамжиж Монгол Улсын төсөвт орох энэ орлого маань яах вэ, ер нь зүгээр арай эрт асуулт байж болоогүй л дээ. Тэгэхдээ яг ямар өөрчлөлтүүд гарч байгаа, энийг би түүрүүн асууж байсан. Энийг хариулж өгөөч гэж байгаа юм.

Бид нар энэ ОУВС-ийн хөтөлбөрт 6 удаа орчихсон байгаа шүү дээ. Тийм ээ, Валютын сангийн аргамжаа нөгөө Монголчууд хүүхдийн аргамждагтай адилхан нэг аргамжаанд орчихсон.../минут дуусав/

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Нямаагийн Энхболд, Цэвэгдоржийн Туваан нарын урилгаар Төв аймгийн Зуунмод сумын сургууль, цэцэрлэгийн багш нарын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сурган хүмүүжүүлэх ажилд чинь өндөр амжилтыг хүсэн ерөөе.

81. Баярсайханы Баярдаваа.

Б.Баярдаваа: Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлт, инфляцтай бол ингээж харилцан гибрид маягаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх ёстой гэсэн энэ таны санал байна. Монголбанк мөнгөний бодлогын шийдвэр гаргахад ер нь бол дандаа баланслуулж, энэ шийдвэрийг бол гаргаж яваа. Бид нарын бүтцийн загварын тооцоо судалгаанд энэ 2 бол ойролцоо жинтэй, ингээж бол тусаж явж байгаа.

Тэгэхээр хэдийгээр инфляцыг тогтворжуулна гэж ярьж байгаа боловч цаана инфляцын эрэлтийн шинжтэй, дарамтгүй эдийн засгийн өсөлтийг дэмжинэ гэдэг ийм агуулгатай бол ийм мөнгөний бодлогын шийдвэрүүд бол гарч явж

байгаа. Энэ утгаар хэдийгээр 2020 он, 2022 он гарснаас хойш 6 хувь байсан бодлогын хүүг 12 хувьд хүргэсэн ч гэсэн бага багаар, аажим аажмаар ингэж 12 хувьд хүргэж ирж байгаа нь ковидын дараах дөнгөж сэргээж байгаа энэ эдийн засгийн өсөлтийг дөнгөж сэргээж байгаа энэ ажил эрхлэлтийн түвшнийг бол бид нар хайрлаж, гамнасан ийм бодлогын хариу арга хэмжээнүүд бол явсан гэдэг нь бол тодорхой бас эндээс харагдаж байгаа байх.

Нөгөө талд нь оны эцэс рүү бид нар хүлээлт ямархуу байгаа вэ гэдэг нь болохоор инфляцыг бид нар ирэх оны төгсгөл гэхэд бол нэг оронтой тоонд оруулж ирж чадна гэж бол харж байгаа. Гэхдээ мэдээж нийлүүлэлтийн шинж чанартай, гадаад орчинтой холбоотой маш тодорхой бус нөхцөл байдлууд бол бид нарыг хүлээж байна. Ялангуяа өдөр ирэх тусам тодорхой болж ирж байгаа зүйл бол энэ геополитикийн хүндрэлтэй асуудал бол илүү сунжрах ийм төлөв рүү орж байна уу даа гэдэг нь бол харагдаж байгаа. Энэ нь бас юугаар ингэж бас давхар мэдрэгдэж байна вэ гэхээр зэрэг олон улсын байгууллагууд дэлхийн улс орнуудын том гүрнүүдийн дэлхийн эдийн засгийн өсөлтийг төсөөлөхдөө 2024 он хүртэл бол ерөнхийдөө нааштай зүйлийг бол харахгүй байна. Тэгэхээр энэ бол 2023 он дуустал бол энэ нөхцөл байдал үргэлжлээд дэлхий нийтээрээ 2024 оноос гайгүй орчин руу шилжих болов уу гэсэн ийм хүлээлттэй байгаа юм болов уу гэдгээ бас харагдаж байгаа юм.

Хоёрдугаарт нь сүүлд 8 сард инфляцын төсөөллүүдээ Төв банкнууд шинэчлэхдээ 5 сарынхтай харьцуулах юм бол нэмэгдүүлж шинэчилж байгаа.

Ялангуяа 2023 оны эцсийн инфляцыг. Тэгэхээр энэ бол бас одоо энэ ялангуяа европ талд нь бий болж байгаа нөхцөл байдал, түүн нь Европоосоо үүдээд Америк бусад өндөр хөгжилтэй болон хөгжингүй зах зээлүүд рүү ийм үнийн дарамт бол цаашаа явж магадгүй нь гэсэн ийм хүлээлтийг үүсгэж байна. Тэр нь хүнсний инфляц, дээрээс нь эрчим хүчний энергийн үнээр дамжсан ийм нөлөөллүүд бол цаашаа бас явж магадгүй, болзошгүй байна. Гэсэн хэдий боловч бид нар чадвал ирэх оны эцэс гэхэд бол нэг оронтой тоонд оруулна гэсэн хүлээлттэй. 2024 оны 1 дүгээр улирал, 2 дугаар улиралд бол инфляцын зорилтот түвшин рүү авчирна гэсэн ийм хүлээлттэйгээр мөнгөний бодлогын шийдвэрийг гаргаад явж байгаа.

Нөгөө талдаа ханишийн яг тодорхой тоог бол хэлэхэд бол хүндрэлтэй байна. Бид нар суурь төсөөлөлтэй болон хувилбар, янз бүрийн төсөөллүүд дээр ханишийн төсөөлөл тоонуудыг бол оруулаад ингээд явж байгаа. Гэхдээ энэ ханишийн хөдөлгөөн бол эцэстээ худалдааны тэнцлээс хамаарах учраас нүүрс, нүүрсний үнэ, зэс, зэсийн үнэ, төмрийн хүдэр энэний бол хэмжээ болон үнээс бол хүчтэй хамаарахаар байгаа. Гэхдээ Хятадын эдийн засгийн өсөлт бол бас сүүлийн үед бол доошоо дэлхийн эдийн засгийн өсөлт ч гэсэн доошоо ингээд тохируулга хийгдэж байгаа нь бол бас санаа зовсон зүйл болж байгаа. Тэгэхээр эрдэс бүтээгдэхүүн дээр шок орж ирж магадгүй ийм хүлээлт байна. Нөгөө талд нь бодлогын хүүг хамгийн сүүлд 200 нэгж хувиар дээш нь нэмэгдүүлсний үр дүнд бид нар инфляцыг нэгээс 1-1.5 хувиар бол өмнөх суурь төсөөллөөсөө бууруулах ийм хүлээлттэй байгаа. Эдийн засгийн

өсөлт ч гэсэн 5-аас бол доошлоод 4.4 орчим руу ингэж орж ирэхээр ийм төсөөлөл, үр нөлөө нь бол урьдчилсан байдлаар гарч байгаа.

Төлбөрийн тэнцэл дээр ирж байгаа том ачаалал бол нэгдүгээрт хэд хэдэн зүйлээс хамаарна. Түрүүн хэлсэн экспортын орлого.

Хоёрдугаарт тодорхой түвшинд энэ бодлого, төсөв мөнгөний бодлогыг чанга авч явж байж түрүүн Батжаргал гишүүн зарим гишүүдийн хэлж байсан энэ тэвчих ёстой импортын төлбөрүүдийг нэгдүгээрт тэвчихээс хамаарна.

Хоёрдугаарт нь Монгол Улс бол олон улсын санхүүгийн зах зээл дээрээс нэлээд том хэмжээний бондуудыг босгочихсон байгаа, хувь, төр. Тэгэхээр энийг дахин санхүүжүүлэх энэ үйл ажиллагааг бол амжилттай хийх шаардлагатай. Үүний хүрээнд бол хөрөнгө оруулагч, санхүүгийн байгууллагуудтай маш сайн хамтран ажиллана.

Г.Занданишатар:

80.Санхүүгийн Зохицуулах хороо Баярсайхан дарга хариулъя.

Д.Баярсайхан: Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Өнгөрсөн 2 жилийн хугацаанд яалт ч үгүй л хамгийн өндөр өсөлт үзүүлсэн салбаруудын нэг нь бол Санхүүгийн Зохицуулах хорооны Хяналт, зохицуулалтын салбар байгаа. Одоо юу гэдэг юм, уламжлалт гэдэг юм уу 95.5 хувьтай, банк болон банкнаас бусад санхүүгийн салбар бол маш их өөрчлөгдөж байна. Өнгөрсөн оны эцсээр бол энэ Санхүүгийн зохицуулах хорооны хяналт

зохицуулалтад байгаа салбарууд бол дотоодын нийт бүтээгдэхүүний 24.3 хувьд хүрсэн. Тэр дотроо хөрөнгийн зах зээл хамгийн өндөр өсөлттэй буюу 15.7 хувьд хүрсэн. Мэдээж олон хүчин зүйлүүд нөлөөлснийг бол хэлэх нь зүйтэй байх. Ялангуяа хөрөнгийн зах зээлтэй энэ өсөлтийг гаргахад бол олон улсын тэр бүртгэлийн журмыг нэвтрүүлсэн.

Дээрээс нь тэр олон улсын стандарт болоод мөрддөг байсан төлбөр тооцооны дараа төлбөрт горимд шилжүүлээ, давхар бүртгэлийн журмыг бол бас хэрэгжүүлж эхэллээ.

Дээрээс нь зөвхөн биржээс санхүүжилт татдаг байсан бол биржийн бус зах зээлээс санхүүжилт татах энэ орон зайг нээж өгсөн. Ерөөсөө 1 жил хүрэхгүй хугацаанд 1.1 их наядын ийм үнэт цаасны бондын бүртгэл хийгдсэн байгаа. 54 үнэт цаас гаргасны 67 бонд бол бүртгэгдсэн гэх мэт олон ажлуудыг хэлж болно. Гэхдээ гишүүн бол яг энэ өгөөжийнх нь талаас хараад байх шиг байна. Ялангуяа Улсын Их Хурал, Засгийн газраас төрийн болон орон нутгийн өмчийг олон нийтийн болгох, олон нийтийн болгосноор иргэд маань бол жинхэнэ утгаар компанийн эзэд болох боломжийг нь нээж өгөх тал дээр илүү ажиллаж байна.

Зүгээр нэг статистик хэлэхэд 2018 оноос хойш нийт IPO хийсэн компаниуд энэ бол төр, хувийн хэвшил хамаа байхгүй. Ингээд аж ахуй нэгжийн орлогын албан татвар нь бол нь IPO-ийнхээ өмнөхөөс 2-3 дахин нэмэгдсэн байгаа. Өөрөөр хэлбэл олон нийтийн компани болсноор засаглал нь сайжирч байна. Тэр хэрээрээ бизнесийн үйл ажиллагаа, эрсдэл буурч

байна. Ашигт ажиллагааны түвшин өндөрсөж байна гэж бид нар үзэж байгаа юм. Энэ нь бол яг бодит үр дүн гэж бас Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс харж байна.

Дээрээс нь энэ банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотой ялангуяа системийн нөлөө, бүхий банкууд, олон нийтийн компани болоод явж байна. Энэ компаниуд маань олон нийтийн компани болсноор зах зээлээс 430-450 тэрбум төгрөг татах байх. Дээрээс нь зах зээлийн үнэлгээ бол өнгөрсөн жилийн оны эцсээр анх удаа 5.98 их наяд хүрсэн бол энэ нь бас 2 дахин өсгөх ийм давалдчих ийм хэмжээнд өсөөд явах боломжтой байгаа гэдгийг бас хэлмээр байна.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн асуултаа тодруулж асууя.

Б.Баттөмөр: Монголбанк маш тодорхой хариулах хэрэгтэй, Лхагвасүрэн захирлаа. Хани ямар байх юм бэ, хэд хүртэл яаж болох вэ, инфляц ямар байх вэ. Энэ хүлээлт гэдэг юм чинь их чухал. Хүлээлтийг бид удирдах хэрэгтэй. Энийг зөв, таны үг одоо маш тодорхой байх юм бол тэр хэмжээгээр энэ сөрөг зүйлүүд чинь эерэг болох гэдэг утгаар асууж байгаа юм. Тийм учраас та энийг нэгдүгээрт хариулаач.

Хоёрдугаарт бол Оюутолгойтой ажилламаар байна. Оюутолгой жилд 2 тэрбум долларын зэсийн баяжмалыг одоо 2021 онд 1.9 тэрбум долларын зэсийг гадагш гаргаад Монголд орж ирж байгаа нь 630 сая доллар орж ирсэн. 2022 оны эхний хагас жилд 414000 тонн зэсийн баяжмал гаргаад 970 сая доллар олоод 350 нь орж ирсэн байгаа юм. Өөрөөр

хэлбэл 3.1 нь ч орж ирэхгүй л байгаад байгаа юм.

Тэгээд энийг одоо байгууллагатай ер нь яаж ажиллах вэ? Энэ Монгол Улсын эрх ашгийг хангуулах.../минут дуусав/

Г.Занданшатар: Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Баттөмөр гишүүний асуултад хариулья.

Баярдаваа захирал бол ерөнхийдөө Монголбанкны гаргаж байгаа шийдвэрүүд, төсөөлөл, тооцооллын талаар ерөнхийд нь хэлсэн. Бидний хувьд бол ерөнхийдөө инфляцын хувьд одоо 9 сарын тоо Үндэсний статистикийн хорооноос урьдчилсан байдлаар авахад 13.5 гэж гарч байна лээ. Тэгэхлээр өнгөрсөн сард 14 байсан 14.4 байсан. Сая ингэхээр 9 сард 0.9 функтээр буурч байна гэж харж байна. Тэрний өмнө бас нэг нэгж хувиар буурсан. 8 сард 7 сараасаа. Тэгэхээр энэ сүүлийн 2, 3 сард гарч байгаа энэ бууралт хандлага хэрвээ энэ хэвээрээ үргэлжлэх юм бол энэ оны төгсгөл рүү 11-12 хувь руу орох боломжтой гэж хараад байгаа юм. Энэ нь өөрөө манай бодлогын хүү 12-той ингээд харьцуулаад үзэх юм бол хасах хүүтэй байгаа бол инфляц нь бодлогын хүүнээс өндөр байгаа бол эргээд.../минут дуусав/

Г.Занданшатар: Цэндийн Мөнх-Оргил гишүүн алга байна. Хойшлууллаа. Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: 2022 онд энэ эдийн засаг бодитойгоороо хүндэрч эхэллээ.

2023 он магадгүй улам таагүй байх нь. Тэгээд энэ бодлогыг ер нь нэг тийм зүүний, барууны бодлого, халамжийн бодлого явууллаа энэ тэр гэхээсээ урьдаар бараг л нэг ийм аргацаасан бодлогуудын үр дүн л ингэж эдийн засаг дээр бодитоор илэрч гарч ирж байна л даа. Тэгээд хэдэн зүйл тодотгоцоод 2 асуулт асууна.

Тодотгох зүйл нь ер нь ирэх жил Монгол Улсад 1.5 доллар, валют, еврогоор нийлээд 1.5 ч байна уу тэрбумтай тэнцэх хэмжээний зээл төлөх ёстой. Танай 2.5 тэрбумтай тэнцэх хэмжээний своп бас байгаа. Одоо төлөх болдог. Валютын нөөц байхгүй, нөгөө талаас бид нар чинь нэг дархан мэхтэй. Өрийг өрөөр дарчихдаг дархан мэхтэй. Дархан мэхээ хийх гэсэн чинь тэр бондын зах зээл дээр бондын үнэ яаж байгаа, хэд хүртэл унаж байгаа, 30, 40 хүртэл уначихсан байгааг та нар мэдэж байгаа. Өнгөрсөн жилүүдэд бонд босгож байсан хүү өгөөжөөс одоо хэд дахиныг илүү амлаж байж шинээр тэр өрийг өрөөр дардаг дархан мэхийг хийх гэсэн чинь тэр чинь одоо би хэлэхэд асар хэцүү.

Одоо зөвхөн энэ жилийн төсөвт 1.2 их наядын зээлийн хүүгийн төлбөр тавигдчихсан. Тэгээд тэр гадаадын хөрөнгө оруулалт гэж ганц жаахан тоолдог юм Оюутолгой байсан чинь Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалт чинь ирэх жил дуусчихна бараг. Тэр байхгүй. Тэр тэгээд одоо бүхий л зүйл дээр экспортод гэдгийг Хятадын эдийн засгийн тэлэлт, өсөлт гэдэг зүйл чинь байгаа юм уу, байхгүй юм уу? Наад яг экспорт гэдэг зүйл чинь олон улсын нөхцөл байдлыг хараад ямар байгаа юм. Тэгэхээр яг одоо нөхцөл байдал бол бараг

маргахын аргагүй нөхцөл байдал бол ийм л байгаа. Төсөв чинь тэлэлттэй, та нарт орон зай байхгүй. Урьдчилаад оршил хэлэхэд нөхцөл байдал бол ийм байгаа.

Тэгэхээр эндээс Лхагвасүрэн Ерөнхийлөгчөөс би 2 зүйл асуух гээд байна л даа.

Нэгдүгээрт нь ер нь энэ саяын бүх зүйл чинь явсаар явсаар байгаад бид нарын хамгийн гол эрсдэл, өртэй холбоотой эрсдэл байна. Энэ өрний талаар Засгийн газраас асуухаар нөгөө гөлөг төөрүүлнэ гэдгээр элдэв янзын тоо яриад Засгийн газарт тэр тэр нь ордог, тэр нь хамаардаггүй, хуулиар тэгдэг гээд ингээд дахин дахин давтаад гөлөг төөрүүлээд явчихдаг. Засгийн газрын хүний ярьж байгаагаар бол Засгийн газрын өр дотоодын нийт бүтээгдэхүүний 50 хувьтай тэнцүү байгаа гэдэг дээр нь танай своп нэмэгдээд 2.5 нэмэгдээд элдэв янзын тэр Хөгжлийн банкны ирэх төлөх гэж байгаа 500, дахиад төрийн өмчит компаниудынх чинь нийлэхээр таны бодлоор энэ хэд вэ. Засгийн газрынх биш, Монгол төрийн хариуцаж байгаа өр яг хэд вэ? Би багцаагаар тооцоход би бол 100 хувь болчихсон гэж боддог. 100 хувь аль хэдийн болчихсон. Засгийн газар 50 гэдэг, танайхан зарим эх сурвалж дээр 60 гэж байна лээ. Дэлхийн банк 90 хувь болчихсон гэдэг. Тэгэхээр та энэ дээр нэг байр суурь саяын тэр өөрийнхөө Монголбанктай холбоотой өр ширээ оруулаад та нэг бодитой нэг тоо хэлээч энэ дээр.

Хоёрдугаарт нь та бас Монголбанкны Ерөнхийлөгчийн хувьд иргэд, ААН, бизнес эрхлэгчдэд нэг сигнал. 2023 оны бизнес. Одоо тэд нар чинь бас адилхан төсөв, төлөвлөгөө

гээд явж байгаа нэг сигнал хэлээч. Ирэх жил ер нь энэ дотоодын банк, аж ахуйн нэгжүүдэд чинь зээл олдох уу? Мөнгөний бодлого хатуурна л гэж байна. Энэ бүхний чинь цаана мөнгө ховордоно, зээлийн хүүтэй болно гэсэн үр дагавар гарах байх. Та энийг бизнес эрхлэгчдэд нэг сигнал хэлээч. Зээлийн хүү ер нь яах юм, зээлийн хүүний дарамт чинь та нарт яах юм, та нар бизнесээ төлөвлөхдөө ингээч гэж.

Хоёрдугаарт нь хөрөнгө оруулалт хийхээр бас тооцож байгаа аж ахуйн нэгжүүд байгаа. Аж ахуй нэгжүүд хөрөнгө оруулалт хийнэ гэдэг чинь гадаадаас бас доллар валютаар нэг гэрээ хийнэ л гэсэн үг. Тэрнийхээ урьдчилгаа төлнө гэсэн үг. Тэд 5, 10 хувийг нь урьдчилгаа төлдөг, үлдэж байгаа 20, 30, 40 хувиа хуваагаад тавьдаг тийм гэрээг хийх гэж байгаа аж ахуй нэгжүүдэд та бас нэг сигнал өгөөч. Та нар минь тэгээрэй, ингээрэй, жоохон азнаарай, аль эсвэл тэр итгэлтэйгээр гэрээ, хөрөнгө оруулалт.../минут дуусав/

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл, Ганибалын Амартүвшин, Тогмидын Доржханд нарын урилгаар Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын 63 дугаар сургуулийн багш, ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сурган хүмүүжүүлэх ажилд чинь өндөр амжилтыг хүсэн ерөөе.

7 хүний асуулт хариултын дараа үг хэлнэ. Асуулт хариултын цаг

дуусаад гишүүд чуулганы танхимд цуглана шүү.

83. Монголбанк, Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

Би танд нэлээн тодорхой тоонуудыг бас хэлчихье. Энэ жил төлөгдөхөөр оны төгсгөлд 137 сая Чингис бондын үлдэгдэл байгаа. 137 сая доллар энийг энэ ондоо төлчихнө. Ирэх онд Засгийн газраас төлөх ёстой Гэрээг бондын 536 сая доллар, Хөгжлийн банкны өөрийнх нь Евро бондын 500 сая доллар. Самуурай Бондын 30 тэрбум юань буюу нэг ойролцоогоор 250-300 сая долларын ийм том өр байгаа. Ер нь бол 2023 он бол хамгийн өртэй холбоотой, хамгийн дарамттай жил нь байгаа. Одоо яг 2023, 2024 он. Тэрнээс цааш бол тийм томоохон өрүүд бол бараг байхгүй болчихож байгаа юм. Тэгэхлээр энэ 2023 оны энэ хамгийн том өрийн дүрийг л одоо өрийн удирдлага маягаар зохицуулах нь л хамгийн нэг номерын хийх ажил гэж харагдаж байгаа.

Тэгэхлээр энэ утгаараа бол одоо Засгийн газар дээр 1 тэрбум 200-300 сая долларын ийм өр бол одоо яг ирэх жил гарч ирнэ. Таны дурдаж байгаа Монголбанкны свопын 1.7 тэрбум долларын өр бас байгаа. Энийгээ бид нар бол дахиад 3 жилээр сунгахаар яриа хэлэлцээгээ эхлүүлээд, ерөнхийдөө зарчмын хувьд бол тохироод явж байгаа. Тэгээд цааш нарийн бүр хэлэлцээ бол 7 сарын 1-нд дуусах учраас 6 сарын өмнө эхлэх ёстой. Тэгэхлээр он гарч байгаад илүү нарийн хэлэлцээгээ ороод явна. Монголбанкны хувьд бол зүгээр хугацааг нь сунгая гэдгээр хүсэлтээ

тавьчихсан байгаа учраас энэ өрийн дарамт бол гайгүй байх гэдгийг харж байгаа.

Оюутолгойтой холбоотой асуудлаар бол хэдийгээр Оюутолгойн бүтээн байгуулалтын үйл ажиллагаа дуусаж байгаа ч гэсэн дахиад энэ бүтээн байгуулалтаас гадна өшөө олон гүний уурхай дотор хийх ажил бас арга хэмжээнүүд байгаа гээд Оюутолгойн гүйцэтгэх захиралтай уулзахад ирэх онд бол 1.1-1.7 тэрбум доллар бас орж ирнэ гэдэг мэдээллийг өгсөн. Тэгэхлээр бидний хувьд бол ирэх жил бол Оюутолгойгоос 1.4-1.7 тэрбум доллар орж ирэх юм байна гэж харж байгаа. Энэ долларыг зүгээр харьцуулаад үзэх юм бол ч Засгийн газрын өртэй бол энэ бараг тэнцүү шахуу харагдаж байгаа учраас энэ өрийг бол ийм замаар шийдэх боломжтой. Нөгөө талаар бол бас дахин санхүүжилтийн л асуудал яригдаж байгаа. Тэгэхлээр дахин санхүүжилт гэдгээрээ бол дахиад цааши хугацааг нь сунгах талаар ажил хийгдэх болов уу л гэж Монголбанкны зүгээс бол ерөнхийдөө төсөөлж байгаа.

2023 онд бизнес ерөнхийдөө ямаршуу байх вэ гэхлээр одоо бид хэд түрүүчийн Их Хурлын гишүүдийн асуусан асуултад нь хариулахад бол их ойлгомжтой, бас тодорхой хэлж байгаа л даа. Өнөөдрийн энэ геополитикийн нөхцөл байдал бол бүрэн шийдэгдэх шинжгүй байна. Яагаад гэвэл тэр олон улсын бусад улсуудын төв банкнуудын хийж байгаа төсөөлөл, ОУВС, Дэлхийн банкны томоохон эдийн засагтай орнууд болон бүс нутгаар нь Азийн бүс ч гэдэг юм уу ингээд төсөөлж байгаа төсөөллүүд бол дандаа инфляцыг бол өндөр хэвээр нь хадгалсан эдийн

засгийн өсөлтийг нь бол бууруулчихсан маягаар ингээд тавьчихсан байгаа. Энэ нь өөрөө ямар дохио, сигнал өгч байна вэ гэхлээр гадаад нөхцөл байдал тийм таатай байхгүй юм байна гэдэг нэг ийм төсөөллийг өгч байгаа.

Нөгөө талаар бас нэг өөр мэдээлэл нь бол түүхий эдийн үнэ бол бас өндөр түвшиндээ хэвээрээ байх юм байна. Ирэх онд гэсэн нэг мэдээлэл байгаа. Тэр нь бол Монгол Улсын хувьд бол бас таатай, яагаад гэвэл манай экспортын 94 хувь нь бол түүхий эд бүтээгдэхүүн байгаа учраас ямар ч байсан үнэ дээрээ бол нэг тийм шок маягийн дарамт бол байхгүй юм байна гэдгээрээ харж байгаа. Банкны сектороос аж ахуйн нэгжүүдэд олгож байгаа зээл бол мэдээж мөнгөний хатуу бодлогынхоо хүрээнд хумигдаж байгаа хэдий ч одоо өнөөдөр Төрийн банк IPO хийгээд дуусаж байна. Нийтэд хувьцааг гаргаад дуусаж байна. 2 банк бол энэ ондоо багтаагаад гаргаад дуусчихлаар зүгээр 3 банкны хувьд бол бараг 300-гаад тэрбум төгрөгөөр өөрийн хөрөнгө маягаар босгох ийм боломжтой. Тэгэхлээр өнөөдөр бол банкууд маань активын чанарын үнэлгээний дараа хэвийн хэмжээнд бол зохистой харьцаагаар хангаж байна гэсэн нэлээн гайгүй үзүүлэлттэй гарсан учраас банкнуудын хувьд бол зээл санхүүжилтээ олгоод явахад бол ямар нэг Монголбанкны зүгээс.../минут дуусав/

Г.Занданшатар:

Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн. Амгалангийн Адьяасүрэн гишүүн. Даваажанцангийн Сарангэрэл гишүүн асуулт асууя.

Д.Сарангэрэл: Бид мөн одоо мөнгөний бодлогын талаар ярьж

байна. Энэ Улсын Их Хурлын чуулганы үеэр Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвасүрэн зохион байгуулаад Ирланд, Швед, ОУВС-ын энэ Монголбанкны чиглэлийн хүмүүс хамтарсан ийм хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын гишүүдийн дунд хийсэн л дээ. Тэгээд бас нэлээн хэдэн гишүүн оролцсон. Тэгээд ер нь бол яах вэ энэ дэлхийн нөхцөл байдалтай холбогдуулаад деполтын ийм нөхцөл байдал Монголд үүсэх үү, үгүй юу гэдэг асуудлыг тэр үеэр ярьсан. Мэргэжлийн хүмүүс Монгол бол тэр түвшинд хүрэхгүй энэ хүнд нөхцөл байдлаас гарах олон арга зам байгаа талаар тийм нэлээн эерэг мэдээлэл өгсөн. Тэгээд тэр үед бол саяын яг Цогтгэрэл гишүүний асуусан өрхийн аж ахуй, айл өрх, мөн том бизнес, бүх чиглэлд тохирсон тийм санхүү, эдийн засгийн мэдээллүүдийг ил тод өгөх нь их чухал шүү гэдэг ийм зөвлөгөөг өгч байсан. Энэ зөвлөгөөний дагуу та бүхэн маань бас ямар үйл ажиллагаа явуулсан бэ гэдэг нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт сая Санхүүгийн зохицуулах хорооны дарга Баярсайхан тийм эерэг мэдээлэл өгч байна л даа. Хөрөнгийн зах зээлийн түвшин бол хэдийгээр эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаа ч гэсэн сая 15.7 гэсэн үү, 17.7 гэсэн үү Баярсайхан захирал тийм ээ. Энэ түвшинд хүрсэн гэдэг эерэг мэдээлэл өглөө. Энэ мэдээлэл нь өөрөө банкнаас илүү Банк бус санхүүгийн байгууллагад итгэх тийм итгэл нөхцөл байдал бол одоогийн Монголын нөхцөлд байгаа шүү гэсэн ийм дохио юу? Энэ одоо ямар учиртай мэдээлэл вэ? гэж Шри Ланкийн хэмжээнд бол Монгол Улс деполтод бол очихгүй гэдэг тийм итгэлтэй, тийм мэдээлэл, дүгнэлтүүдийг хийж байна лээ л дээ. Та бүхэн маань энэ дүгнэлттэй холбоотойгоор олон нийт рүүгээ

чиглэсэн бодит ямар мэдээллийг өнөөдөр өгөхөд бэлэн байгаа вэ гэсэн 3 асуулт тавиад дараа нь би тодруулъя. Баярлалаа.

Г.Занданшатар: 83.
Монголбанк Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Сарангэрэл гишүүний асуултад хариулъя.

Тийм Олон Улсын Валютын сангийн олон нийттэй харьцах тэр газраас Шведийн Төв банк, Английн Төв банкны олон нийттэй харьцдаг нэлээн өндөр мэргэжлийн хүмүүсийг авчраад бид хэд хэлэлцүүлэг хийсэн байгаа. Тэгээд тэр явцад бол Төв банк бол аль болохоор олон нийтэд мэдээллээ нээлттэй, ил тод байдалд хүргэх, ялангуяа тэр зорилтот бүлгүүдэд яг чиглэсэн тэр мэдээллийг өгч байх ёстой. Тэр нь өөрөө мэдээж парламентын гишүүдэд шийдвэр, хууль тогтоогч нарт өгөх мэдээлэл нь ямар хэмжээнд байх вэ, олон нийтэд яаж энгийн үг хэллэгээр энэ мэдээллээ хүргэж байх вэ? Бизнес эрхлэгчдэд бас хүлээлтийг удирдах маягаар ямар дохио сигнал өгч байх вэ гэдгээрээ нэлээн тийм зөвлөгөө өгөөд зөвлөгөө нь бол эцэслэгдэж бас ирээгүй байна. Одоо ингээд олон улсын энэ удахгүй ирэхлээр Монголбанк өөрийнхөө хэмжээнд бас бүтэц зохион байгуулалт дээрээ анхаараад яг олон нийтэд чиглэсэн энэ мэдээллийн сувгуудаар яаж ажиллах вэ, мэдээллээ яаж тогтмол хугацаанд хүргэж байх вэ гэдгээрээ нэлээн нарийн тийм зохион байгуулалтын ажил хийх гэж байгаа. Тэгээд яах вэ бас энэ далимд дурдахад энэ 2023 оны төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн дотор энэ 7 дугаар заалт, Засгийн газар, төрийн бусад байгууллагуудтай

хамтран хэрэгжүүлэхээр нэг заалтыг бол тусгасан байгаа.

Санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих, санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор иргэд олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны төслийг боловсруулж хэрэгжүүлнэ гээд. Тэгээд энийгээ болохлоор мэдээж Засгийн газрын тодорхой яам, агентлагуудтай Санхүүгийн Зохицуулах хороо, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам гэдэг юм уу, эдгээр байгууллагуудтайг хамтраад ийм төсөл хэрэгжүүлэхээр ингээд төслөө боловсруулаад эхэлчихсэн. Энэнийхээ дагуу ингээд хэрэгжүүлээд явна.

Г.Занданшатар: Санхүүгийн зохицуулах хорооны дарга Дэмбэрэлдашийн Баярсайхан хариулна.

Д.Баярсайхан: Гишүүний асуултад тодруулга өгье.

Энэ 24.3 хувь гэдэг нь Санхүүгийн зохицуулах хорооны хяналт зохицуулалтад байгаа бүх салбар нийлээд байгаад байгаа. Үнэт цаасны хөрөнгийн зах зээл, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж зээлийн хоршоо, дээрээс нь мөн гол терроризмын санхүүжилттэй тэмцэх үйл ажиллагааны хүрээнд бид нар үл хөдлөх хөрөнгө, үнэт металл, түүгээр арилжаа эрхлэгчид, дээрээс нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарыг нийлүүлээд авсан статистикийг ерөнхийд нь хэлчихье гэж бодож байна. Энэ 24.3-ын 15.3 нь бол хөрөнгийн зах зээл, үнэт цаасны зах зээл гэсэн үг. Даатгалын зах зээл энэ дотоодын нийт бүтээгдэхүүний 1.1 хувь, ББСБ энэ нь

бол 6.9, 7 хувь орчим байгаа. Хадгаламж зээлийн хоршоо бол 0.7 хувь орчимтой гэсэн ийм статистиктай байж байгаа. Тэгээд энэ дотроо бол хамгийн өндөр өсөлт үзүүлсэн нь бол хөрөнгийн зах зээл буюу өнгөрсөн оны мөн үеэсээ харьцангуй өндөр өсөөд 64 хувийн өсөлт үзүүлээд ДНБ-ний 15 хувьд хүрчхээд байгаа юм.

Г.Занданшатар:

Даваажанцангийн Сарангэрэл гишүүн тодруулж асууя.

Д.Сарангэрэл:

Дэлхийн тэргүүлэх банкуудын төлөөлөл оролцсон энэ хэлэлцүүлгээр бол ер нь бол Монгол Улсын энэ парламент, ялангуяа харьяа байгууллагын хувьд Монголбанкаа дэмжиж хамтарч ажиллах нь бол өнөөгийн энэ дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн хүнд нөхцөл байдал бол эерэг нөлөө үзүүлэх юм байгаа юм. Тийм учраас бол парламент банкаа дэмжиж ажиллах юм бол хамтарч ажиллах юм бол үр дүн бас илүү гарна шүү гэдэг ийм зөвлөгөөг давхар өгч байсан. Тэр үед бол 2023 оны хагас жилээс эдийн засгийн нөхцөл байдал дэлхий даяар нэлээн тийм бас эерэг болох ийм мэдээллийг өгч байсан. Сая та бүхэн маань бол 2024 оноос эхэлж бол бас эерэг нөхцөл байдал мэдрэгдэх байх гэж хэлж байна. Тэгэхээр энэ хагас жилийн энэ цоорхой энэ нөхцөл байдал бол та бүхэн маань яаж нөхье гэж бодож байгаа. Энэ хугацаанд бол бас би бодлого төлөвлөгөөгөө тодорхойлсон гэж бодож байна л даа. Энэ дээр тодруулга авъя. Баярлалаа.

Г.Занданшатар:

83. Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Сарангэрэл гишүүний асуултад тодруулаад хариулчихъя.

Тийм, энэ 2 сарын өмнө уулзалт маань болж байсан. Тэгээд 2 сарын хугацаа бол хэдийгээр богино хугацаа ч гэсэн бас дэлхийн нөхцөл байдал бол амаргүй байгаа нь бол одоо бас анзаарагдаад 2 сарын нөхцөл байдлаас бол одоо Украин ОХУ-тай холбоотой геополитикийн асуудлаар ерөнхийдөө Европын холбоо их төвөгтэй байдалд байгааг бас зарлаж байгаа. Ялангуяа тэр хүнсний бүтээгдэхүүний үнэ, энерги буюу эрчим хүчний үнэ бол энэ өвөл их төвөгтэй байна гэдгээрээ ингээд зарлаад явж байгаа. Тэгээд тэр утгаар олон улсын байгууллагууд нөгөө 2023 оны хагас жилд байсан үр дүнгийнхээ үзүүлэлтүүдийг эргээд дахиад хагас жилээр хойшлуулсан. Тэгэхээр 2023 оны төгсгөл болж, нөгөө эерэг үзүүлэлтүүд маань ингээд хойшоо бас хугацаа нь сунгаад явж байгаа. Монгол Улсын хувьд ч гэсэн мэдээж бид нар мөнгөний бодлогоо боловсруулахад яг л энэ төсөөллүүдийг бүгдийг нь бол өөрийнхөө тооцоо судалгаанд л бол хийсэн байгаа. Тэр утгаар ч тэр одоо уг нь бол энэ бид инфляцын түвшин бол б нэмэх.../минут дуусав/

Г.Занданшатар: Гүйцээгээд хариулчих. 83. Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Инфляцын түвшинг б +2 хувь руу бол 2023 оны төгсгөл рүү ер нь авчрах боломж байгаа болов уу гэж харж байсан чинь одоо саяын энэ бусад улс орнуудын жишгийг хараад дагуулаад 2024 оны эхний хагас болгож ингээж хойшлуулсан. Мөн 2023 оны эдийн засгийн өсөлтөөр 5 хувьтай байсан

бол 5 хувиа 4.5 болгож бас нааш нь 0.5 хувиар бууруулж бас татсан байгаа. Тэгэхээр энэ бүх тооцооллыг бол энэ тооцоо судалгаандаа бол хийж оролцуулж тооцсон байгаа.

Г.Занданшатар: Нанзадын Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар: Тойргоор бас иргэдтэйгээ уулзаж санал бодлыг нь сонсож явсан. Тэгээд хөдөө орон нутагт бол ялангуяа бас ард түмний амьдрал хүнд байна. Өдрөөс өдөрт л одоо юмны үнэ өсөж байна. Мал, махны үнэ бага байна. Аж ахуй эрхлэгч нар маань зээл олдохгүй байна гээд тэгээд бас зарим нэг зүйлийг бас тодруулж та бүхнээс асууя гэж бодсон юм. Ипотекийн зээл хөдөө орон нутагт 2023 оны төсөв дээр тавигдсан. Одоо хөдөө орон нутагт шилжиж очихоос гадна тэнд байгаа хүмүүс ипотекийн тэр 3 хувийн хөнгөлөлттэй зээлүүд олгогдох юм болов уу? Мөн өмнө нь авсан 6 хувийн хүүтэй авсан хүмүүс энэнд хамрагдаж болохоор байгаа юу гэж тодруулж байна? Мөн одоо ипотекийн төлөлтийг хойшлуулах боломж байгаа юу? Одоо энэ он чинь дуусаад 1 сарын 1-нээс эхлээд төлнө, төлөхөөр байгаа.

Тэгээд ийм хүнд цаг үед бас хойшлуулах ийм боломж байгаа юу гэдэг саналуудыг их гаргаж байна. Мөн энэ гадаад валютын нөөц бол багасчихсан байгааг бүгд мэдэж байна.

Тэгээд боомтоор экспорт бол гайгүй сайн яваад ер нь хуучин үедээ нэлээд ойртож байгаа нүүрсний экспорт. Тэгсэн мөртөө валют орж ирсэн валют нь хаашаа явчихдаг юм бэ гэдэг асуудлыг их ярьж байгаа. Тийм учраас та бүхэнд тоон мэдээлэл байна

уу? Хэдий хэмжээний энэ жил экспортоор валют орж ирсэн юм.

Ялангуяа нүүрсний энэ оптик гэрээ нь одоо хэдэн хувь нь экспортод гарч байгаа нүүрсний хэдэн хувь нь оптик гэрээ байгаад байгаа юм. Тэгээд ирэх жил үргэлжлээд ингээд бас өрөндөө нүүрснүүд гараад явчих юм уу, ер нь энэ хани долларынхоо нөөцийг яаж нэмэгдүүлэх гэж байгаа юм гэдэг дээр тэгээд ирэх жил төлөх гадаад өрийг Засгийн газрын өр хэчнээн доллар байгаа юм. Одоо үлдэгдэл 2.5 тэрбум америк доллар гэж байсан. Ирэх жил хэчнээнийг төлөх юм. Энэ чинь хүрэлцээтэй юм уу? Нэмж яаж нөөцөө нэмэгдүүлж өрөө төлөх юм гэдэг ийм асуудлуудыг бас их ярьж санаа зовж байгаа.

Мөн одоо энэ инфляц юмны үнэ чинь ингээд цаашаага өсөөд ингээд яваад байх юм уу гэдэг асуудал инфляцыг бууруулах, юмны үнээ тогтворжуулахад та бүхэн ямар арга хэмжээ авах юм бэ гэдэг ийм асуудлуудыг сонгогчдын зүгээс ярьж асууж байна. Та бүхэн дээр бас тодорхой мэдээлэл өгөөч гэж хүсье.

Г.Занданшатар: 83.
Монголбанк Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Тийм, энэ Засгийн газар дээр нэг ийм орон нутгийн орон сууц, ипотекийн зээлийг дэмжих зорилгоор 6 хувийн хүүтэй зээлийг 3 жилийн хугацаатай, 3 жилийнх нь эхний 3 жилийн хугацаанд нь 3 хувьтай байлгахаар ийм төсөл яригдаж байгаа. Тэгэхлээр энэ төслөөр явах юм бол ерөнхийдөө шинээр зээл авч байгаа иргэнд хамаарах юм байна лээ.

Тэгэхээр шинээр зээл авч байгаа иргэн бол эхний 3 жилдээ 3 хувиар төлөөд явахаар ийм өшөө одоо урьдчилгаа нь 30 хувь байх юм бол тэгээд 20 хувь болгож буураад 10 хувь дээр нь бол тэр зээлийн батлан даалтын сан баталгаа гаргаад явахаар ийм төсөл бол хийгдчихсэн байгаа юм байна лээ. Тэгэхлээр энэ бол ингээд хийгдээд явах байх. Зүгээр одоо зээлээ авчихсан, одоо 6 хувийн хөтөлбөрт хамрагдсан улсууд бол ийм 3 хувийн хөтөлбөрт хамрагдах тийм боломж байхгүй байх. Тэр журмынх нь дагуу л, тэгэхлээр энэ бол шинээр зээл авч байгаа иргэдэд л хамаатай ийм хөтөлбөр байгаа. Ерөнхийдөө 8 хувийн болон 6 хувийн ипотекийн хөтөлбөрийн зээлийг бол одоо ковидын цар тахлын хүнд нөхцөлд бол төлөхгүй төлөх хугацааг нь Ковидын хуулийн дагуу энэ 12 сарын 31 хүртэл бол хойшлуулсан. 1.5 жилийн хугацаанд бол 64000 гаруй иргэний 3.6 их наяд төгрөгийн зээлийн сар тутамд төлөх төлбөрийг бол 1 жилээр төлөхгүй байхаар чөлөөлчихсөн. Чөлөөлөх юу байх вэ хугацааг нь хойшлуулчихаад явж байгаа. Тэгээд энэ ковидын хууль маань энэ оны төгсгөлд дуусахаар эргээд шинэ 2023 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлээд хуваарийнхаа дагуу сар болгоны хураамжийг ингээд төлөөд явахаар ийм хуулийн зохицуулалт байгаа.

Экспортын орлоготой холбоотой асуулт дээр ерөнхийдөө Монгол Улсын экспорт бол 8 сарын байдлаар 5.2 тэрбум доллар байгаа. Тэрний 5.2 тэрбум доллароос яг Монгол Улсад мөнгөөр орж ирсэн нь бол 2.8 тэрбум доллар. Тэгэхээр энэнд бол ингээд бараг 2 тэрбум доллар гаруй бэлэн мөнгө урсгал бол байхгүй байна гэж харж байгаа. Яг тухайлан бүр яг нүүрсний компаниуд дээр ярих

юм бол нүүрсний экспорт маань 3.8 тэрбум доллар, тэрний орж ирсэн нь бол 1.3 тэрбум доллар. Тэгэхлээр энэний зөрүү гэхэд бараг 2.5 тэрбум доллар байх жишээтэй. Тэгэхлээр энд таны дурдаж байгаа тэр урьд нь бол оптекоор авчихсан ийм зээлүүд байгаа.

Өглөө асуултад бол бас Сангийн сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд Хүрэлбаатар хариулж байхад бол оптекийн зарим гэрээнүүд бүр 2019, 2018 оны оптекууд одоо хүртэл мөнгийг нь авчхаад бүтээгдэхүүнээ гаргаагүй явж байгаа юм байна лээ гээд. Энэ нь бол ойролцоогоор 15, 20 орчим хувийг одоо зөөж байгаа.

Хэдийгээр өнөөдөр нүүрс маань өөрөө ковидын өмнөх хэвийн хэмжээндээ тээвэрлэлт очиж байгаа ч гэсэн бидний өмнө нь мөнгийг нь аваад хэрэглэчихсэн ийм тодорхой нүүрснүүд бол гараагүй гэдгээрээ одоо гараад мөнгөний урсгалын орлогыг бол ингээд бууруулж байгаа.

Өөр нэг зүйл нь бол одоо бас зарим компаниуд ялангуяа нүүрс экспортлогч компаниуд энийгээ бэлэн мөнгөөр биш зөрөөд нөгөө бүтээн байгуулалтын бартер маягийн бараа бүтээгдэхүүнүүд аваад явж байгаа нь өөрөө энэ орлогыг бол тэр хэмжээгээр бууруулж байгаа юм. Ирэх онд төлөгдөж байгаа зээлтэй холбоотой өр авлагатай холбоотой асуудлыг бол Сангийн яамтай нэлээд яриад явж байгаа. Тэгээд 2023 он бол хамгийн дарамттай, нэг доор төлөх хамгийн том хэмжээтэй өрийн хэсэг байгаа. Тэгээд өрийн удирдлагынхаа хүрээнд бол энийг бол төлнө гэж явж байгаа хамгийн том өр нь бол Хөгжлийн банктэй холбоотой 800 сая долларын өр байгаа. Гэрээгээ бондын 500 гаруй

сая долларын өр бол ингээд ирэх онд төлөгдөхөөр байгаа учраас бол энийг дахин санхүүжүүлэх юм уу, эсвэл олон улсын байгууллагуудтай ярьж, тодорхой шийдлийг гаргахаар ярьж байгаа.

Г.Занданшатар: Зочдоо танилцуулъя.

Нийслэлийн ерөнхий боловсролын 52 дугаар сургуулийн ахлах ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Золзаяа багштай ангийн хамт олон та бүхэнд сурлагын өндөр амжилтыг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсье.

Одоо 2 гишүүний асуулт хариултын дараа, нэг гишүүний асуулт хариултын дараа санал хураалт явуулна. Үг хэлнэ гишүүд чуулганы танхимд цуглаарай.

Одоо Шатарбалын Раднаасэд гишүүн алга байна. Одоо Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна. Энэ асуулт хариултын дараа гишүүд чуулганы танхимд цуглаарай. Үзээд сууж байгаа гишүүд орж ирээрэй.

Ж.Бат-Эрдэнэ: Нэлээдгүй зүйл сонслоо.

2023 онд барих мөнгөний бодлогын талаар Монголбанкнаас гаргасан мөнгөний бодлогыг танилцуулах шиг боллоо. Нэлээдгүй асуултууд ч орж ирлээ. Ер нь бол зүгээр дүгнээд хэлэхэд өөдрөг харж өөдрөг амьдарцаа гэсэн ийм дүгнэлт гарч байх шиг байна. Яг эдийн засаг маань ямар хэмжээнд байгаа билээ, ямар уналтай байгаа билээ, долларын

чинь ханш яг өдийд ноднин жил бол 2800 хэдтэй л байсан. Яг ийм хэмжээний бодлого ноднин жил бас дахиад л орж л ирж байсан. Энэ жил дахиад ийм бодлого орж ирж л байна. Гадна нөхцөл байдал яах вэ, нөлөөлж байгаа байх. Гэхдээ жил болгоны та бүхний оруулж ирдэг бодлого иймэрхүү зүйл л орж байдаг шүү дээ. Нэг асуулт байна. Ажлын хэсэг дээр чинь та бүхэн яг өөрсдөө оруулж ирсэн үү, эсвэл одоо Засгийн газар хэр оролцоотой байсан юм. Та бол үндсэндээ одоо Монгол Улсын Засгийн газрын тэргүүн Оюун Эрдэнэ сайдын өмнөөс 80 хувийг нь бол хариулчихлаа.

Мөнгөний бодлого гэдэг бол Монголбанкнаас барьж байгаа инфляцтай холбоотой асуудлууд, үнийг тогтвортой байлгах асуудал, тэгээд инфляцын түвшин бага байх ёстой, энэ дээр одоо та мөнгөний бодлого, тэр үндсэн хүүгийн дээш нь доош нь татах энэ тэр гэсэн ийм гол асуудлууд л байх байх. Энэнтэй уялдаад цаашаа эдийн засаг ямар арга хэмжээ авах юм. Жишээ нь бол одоо уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ л гэж байна. Анхан шатыг нь нэмэгдүүлнэ л гэж байна. Үгүй тэгээд энэ чинь одоо Засгийн газрын асуудал шүү дээ. Та үндсэндээ бол 80 хувийг нь Засгийн газрын өмнөөс хариулчихлаа. Тэгээд ажлын хэсэг чинь хир Засгийн газрын энэ үйл ажиллагаануудад оролцсон юм, нэгдүгээрт.

Дараа жилийн өдийд бид нар энэ мөнгөний бодлоготойгоо уялдуулаад эдийн засаг хир өссөн бэ гээд. Өөрөөр хэлбэл одоо та ирэх жилүүдэд 4-5 хувь эдийн засаг өснө л гэж байна.

Дээрээс нь инфляцын түвшинг бууруулна. Нэг оронтой тоо руу оруулна. Тэгээд 2024 онд бол бүр 6 хувь руу оруулна л гэж байх шиг байна. Тэгээд энд чинь маш олон зүйлүүд хийгдэнэ шүү дээ. Экспортоо нэмэгдүүлэх шаардлагатай болно, бодит эдийн засгаа хөгжүүлэх хэрэгтэй болно, уул уурхай, тээвэр ложистик гээд маш олон зүйлүүд хийгдэнэ шүү дээ. Энийг та хийх юм уу? Монгол Улсын Засгийн газар хийнэ шүү дээ. Яамдууд хийнэ шүү дээ. Тэгээд өнөөдөр одоо яамдуудынх нь орж ирээд энд яг бодит уг нь бол таны өмнөөс энэ хүмүүс хариулж байх ёстой шүү дээ.

Экспортыг одоо нэмэгдүүлнэ гэж яг бодит байдлаар уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэхэд анхан шатных нь асуудал дээр та нэлээдгүй зүйл ярилаа. Бодит байдал дээр яаж экспортоо нэмэгдүүлэх юм. Махных экспортыг нэмэгдүүлэх юм уу, тэр малын бүтээгдэхүүний гол бүтээгдэхүүн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээ гадагшаа гаргах юм уу? Гаргана гэж байгаа бол юу юу чинь гарах юм, тэр дотор.

Дээрээс нь дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх ёстой. Үндсэндээ бол Монгол Улсын эдийн засаг, татвар төлөгчтэйгөө хэдэн төгрөгөөр, улсын төсөв дээрээ хэдэн барилга байшин тусгадаг, эндээ буцаад аж ахуйн нэгжүүд нь энд нь тендерт орж энэ бүтээн байгуулалтаа хийдэг. Эргээд нэг хэдэн төгрөгийн татвар төлдөг, дахиад нөгөө татварынхаа тендертээ орж нөгөө бүтээн байгуулалт, цэцэрлэг, сургуулийнхаа бүтээн байгуулалт руу ордог. Үндсэндээ нэг жижигхэн тогоон доторх зүйл явагдаад байна шүү дээ.

Тэгэхээр энэний цааш валют орж ирдэг бүтээн байгуулалт хийдэг, дээрээс нь баялаг бүтээх талын энэ асуудлууд чинь энэ дээр хардахгүй байна шүү дээ. Үндсэндээ бол мал нь үржиж байна гэдэг нь бол үндсэндээ баялаг бүтээгдэж байгаа байх. Цаана нь хөдөө аж ахуйн ургац жил болгон нэг тодорхой хэмжээний ургац хураалтаар бас баялаг бүтээгдэж байгаа байх. Үндсэндээ бол баялаг ингээд цаашаа бүтээгдэхгүй байна шүү дээ. Тэгэхээр энэ баялаг бүтээгдэж байгаа эдийн засгийн эргэлтэд орж байгаа мөнгөний нийлүүлэлт орж байгаа тэр тусмаа нөгөө 10 их наядын төсөв хөтөлбөрөөс чинь энэтэй яаж уялдаж явах юм гэдэг нэг ийм зүйл дээр хариулт өгөөдхөөч.

Г.Занданишатар: 83.
Монголбанк хариулъя.

Б.Лхагвасүрэн: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Монголбанк бол мөнгөний бодлогоо гаргахдаа түрүүн бас Баттөмөр гишүүний асуултад бид хариулахад бол эдийн засгийн өсөлт, инфляц хани, энэ төлбөрийн тэнцэл, бусад макро бүх л зохистой харьцааны үзүүлэлтүүдийг хооронд нь тэнцвэрийг нь хадгалах маягаар хийгээд явж байгаа. Тэр ч утгаараа мөнгөний бодлогоо хүртэл огцом чангалуулахгүйгээр ингээд аажим чангаруулаад л явж байгаа. Энэний үр дүн гэж хэлж болохоор бас зүйлүүд бол гарч ирээд байгаа. Ялангуяа Монгол Улсын эдийн засаг нэгдүгээр улиралд 3.8 хувийн агшилттай байсан бол, 2 дугаар улиралд нэмэх нь 1.9 хувийн өсөлттэй гарсан. Зөрүүгээрээ бол бараг 5.7 хувийн ийм эдийн засаг

сэргэсэн гэсэн статистик тоо баримт байна. Үндэсний статистикийн хорооноос хагас жилийн тайланг бол ингэж танилцуулсан байгаа. Энэ дотор бол уул уурхайн салбар, уул уурхайг дагасан тээврийн салбар, барилгын салбар 3 бол уналттай байгаа. Бусад салбарууд дээр буюу хөдөө аж ахуйн салбар үйлчилгээ, худалдаа, тэгээд боловсруулах үйлдвэрийн салбарууд дээр өсөлттэй гарсан. Өсөлт нь бол зөвхөн энэ 1, 2 дугаар улирлын энэ оны өсөлт биш. 2019 оны хагас жилтэй харьцуулахад 2019 оны буюу Ковидын өмнөх үетэй харьцуулахад өсөж ингэж гарсан нь Ковидын дараах хамгийн том сэргэлт гарч байгаа ийм салбарууд болсон.

Тэгээд энэ ялангуяа тэр уул уурхайн бус тээвэр барилгын салбараас бусад салбар гэдэг маань хамгийн их хүн ажилладаг, хүний оролцоо ихтэй, ажиллах хүчний оролцоо өндөртэй ийм салбарууд дээр сэргэлт гарч байгаа нь ерөнхийдөө эдийн засгийг эдгээр салбаруудаар сэргээд явахад бол боломж байна гэдгээр харж байгаа. Тэгээд энэ нэг эмзэг сэргэлтийг бол тодорхой түвшинд нь хадгалах нь төсөв мөнгөний бодлогоор бол тодорхой хэмжээнд бас дэмжих л зайлшгүй шаардлага байгаа гэдэг утгаар бас мөнгөний бодлогоор бол дэмжих, бас энэ орон зайг нь хадгалах ёстой гэдгээрээ харж байгаа. Энэ өнцгөөсөө бол ирэх оны мөнгөний нийлүүлэлт бол 10-15 хувийн өсөлтийн орчим гарах болов уу гэж бид өөрсдөө төсөөлж байгаа.

Өнөөдрийн байдлаар бол өнгөрсөн онтой харьцуулахад бол мөнгөний нийлүүлэлт маань бараг 1.4 хувиар бол буурчхаад явж байна.

Ерөнхийдөө буураад ингээд нэлээн хатуу мөнгөний бодлогыг явж байгаа ийм статистик тоо баримтууд маань харагдаж байгаа. Тэгэхдээ энэ сэргээж байгаа эдийн засгийг тодорхой хэмжээнд сэргээх, ялангуяа хавтгайд нь биш, ялангуяа тэр экспортод чиглэсэн уул уурхайн бус экспортод чиглэсэн төрөлжсөн тэр үйлдвэрүүдийн дахин боловсруулах шат дамжлагыг дээшлүүлэх тал руу нь санхүүжилтийг илүү олгох, илүү зорилтот хэсэг рүү нь олгож ажиллаж гэдгээрээ Монголбанк энэ дээр нэлээн түлхүү оролцъё гэж явж байгаа юм.

Тэгээд өнгөрсөн энэ 2022 онд, 2022 оны эхнээс эхлээд бид ноолуурын салбар дээр тэр нийлүүлэлтийн сүлжээн дээр нь тодорхой үйлдвэр, ААН-үүдтэй ингээд туршилт хийгээд явсан. Энэ туршилт бол нэлээн амжилттай яваад л болох юм байна гэдэг нь харагдсан учраас ноолуураас гадна бас тодорхой экспортод гардаг бусад бүтээгдэхүүн үйлчилгээн дээр энийгээ бас дамжаад залгуулаад явъя гэдгээрээ энэ 2023 оны төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг боловсруулсан. Энэ дээрээ ч гэсэн хамтран ажиллахаар талуудтай ярилцаад энэ 10 дугаар сарын сүүлээр Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтраад экспортлогчдын ийм том хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгуулах гэж байгаа. Мөн Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтраад экспортод гаргадаг тэр салбарууд ААН-үүддээ илүү дотно мэдээллийн сан үүсгэж ажиллаад санхүүжилтийг нь бол цаг алдалгүй өгч, энэ нийлүүлэлтийн сүлжээг тасалдахгүй байх тал дээр нь хамтран ажиллахаар тохирч байгаа.

Тэр талаас л мөнгөний бодлого боловсорсон. Тэрнээс биш бусад яамд,

Засгийн газрын ажлыг бол урдуур нь орж хийхээр тийм зүйл байхгүй байгаа.

Г.Занданшатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя. 1 минут.

Ж.Бат-Эрдэнэ: Мөнгөний бодлогынхоо хүрээнд бол та бүхний гаргаж байгаа зүйл зөв байх. Мэдээж технологийн хувьд олон улсын түвшний хийдэг жишигийн хувьд эдийн засгийнх энэ хүндрэлийг даван туулах бодлогууд чинь болж байгаа байх гэж бодож байна. Ганцхан энэнтэй уялдаад та хэллээ шүү дээ. Талуудтай хамтарч ажиллаж байгаа гэж байна. Талуудтай хамтарч ажиллана гэдэг маань энэ чинь хамгийн гол бодит салбарууд дээр байж байгаа Монгол Улсын Засгийн газар болон яамдуудтайгаа ажиллах асуудал бодож байгаа шүү дээ. Тухайн зах зээлээ яах юм? Одоо жишээ нь тээвэр ложистикийн асуудлууд гээд л ярьж байна. Тээвэр ложистикийн асуудлуудыг нээх бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг сайжруулна. Энэ дээр ямар асуудлууд гаргаж ирэх юм бэ?

Тэгэхээр миний асуугаад байгаа зүйл тэр байхгүй юу даа? Яг энэ бодит бүтээн байгуулалт хийж байгаа яамдууд салбаруудынхаа тэр бодлоготой энэ бодлого чинь уялдаад таны гаргасан бодлого, таны мөнгөний хоорондын уялдааг яг гүйцэтгэл дээрээ хийж байгаа хүмүүс чинь яг нэг ойлголттой байгаа юу гэдгийг л би асуугаад байгаа байхгүй юу даа. Хамтарч болно.../минут дуусав/

Г.Занданшатар: 83. Монголбанк Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Бат-Эрдэнэ гишүүний асуултад тодруулаад хариулъя.

Тийм тэгэхлээр нөгөө түрүүн миний хэлээд байгаа тэр Худалдаа аж үйлдвэрийн танхим гэдэг маань тэр нөгөө салбаруудын холбоодууд байгаа. Дээр нь мэдээж Засгийн газар, яамдуудын хувьд бол бодлого гаргаж байгаа гэдэг утгаар энэ дээр ямар бодлогын шийдвэр гаргавал нийцтэй байх вэ гэдгээрээ л эхний хэлэлцүүлгээ хийгээд тэрэн дээрээ ажиллаад явъя гэж харж байгаа. Түрүүн Баттөмөр гишүүний асуултад манай бас Баярдаваа захирал хариулж байсан. Экспортод бүтээгдэхүүнээ гаргахын тулд 28 тусгай зөвшөөрөл лиценз аваад явж байгаа гээд ийм зүйлүүд байгаа. Тэгэхлээр энэнийх нь аль хэсэг нь хэрэгтэй, аль нь хэрэггүй, энийг нь яаж цахимжуулбал яаж хурдасгах вэ? Нийлүүлэлтийн сүлжээн дээр хаана нь тэр санхүүжилтийг нь доголдол байгаа юм, хаана нь тэр санхүүжилт нь цаг алдахгүй олгогдоход энэ бүтээгдэхүүн үйлчилгээ маань өөрөө экспортод чөлөөтэй гарч болох юм. Мөн олон улсын зах зээл рүү гаргахад тэр худалдааны санхүүжилт буюу банкны зүгээс энд нь яаж дэмжлэг үзүүлж ажиллах юм гэдэг бүх талаас нь сууж байгаад нэг ийм бодлогын шийдлийг гаргахаар л ажиллаж байгаа юм.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Доржханд гишүүн, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн. Тогмидын Доржханд гишүүн үг хэлнэ.

Т.Доржханд: Баярлалаа. Тэгэхлээр 2 зүйлийг тов тодорхой хэлье.

Нэгдүгээрт, энэ мөнгөний бодлогын зорилт чинь биелэхгүй ээ, бодитой биш тооцоолол оруулж ирсэн. Ирэх жил инфляцыг 6 хувь дээр барина гэдэг бол бүтэхгүй, бүтэхгүй шүү дээ.

Хоёрдугаарт энэ ханиш бас тогтворжуулна гээд бүтэхгүй. Тэгээд энийгээ Монголбанкныхан маш сайн мэдэж байгаа. Бүх эдийн засагчид маш сайн мэдэж байгаа. Энийгээ хэлж чадахгүй л байгаа.

Тэгэхээр одоо энийгээ та нар шинэчлэх хэрэгтэй, өөрчлөх хэрэгтэй, зорилтоо яг тодорхой түвшинд нь аваачих хэрэгтэй. Яагаад бүтэхгүй байгаа юм бэ гээд тэгэхээр өнөөдөр Монгол Улсын төсөв тэлсэн 20.5 их наядаар ороод ирсэн. Энэ чинь бүгдээрээ импортыг дэмжиж байгаа. Импортыг дэмжиж байгаа гэдэг чинь долларын эрэлтийг бий болгож байгаа юм. Долларын эрэлтийг бий болгож байна гэдэг чинь бид нар нөөцөө алдана гэсэн үг. Ханишаа барьж дийлэхгүй. Нөгөө талдаа инфляцын асуудал чинь бол тодорхой хэсэг нь нийлүүлэлтийн инфляц байна. Тэр чинь бол богино хугацаанд шийдэгдэх асуудал биш. Тээвэр ложистикийн асуудал байгаа гээд. Монголбанкныхан бол хэлээд байгаа шүү дээ. Яах вэ Засгийн газар зарим яамд болохлоор үгүй ээ, энэ чинь эрэлтийн инфляц гээд. 2 талдаа бөмбөг шидээд байгаа байхгүй юу. Гэхдээ яг бодит байдал нь бол юу байна вэ гэхээр энэ инфляцыг та нар шийдэх боломж нь бол байхгүй. Яагаад гэвэл ийм их өндөр төсөвтэй юм чинь дээ. Би ганцхан юм хэлье.

Өнөөдөр Монгол Улсын төсөв тэлээд 20.5 болчихсон. Гэтэл Монголбанкаар банкнуудаар дамждаг мөнгө чинь буураад 25 тэрбум болчихсон. Хоорондоо яг адилхан болчихсон нэг нэг. Төсвөөр чинь ингээд халамж гээд төр ингээд санхүүжүүлдэг бол банкны системээр чинь бизнесийг дэмждэг. Үгүй тэгээд өөрөөр хэлэх юм бол ингээд бизнесийг дэмждэг санхүүжилт чинь нэг нэг болчихлоо. Олон улсад энэ чинь 80/20 байдаг юм. Олон улсад тийм байдаг. Гэтэл манайх ингээд төр ийм болчихлоо, данхайчихлаа. Тэгээд төсөв нь өөрөө ингээд данхайхаар чинь мөнгөний бодлого дээр ямар ч орон зай байхгүй. Огт байхгүй, худлаа. Ийм болохоор энэ удаа бид нар мөнгөнийхөө бодлогыг урдаа тавиад, төсөв нь түүнд тохируулагч байдлаар явах ийм л бодлогын сонголт байгаа.

Харамсалтай нь энэ сонголтыг гаргаж өгсөнгүй. Яагаад гэвэл төсөв маань тэлчихсэн ороод ирчихлээ. Тэгээд Монголбанк бол ийм их тэлчихсэн тэлчихсэн төсөв дээр бодлогын хүүгээ мянга нэмээд ямар ч үр дүн гарахгүй. Бодлогоо хатууруулаад ч гэсэн үр дүн гарахгүй. Аль алийг нь л төсвөө тэл, хумих ёстой. Нөгөө талдаа бол мөнгөнийхөө бодлогыг чангаруулах ёстой. Ингэж байж л бид нар энийг хохирол багатай давна.

Хоёрдугаарт бол хамгийн том эрсдэл хаана вэ гэхлээр төлбөрийн баланс шүү дээ. Хамгийн том эрсдэл бол төлбөрийн баланс байна. Төлбөрийн баланс дээр яагаад вэ гэхлээр ирэх жил маш олон бондуудын төлбөрүүд хийгдэнэ. 500 гаруй сая долларын бондын төлбөр хийгдэнэ. Хөгжлийн банкны бас баталгаатай 500 гаруй сая долларын бондын төлбөр

хийнэ. Хөгжлийн банк энийгээ санхүүжүүлэх мөнгө байхгүй шүү дээ, Самурай бондын төлбөр хийгдэнэ оны эцсээр. Дээр нь болохоор 200 гаруй сая доллар. Тэрийгээ бол харин хийж магадгүй байх. Тэрбум долларын ийм санхүүжилтийн хэрэгцээ байна нэмэх нь Хятадын төв банкны своп ллайн 2.5 тэрбум доллар хугацаа нь дуусаж байгаа.

Ингэхлээр энэ асуудлыг шийдэж чадахгүй бол деполт болно. Энэ бол тодорхой. Чадахгүй тохиолдолд. Яг энэ бодлогоороо явах юм бол чадахгүй байх эрсдэл байна. Бодлогоо өөрчлөхгүй бол болохгүй нь ээ Монголбанкныхан. Харин би Монголбанкны удирдлагуудыг хариуцлага тооцох ёстой гэдэг байр суурин дээрээ байгаа шүү. Яагаад вэ гэхээр он гарснаас хойш 4.1 тэрбум ам.долларын интервенц хийсэн. Энэ бол өмнөх жилүүдийн дундажтай харьцуулах юм бол 2-3 дахин өндөр үзүүлэлт ойлгож байна. Дайн тулаантай Оросууд худалдаж авсан байна гээд. Гэхдээ энэнийхээ үр дүнд 1.7 тэрбум долларынхоо нөөцөө алдчихсан. Үр дүнд нь юу болж байгаа юм, бүгдээрээ харлаа шүү дээ.

Монгол Улсын бондын үнүүд зах зээл дээр ингээд шалаар нэг боллоо шүү дээ. Яасан гол мессеж нь бол нөөцөө алдчихлаа. Нөөц байхгүй юм байна. Төлчхөж чадахгүй юм байна. Ийм болохоороо ингээд өгөөж нь 30-40 хувь байна шүү дээ. Одоо жиргээгээр бүгдээрээ л санхүүч нар бичээд л явж байна. Бодит байдал нь бол энэ. Өгөөж 30-40 хувь гэдэг чинь өөрөөр хэлэх юм бол манай үнэ цэнэ уначхаж байна гэсэн үг байхгүй юу. 85 хувь руу ингээд уначхаж байна гэсэн үг. Үр дүнд нь манайх бонд арилжих боломжгүй.../минут дуусав/

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогтын урилгаар Монголын Үйлдвэрлэл үйлчилгээний хоршоодын холбооны Ховд аймгийн ахмад ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт ахмадууд, аж үйлдвэрийн тэргүүнүүд та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсье.

Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн үг хэлнэ.

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын эдийн засаг үндсэндээ бол жил болгоны хөрөнгө оруулалт, шинэ бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт дээр ер нь тогтоож байгаа шүү. Дээрээс нь уул уурхайн бүтээгдэхүүн, экспорт бас нэлээн нөлөөлж байгаа байх. Нэлээн татаж авч явж байгаа. Одоо нүүрсний экспортод бид нар зам тээврийнхээ асуудлууд, ложистикийн асуудлууд, тээврийн асуудлуудыг нэлээд шийдээд Монгол Улсын Засгийн газрын хэмжээнд боомтын асуудал шийдсэн сайдтай болоод нэлээн гарах байх. Бас хаалга үүд нь нээгдэх байх. Тэглээ гээд буцаад орж ирж байгаа яг бодит хөрөнгө оруулалт бодит валют, доллар нь бол байхгүй алга болчихоод байна шүү дээ.

Хоёрдугаарт, жил болгон хийж байгаа хөрөнгө оруулалтууд энэ бол бас ААН-үүд амьдрах ААН-үүд ажиллах ийм боломж бололцоог нээж байгаа. 2023 оны бүтээн байгуулалт, шинэ бүтээн байгуулалт. Жишээ нь бол байхгүй. Шинэ бүтээн байгуулалт энэ төсөв дээр орж ирээгүй. Тэгэхээр

үндсэндээ бол одоо бид нарын хуучин бүтээн байгуулалт дээр орж ирж байна. Өөрөөр хэлбэл 2023 онд баялаг бүтээх ийм боломж бололцоо бол үндсэндээ бас зогсонги байдалтай байж байгаа юм. Мөнгөний нийлүүлэлт чинь хүнд болчихсон байна. Эдийн засгийн судас болсон, мөнгөний нийлүүлэлт нь зогсонги байдалд орчихсон, валют өсчихсөн нөхцөл байдал хүнд байгаа шүү. Ямар ч байсан зүгээр бодлогын хүрээнд бид нар нэлээн өөдрөгөөр төсөөлж орж ирж байгаа юм байна. Хойтон жил гээд тэгэхэд бид нар инфляцаа болоод 6 хувь руу оруулъя, нэг оронтой тоо руу оруулъя гэсэн ийм бодлоготой байгаа юм байна. 2023 ондоо бас эдийн засаг нэлээн өсөлттэй гарна гэж үзэж байгаа юм байна. Гэхдээ та нарын саяын танилцуулга дотор бол яг бодит хөрөнгө, салбаруудын өсөлт нь бол харагдахгүй байгаад байгаа шүү дээ.

Одоо ажиллаж гадаа байгаа ААН-үүдийн ярьж байгаа, хэлж байгаа зүйлүүдийг та нар бас сонсох хэрэгтэй шүү дээ. Мөнгөний нийлүүлэлт байхгүй болчихсон, хөрөнгө оруулалтын асуудлууд нь зогсчихсон, банк ямар нэгэн цус төлжүүлэх зээл тусламж юу хаачихсан. Өнөөдөр та бүхэн ингээд л яриад банкны зээлийг бол нээчихнэ гэсэн маягийн л юм ярих шиг боллоо. Энэ чинь яг цаашаагаа нэгдүгээрт нээгдээд явж байгаа юу, явах уу, үгүй юу гээд,

Хоёрдугаарт, миний нэг эмзэглээд байгаа асуудал шүү дээ. Та бүхний гаргаж байгаа энэ бодлого, энэний яг хэрэгжүүлэлтэд Монголбанкны хүрээнд та нарын бодлого бол зөв явж байгаа байхаа. Яг энэний хэрэгжилт дээр бол хүссэн,

хүсээгүй Засгийн газрын хэрэгжүүлэх бодлого бол орж ирэх ёстой шүү дээ залгаад. Тэгээд өнөөдөр яг энэ бодит салбарын сайд нартай таны хариулж байгаа хариулт уялдаад явж байгаа юу, үгүй юу гэдэг чинь бас маргаантай байна шүү дээ. Өнөөдөр энэ дотор 5, 6 том том заалтууд байж байна. Уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлье, боловсруулалтын шатыг нэмэгдүүлье маш зүйтэй. Олон жил ярилаа шүү дээ бид нар энийгээ. Олон жил яриад хийж чадаагүй өнөөдрийг л хүрсэн. 1 жилийн хугацаанд бол бид нар энийг хийнэ гэдэг бол бас л итгэл үнэмшил хүрэхгүй байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр энийг итгэл үнэмшил хүргэхийн тулд хэн хэнийг ард нь зогсох юм бэ гэхээр яг энэ мөнгөний бодлого дээр давхар Засгийн газрын Монгол Улсын Ерөнхий сайд Оюун Эрдэнэд үүрэг өгчихсөн байж байгаатай уялдуулаад Засгийн газрын сайд нар маань энэ дээр итгэл үнэмшилтэйгээр таны хариулсан хариултыг хариулаад явбал бид нарт илүү итгэл үнэмшилтэй болох ёстой байхгүй юу.

Тэгэхээр яг энэний ар дээр ямар бодлогууд байх юм. Одоо төсөв орж ирж байна. Төсөвтэй уялдаад ямар, ямар бодлогууд орж ирэх юм. Нэлээн одоо төсвийн хэмжээнд бол шинэчлэл бол хийгдэж байгаа. Энийг бол сайшаалтай харж байна. Гэхдээ эдийн засаг болоод гадна та одоо жишээ нь ААН-үүдтэйгээ уулзаад гэж байна. Аж ахуйн нэгжүүдтэй уулзах бодлогын хүрээнд ямар дэмжлэг байх юм. Ер нь эцсийн эцэст бол дэмжлэг шүү дээ.

Хоёрдугаарт, 10 их наядтай холбоотой асуудлуудыг би сая сөхөж тавилаа. Энэ 10 их наяд төгрөг чинь үндсэндээ бол экспорт, импортыг

дэмжсэн үйлчилгээгээ дэмжсэн ийм л төсөл хөтөлбөр болоод өнгөрсөн шүү дээ. Энэ чинь буцаад нөгөө нэг валют нэмэгдэх, долларын ханш өсөх энэ нөхцөл байдлыг бол доод сууриар нь хийчихсэн. Нэг талдаа бол коронагийн хүнд хэцүү байдлаас бид нар гарсан ч гэсэн бодит салбар руугаа хандсан энэ 10 их наядтай холбоотой таны ярьсан уул уурхайн бусад бүтээгдэхүүнийг экспортод оруулсан импортоо тодорхой хэмжээнд зохицуулалт хийсэн. Тэгээд дотоодын баялаг бүтээгч рүүгээ хандчихсан, мөнгөний нийлүүлэлтээр юу гэдэг юм эдийн засаг хөдөлгөөнд орсон ийм бодлоготой одоо таны мөнгөний бодлого чинь уялдах ёстой л гэж харж байгаа шүү. Амжилт хүсье.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Тэгээд энэ гишүүдийн яриад байгаа төлбөрийн тэнцэл яг 1 жилийн дотор ингээд сайжирчхаад нэг оронтой тоон дээрээ болчихно гэдэг бол үнэхээр боломжгүй шүү дээ. Тэгэхээр энэ бол зүгээр би зорилт тавьж байгаа б +2 гээд яриад байгаа шүү дээ. Тэгэхээр та нар маань төлбөрийн тэнцэл дээр нүүрсний экспорт нэг удаа тэр 36 сая тонноор гарчихвал боломжтой гэж ярьж байгаа бол ганц нүүрс биш зэс, алтны тухай ярьж байна шүү. Тэгэхдээ алт бол өөрөө бас амаргүй байна гээд сая Уул уурхайн сайд ярьж байна. Тэгэхээр энэ алт хөтөлбөр энэ тэрээ төсөвтэйгөө уяад энэ нөөцүүдээ та нар бас зоригтой оруулж ирж магадгүй стандарт бус арга хэмжээгээ аваад явчих шаардлагатай байна шүү.

Өнөөдрийн бүтэн өдрийн хариултуудаас харахад төлбөрийн

тэнцлийг сайжруулах тал дээр бас л яг бодит энэ тохиргоогоо төсөвтэй уяж хийсэн зүйлүүд нь бол нэлээд тийм бүрхэгдүү ерөнхий байна шүү Ерөнхийлөгч өө. Тэгэхээр та энэ дээр маш сайн анхаарч, энийг уях хэрэгтэй шүү. Одоо 2 дугаар хэлэлцүүлэг гээд явахад тэгээд төсөв орж ирж байгаа юм чинь. Яагаад гэвэл ингээд хараад байхад төсөвтэй уях юм, бас нэлээд дутуу юмнууд бол байна. Инфляц дээр ч байна, төлбөрийн тэнцэл дээр байна. Тэгэхээр энэ дээр илүү их анхаарах хэрэгтэй нь сая харагдаж байна.

Хоёрдугаарт, миний байнгын яриад байгаа түрүүн бас хэлсэн. Бичил болон жижиг, дунд, бизнес эрхлэгчдэд ус агаар шиг хэрэгтэй байгаа энэ жижиг санхүүжилтийг олгох тэр итгэлцлийн зээл юм уу, тэр микро файнас талын юмнууд дээр та бүхэн маань үнэхээр бодлого боловсруулаад оруулж ирээд, энэ дээр тэр арилжааны банкнуудаа өмнөх тэр хэлээд байгаа шүү дээ. Хас банк, Хаан банк ямар амжилттай хэрэгжээд дэлхийд энэ чинь өөрөө жишиг болоод тэр нь өөрөө ядуурлыг үнэхээр бууруулж чадсан шүү дээ. Ажлын байрыг дэмжиж чадсан олон жижиг бичил бизнесийнхэн подволоос гарсан шүү дээ. Тэгэхээр одоо энэ өөрөө их хэрэгцээтэй байгаад байгаа учраас та бүхэн маань мөнгөний бодлогодоо энэ итгэлцлийн зээл гэдэг юм уу, эсвэл макро финансаар нь явдаг юм уу? Энийг зайлшгүй бодлогын түвшинд гаргаж ирэх хэрэгтэй шүү. Тэр гүйцэтгэлийн аудит, хөдөлмөр эрхлэлтийг 2016-2020 онд, 2020-2021 онд дэмжсэн байдлыг харахад яг энэ дээр үр нөлөө үзүүлсэн эсэх нь тодорхойгүй байгаад байна.

Энэ мөнгө үнэхээр үр дүн өгсөн үү, байнгын ажлын байртай болгосон

уу, хөдөлмөр эрхлэлтийг эсвэл хөдөлмөрийг шүтэх юманд хүнийг татаж чадсан уу гэхлээр ямар ч үнэлэх боломжгүй байна гээд аудитын дүгнэлт гараад байгаа шүү дээ. Гэтэл Улсын Их Хурал, Засгийн газар нь 10 их наядаар нь хөрөнгө мөнгө баталж өгөөд байхад тэнд иргэдэд энэ маань өөрөө яг ажлын байр болж очихгүй, орлого болж очиж чадахгүй байгаад байгаа дээр бас дунд шатанд ч юм уу асуудал байгаад байгаа юм.

Тэгэхээр та бүхэн маань энэ төсөв мөнгөний бодлогыг ялангуяа энэ жижиг бичил, дунд бизнес эрхлэгчид рүүгээ чиглэсэн арга хэмжээн дээр бас анхаарах их чухал байгаа шүү гэдгийг би үг авч бүр хэлье гэж бодсон юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд иилжүүлж байна.

16.27 цагт

Дараагийн асуудалд орно. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулна.

Хуулийн төслийн талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун Эрдэнэ танилцуулна. Индэрт турж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Эрхэм Монгол ахан дүүсээ, Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Миний бие Монгол Улсын Ерөнхий сайдын хувьд 2 дахь удаагаа улсын төсвийн танилцуулгыг Монгол Улсын Их Хуралд танилцуулж байна.

Өнгөрсөн жил та бүхний баталсан 2022 оны улсын төсөв бүхэлдээ цар тахлын хүндрэлийг даван туулахад чиглэгдсэн билээ. 2022 оны төсвийн бодлогын хүрээнд Монгол Улс цар тахлын үед эрүүл мэнд, эдийн засаг харилцан хамааралтай тул шат дараатай, хатуу хөл хориог суллаж, энгийн амьдралд эргэж орох зорилго бүхий эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц бодлогыг дэвшүүлж хэрэгжүүлсэн билээ. Энэхүү бодлогын хүрээнд зорилтот бүлгийн иргэдийн 90 гаруй хувийг вакцины бүрэн тунд цаг алдалгүй хамруулсан дэлхийн эхний улс орнуудын нэг болж хамтдаа чадсан. Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага болон бусад мэргэжлийн байгууллагууд манай улсыг цаг алдалгүй дархлаажуулалтыг зохион байгуулж чадсанаар 40 гаруй мянган иргэдийн амь насыг болзошгүй эрсдэлээс хамгаалсан төдийгүй энгийн амьдралын хэмнэлд шилжиж, эдийн засгаа нээсэн олон улсын загвар улс орнуудын нэг болсныг онцлон тэмдэглэсээр байна.

2022 оны улсын төсөв, эрүүл мэндийн салбарт сүүлийн 12 жилийн хугацааны нийт хөрөнгө оруулалттай тэнцэхүйц хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэсэн байна. Аж ахуйн нэгжүүдийг дэмжсэн ажлын байрыг хадгалах, 3 хувийн хүүтэй зээл болон иргэд, аж ахуйн нэгжүүдийн дулаан, цахилгааны төлбөрийг төрөөс хариуцаж, хүүхдийн мөнгө нэмэгдүүлсэн бодлогууд ч цар тахлын сорилтыг

даван туулахад чухал түлхэц болсон гэж үзэж байна.

2022 оны төсвийн төслийг боловсруулж байсан цар тахлын үед Монгол Улсын эдийн засаг -5.3 хувиар унасан байсан бол энэ оны эцэс гэхэд 3 хувийн өсөлттэй гарах төлөвтэй байна. Өнөөдрийг хүртэл дэлхийн олон улс орон цар тахлын улмаас хатуу хөл хориотой хэвээр байна. Харин бид энгийн амьдралын хэмнэлд шилжсэнээр тэр өдрүүдийг бараг мартжээ. Нэг үгээр хэлбэл 2022 оны улсын төсөв, тодотголын хамт цар тахлын хүнд үед түүхэн үүргээ гүйцэтгэсэн гэж дүгнэж болохоор байна.

2022 оны улсын төсвийг баталж, цар тархлын хүндрэлийг даван туулах боломжийг Монгол Улсын Засгийн газарт олгосон Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд Та бүхэнд гүн талархал илэрхийлье ээ.

Цар тахлын хатуу, хөл хориотой хүнд үед Засгийн газраас гаргасан амаргүй шийдвэрүүдийг ойлгон дэмжиж, хамтран ажилласан нийт иргэддээ болон аж ахуйн нэгжүүддээ чин сэтгэлийн талархал дэвшүүлье ээ.

Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

2022 оны улсын төсөв, цар тахлын хүндрэлийг даван туулахад бүхэлдээ зориулагдсан бол өнөөдөр барьж буй 2023 оны улсын төсвийн төсөл эдийн засгийг тогтворжуулж, макро тэнцвэрийг хангахад бүхэлдээ зориулагдаж байна. Олон улсын геополитикийн хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гадаад үнийн өсөлт, валютын ханшийн огцом

өсөлт, дэлхий нийтэд үүсэж буй хүнсний хомсдол зэрэг эдийн засгийн хүндрэлүүдийг даван туулж, макро эдийн засгийг тогтворжуулах нь улс орон бүхний энэ цаг үеийн амаргүй сорилт болж байна. Дэлхий даяар хүнс, эрчим хүчний үнийн огцом өсөлт, нийлүүлэлтийн сүлжээний тасалдлын улмаас сүүлийн 20-40 жил байгаагүй инфляцын савалт үүсэж байна. Гэвч бид нэгдмэл бодлоготой байж чадвал цар тахлын хүндрэлийг давж чадсан шигээ олон улсын геополитикийн нөхцөл байдлаас үүдэлтэй энэхүү сорилтыг ч мөн даван туулж чадна.

2023 оны улсын төсвийн энэхүү өргөн баригдсан хувилбараар батлагдвал эдийн засгийн өсөлт 5 хувьд хүрч, инфляц нэг оронтой тоонд хүрч буурч, экспортын биет хэмжээ цар тахлын өмнөх үе буюу 2019 оны түвшинд хүрч, төлбөрийн урсгал тэнцлийн алдагдал буурч, валютын хани тогтворжиж чадна гэдэгт Засгийн газар бүрэн итгэлтэй байна. Макро эдийн засгийн тэнцвэр хангагдсанаар хөрөнгө оруулалт, бизнесийн орчин сайжирч, иргэдийн орлого бодитоор өсөх суурь нөхцөл бүрдэнэ.

2023 онд шинэ сэргэлтийн бодлогын аж үйлдвэржилтийн сэргэлтийн хүрээнд дэлхийд 4-т эрэмбэлэгдэх Оюутолгойн гүний уурхай ашиглалтад орж, боомтын сэргэлтийн хүрээнд экспортын шинэ төмөр замын гарцууд бүрэн хүчин чадлаар тээвэрлэлтээ эхлүүлснээр Монгол Улсын экспортын орлого түүхэндээ анх удаа 11 тэрбум ам.долларын босгыг давна гэж тооцоолж байна.

Аж үйлдвэрийн сэргэлтийн хүрээнд ган, зэс, алтны

үйлдвэржилтийг дэмжих бодлого явуулж, аж үйлдвэрийн боловсруулалтыг нэг шатаар ахиулж, нэмүү өртөг шингээх зорилтыг мөн дэвшүүлж байна. Ирэх жилийн төсөвт эрчим хүчний сэргэлтийн бодлогыг эрчимжүүлнэ. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, Тавантолгойн цахилгаан станц зэрэг олон жил гацсан бүтээн байгуулалтын ажлуудыг 2023 оны төсвийн жилд багтааж эхлүүлнэ. Амгалан дулааны цахилгаан станц эрчим хүчний хуримтлуурын бүтээн байгуулалтыг мөн 2023 оны төсвийн жилд багтаан бүрэн ашиглалтад оруулна. Ямар ч улс төржилт, ямар ч эсэргүүцэл, хөрш орнууд болон бусад Засгийн газартай хэлэлцэн тохиролцсон томоохон төслүүдийг гацаах ёсгүй гэдгийг Ерөнхий сайдын хувьд харууцлагатайгаар дахин илэрхийлж байна. Төрийн өмчит компаниудын засаглал, үр ашгийг сайжруулж, хөрөнгийн зах зээлээр дамжуулж олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг ирэх онд мөн идэвхжүүлнэ.

Саяхан Төрийн банкиг олон нийтийн хяналтад оруулах ажил амжилттай хэрэгжүүлсэн бол Хөрөнгийн биржийг олон улсын жишигт нийцсэн нээлттэй компани болгох ажлыг ирэх жилийн төсвийн жилд багтаан зохион байгуулахаар төлөвлөж байна.

Эрдэнэс Монгол компанийн бүтэц, үйл ажиллагааг Баялгийн сангийн олон улсын жишигт нийцүүлж өөрчлөн зохион байгуулснаар нүүрс, зэс, өнгөт металл, эрчим хүчний төслүүдийн бүтээн байгуулалтууд идэвхжиж, уул уурхайн шинэ төслүүдэд шууд гаднын шууд хөрөнгө оруулалт идэвхтэй

татах боломж нэмэгдэнэ гэж тооцлоо.

Уул уурхайн бүтээгдэхүүний бирж байгуулагдсанаар борлуулалт ил тод, нээлттэй болж, ашигт малтмал дагасан далд эдийн засаг, авлигын асуудал бүрэн цэгцэрнэ. Хавтгайрсан халамжийг үе шаттай хязгаарлаж, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан төрийн албаны цалингийн тогтолцоог шинээр нэвтрүүлнэ. Төрийн жинхэнэ албан хаагчийн цалингийн 160 гаруй өнөөдрийн салангид тогтолцоог 20 болгон бууруулж, олон улсын нийтлэг жишигт нийцүүлэхээр энэхүү төсвийн төсөлд тусгалаа. Улсын төсвийг тэгшитгэн хувааж, асуудлыг гал унтраах байдлаар аргацааж шилжих төслүүдийн урсгал зардалд төсвийн дарамт үүсдэг байсан тогтолцоог халж, цаашид шинээр санхүүжүүлэх төслүүдийг алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлж Эдийн засгийн хөгжлийн яам нэгдсэн байдлаар төлөвлөж, Сангийн яам санхүүжүүлдэг тогтолцооны реформ руу энэ жилийн ирэх жилийн төсвөөс эхэлж шилжинэ.

Цаашид зураг төсөв, тооцоо судалгаа, нийгэм, эдийн засгийн үндэслэлгүй төслүүдийг улсын төсвөөс санхүүжүүлэхгүй байх нөхцөл энэхүү реформын хүрээнд бүрэн шийдэгдэнэ гэж үзэж байна. Бид тойрогт шүтсэн тэгшитгэн хуваах зарчмаас илүүтэйгээр улс орны хөгжлийг тодорхойлох томоохон асуудлуудад төвлөрч ажиллах нь ирээдүйн Монголын хувь заяаг шийдэхэд нэн чухал үүрэгтэй билээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан хүнсний хангамж, аюулгүй байдлын үндэсний

хөдөлгөөнийг дэмжиж, бодит ажил болгох ажилд Засгийн газар 2023 оны төсвийн жилд онцгой анхаарал хандуулна. Эрүүл хүнс бол Монгол Улс эрүүлжих суурь нөхцөлийг бүрдүүлэх төдийгүй экспорт нь 92-94 хувь уул уурхайгаас хамааралтай манай улсын хувьд төрөлжин хөгжих боломж бүхий эдийн засгийн 2 дахь том салбар болох хөдөө аж ахуй юм. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, тэр тусмаа мах, ноолууран бүтээгдэхүүний экспортыг 2023 оны төсвийн жил тухайлан дэмжих бодлого барьж ажиллана. Эдгээр бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхийн тулд Монгол Улсын нэгдсэн стандартыг олон улсын жишигт нийцүүлэн бодитой шинэчлэл хийх зайлиггүй шаардлага урган гарч ирж байна.

Засгийн газраас 2023 оныг Монголд зочлох жил болгон зарлаж байна. Энэхүү бодлогын хүрээнд Аялал жуулчлалын үндэсний хороог Ерөнхий сайд биечлэн удирдаж, олон улсад улсынхаа нэр хүндийг өсгөхөд онцгой анхаарал хандуулна. Аялал жуулчлалын стандартыг эрс шинэчлэх ажлыг хувийн хэвшилтэйгээ хамтран зохион байгуулах болно. Аялал жуулчлалын салбар бол эдийн засгийн хувьд та бидний хамтдаа төрөлжүүлэн хөгжүүлэх боломж бүхий 3 дахь том салбар юм.

Ирэх оны төсөвт нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн парк шинэчлэл, үйлчилгээний чанарын асуудлыг цогцоор шийдвэрлэж, шинэ түвшинд хүргэх томоохон зорилтыг мөн Засгийн газраас дэвшүүлж байна. Сүүлийн 20 орчим жил түгжрэл гэдэг ерөнхий сэдэв ярьж, багагүй хэмжээний санхүүжилтийг тэгшитгэн

хуваарилсан боловч бодит үр дүн гарсангүй ээ.

Тиймээс цэцэрлэгийн сугалааны асуудлыг 2022 оны төсвийн тодотголоор шийдвэрлэж чадсан шигээ 2023 онд нийтийн тээврийн асуудлыг шийдвэрлэхийн төлөө хамтдаа хичээцгээе. Нийтийн тээврийн чанар хүртээмжийг олон улсын жишигт хүргэн сайжруулж чадвал түгжрэлийн эсрэг дараа дараагийн хатуу арга хэмжээ авах суурь нөхцөл бүрдэнэ. 2023 оны төсвийн жилд багтаж нийтийн тээврийг сайжруулах цогц арга хэмжээнд Улсын Их Хурлын эрхэм гишүүд Та бүхнийг идэвхтэй оролцож, дэмжинэ гэдэгт итгэлтэй байна. Мөн иргэд, аж ахуйн нэгжүүдийг ч энэ асуудалд анхаарлаа хандуулж, хамтран ажиллахыг уриалж байна.

Мөн нийтийн тээврийн зогсоолын асуудлыг нийслэл, дүүргийн төсөвт тусгаж ажиллахыг шат шатны Засаг даргад үүрэг болгож, Иргэдийн Хурлын төлөөлөгчдийн төлөөлөгчдөд мөн зөвлөгөө өгч байна. Хотын хэт төвлөрөл багасна гэдэг бол дагуул хотууд болон хөдөө, орон нутгийн хөгжлийн асуудалтай салшгүй холбоотой асуудал билээ. 2023 оны улсын төсөвт Хөшгийн хөндийн дагуул хотын бүтээн байгуулалтын дэд бүтцийн хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхээр тусгалаа.

Орон нутгийн хөгжлийн бодлогыг дэмжих зорилтын хүрээнд орон нутгийг орон сууцжуулах дэд бүтцийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэж, орон нутагт ипотекийн зээлийн хүүг 3 хувьд хүргэхээр тусгалаа. Чадварлаг хүний нөөцийг орон нутагт ажиллах сонирхлыг

нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд орон нутгийн төрийн захиргааны байгууллагын албан хаагчдын цалинг 20-100 хувь хүртэл үр дүнд тулгуурлан нэмэгдэх ажлыг ирэх жилийн төсвийн жилээс эхлэн зохион байгуулна. Орон нутагт ашигт малтмалын орд газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, уул уурхай эрхэлдэг аж ахуйн нэгжүүдээс орон нутагт олгодог хандив тусламжийг орон нутгийн санд төвлөрүүлж, иргэдийн оролцоог хангах эрх зүйн зохицуулалтыг бий болгохоор тусгалаа. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн хүрээнд дулаан, цахилгаан үйлдвэрлэх шинэ төслийн орлого олж эхэлсний дараачийн жилээс эхлэн 3 жил 90 хувиар, дараагийн 3 жилд 50 хувиар татварын хөнгөлөлт үзүүлэхээр тусгалаа.

Нийслэл Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт үйлдвэрлэл агуулах нүүлгэсэн, орон нутагт шинээр үл хөдлөх хөрөнгө бий болгосон, ажлын байр нэмэгдүүлсэн аж ахуйн нэгжүүдэд мөн татварын дэмжлэг үзүүлнэ.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын 21 аймгаас Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Өмнөговь, Сэлэнгэ, Орхон аймаг улсын төсөвт орлого төвлөрүүлж, бусад нь улсын төсвөөс татаас авч байна.

Цаашид аймаг бүр төсвийн орлогоо бие даан бүрдүүлэхэд чиглэгдсэн хөрөнгө оруулалтыг Засгийн газар бодлогоор дэмжих болно. Ерөнхий сайдын хувьд шинэ сэргэлтийн бодлогын, хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд орон нутаг, төсвөө бие даан бүрдүүлэхэд нэн шаардлагатай томоохон төсөл,

хөтөлбөрийг орон нутгийн иргэдийн оролцоонд тулгуурлан шийдвэрлэх болно. Өмнө нь биечлэн ажилласан аймаг, дүүргийн удирдлага болон иргэдийн эрэмбэлсэн 70 гаруй төслүүдийн 70 гаруй хувь нь зураг төсөвгүй байна. Тиймээс эдгээр ажлын бэлтгэл ажлыг хангах, ТЭЗҮ-ийг боловсруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг 2023 оны төсөвт бүрэн тусгаж, төслүүдийн жагсаалтыг хавсралтаар батлуулахаар өргөн барилаа.

Цаашид аймаг, дүүргүүд Эдийн засгийн хөгжлийн яам болон холбогдох бусад яамдуудтай хамтарч орон нутгийн төсвөө бие даан бүрдүүлэхэд шаардлагатай томоохон төслүүдийн зураг төсөл, бэлтгэл ажлыг хангахад хариуцлагатай хандах шаардлагатай байна. Бид цаашид тооцоо судалгаагаар, нийгмийн болон эдийн засгийн бодит үр өгөөжтэй, зураг төсөвтэй, хэрэгжихүйц төслүүдийг л дэмжих болно. Төрийн бодлого ерөнхийгөөс тодорхой руу, бас тооноос чанарт шилжих шаардлагатай байна.

Өнгөрсөн хугацаанд эхлүүлсэн олон төсөл хөтөлбөр байдаг ч бүрэн дуусаж, үр дүнгээ өгсөн нь хуруу дарам цөөхөн байна. Зарим төсөл хөтөлбөр эхэлснээсээ хойш 10 гаруй жилийн хугацаанд ашиглалтад орж чадаагүй царцсан арга хэмжээнүүд ч цөөнгүй байна. Энэ нь төсөвт өртгийг хэд дахин нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтын ач холбогдлыг бууруулж, төсвийн үргүй зардлыг нэмэгдүүлж, төр хувийн хэвшлийн итгэлцлийг алдагдуулсан туйлын хариуцлагагүй, дахин давтаж болохгүй алдаа юм.

Монгол Улс анх удаа 2023 оны төсөвт шинэ хөрөнгө оруулалтыг

хязгаарлаж, зөвхөн өмнө нь эхлүүлсэн нийт төслүүдийг үр ашигтай дуусгах томоохон зорилтыг дэвшүүлж байна. 2023 оны төсөв хэрэгжсэнээр өмнө нь эхлүүлсэн нийт төслийн 86 хувийг бүрэн дуусгаж ашиглалтад оруулна. Өмнө нь бид нар төсөвтөө 40 хувиас хэтэрч чадахгүй явж байсан. Бид олон жилийн турш төсвийн шинэчлэлийн талаар ярьсан ч тойргийн эрх ашиг, сонгуулиас сонгууль дамжсан амлалт, зураг төсөв, эдийн засгийн тооцоогүй хөрөнгө оруулалтуудаас салж чадалгүй өнөөдрийг хүрсэн нь гашиуун үнэн билээ.

Энэ агуулгаар 2023 оны төсөв бол олон жил яригдсан төсвийн реформын чухал эхлэл, цэг болох учиртай. Мэдээж 2023 оны төсөв зарим талаар давс мэт шорвог сонсогдож магадгүй. Гэвч бид ирэх жилүүдэд улс орны нийгэм, эдийн засагт хэрэгтэй чухал төслүүдийг цаг алдалгүй богино хугацаанд хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлж байгаагаар энэ жилийн төсөв бол шинэ сэргэлтийн төсөв байх болно. Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнээр энэ жилийн төсөвт оны эцэс гэхэд 200 тэрбум төгрөг хэмнэгдэх бол ирэх 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын болон урсгал зардал, төрийн хэмнэлтийн тухай хууль болон цахим шилжилтийн үр дүнгийн хүрээнд нэг их наяд төгрөгөөр хэмнэгдэх тооцоолол гарч байна.

Ирэх 2023 оны төсвийн жил төрийн бүтээмжийг сайжруулахын тулд цахим шилжилтийн ажлыг улам бүр эрчимжүүлнэ. Цахим гарын үсгийг хэрэглээнд бүрэн нэвтрүүлж, төрийн үйлчилгээний и-монгол цонхоор дамжин цахим шуудангаар иргэдтэйгээ шууд харилцдаг болох зорилтыг мөн дэвшүүлээ. Авлигын

эсрэг анхан, дунд шатны төрийн байгууллагуудын хүнд суртлын эсрэг тэмцэлд иргэн таны оруулж чадах хамгийн том хувь нэмэр бол цахим гарын үсгээ авч, цахим шууданг нээж, цахим хэрэглээг эзэмших шийдвэр юм шүү.

2022 оны төсөв дотоодын нийт бүтээгдэхүүний 5.1 хувь буюу 2.4 их наяд төгрөгийн алдагдалтай байсан бол 2023 оны төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний 2.8 хувь буюу 1.5 их наяд төгрөгийн алдагдалтай байхаар тооцож өргөн барьж байна. Энэ нь 833.5 тэрбум төгрөгөөр алдагдлыг өмнөх жилээс бууруулсан гэсэн үг юм. Төсвийн алдагдал гэдэг бол Засгийн газрын өр юм.

Тиймээс цаашид төсвийн алдагдалгүй улс болж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, төсвийн сахилга баттай төр засаг болохын төлөө хариуцлага ухамсарлаж, хамтдаа хичээцгээе. Сүүлийн хагас жилийн хугацаанд Хөгжлийн банканд үүссэн эргэн төлөгдөөгүй зээлээс 766.5 тэрбум төгрөгийн хохирлыг эргэн төлүүлээд байна. Цаашид оны эцэс гэхэд нийт нэг их наяд төгрөгийг эргэн төлүүлэх болно оо.

Ингэснээр улсын төсөвт өрийн дарамт учрах эрсдэл үүсгээд байсан 2013 онд гаргасан Самурай бондын 30 тэрбум юань буюу 200 орчим сая ам. долларын өрийг Хөгжлийн банк бие даан төлөх боломж бүрдэж байна.

Энэхүү эргэн төлөлтийг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулсан олон нийт 4 дэх засаглал болсон хэвлэл мэдээллийнхэн, хууль хяналтын байгууллагын тангараг өргөсөн албан хаагчдад Монгол Улсын Ерөнхий

сайдын хувьд талархал илэрхийлье. Улсынхаа нэрээр бонд босгож, нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг сайтар тооцоолоогүй төсөл хөтөлбөрийг сонгон шалгаруулж, улс орноо дампуурлын ирмэгт аваачсан гашуун түүх дахин давтагдах ёсгүй ээ.

Товчоор дүгнэж хэлэхэд 2023 оны төсөв эдийн засгийг тогтворжуулж, төсвийн сахилга батыг бүх шатанд хэрэгжүүлэх төсөв байх учиртай.

Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Г.Занданшатар: Одоо төсвийн төслийн талаарх төрийн аудитын төв байгууллагын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат танилцуулна.

Д.Занданбат: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсан Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийг та бүхэнд тоймлон танилцуулъя.

Төрийн аудитын байгууллага Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22

дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийн дагуу Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсан Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар аудит хийж, дүгнэлт гаргалаа.

Дараах асуудлын хүрээнд аудитыг төлөвлөн гүйцэтгэлээ.

Үүнд: Төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуурыг хангасан эсэх, төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар төсвийн төсөл нь тогтвортой хөгжлийн бодлого, Үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэх өргөн барьсан 2023 оны нэгдсэн төсвийн төсөл нь шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх замаар хямралын үеийн эдийн засгийг тогтворжуулах, төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах, төсвийн зарлага болон бараа, үйлчилгээний үнийн өсөлтийг хязгаарлах бодлогыг мөнгөний бодлоготой уялдуулан хэрэгжүүлэхэд чиглэжээ.

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 18.9 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 34.7 хувь, нийт зарлагыг 20.5 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 37.6 хувь тэнцвэржүүлсэн тэнцлийг 1.5 их наяд төгрөгийн алдагдалтай буюу дотоодын нийт бүтээгдэхүүний -2.8 хувьтай тэнцэхээр төсвийн төсөлд тусгасан байна. Төсвийн алдагдлыг Засгийн газрын үнэт цаасаар нэг их наяд төгрөг, Засгийн газрын зээлээр 417.5 тэрбум төгрөг,

тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдлээс 132.7 тэрбум төгрөгийн эх үүсвэрээр нөхнө гэж тооцжээ. Төрийн аудитын байгууллага Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн төсөлд дараах дүгнэлтийг гаргаж байна.

Үүнд: Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн төсөлд тусгасан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан үзүүлэлтүүд төсвийн тусгай шаардлагыг хангаж байгаа ч өргөн барьсан төсөв, урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого зорилттой уялдахгүй байх, төсвийн удирдлагын зарчим алдагдах эрсдэлтэй нөхцөл байдал хэвээр үргэлжилсээр байна.

Тухайлбал, Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудитаар өгсөн зарим зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, зөрчил дутагдал давтагдсан хэвээр байгаа бөгөөд хүлээгдэж буй үр дүнд хүрээгүй байгаа нь өмнөх дүгнэлтийн ач холбогдол, үр нөлөөг бууруулж, төсвийн сахилга, хариуцлага шат шатанд алдагдаж байгааг харуулж байна. Улс орны гадаад, дотоод нөхцөл байдал хүндрэлтэй байгаа энэ цаг үед төсвийн болон мөнгөний бодлого, төсвийн зарлага тэлэх, халамжийн бодлогын орон зайн зохистой харьцааг баримтлах оновчтой бодлого хэрэгжүүлэх замаар төсөв, санхүүгийн хямралт үеийг тогтворжуулах, даван туулах шаардлага тулгарч байна. Төсвийн төсөлд тусгасан зарим хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжих боломж, нөхцөлийг үндэслэлтэй судалж ангилах, эрэмбэлэх ажиллагааг дутуу хийснээс ирээдүйд бий болох үр дагавар нь зардлыг улам нэмэгдүүлсэн,

үр ашиг, үр дүнгүй болох эрсдэлтэй байна.

Тухайлбал, Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах зорилгоор 2023 онд цахилгаан тээврийн хэрэгслийн хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг хугацаанаас өмнө хэрэгжүүлэхээр төсөвт тусгасан байна. Цахилгаан автобусны хэрэглээ, цэнэглэлт цэнэглэх, нэг цэгүүдийн байршлыг тодорхойлох, газар чөлөөлөх асуудлыг бүрэн шийдээгүй байгаа нь энэ ажлыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэхгүй байх эрсдэл өндөр байгааг харуулж байна. Мөн дизель автобус худалдан авахаар төлөвлөхдөө орчны нөлөөллийн үнэлгээ хийгээгүй, Евро-5 стандарт шаардлагыг хангаж буй эсэхийг тодорхойлоогүй нь агаарын бохирдлыг бууруулах, нэмэлт төхөөрөмж суурилуулах зэргээр зардал нэмэгдүүлэх болзошгүй юм.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө барилга угсралтын ажлыг гүйцэтгэх салбарын чадамж, дотоодын барилгын материалын үйлдвэрлэлийн хүчин чадалтай уялдуулаагүй, нэг дор хэт олон арга хэмжээг зэрэг эхлүүлж байгаа нь 2010-2019 онд хэрэгжсэн нийт 993 тэрбум төгрөгийн 183 төсөл, арга хэмжээ 2023 онд үнийн өсөлтөд өртөж, 100.4 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилт олгох үр дагаварт хүргэсэн байна. Үнийн өсөлтийн тооцоололд нэг төрлийн материалын үнийг өөр өөрөөр илэрхийлсэн үнийн индексээр тодорхойлсон өртөг нь зах зээлийн үнэтэй харьцуулахад харьцангуй өндөр байх, үнийн өсөлтийг тооцохдоо бодит ажлын гүйцэтгэлд үндэслэлгүйгээр төсөвт туссан

материалаар тооцсон нь материалын чанар байдлыг доройтуулж, гүйцэтгэгч нарт илүү санхүүжилт олгох нөхцөл бий болохоор байна.

Төсвийн төсөл нь үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэхийг үнэлж дүгнэх шаардлага бий болсон бөгөөд энэ ажлыг хэрэгжүүлэх горим, тогтолцоо, төлөвшөөгүй арга зүй, нарийвчилсан аргачлал, шалгуур үзүүлэлт тодорхойгүй байгаа тул дүгнэлт гаргахад хүндрэл учирч байна.

Иймд төсвийн төслийг үндэсний аюулгүй байдлын бодлогод хэрхэн нийцүүлэх арга замыг цаашид тодорхойлж баталгаажуулах шаардлагатай байна.

Эрхэм Улсын Их Хурлын гишүүд Та бүхэнд төсвийн төсөлд хийсэн аудитын тайланг хүргүүлж буй тул тайлангаас дэлгэрэнгүй танилцах боломжтойг харгалзан дүгнэлтээ хураангуйлан танилцууллаа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Одоо ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Монгол Улсын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Даишэвэгийн Амарбаясгалан, Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар, Сангийн сайд Болдын Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар, Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Барилга, хот байгуулалтын

сайд Бэгзжавын Мөнхбаатар, Соёлын сайд Чинбатын Номин, Эрүүл мэндийн сайд Сэрээжавын Энхболд, Боловсрол, шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт, Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд Жамбалын Ганбаатар, Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Ням-Осорын Учрал, Монгол Улсын сайд, Нийслэлийн Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Жамъянхорлоогийн Сүхбаатар, Монгол Улсын сайд, Олимп, Нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дарга Дорждамбын Зүмбэрэллхам, Шүүхийн сахилгын хорооны дарга Домборойн Мягмарцэрэн, Монгол Улсын ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янгугийн Содбаатар, Төрийн албаны зөвлөлийн дарга Балдангийн Баатарзориг, Санхүүгийн Зохицуулах хорооны дарга Дэмбэрэлдашийн Баярсайхан, Сонгуулийн Ерөнхий хорооны дарга Пүрвээгийн Дэлгэрнаран, Үндэсний Статистикийн хорооны дарга Батмөнхийн Батдаваа, Хүний Эрхийн Үндэсний комиссын дарга Жаргалсайханы Хунан, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газрын дарга Барсүрэнгийн Баасандорж, Сангийн дэд сайд Санжаагийн Мөнгөнчимэг, Эдийн засаг хөгжлийн яамны дэд сайд Санжаагийн Наранцогт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд Зархадын Зулпхар, Үндсэн Хуулийн Цэцийн Тамгын газрын дарга Даньхүүгийн Баянбилэг, Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга

Содномцэрэнгийн Заяадэлгэр, Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга Доноровын Цогтбаатар, Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын Хөрөнгө оруулалт гүйцэтгэлийн албаны дарга Дамдингийн Чулуунбат, Авилгатай Тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Загараагийн Баасанням, Үндэсний Аюулгүй Байдлын зөвлөлийн ажлын албаны дарга Дашиживаагийн Ариунболд, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Содномдаржаагийн Батбаатар, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Ядамсүрэнгийн Сарансүх, Үндэсний аудитын газрын аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Цэвэгсүрэнгийн Наранчимэг, Үндэсний аудитын газрын гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Дэлгэрийн Энхболд, Эдийн засаг хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганжавын Батжаргал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Гомбосүрэнгийн Өнөрбаяр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Батсүхийн Сүх-Очир, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, Хөрөнгө оруулалтын газрын дарга Чойгүнсэнгийн Чимэдсүрэн, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Зоригтбаатарын Энхболд, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Байгалмаагийн Одонтуяа, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Жамъяншаравын Дэлгэржаргал, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн

дарга Булганхүүгийн Ганзориг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Амарсайханы Хишигбаяр, Хүнс, хөдөө аж ахуй Хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Бадарчийн Отгонцэцэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлын газрын дарга Лхагвабаярын Энх-Амгалан, Батлан хамгаалахын дэд сайд Баярмагнай гэсэн ажлын хэсгийг танилцууллаа.

Одоо илтгэл, дүгнэлт болон төсвийн төсөлтэй холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд бүртгүүлнэ үү.

Энэ хооронд зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Даидэмбэрэлийн Бат-Эрдэнийн урилгаар Монголын үйлдвэрлэл үйлчилгээний хоршоодын холбооны Өмнөговь аймгийн ахмад ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт ахмадууд та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

Нэр орсон байна уу. Тогтохсүрэн дарга Мөнхбат бүгд байна. Хойно нь байна. олон битгий дарж бай, нэг л дарж бай гэж. Нэр тасаллаа. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: 2023 оны төсвийг хэлэлцэх энэ танилцуулж байх явцад бас эхний үг хэлэх завшаан олдсонд бас их баярлаж байна. Ер нь бол 2020 онд Засгийн газраас өргөн мэдүүлж баталсан Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр

эмч, сувилагч, эрүүл мэндийн салбарын ажилтнуудын олон жил хүсэн хүлээсэн хөдөлмөрөө шударгаар үнэлүүлэх, хийсэн ажилдаа тохирсон цалин хөлс авдаг, авсан цалин нь амьдралд хүрдэг байх тийм тогтолцоог бид эхлүүлж чадсан. Энэ ч утгаараа бид одоо 2021, 2022 оны ковид цар тахалтай үнэхээр сайн тэмцэж чадсан. Энэ бол одоо төсвийг эрүүл мэндийн салбарт онцгойлон анхааран шийдэж чадсанаар бид эрүүл мэндийн салбараараа ард иргэдээ энэ өвчин зовлонг байдлаас авч гарч чадсан том амжилт байсан.

Эрүүл мэндийн сайд та Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн дарга таны баталсан 2022 оны нэгдүгээр тогтоолын 3.1.1-д зааснаар албан ёсны статистикаар жилийн инфляцын сүүлийн 2 жилийн нийлбэр 10 хувиас давсан, 3.1.3-т зааснаар америк долларын төгрөгтэй харьцах хани сүүлийн 2 жилийн дотор 20-оос дээш хувиар өссөн тохиолдолд тусламж үйлчилгээний суурь тарифыг заавал шинэчилнэ гэж баталсан. Монголбанкны албан ёсны цахим сайтад сүүлийн 2 жилийн инфляцын нийлбэр, одоо дүнг бид бүхэн мэднэ. Сүүлийн 2020 онд бол одоо 2021 онд 9-10, 2022 онд одоо 14-16 хувьтай байна. ЭМД-ын Үндэсний зөвлөлийн 2022 оны 1 дүгээр тогтоолоор баталсан өртгийн жин нь эмч, ажилтнуудынхаа цалин нэмэх битгий хэл гарсан бодит зардлаа ч нөхөж чадахгүй болоод байна. 2023 оны төсвийн төслийг өргөн барихад хуучин өртгийн жингээр тооцож 2022 онд төсвөөр дахин оруулж ирсэнд үнэхээр харамсаж байна.

Эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн санхүүжилтийн хамгийн гол орц нь эм эмнэлгийн

хэрэглэгдэхүүнүүдийн 90 хувь нь гаднаас худалдаж авдаг.

Өнөөдөр бид мөнгөний бодлого ярихдаа инфляцын түвшин ямар байгаа, долларын ханиш яаж өссөн талаар бид өнөөдөржингөө үдээс өмнө ярилаа. Арай гэж эмнэлгүүд одоо 2022 онд тусламж үйлчилгээ бүртээ квот тогтоолгон зардлаа нөхөхгүй үгүйтэй ажилласан. Энэ бүхний цаана очер дараалал, эмнэлгүүдэд тодорхой үйлчилгээг нь заагаад өгчхөж байгаа учраас очер дараалал ихтэй өвчтөнүүд эмнэлгийн цаг авах гэж сараас 3 сар очерлох ийм тогтолцоог бид бий болгочихлоо.

Иймээс нэг тодорхой 5 асуулт асууя.

Нэгд, Эрүүл мэндийн сайд өөрийнхөө баталсан ЭМДҮЗ-ийн тогтоолоо зөрчиж тусламж үйлчилгээний төлбөрийн хэмжээг инфляц, долларын ханшийн өөрчлөлт, багаж хэрэгсэл, эм тарианы үнийн өсөлттэйгөө уялдуулан нэмэгдүүлж, шинэчилж, эрүүл мэндийн салбарын 2023 оны төсвийг бодитой тооцож яагаад нэмэгдүүлж оруулж ирсэнгүй вэ.

Хоёрдугаарт, 2022 онд батлагдсан ЭМД-ын хуулийн 14.9.12-т зааснаар ЭМД-ын Үндэсний зөвлөл тусламж үйлчилгээний өртгийн жинг батлахдаа орон тооны бус техникийн хорооны мэргэжисэн шинжээч, судлаач нараар бодитой тооцоо хийлгэж, дүгнэлт зөвлөмжид нь үндэслэн шийдвэр гаргана гэж хуульчлан баталсан. Гэтэл Улсын Их Хурлаас баталсан хуулийг 2 жилийн хугацаанд яагаад хэрэгжүүлээгүй вэ? Яагаад техникийн хороог байгуулаагүй вэ? Энэ бол одоо Үндсэн хуулийн 38.2.1-д

заасан хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах гэсэн заалтыг зөрчиж байгаа юм биш үү.

Гуравдугаар асуулт. Бид хөнгөлөлттэй эмийн хөнгөлөлттэй иргэдийн санхүүгийн эрсдэлээс хамгаалж, үнийг нь даасан шиг даадаг болохоор хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Өнөөдөр иргэд хөнгөлөлттэй эмээ төвөгтэй буцаад авдаг болчихлоо, нөгөө цалин хөлс нь хүрдэггүй, тэтгэмж нь хүрдэггүй, зөвхөн эмдээ зарцуулдаг болчихлоо. Энийгээ яаж шийдэх гэж байна вэ?

Дөрөвдүгээрт, Улсын Их Хурлаас 2020 онд Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг батлахдаа миний бие эрт илрүүлэх, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлэх талаар оруулж өгсөн. 2022 оны төсөвт 60 тэрбум төгрөгийг төсөвлөж өгсөн, гэтэл 2023 онд эрт илрүүлэх яагаад санхүүжилт.../минут дуусав/

Г.Занданишатар: Хэн хариулах вэ? Эрүүл мэндийн сайд. 95. Сэрээжавын Энхболд сайд хариулъя.

С.Энхболд: Чинбүрэн гишүүний асуултад хариулъя.

Инфляцтай уялдуулж өртгийн жинг яаж тооцож оруулж ирээгүй вэ гэж байна. Бид нар Сангийн яаманд ЭМДҮЗ-ийн төслөө оруулахдаа бол энэ чинь тодорхой, бас тусламж үйлчилгээний тариф дээр өөрчлөлтүүдийг нэмж, зарим тусламж үйлчилгээг нэмж оруулсан. Бид нар 1 их наяд 570 тэрбум гэж оруулсан. Бид нар Сангийн яамнаас 1 их наяд 481 тэрбум төгрөгөөр бол даатгалын санг баталсан байгаа. Энэ дээр бид нар бас тодорхой амбулаторийн тусламж үйлчилгээ,

тусламж үйлчилгээний үйлчлүүлж байгаа статистик тоон мэдээг харсан байгаа. Бид нар бас энд тодорхой нэр төрлөөр ЭМД-ын сан бол 705 оношийн бүлгээр эрүүл мэндийн байгууллагууд маань санхүүжилтийг гүйцэтгэлээр авч байгаа. Энэ дээр бас тодорхой юунуудын үнэлгээнүүдийг хийж байгаа. Мэдээж энэ тусламж үйлчилгээний батлагдсан тарифтай бол захирагдаж ажиллана мэдээж. Энэ оны 5 сарын 1-нээс эхлэн эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг хийгдсэн учраас тодорхой өөрчлөлтүүд бас гарна гэж бодож байгаа юм.

Хоёрдугаарт, орж ирж байгаа эм эмнэлгийн хэрэгслийн, тэрэн дээр бол яалт ч үгүй бид нар энэ хяналтын техникийн хороог бол ЭМДҮЗ дээр бол яригдсан байгаа. Бид нар энийг тун удахгүй байгуулна гэж бодож байгаа.

Гуравдугаарт бол эрүүл мэндийн тусламж хөнгөлөлттэй эм дээр бол бид нар тарифыг бол нэмсэн байгаа. 2022 оны төсөв дээр бол 67 тэрбумаар тавигдсан. Энэ он дээр бол 90 тэрбум төгрөгөөр бид нар нэмж тавьсан байгаа юм. Яагаад гэхээр энэ жилийн бас одоо ард иргэдийн үйлчлүүлсэн даатгалын сангаас хөнгөлөлттэй эмээр авч байгаа хөнгөлөлтийн тариф бол бас өнөөгийн байдал 80 тэрбум гарсан байгаа учраас бид нар бас ирэх оны төсөв дээр бол энийг нэмэгдүүлсэн. Төрөөс хөнгөлөлттэй эмийн юу бол, 30-100 хувь хөнгөлж явж байгаа. Тэгэхээр энэ дээр бол бид нар бас энэ тарифыг өсгөж өгсөн учраас энэ дээр бол ямар нэг 2023 онд бол эрсдэл гарахгүй гэж үзэж байгаа.

Дөрөвдүгээрт, эрт илрүүлгийн энэ тусламж үйлчилгээнийхээ юманд орчихсон явж байгаа. Энэний задаргааг нь бид нар буцаад ЭМДҮЗ-ээс баталж, энэ дотор нь задаргаа хийж өгнө гэсэн үг. Тэгж байж ерөнхийдөө бид нар энэ жил бол 60 тэрбумаар тавьсан. Бид нар 100 тэрбум гэж саналыг өгсөн хасагдаад энэ дээр дахиж ЭМДҮЗ-ээр батлахын тулд эндээ тохируулгаа хийнэ гэсэн үг. 60-аас дээш гаргаж батална гэсэн үг.

Г.Занданшатар:

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн тодруулж асууна.

Ж.Чинбүрэн: Үнэхээр одоо эрүүл мэндийн салбарын тусламж үйлчилгээ үнэхээр урагшилж, шинэчлэл бол сайн явж байсан. Тэгэхлээр одоо ЭМДҮЗ-ийн санг ЭМЯ 1.57 буюу 1.6 руу дөхүүлж аваачсан юм байна. Тэгэхлээр Сангийн яам хассан гэж би ойлголоо. Тэгэхлээр бол зүгээр инфляцын түвшин 20 хувьд гээд бодоход энэ маань дор хаяж 1 их наяд 600 тэрбум болохгүй бол бол 2023 оны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гацна. Бид том реформ хийчхээд тэр реформоо үргэлжлүүлж чадахгүй, буцаагаад хазаарыг нь татдаг бол буруу. Тийм учраас энийг одоо төсөв хэлэлцэх үед бол онцгой анхаараасай гэж хүсэж байна. Ерөнхий сайд ч бас энд сонсож байгаа байх. Тэгэхлээр бид ийм том алхам хийчхээд үүнээсээ ухралт хийлээ. Тийм учраас энэ бол болохгүй ээ.

Дараагийн асуудал бол бид энэ эмийн хөнгөлөлттэй эмийн асуудал дээр мөнгө тавьж болно. Тэгвэл зохион байгуулалтаа сайжруулаа. Сум, өрхийн эмчийн бичдэг эрх болоод байсан юмыг битгий болиул л даа. Бөөн очер.../минут дуусав/

Г.Занданшатар: Одоо Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүн асуулт асууна.

Ё.Баатарбилэг: Би хэдэн асуулт асууя.

Энэ Төсвийн хуулийн төсөлд суусан энэ он дамжиж байгаа барилгуудын магадлангаар ороогүй барилгууд байгаа. Тэгээд хуучин 2000 одоо энэ 2022 оны төсөвт суусан үнийн дүнгээрээ голдуу он дамжиж ирэх жилийнх дээр үлдэгдэл санхүүжилтүүд сууж байна. Тэгэхээр энэ дээр манай Сангийн яамны нөхдүүдээс 2,3 зүйл тодруулга өгөөдхөөч. Одоо энэ магадлангаар ороогүй гэдэг шалтгаанаар ингээд хуучин үнийн дүнгээрээ 2021, 2022 оны төсөвт суусан дүнгээрээ 2023 онд үргэлжлэх буюу дуусгахаар орж ирж байгаа барилгууд ер нь энэ ирэх жил яг энэ дүнгээрээ сууж байна шүү дээ. Тэгэхээр энүүгээрээ хэрэгжих боломж байна уу. Юмны үнийн өсөлт байна, нөгөө барилгууд нь магадлан гээд баахан өсөлтүүдээ тооцоод өгчихсөн байгаад байдаг. Бид нар хуучин дүнгээр нь үлдэгдэл санхүүжилтийг нь хийчхээд байдаг. Тэгэхээр энүүгээр хэрэгжээд явах боломж байгаа юу? Энэ дээр та бүхэн яаж харж байгаа вэ? Магадгүй он гараад одоо ахиад юмны үнийн өсөлт тооцоод төсвийн тодотголын асуудал босож ирэхийг үгүйсгэхгүй л болох гээд байна л даа.

Хоёрдугаарт, энэ 2022 оны энэ хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр төсвийн гүйцэтгэлээр энэ он дуустал энэ хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэл хэр явахаар байгаа юм бол? Нэлээд их барилгууд нэлээн дутуу байна л гэж л юм яваад байна л даа.

Энэ бол нэг багц асуудал байгаа юм, энийг нэг тодруулаадах.

Хоёрдугаарт, энэ Төрийн хэмнэлтийн хуулиар нэлээд олон байгууллагууд зүгээр ингээд харж байхад нэлээд олон байгууллагууд дээр төсвийн хэмнэлтийн хуулийн дагуу гээд худалдан авах ажиллагаанууд зогслоо, бүр буцаалаа, цуцаллаа гээд л ингээд юмнууд явж байгаа. Автомашин, янз бүрийн техник, тоног төхөөрөмж худалдаж авах гэж байгаад болилоо. Зарласан, шилэн дээр явж байгаа олон нийтийн шүүмжлэлд өртөөд татагдлаа л гэдэг. Тэр байгууллагууд дээр энэ төсвийг нь одоо юунд зарцуулж байна гэдэг дээр нь хяналт байгаа юу? Жишээлэхэд, нэг машин авна гээд зарлачихсан байсан болилоо л гэхчхэдэг. Тэгэхээр нь хууль хэрэгжүүлж байна гэдэг. Тэгж байтал үнэхээр тийм мөнгө нь байгаа бол тэр чинь буцаад татагдаж байгаа юу, өөр юманд зарцуулаад явчхаж байна уу гэдэг. Энэ ямархуу маягтай явж байна гэж?

Зүгээр төвлөрлийг сааруулах хүрээнд шинээр юм тавьсангүй. Суманд байгаа соёлын байгууллагууд, спортын байгууламжууд, спорт заал, усан бассейн, соёлын төв гээд ерөөсөө маш их шүүмжлэл дагуулаад байгаа л даа. Төвлөрлийг сааруулна гэж ярьж байгаа бол бид нар чинь угаасаа энийгээ орон нутаг дахь тэр хүн амьдрах энгийн наад захын дэд бүтцүүдээ бий болгож байж л бид нарын төвлөрлийг сааруулах асуудал, орон нутаг руу хүн шилжиж амьдрах боломжийг бүрдүүлнэ шүү дээ. Одоо яах вэ 2022, 2023 оны төсөв дээр нэг ч шинэ юм тавигдсангүй тэгж байтал нөгөө нэг 2050 алсын хараад чинь нөгөө эрүүл идэвхтэй аж төрөх, тэгээд энийгээ дагуулаад нийтийн

биеийн тамир спортыг хөгжүүлэх гээд том том зорилтууд тавьчихсан байгаад байдаг. Орон нутаг дахь тэр бүх дэд бүтцийнх нь юмнууд нь бол одоо төсвийн хэмнэлт гээд бүгд зогсоод байна л даа. Тэгээд нэг спорт, соёл 2-ын юмыг л ингээд хойш нь тавиад байдаг юмнууд одоо нэлээн л эргэж хармаар байгаад байгаа юм.

Зүгээр энэ 2024 онд олимп болно. Энэ улсын төсөв дээр энэ улсын шигшээ багийн гадаад дотоод тэмцээн уралдаанд явах юмнууд нь хуучин төсвөөр тавигдчихсан харагдаад байх юм. Нөгөө долларын хани л нөгөө билетийн үнэ гээд нөгөө улсын шигшээ багийн тамирчдын чинь гадаад, дотоод уралдаан тэмцээнд орох олимп, тив дэлхийн нөгөө олимпын эрх авах тэмцээнүүд 2023 онд хүлээгдээд байдаг. Энэ мөнгө нь хангалттай суусан гэж үзэж байна уу? Яг одоо Спортын сайдаас бас асуухад. Энэ дээр ямар хүндрэлүүд байна гэдэг дээр бас спорт хариуцсан сайд.../минут дуусав/

Г.Занданишатар: Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя. Дараа нь Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ сайд.

Б.Жавхлан: Гишүүддээ бүгдэд нь оройн мэнд. Баатарбилэг гишүүний асуултад хариулъя.

Ер нь төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын хувьд бид энэ жил нэлээн төсвийн шинэчлэлийн хүрээнд томоохон тохируулга хийе гэж ингэж зорьж өргөн барьсан байгаа. Тэр хүрээнд ирэх жил хийгдэх нийт 1061 төслийн 914 төсөл буюу 86 хувь нь 2023 онд ашиглалтад орж дуусахаар оруулж ирсэн байгаа юм. Өмнө нь бол энэ коэффициент бол 40 орчим хувь байдаг байсан ингээд бид

өмнөх жилүүдийн хуримтлагдсан шилжиж ирсэн бүх хөрөнгө оруулалтуудыг цаашид даамжрах эрсдэл нь цаашид үргэлжлэх өндөр эрсдэлтэй үнийн өсөлт энэ бүхнээс урьдчилан сэргийлж ирэх жил энэ эхлүүлсэн, олон жил дуусаагүй, мөн ойрын жилүүдэд шилжиж ирсэн бүх төслүүдээ дуусгая гэдэг ийм зорилт тавьсан байгаа шүү. Энэ хүрээнд шинэ хөрөнгө оруулалтуудаас татгалзъя гэсэн ийм бодлого оруулж ирсэн. Гишүүд мөн дэмжиж байгаад бид талархалтай байгаа.

Үнийн өсөлт, төсөвт өртгийн нэмэгдэл гээд 2 өөр ойлголт байгаа. Үнийн өсөлтийн хувьд бол Улсын Их Хурлаас Засгийн газарт өгсөн чиглэлийн дагуу 2021 оны 88 дугаар тогтоолоор Засгийн газар энэ дээр бид хуулийн хүрээнд Барилга, хот байгуулалтын яамтай хамтраад Сангийн яам хамтарч оролцоод яамдуудаас төсвийн ерөнхийлөн захирагч нараас саналыг нь аваад Барилга, хот байгуулалтын яамны дэргэд байдаг хөгжлийн төв, Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэд байдаг, мөн Хөгжлийн төвөөр дамжуулж магадлан хийгдсэн, нийтдээ 644 төслийн 303 тэрбум төгрөгийн үнийн нэмэгдлийг 100 хувь төсөвтөө оруулсан байгаа. 100 хувь оруулсан байгаа шүү.

Мөн үүнээс гадна төсөвт өртгийн нэмэгдэл буюу эдгээр төслүүдийг эхний шатанд аудит хийгээд үзэхээр анхны зураг төсвөөсөө өөрчлөгдсөн, анхны зураг, төсвийн бэлтгэл ажил дутуу хангагдсанаас болоод холболтын өртөг, зураг төсөв болон газар гээд бусад өөр асуудлуудаас болоод төсөвт өртөг нь нэмэгдсэн асуудлуудыг бол тусад нь авсан байгаа. Ингээд энэ томоохон

хөрөнгө оруулалт дээрээ тохиргоо хийсний үр дүнд бидэнд 2024 онд нэлээдгүй орон зай гарч ирнэ. Тийм учраас энэ төсөвт өртөг нь нэмэгдсэн эдгээр 300 гаруй тэрбум төгрөгийн төслүүд байгаа. Энэ тоо бол бас нэмэгдэж хасагдаад яваад байгаа юм. Тийм учраас энийг 2023 онд бэлтгэл ажлыг нь хангаж аудит хийгдэнэ. Аудит хийгдэнэ. Ингэсний үр дүнд нэлээн филтэрдэх болно. Ингээд 2024 онд яг шаардлага хангачихсан төслүүдийг төсөвт өртгөөр нь нэмэгдлийг нь тодорхой хэмжээнд оруулах ийм бодлоготой явж байгаа шүү.

Төвлөрлийг, сааруулах, түгжрэлийг бууруулах гээд энэ бодлогын хүрээнд яг тантай санал нэг байна. Засгийн газрын бодлого бол яг ингэж орж ирсэн байгаа. Түгжрэлийг бууруулах тал дээр Сүхбаатар сайдын багцад Улаанбаатар хот руу чиглэсэн ийм хөрөнгө оруулалтын бодлогууд байна. Нөгөө талдаа яг Улаанбаатар хотын хүн амыг хөдөө рүү чиглүүлэх, мөн хөдөөнөөс хот руу явж байгаа энэ урсгал нүүдлийг бууруулах, хөдөөд нь хүн амыг илүү их тогтвор суурьшилтай амьдруулах ийм бодлогыг бол дэмжиж оруулж ирж байгаа юм. Энэ дээр нэлээн тийм багц татварын болон төсвийн дэмжлэгүүдийг бид оруулж ирсэн байгаа. Сая Ерөнхий сайдын илтгэл дотор дурдагдсан тэр хөдөө орон нутаг дахь цалин. Жишээ нь доод суурийг нь бид 20 хувиар нэмж байгаад 20-100 хувь хүртэл нэмэх боломжийг нь бол орон нутагт нь төсвийн эрх мэдлийг нь өгч байгаа. Ингэснээр бол орон нутагт мэдээж төрийн албан хаагч нарын хувьд тогтвор суурьшилтай ажиллах, өсөж дэвжих ийм боломжийг олгоно гэж.../минут дуусав/

Г.Занданшатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ сайд. Олимп, нийтийн биеийн тамир, спортын сайд Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ.

Б.Бат-Эрдэнэ:

Баярлалаа. Баатарбилэг гишүүний асуултад хариулъя.

Тантай санал нэг байгаа. Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримтуудад алсын хараа 2050 Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлж байгаа энэ бодлого, зорилтод бол энэ биеийн тамир, спорт, ялангуяа нийтийн биеийн тамир бол энэ хүний хөгжлийг хангах нэг чухал суурь нөхцөл нь мөн гэж үзээд томоохон зорилтуудыг дэвшүүлсэн. Энэ хүрээндээ нэлээн ажлууд хийхээр бид төлөвлөж байгаа. Харамсалтай нь бол энэ дэлхий нийтийг хамарсан Ковид, дайны нөхцөл байдал, энэ эрүүл мэнд, эдийн засгийн хямралт байдлаас шалтгаалаад төсөв хөрөнгө хангалтгүй, тун тааруухан байна.

Ер нь ард иргэд, сонгогчдын зүгээс энэ биеийн тамир, спорт, залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, иргэдийн хөдөлгөөн, эрүүл, идэвхтэй амьдралын нэг нөхцөл болсон биеийн тамир, спортын барилга байгууламжтай холбоотой их санал санаачилгууд гардаг. Үүнийх нь дагуу манай Их Хурлын гишүүд өөрсдийнхөө сонгогдсон тойргууд дээр ер нь овоо бололцоотой, ажлуудыг эхлүүлсэн байна. Тэгээд Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяанд байсан энэ барилга байгууламжууд бол манайх руу шилжиж ирсэн. Энэний явц

байдал, нөхцөлтэй нь танилцуулах үүднээс манай биеийн тамирын хорооноос ажлын хэсэг гарч 8 аймгийн нэлээн олон сумдуудад явж ажиллаад энэ нөхцөл байдалтай нь нэлээн танилцаад ирсэн. Ажлууд нь бол нэлээн идэвхэжсэн ийм байгаа. Яах вэ, энэ хүрээндээ бол шилжчих барилгуудыг санхүүжүүлж байгаа энэ дүнгээр жаал ажлууд хийгдэж байна. Нөгөө талд нь таны хэлж байгаатай бол санал нэг байгаа. Та өөрөө БСШУС-ын яамыг хариуцаж байсан. Таны эрхлэх асуудлын хүрээнд энэ спортын салбар хариуцаж байсан учраас арга байхгүй, одоо асуудлаа мэдэж тавьж байна.

Тэгэхээр Биеийн тамир, спортын тухай хуульд бид нэмэлт, өөрчлөлтөөр хуульд өөрчлөлт оруулаад энэ биеийн тамир, спортын арга зүйчийг сумдад орон тоогоор ажиллуулахаар хууль гарчихсан боловч энэ бодит хэрэгжиж чадахгүй явж ирж байгаа юм.

Тэгэхээр энэ төвлөрлийг сааруулах энэ Засгийн газрын томоохон бодлогын хүрээнд бол энэ орон нутагт ажиллах, амьдрах, тийм боломж нөхцөлийг нь бүрдүүлэх, бий болгох чиглэлээр арга хэмжээ авах юм бол энэ зайлиггүй хийгдэх ёстой ажил бол энэ биеийн тамир, спортыг ядаж нэг сумандаа, нэг хариуцсан нэг хүнтэй байх ийм зайлиггүй шаардлага байна л даа. Одоо сумын соёлын төвд чинь бол 5 орон тоотой хуучин хоёрхон хүнтэй байхад ямар хэмжээнд байлаа. 5 орон тоотой болчихсон, сумдын соёлын төв бол нэлээн аятайхан болчихсон гэдгийг бид нар мэдэж байгаа.

Гэтэл энэ биеийн тамир, спорт гээд том салбар байхад нэг ч хүн

байхгүй, хууль нь гарчихсан байдаг, тэгээд л иймэрхүү байдалтай байгаа. Эдийн засаг амаргүй, хүнд нөхцөл байдалтай байгаа. Аргагүй байх. Яах вэ, Баянхонгор аймаг бусад хэд хэдэн аймгууд бол орон нутгийнхаа өөрөө удирдах ёсны байгууллагаар орон тоо, цалинг нь шийдвэрлээд явж байгаа сайн жишиг байна. Одоо Баянхонгор аймаг бол ер нь бараг бүх сумдад биеийн тамирын арга зүйчийг ажиллуулаад, ер нь олон ч сум биеийн тамирын цогцолборууд ашиглалтад оруулчихсан байж байгаа ийм жишиг байгаа юм.

Хамгийн сүүлийнх нь тэр олимпын эрх авахтай холбоотой. Гарцаа байхгүй энэ олимпын өмнөх жилүүдэд л одоо эрх авах томоохон тэмцээнүүдэд орох ёстой байдаг. Энэ хүнд нөхцөл байдалд байгаа ч гэсэн Засгийг газар, Сангийн яам бол тодорхой хэмжээнд анхаарал тавиад мөнгө хөрөнгөний нэмэгдлийг бол тавьж өгсөн байгаа, 10 тэрбумаар нэмэгдүүлсэн. Энэ бол бас яг бүрэн хэмжээнд асуудал шийдэх үү? Гэвэл яг тантай санал нэг. Энэ үнэ, инфляци, валютын ханшитай холбоотой.../минут дуусав/

Г.Занданшатар:

Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүн тодруулж асууя.

Ё.Баатарбилэг:

Тэгэхээр ирэх жил бол 2023 онд нөгөө үргэлжилж байгаа төсөвт хөрөнгө оруулалтын ажлуудын 86 хувь бол бүрэн дуусахаар өргөн баригдсан гэж Сангийн сайд хэлж байна. 914 төсөл. Тэр миний сан зовоод байгаа юм, тэр 303 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий барилгын ажлууд л зогсох маягтай болчихоод байгаа юм байна гэж би ойлгосон. Яагаад гэхээр нөгөө нэг одоо

эндээ бол суугаад ороод явчихна. Ирэх жил яг хэрэгжих болохоор нөгөө магадлангийн нь юмнууд нь тэрэн дээрээ гацаад, нөгөө компани, ААН-үүд чинь энийг бол ерөөсөө ингээд үнийн өсөлтийг тооцохгүй л бол явах боломжгүй боллоо гэдэг юм уу, явуулж байгаад ингээд зогсдог нэг ийм юм руу л орох болчихоод байна л даа. Тэгэхээр энэн дээр яах вэ Засгийн газар дээрээ та бүхэн бас нэг эргэж харахгүй бол хойтон жил, оны дундуур юм уу, нэг барилгын ажил ид эхлээд л энэ нэг 300 гаруй тэрбум төгрөгийн ажил чинь ер нь бол зогсох маягтай болчихоод байгаа шүү гэдгийг л одоо хэлэх.

Г.Занданшатар: Болдын Жавхлан Сангийн сайд хариулъя.

Б.Жавхлан: Баатарбилэг гишүүн ээ уучлаарай, сайн ойлгосонгүй

303 тэрбум төгрөгийн ингээд магадлан гараад ирчхэж байгаа шүү дээ. Одоо үнийн өсөлтөөр одоо яг ийм байдлаар одоо магадлан хийгдээд ингээд энэ барилгын ажил маань дуусах нь ээ гээд. Яг тэр 303 тэрбум төгрөгийг чинь төсөл бүр дээр нь ингээд яг магадлангаар нь суулгачхаж байгаа байхгүй юу. 2023 оны төсөв дээр нэмээд суулгачхаж байгаа юм. Тэрчлэн дуусахгүй байх эрсдэл байхгүй. Магадлан хийгдсэн бол тэр дүнгээрээ дуусах л ёстой.

Яалаа гэж суучихсан байхгүй юу. Нэмээд суулгаад оруулчихсан байхгүй юу, төсөл болгон дээр нь тийм. Бүгд явна гэсэн үг. 2024 ондоо.

Г.Занданшатар: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууя.

Х.Булгантуяа: 2023 онд бол амаргүй он жил байна. Тэгэхдээ энэ цаг үед бас төсвийнхөө алдагдлыг 1.5 их наяд төгрөг болгож бас бууруулж оруулж ирж байгаа Засгийн газарт, бас нийт иргэдийнхээ өмнөөс энэ төсвийн бодлого бол зөв явах юм бол иргэдийн амьдрал, амьжиргаа, улс орны эдийн засаг бас сайжирна ийм хүлээлттэй байсан учраас бас та бүхэнд баярласан талархсан бас илэрхийлье ээ.

Төсвийн алдагдлыг хүн болгон бид нар Монгол Улс одоо Шри Ланк шиг болчих юм биш биз дээ, Төсвийн алдагдал нэмэгдээд энийгээ гадаадын өр зээлээр дарсаар байгаа аад өрөнд идэгдчих юм биш биз дээ гэж маш их хүлээлттэй байсан.

Үүнтэй холбоотойгоор би бас нэг хэдэн асуултууд асууя гэж бодож байгаа юм.

Энэ Үндэсний аудитын газраас гаргасан дүгнэлтийн дагуу энэ хүнсний хангамж, Аюулгүй байдал, үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрт шаардагдах зээлийн эх үүсвэр шийдэгдээгүй байна гэсэн гэж Үндэсний аудитын газрын дүгнэлт гарсан байна. Тэгээд энэ хүнд цаг үед иргэдийн зүгээс, ялангуяа хүнсний хангамж, энэ аюулгүй байдал дээр онцгой ач холбогдол өгч анхаарч байгаа. Өнгөрсөн хаврын Эмээлтийн махны асуудал, энэ цаг үед ингээд гурилын үнэ өсөж байгаа, махны үнэ өсчих вий гэсэн ийм айдас байгаа цаг үед үүний эх үүсвэрийг хаанаас яаж шийднэ гэж одоо оруулж ирж байгаа вэ? Ерөнхийлөгчийн санаачилсан энэ үндэсний хөдөлгөөн дээр бол хүнсний хангамж, аюулгүй байдлын үндэсний хөдөлгөөн дээр.

Тэгэхээр үүний эх үүсвэрийг хэрхэн яаж шийдэх гэж байгаа вэ? Ерөнхийлөгчийн санаачилсан энэ хөдөлгөөн дээр иргэдийн хүлээлт бол маш их байгаа. Мөн хүнсний хангамж, мөн төсвийн орлогыг гол бүрдүүлдэг уул уурхайн салбарын гол хэрэглээ болсон түли, бензин шатахууны асуудлыг 2023 онд хэрхэн яаж одоо шийдэх гэж байгаа вэ? Энэ хэрвээ үнийн өсөлт хэрвээ их байх юм бол эс үгүй бол ханган нийлүүлэх тал дээрээ ямар нэгэн асуудал үүсэх юм бол шууд инфляц дээр энэ нь нөлөөлж орж ирдэг ээ. Тэгэхээр уул уурхайн сайдаас түлшний асуудлыг 2023 онд хэрхэн яаж шийдэх вэ? мөн хүүхдийн мөнгийг 91 хувьд нь олгохдоо анх 2022 онд хадгаламжтай хүүхэд гэж 50 хувийг нь хадгаламж болгож өгнө өө гэж байсан.

2023 онд үүнийг бас хэрхэн яаж шийдэх гэж байгаа вэ? Иргэдийн зүгээс өнөөдөр энэ төсвийг хараад 2023 оныхоо өөрсдийнхөө одоо амьдрал, бизнес эрхлэгчдийн хувьд ч гэсэн дээ бизнесийнхээ төсөл төлөвлөгөөг бас боловсруулж байгаа байх. Мөн Аудитын дүгнэлтийн 4.18 дээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг энэ 2023 оны төсөвт бол одоо сайн тусгаж оруулж ирсэн нь энэ төсвийн алдагдлыг бууруулахад ч гэсэндээ нөлөөлсөн байх. Тэгэхдээ энэний 3.1.3, 3.1.4-т зааснаас бусад төрийн албан хаагчид энэ төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрвээ зөрчих юм бол ямар хариуцлага, хэн хүлээлгэх нь бас тодорхойгүй байна шүү гэж зааж өгснийг та бүхэн маань бас анхаараарай. Мөн энэ 4.20 дээр нийгмийн халамжийн арга хэмжээнд 2018 онд 623.8 тэрбум төгрөгийг зарцуулдаг байсан бол 2023 онд 1 их наяд 991.4 тэрбум төгрөг бараг 2 их

наяд төгрөг болж нэмэгдсэн байна. 3.3 их наяд төгрөг.

Иргэдийн өнөөдөр амьдрал, амьжиргаа хүнд байгаа цаг үед халамж нэн шаардлагатай иргэдээ халамжлалгүй яах вэ? Тэгэхдээ энэ ажлын байрыг бий болгож байгаа энэ ААН-үүдээ бас бид нар халамжлахгүй бол энэ цаг үед бол үнэхээр хүнд байна. Тэгээд үүн дээр бас 2023 оны төсөв дээр ямархуу гол одоо бодлогуудыг явуулна гэж төлөвлөж байгаа вэ? гэдэг ийм хэдэн асуултыг асуух гэсэн юм.

Г.Занданшатар: Эхлээд Сангийн сайд Болдын Жавхлан, дараа нь Ганбаатар сайд.

Б.Жавхлан: Булгантуяа гишүүнд баярлалаа.

Бид төслийн тэнцлээ үнэхээр одоо нэлээн хичээж байж болох хамгийн бага алдагдлын хэмжээнд ингэж орж ирсэн байгаа. Тэрийг үнэлж хэлж байгаад талархлаа. Бид сүүлийн асуултаас явъя. Халамж бол ийм байгаа шүү. Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдын багц дээр хүүхдийн мөнгө одоо эргэж орж ирж байгаа юм. Тэгээд 1.9 буюу 2 их наяд руу ингэж харагдаж байгаа юм шүү. Тэр 600 тэрбум чинь бол хуучин нөгөө хүүхдийн мөнгөнөөс бусад Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд олгогддог тэр 60 гаруй төрлийн одоо нийгмийн халамжийн багцын нийт дүн нь энэ жилийнхээ механик өсөлтөөр үнийн өсөлтийн тоогоор ингэж орж ирж байгаа юм.

Хүүхдийн мөнгө ч гэсэн дээ мөн адил. Ер нь яг механик өсөлт орж ирж байгаа. Мөн одоо энэ жилээр бид одоо Халамжийн хууль руу энэ хүүхдийн

мөнгө маань одоо багтаж ингээж орж байгаа. Өөрөөр хэлбэл халамжийн нэг төрөл ингээд одоо өндөр орлоготой хэсэг нь буюу одоо 9 орчим хувь нь ингээд хүүхдийн мөнгөнөөс татгалзъя гэдэг ийм Засгийн газрын бодлогыг танилцуулж байгаа. Энэ хүрээнд 1.4 их наяд төгрөг, хүүхдийн мөнгө ингээж орж байгаа нь нийлээд 2 их наядын байгаа юм шүү. Ингээж нөгөө багц нь томорч харагдаж байна. Аудит дээр хийгдсэн дүгнэлтүүдийг мэдээж бид цаашидаа одоо ажлынхаа зарчим болгож ингээж явна.

Хөдөө аж ахуйн сайд байхгүй байгаа учраас би өмнөөс нь хариулчихъя. Нийтдээ 228 тэрбум төгрөгийн ХАА-н сайдын багц дээр хүнсний аюулгүй байдлын ийм багц болж суусан байгаа аа. Энэ нь бол мэдээж Улсын Их Хурлын тогтоолоор баталгаажиж гарсан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Үндэсний аюулгүй байдлын энэ одоо төлөвлөгөөтэй холбоотой, ингээж Засгийн газраас дэмжиж оруулж байгаа багц юм байгаа юм. Энийг одоо танд би товчхон. Хүнсний үйлдвэрлэлийг 175 сая МАА-н салбарыг 4 тэрбум, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 41 тэрбум, газар тариалангийн салбарыг хөгжүүлэх 40 тэрбум, хүнсний үйлдвэрлэлээ хөгжүүлэх 67 тэрбум, МАА-н салбарыг хөгжүүлэх 17 тэрбум, газар тариалангийн салбарын 53 тэрбум, нийтдээ 228 тэрбум төгрөг байгаа юм.

Дээрээс нь үүний хажуугаар татварын бодлогоор бид ХАА-н салбарт одоо боловсруулах шатны үйлдвэрүүдийг дэмжиж байгаа. Ингээд яг эцсийн бүтээгдэхүүн гаргах, боловсруулах шатны үйлдвэрт зориулж орж ирж байгаа тоног

төхөөрөмжүүдийг бид Гаалийн албан татвараас бүрэн чөлөөлж байгаа. 2027 он хүртэл. Энэ бол одоо багагүй дэмжлэг болно гэж ингээж харж байгаа юм.

Хүүхдийн мөнгөн дээр ер нь бид нэлээн судалгаа хийж байгаа. Ингээд 100 мянган төгрөг болсноос хойш хүүхдийн мөнгөний одоо хэрэглээг бид судлахад энэ жилд дунджаар 33 хувь нь ерөөсөө шууд хадгалж байгаа. Хэрэглэхгүйгээр 33 хувь нь. Өөрөөр хэлбэл энэ яг хүүхдийн мөнгөөр дамжсан одоо хэрэглээнээс гадуур, одоо шууд хүүхдийн хуримтлал болж байгааг бас ер нь бол энэ хүүхдийн мөнгөөр дэмжиж байгаа гэж хэлэхэд бол болно.

Дээрээс нь бид өмнө нь бол хүүхдийн мөнгө, хадгаламжийг шууд асуугаад мөнгө хэлбэрээр нь авах уу, хадгаламж хэлбэрээр нь авах уу гэхэд бол ер нь 90 гаруй хувь нь бол шууд авдаг. Гэхдээ цааш нь бол хадгалах ийм дараагийн процесс ингээж заавал явагддаг. Ийм одоо дадал бий болсон байна.

Тийм учраас бид нар одоо хүүхдийн мөнгө маань өөрөө давхар, бас хүүхдийн хуримтлалыг одоо шууд дэмжсэн ийм бодлого байгаа шүү гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Жамбалын Ганбаатар гишүүн хариулна. Уул уурхайтай холбоотой асуудлыг.

Ж.Ганбаатар: Булгантуяа гишүүний асуултад хариулья.

Монгол Улсын нийт шатахууны нийт хэрэглээ 1 сая 500 мянган тонн шатах тослох материалтайг нийлүүлбэл 1.8 сая тонн байдаг гэдгийг

бас танд хэлье. Сая Монгол Улсын Ерөнхий сайдын одоо ОХУ-д хийсэн айлчлалын үр дүнд шатахууны асуудлаар тогтвортой бас гэрээ байгуулах энэ эхлэл тавигдсан. Энэ хүрээнд АИ-92 бензин 815 доллароор 5 жилийн туршид одоо хадгалагдах ийм боломжтой болсон байгаа. Тэгэхдээ энэ гэрээ бол арай байгуулагдаж амжаагүй байна. Одоо манай яамнаас дэд сайдаар ахлуулсан хэсэг одоо ААН-үүдээ энэ ирэх 7 хоногт авч яваад энэ гэрээ байгуулагдахаар ингээд явж байгаа. Дизелийн түлшний хувьд бол зах зээлийн үнээс 10 хувийн хямдрал авч байгаа. Мөн дотоод зардлуудаа тодорхой хэмжээгээр Орос нефть компани буулгаж байгаа. Энэ өөрөө ер нь бол урьд өмнө байгаагүй тодорхой, одоо хямдралуудыг нийлүүлэгч тал үзүүлж байгаа. Хэрвээ зах зээлийн үнэ 9 сарын 2-ны байдлаас 30 хувиар 3 сар дараалан савласан тохиолдолд эргэж харх энэ хэлцэлд бас ийм зүйл тусгагдсан байгаа. Зах зээлийн үнэ огцом буух юм уу, огцом өсөх, тэр нь одоо 3 сар дараалан гэсэн ийм зүйлүүд бол бид нар бас тусгуулж чадсан.

Хэрвээ одоо зах зээлийн үнэ тогтвортой байсан тохиолдолд бол 2023 онд одоо шатахууны үнэ нийлүүлэгч талаас тогтвортой хангана гэдгийгээ 5 жилийн гэрээгээр хангана гэдгийгээ илэрхийлж байгаа. Тэгэхлээр энэ бол нэлээн тийм сайн үр дүн байгаа гэдгийг хэлье.

Ойрын өдрүүдэд бас Уул уурхайн яам нэг их зарлахгүй байгаа боловч одоо дизель түлшний хувьд бол яг энэ хэрэглээний энэ саруудад бол тодорхой хувиар 300 төгрөгөөр 350 төгрөгөөр дизель түлш бууж байгаа нь одоо ОХУ-д Ерөнхий сайд очиж, одоо эхлэлийг нь тавьсан ажлын үр

дүн бас нөлөөгөө үзүүлж байгаа гэдгийг хэлье ээ. Баярлалаа.

Г.Занданшатар:

Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн тодруулж асууя.

Х.Булгантуяа: Иргэдээс бас ийм асуултууд ирж байна.

Цахилгаан тог энэ жил, өнгөрсөн жил Эрдэнэт үйлдвэрээс төлж байсан. Энэ одоо 2023 онд яах вэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт хатуу түлш, сайжруулсан түлшийг бас хөнгөлөлттэй үнээр иргэдэд олгож байсан. Агаарын бохирдолтой холбоотойгоор тодорхой төсөв Байгаль орчны сайдын багц дээр бас тавигдаж явж байсан. Ирэх онд энэ бас яах вэ? 2023 онд бид нар ямар ямар одоо зээлүүдээ өөрсдөө ипотекийн зээлүүдээ төлөгдөж эхлэх нь үү? Хатуу түлш нь ямар үнээр борлогдох нь вэ? Тог цахилгаан өөрсдөө төлж эхлэх нь үү? Хүүхдийн мөнгө маань 50, 100 мянгаараа бүтнээрээ олгогдох нь уу? 50000 шууд дансанд нь хүүхдэд хадгаламжаар ороод 50000 нь бэлгээр очих юм уу, яах юм бол гээд нөгөө 2023 оныхоо амьдралыг бас айл өрхүүд төлөвлөх гээд байх шиг байна л даа. Тэгээд энэ асуудлыг энийг Байгаа аль орчны сайд хариулах байх тэ.

Г.Занданшатар: Тийм Бат Өлзийн Бат Эрдэнэ сайд. 92.

Б.Бат-Эрдэнэ: Булгантуяа гишүүний асуултад хариулья.

2023 оны төсөв дээр Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр дээр нийтдээ 27.2 тэрбум төгрөгийг суулгаж өгсөн 27.2 тэрбум төгрөг

дотор бол аймгуудын дулааны станцын зуухны яндангийн утаа шүүгч суурилуулах. Шаардлага хангасан сайжруулсан түлшний үйлдвэрлэлд буюу одоо 2022 онд 4 аймагт бол баригдаж байгаа 4 үйлдвэр байгаа. Энэний үргэлжлэл болсон төсвийг дээрээс нь цахилгаан автомашин цэнэглэх станц байгуулах буюу энэ агаар орчны бохирдол дээр бас тодорхой хэмжээний нөлөөлж байгаа энэхүү асуудлыг бас цэгцлэх, агаар орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэлийн судалгааны ажлыг, ногоон зээлийн бүтээгдэхүүн бий болгох стандартын шаардлага хангасан аюултай хог хаягдлын агуулахуудыг аймгуудад буюу одоо Баян-Өлгий, Говь Алтай, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Ховд зэрэг аймгуудад байгуулах, гол нууруудын хурдас цэвэршүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, олон нийт рүү чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилга аймгийн төв 10000-аас дээш хүн амтай, томоохон төв суурин газарт агаарын чанарын иж бүрэн автомат суурин харуул суурилуулах, нийслэл болон 21 аймгийн төв, 10000-аас дээш хүн амтай томоохон суурь төв суурин газруудад ойн анги байгуулах, мод тарих мод үржүүлгийн техник тоног төхөөрөмж, усалгааны систем бий болгох. Орчны бохирдол бууруулах үндэсний хороо, ажлын албаны үйл ажиллагааны зардал 4 аймгийн 20000 айл өрхүүд угаарын хийн мэдрэгч, 20000 угаарын хий мэдээлэл дамжуулах төхөөрөмж суурилуулах гэх мэтчилэнгээр ингээд нийтдээ 27.2 тэрбум төгрөгийг суулгаж өгсөн.

Сайжруулсан шахмал түлшний үнийг бол хямдруулахгүй. Өнгөрсөн хугацаанд бол ковидтой холбоотойгоор сайжруулсан шахмал

түлшний үнэ тарифыг бол хямдруулж ирсэн, үүнээс улбаатай сөрөг нөлөөллүүд бас байгаа. Тэгэхээр энэ удаад бол сайжруулсан шахмал түлшин дээр бол үнийг хямдруулахгүй ээ.

Г.Занданшатар: Тог цахилгаан яах вэ?

Б.Бат-Эрдэнэ: Тог цахилгааны хөнгөлөлт бол 27.2 тэрбум төгрөгийн дотор бол суугаагүй байгаа.

Г.Занданшатар: Эрчим хүчний үнийн чөлөөлөлттэй дээр.

Салдангийн Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: 7 асуулт байна өнөөдөр одоо Монгол Улс энэ эдийн засгийн одоо хямрал гүн балчигт шигдчихлээ. Тэгээд ийм жирийн үе шиг иймэрхүү одоо нэг тайван гэдэг юм уу, бодит биш, эдийн засгийн том реформ хийхээргүй ийм төсөв орж ирсэн байна. Аудит бол маш сайн, бодит ийм хатуу дүгнэлт өгсөн байна. Аудит бол энэ дээр маш сайн, одоо ажилласан байна. Энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ч гэсэн ер нь сайн дүгнэлтүүд хийсэн байна. Тэгэхээр бид одоо зоригтой том эдийн засгийн реформ хийхгүйгээр энэ хямралаас бол гарч чадахгүй шүү дээ. Нэг жсоохон жсоохон юм хэмнэлээ, жсоохон жсоохон юм оролдсоноо бага зарлаа гээд. Ерөөсөө энэ бол нэг их тийм бодитой үр дүнд хүрэхгүй. Өөрөөр хэлбэл орлогыг бид нар огцом нэмэгдүүлж байж энэ хямралаас гарна. Тийм, мэдээж яах вэ, сайн зүйлүүд бол байна. Тэр төсвийн алдагдал буурч орж ирсэн байна, хэмнэлтүүд байна. Одоо энэ гадаадын иргэдийг одоо ойлгох, татах, орлого олох гээд ийм зүйлүүд бол байна. Хамгийн гол асуудал юу вэ

гэхээр эдийн засаг дахь энэ төсвийн зардал чинь 34.7 хувь гэж байгаа юм.

Тэгэхээр энэ чинь төрийн эдийн засаг дахь оролцоо чинь дахиад л багасахгүй байгаа байхгүй юу. Ардчилсан нам энийг байнга хэлдэг шүү дээ. Энэ төрийн эдийн засагт оролцоогоо л багасгаад, хувийн хэвшлийг дээшлүүлээд өгөөч ээ л гэдэг. Тэгэхээр энэ эдийн засгаас сэргээх өмнөх одоо туршиллагууд Монгол Улсад байна шүү дээ. Энийгээ бид ашиглая л даа. 1990 онд ийм туршилага байсан шүү дээ. Эдийн засгийн хямрал болсон, лангуу хоосорсон иргэд мөнгөгүй болсон, яахаа мэдэхгүй байхад бас зөв бодлого яваад л ерөөсөө иргэдийн энэ хямралаас гарах ажлыг иргэдэд л хариуцуулсан шүү дээ.

Гадаад паспортыг нь өгсөн, ганзаганд явах нь явсан, хуулиар хориглохгүй бүх зүйлүүдийг хийсэн. Энэ ашиглалтгүй баахан подвалууд чинь бүгд оёдлын одоо цехүүд болсон. Тохиролцооны дэлгүүрүүд болсон. Дороо л эдийн засаг сайжраад л ирсэн шүү дээ. Тэгэхээр энэ төр өөрөө бүх юмыг хийх гээд байгаа биш, эдийн засгийн эрмэлзлийг нь сайжруулах л асуудал дээр ерөөсөө би Монголын төр ажиллахгүй байна л гэж хэлээд байгаа шүү дээ.

Өнөөдөр Монголчууд эдийн засгаа дээшлүүлэх, бизнес хийх эрмэлзэл нь байхгүй болчихлоо. Энэ хамгийн аюултай үзэгдэл байхгүй юу. Одоо ерөөсөө эдийн засагчдын гаргаж байгаа дүгнэлт чинь л тэр шүү дээ. Иргэдийг ядуурлаас гаргая, сайн эдийн засгаа өсгөе гэдэг дүгнэлт бол юу вэ гэхлээр ерөөсөө л нийгмийн гишүүдийн харилцаа. Энэ хүмүүс эдийн засгаа дээшлүүлэх эрмэлзэлтэй болох энэ л хамгийн чухал байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ 1990-ээд оныхоо туршилагыг хараач ээ.

Энэ чинь хийж болно шүү дээ. Юмнууд ажиллаж болно. Хятад улс жишээлэхэд, энийг хамгийн сайн хийж чадаж байгаа. 100 хүнд оногдох боловсролтой иргэдийн тоогоор дэлхийд хамгийн сүүлээр ордог хэрнээ Хятад хүний энэ ядуурлаас гарах эрмэлзлийг хэн ч зогсоож чаддаггүй. Тийм учраас энэ дээр одоо бид төр засаг их дутуу ажиллаж байна.

Тэгээд Ерөнхий сайд яг энэ дээр одоо иргэдийнхээ энэ бизнесийг эрмэлзлийг дээшлүүлэх чиглэлээр одоо яг ямар ажил хийх гэж төлөвлөж байна вэ гэдгийг бас нэг тодорхой асуумаар байна.

Хоёр дахь асуудал бол энэ халамжаас хөдөлмөрт шилжинэ ээ гэсэн. Гэтэл халамжийн сангийн нийт зардлыг 113.9 тэрбумаар нэмсэн байгаа. Энэний одоо шалтгаан нь юу юм бол оо? Юун дээр нэмэгдэх юм? Би тэгээд НӨАТ-ыг бас нэг 5 хувь болгочхооч ээ гэсэн санал гаргаад л байгаа. Манай бүлгийнхэн бас гаргадаг.

Ядаж 2 жил, нэг хямралаас гартал 5 хувь болгочихъё л доо. Энэ чинь том реформ мөн үү мөн шүү дээ. Өөрөөр хэлбэл 10 хувь гээд хагас нь төлж байснаас 5 хувиар бүгдээрээ төлдөг больё. Энэ чинь татварын орлого нэмэгдээд л явна. Тэгэхээр иймэрхүү чиглэлийн зоригтой шийдлүүдээ одоо хийж болдоггүй юм уу гэдэг ийм иргэдийнхээ нуруун дээр үүрч байгаа ачааг хөнгөлөх энэ зүйл. Яах вэ төсвийн орлогын 25 хувь нь энэ НӨАТ-аас орж ирнэ гэж байна л даа. Үгүй ээ яах вэ дээ, бүгдээрээ төлдөг болчихвол энэ орлого чинь буурахгүй,

харин нэмэгдээд ирэх магадлалтай шүү дээ. Тийм учраас энэ иргэдээ л ерөөсөө татвар төлдөг болъё, бизнес эрхэлдэг болъё. Энэ ногоо тарьдаг болъё гэдэг энэ эрмэлзлийг л унтраачихснаараа бид нар хамгийн гол.

Г.Занданишатар: Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин, Даваажанцангийн Сарангэрэл, Тогмидын Доржханд нарын урилгаар Хан-Уул дүүргийн ахмадын хорооны дарга нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт ахмадууд та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

Асуултад хариулна, хариулт хангалтгүй гэж үзвэл. Чимэдийн Хүрэлбаатар сайд.

Ч.Хүрэлбаатар: Бид нар ер нь нэлээд жсоохон бодитой амьдралтай байх ёстой. Романтизмаар хол явахгүй болов уу гэж бодож байгаа. Тэгээд бусад орнуудын эдийн засаг дээр гарсан алдаануудыг бас бид нар харж зөв зүйтэй бодлогуудыг авч хэрэгжүүлж явах болов уу, явах нь зөв байх гэж бодож байгаа юм. Яг өнөөдөр бол Монгол Улсын эдийн засагт тулгамдаад байгаа асуудал бол энэ эдийн засгийг тогтворжуулах асуудал байгаа. Бид бүгд бас энэ яг одоогийн болж байгаа зүйл бол Монгол Улсад тохиолдсон олон хямралуудаас хамгийн удаан үргэлжилж байгаа хямрал нь энэ болчхоод байгаа юм. Хамгийн удаан нөгөө 2008, 2009 оны дэлхийн санхүүгийн хямрал, дараа нь 2014 оноос эхэлсэн тэр томоохон

агшилт эд нар бол үндсэндээ 2 жил, 2, 3 жил яваад зогсчихсон бол энэ удаагийн хямрал одоо ингээд цааш үргэлжлээд явж байна.

Тэгэхээр бид нарын түрүүн Ерөнхий сайд үгэндээ хэлсэн. Хамгийн том зорилго бол макро эдийн засгийг тогтворжуулах, энэ нь бол үндсэндээ цаанаа эдийн засгийн өсөлтийг ханшийг тогтворжуулах, инфляцыг тогтворжуулах, ийм зүйл болчхож байгаа юм. Энэ нь тогтворжихгүй байгаа учраас хүмүүсийн одоо хэчнээн сайхан эрмэлзэл, бизнес хийх эрмэлзэл, бас сүүлийн 30-аад жилийн хугацаанд бас цуглуулсан энэ турилага, мэдлэг, гадаад дотоод явж үзсэн, харсан, энэ бүхнийгээ ажил хэрэг болгоход нь одоо саад болж байгаа зүйл бол энэ эдийн засгийг тогтворжуулаагүй ийм зүйл юм байгаа юм. Тэгэхээр бид нар хэрэгжүүлэх ёстой ажлуудаа эрэмбэлж байгаад энэ удаа бол нэг номерт нь эдийн засгийн хувьд эдийн засгаа Засгийн газар оруулж ирсэн. Ийм ч учраас үндсэндээ 2022 онтой харьцуулах юм бол төсвийн алдагдал чинь 2.4 их наядаас бараг 2 дахин, 2 дахин гэж арай ч хэлж болохгүй байх, 1.5 их наяд төгрөг болгож төсвийн алдагдлаа буулгаж байна.

2024 онд хүрэх ёстой төсвийн алдагдлынхаа зорилтыг 1 жилээр наашлуулж 2023 он болгож байгаа. Энэ бүгдийгээ эхлээд хийчхээд эдийн засгаа тогтворжуулчих юм бол Одонтуюа гишүүний хэлж байгаа энэ зүйлүүдийг бид нар бас хийгдээд явчих боломжтой болов уу л гэж бодож байгаа. Тэгээд нэг номерынхоо зорилгыг бид нар эдийн засгийг макро эдийн засгийг тогтворжуулах гэдэг ийм зорилт тавьсан юм гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Салдангийн Одонтуяа гишүүн тодруулж асууна. 1 минут.

С.Одонтуяа: Өнөөдрөөс л тэгэхээр яах вэ, олон жил сайхан юм ярилаа шүү дээ. Олон жил сайхан онол ярилаа. Эдийн засаг гэдэг чинь ерөөсөө айлд талх байна уу, мах байна уу, бензин байна уу л гээд л ярья л даа. Тэгэхээр н эдийн засгийг тогтворжуулна гэж өнгөрсөн 3 жил одоо савлуулаад л баахан хэрэгтэй хэрэггүй хөрөнгө оруулалт хийчхээд одоо бүгдийг нь хаслаа гэдэг чинь энэ савлаж байгаа юм мөн л байхгүй юу. Ингэж тогтвортой бол байлгаж болохгүй. Тэгэхээр төр би хэлээд байна шүү дээ. Төр бүх юмыг хийж чадахгүйгээр одоо бид нар хүлээгээд иргэд рүүгээ энэ ядуурлаас гарах иргэдээ төр эдийн засгаа сайжруулах зүйл рүү л оруулаач ээ л гэж хэлээд байгаа. Төрийн ачааг хөнгөлөе өө л гээд байгаа байхгүй юу. Энэ чиглэлээр үр дүнд хүрсэн юм алга. Тийм учраас би энийг л хэлээд байгаа юм.

Төмөр замын чиглэлээр нэг юм асуух гэсэн юм. Энэ төмөр зам дээр одоо ерөөсөө дорвитой шинэчлэл хийхгүй бол одоо энэ хамаг вагон зүтгүүр, тэгээд л энэ иргэдийн явж байгаа энэ төмөр замын галт тэргүүд чинь ерөөсөө бүр хуучирчихлаа. Одоо бараг социализмын үед ч ийм юм байгаагүй.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд гүйцээж хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Одонтуяа гишүүнтэй санал нэг байна. Ер нь энэ төр алив бизнесээс татгалзана. Аль болохоор төр, хувийн хэвшил хийж чаддаг бүгдээс татгалзана гэдэг бодлогыг Засгийн газар бол олон удаа

хэлээд ажил хэрэг болгох чиглэлээр нэлээд ажиллаж байгаа. Ер нь тэгээд хувийн хэвшил бол Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн хөдөлгүүр нь шүү дээ. Тийм учраас хувийн хэвшлийгээ дэмжих чиглэлийн бодлогыг бол маш тууштай, цаашид үргэлжлүүлж явуулна. Одоо төр элдэв бус, янз бүрийн бизнест хутгалдаад хийгээд байдаг зүйлүүдийг ер нь зогсоох ийм чиглэлээр л ажиллаж байгаа гэдгийг би хэлье.

Бямбацогт сайд. Дараа нь Жавхлан сайд хариулаад явчих.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт Зам тээврийн хөгжлийн сайд хариулна.

С.Бямбацогт: Одонтуяа гишүүн бас чухал асуудал хөндөж байна. Монгол Улс УБТЗ-ыг ганцхан төмөр замтай, түүнийг нь Орос, Монгол 50:50 хувь хамтарч эзэмшдэг ийм байгаа. Сүүлийн жилүүдэд бол нэлээн олон төмөр зам баригдаж байгаа. Гэхдээ УБТЗ маань нийт Монгол Улсын ачаа эргэлт, зорчигч тээврийн дийлэнхийг нуруун дээрээ үүрч явдаг ийм чухал салбар. Энэ төмөр замын салбарт үндсэндээ төмөр замын тээврийн тарифыг бас олон жил барьж ирсэн. Ер нь сүүлийн 20-иод жил арваг хэдэн жил ер нь нэмээгүй. Үүнтэй холбоотойгоор үндсэндээ нэлээд алдагдалтай тээврүүд хийгддэг. Үүнээсээ болоод техник тоног төхөөрөмжөө шинэчлэх, парк шинэчлэлт хийх, дээрээс нь мөн ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хөрөнгө оруулалт үйлчилгээг сайжруулах тал дээр бас нэлээн дутагдалтай байдаг юм байна лээ. Тийм болохоор тодорхой эрэмбэтэйгээр өөрөөр хэлэх юм бол

нийгмийн шинж чанартай ачаа буюу шатахуун.../минут дуусав/

Г.Занданишатар: Болдын Жавхлан сайд.

Б.Жавхлан: Одонтуяа гишүүний асуултад нэмж хариулъя. НӨАТ-тай холбоотой асуудал. НӨАТ бол ер нь олон улсын ийм сонгодог татвар. Ер нь 170 гаруй улсын НӨАТ-ын татварын системтэй их удаан явж явж байгаа. Маши сайн хөгжиж ирсэн ийм систем байдаг. Хувь хэмжээний хувьд бол манайх харин багадаа ордог. 10 буюу 10-аас доош байдаг цөөхөн 20 гаруй улсын хэмжээнд. Та бүхэн сайн мэдэх байх. Хойд хөрш, урд хөрш 2 маань бол нэг нь 17, нэг нь 20 шүү дээ. Европ бол евро зон бол бүр 20 хувьтай байдаг. Тэгэхээр энэ хэмжээнээсээ болоод НӨАТ төлөхгүй байгаа асуудал ерөөсөө огт биш. Энэ НӨАТ-ын системд ороод бид нар яг одоогийнхоо байгаа тогтолцоонд чинь ороод 7 дахь жилдээ явж байна. Анх энэ 46 хувьтай эхэлсэн, одоо 67 хувьтай байгаа юм. Тэгэхээр бидний зорилго бол нэг 90 хувь гаргах. Тэгэхээр 7 жилийн хугацаанд 20-иод хувь.../минут дуусав/

Г.Занданишатар: Одоо Тогмидын Доржханд гишүүн.

Т.Доржханд: Баярлалаа. Надад тов тодорхой 5 асуулт байна.

Нэгдүгээрт. Ерөнхий сайд маань энэ баялгийн сан, тэтгэврийн шинэчлэл гэж маш их ярьсан, ярьдаг. Тэрийгээ хийх ёстой. Гэтэл энэ ирэх жилийн төсөв дээр тэтгэврийн шинэчлэлтэй холбоотой ямар ч зардал тусаагүй байна. Тэгэхээр та чинь энэ шинэчлэлээ хэзээ хийх гэж байна. Энэ дээр тодорхой хариулт өгмөөр байна.

Хоёрдугаарт. Эдийн засгийн сайд Хүрэлбаатар төсвийн гадуурх мөнгө, Эрдэнэс Таван толгой, Эрдэнэт гээд төсвийн шинж чанартай төсвөөсөө хэд дахин илүү их мөнгө яваад байна. 2012-2016 оны үед Монгол Улс 4 төсөвтэй болчихлоо, дампуурлаа гэж хамгийн их, чанга ярьж байсан хүн бол та. Тэр бол зөв байсан. Гэтэл яг өнөөдөр ингээд төсвөөсөө илүү дахиад төсвийн шинж чанартай нэмэлт төсөв гарч ирчихсэн байна. Тэгээд гарч ирэхдээ энд ингээд Улсын Их Хурлын 76 гишүүд тойргийнхоо мөнгөн дээр ингээд яаж энийгээ тусгах вэ гээд алаан болдог бол тэнд нэг захирал шийдээд байна шүү дээ. Улсын төсөв чинь иргэдэд нээлттэйгээр хэлэлцэгддэг бол улсын төсвийн хөрөнгө оруулалтаас хэд дахин илүү мөнгө тэнд шийдэгдээд байна шүү дээ.

Төмөр зам барьж байна. Төмөр замыг хэн барьдаг юм. Нэг бол төсөв, хувийн сектор хамтарч барьдаг тийм биз? Энэ чинь төсвийн шинж чанартай дэд бүтцийн төсөл байхгүй юу? Жорлонгийн юм барьдаг юм. Эрдэнэтээр жорлон бариулж байна шүү дээ тухайлбал. Халамжилж байна. Үгүй ээ, тэгээд халамж гэдэг чинь төсөв байдаг шүү дээ. Тийм болохоор энэ мөнгөө хэзээ, яаж төсөвтөө төвлөрүүлэх юм бэ? Энэ бодлогоо яаж гаргах юм бэ? Тэгээд тэр нь нэг улсын нууцад оруулчхаад байгаа нүүрсээр төлбөр хийдэг. Энэ хүүгийн системийн хэзээ ил болгох юм бэ? Энийгээ чуулган дээр та тов тодорхой хариулаад өг гэж.

Дараачийнх нь Сангийн сайдад 2 асуулт байна. Шинээр хөрөнгө оруулалт тавиагүй гээд зөв. Цаашаа харин бүр балансыг нь тэглэмээр

байгаа байхгүй юу. Алдагдалгүй амар байгаа юм. Гэхдээ шинэ хөрөнгө оруулалттай холбоотойгоор нэг иргэнд ч гэсэн хүсээд байх шиг байна. Энэ Хэнтий аймагт шинэ хөрөнгө оруулалт байгаа юу? Дархан аймагт шинэ хөрөнгө оруулалт байгаа юу? Тэрийгээ та нэг тодорхой хэлээдхээрэй.

Дараагийн асуулт нь төр хийх шаардлагагүй ажил үйлчилгээнүүдийг хувийн секторт хийх байдлаар төрөө жижиглэ гээд төрийн санхүүжилт чинь өнөөдөр 20.5 их наяд, бизнесийг дэмждэг санхүүжилт чинь 25 их наяд гээд ижилхэн болчихлоо. Дэлхийд ийм байдаггүй. Дэлхийд энэ чинь 80:20-той байдаг. Гэтэл манайх ингээд төр бүгдийг нь шийдэх ийм юм руу явчихлаа. Тэгэхээр асуулт нь яаж энэ төрийн оролцоог жижиглэх юм бэ? Энэ бодлогынхоо зөв арга хэмжээнүүдийг зоригтойгоор авч хэрэгжүүлэх юм уу? Хэрэгжүүлэхгүй юм уу? энэ дээр тодорхой тайлбар өгөөрэй.

Тэгээд тавдугаарт, Үндэсний аудитын дүгнэлтийг үзлээ. Сайн дүгнэлт байна. Тухайлбал, Үндэсний аудитын дүгнэлтийн 5-д Энэ төсвийн төсөвт халамжийн зардлыг өмнөх онуудаас бууруулахгүй төсөвлөж байгаагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хэрэгжих нөхцөл бүрдэхгүй гэж тов тодорхой ярьсан байгаа биз. Би хэлж байгаа юм биш. Тэгэхдээ бүх эдийн засагчид хэлж байгаа. Төсвийн зардлын 2 төгрөг тутмын 1 нь халамж. Үгүй ээ, тэгээд цаашаага энэ өсөөд явах юм бол бид нар 2023 оны төсөв гэдэг нэртэй биш, харин 2023 оны халамж гэдэг нэртэй бодлогын бичиг баримт ярих хэрэгтэй байхгүй юу. Шулуухан хэлэхэд энэ халамжаас хөдөлмөр рүү шилжинэ

гэдэг бодлого чинь тодорхой тусахгүй байна. Үр дүн харагдахгүй байна. Тэгэхээр Аудитын газар энд тайлбар хийх хэрэгтэй байна. Яг ямар үндэслэлээр, яг ямар байдлаар та нар харж байгаа юм бэ? Энэ дээр бол эдийн засагч.../минут дуусав/

Г.Занданшатар: Чимидийн Хүрэлбаатар сайд.

Ч.Хүрэлбаатар: Доржханд гишүүний 2 асуултад хариулъя. Хоёулаа их чухал асуулт байгаа.

Нэгдүгээрт нь энэ төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн мөнгийг улсын төсөв дээр татаж авчраад нэг болго гэдэг ийм зүйл хэлж байгаа. Өмнө нь олон төсөвтэй явж байсан. Тэр бол арай өөр, Засгийн газар нь өөрөө бондоо гаргачхаад, үүнийгээ тусдаа зарцуулж байсныг бид нар бол энийг өөр төсөвтэй явж байгаа буруу гэж хэлж байсан. Энэ дээр бид нар Эрдэнэс Тавантолгой төмөр замыг хаанаас хийх вэ гэдэг энэ асуудал их олон жил яригдсан юм. Тэр улсын төсвөөс мөнгө гаргаад хийх ёстой гэж хэлдэг. Тэрийгээ цэргүүдээр бариулах ёстой гэж үзээд хийж явж байсан ч хүмүүс бас бий. Зарим нь бол бүр Монголбанкаар төгрөг хэвлүүлээд наадахаа гаргаа хий гээд ингээд шахаж байсан. Тэгээд явж, явж эцэстээ бид нар чинь энийг чинь зүгээр бас нэг өдөр юу гэдэг юм, дээшээ харж хэвтэж байгаа гээд ер нь хийчихсэн зөв юм байна гэж үзээгүй. Бас бусад орнуудын хувьд авч үзэж харж байгаад нэгэнт 5 толгой гэдэг тэр том нүүрсний бассейн байж байгаа бол, энэ дээрээс нүүрсээ зөөж байгаа бол энэ яг цэвэр бизнесийнхээ зарчмаар л яваг. Тавантолгой өөрөө санхүүжүүл үүнийгээ гэж байгаа.

Тэгэхээр тэр урагшаагаа явсан төмөр зам, зүүн тийшээ явуулсан төмөр зам, бас тэнд цахилгаан станц хэрэгтэй гэж байгаа юм. Бас нүүрс баяжуулна гэж байгаа юм уу? Усны асуудал. Энэ бүгд өөрөө тэр үйлдвэр нь өөрөө хийгээд явах ийм учиртай юм байгаа юм. Тэнд байгаа бүх бизнесүүдийн мөнгийг нүүл болгож нэгтгэж, хийж явах үндсэн зарчим нь бол энэ. Эндэх төрийн оролцоо л бага байгаасай гэж бодож явж байгаа. Ийм учраас Засгийн газраас тухайн үедээ тогтоол гаргаад үүнийгээ хийгээд яв гэдэг ийм л шийдвэр гаргасан. Нэг л алдаа байгаа юм. Энэ төслүүдээ эрэмбэлэх ёстой. 1 номерт нь хил рүүгээ явсан төмөр замаас санхүүжүүлэх юм уу, зүүн тийш яваад олон 10, 20 жилийн дараа хэрэглэгдэх тэр ашгаа өгөх төмөр зам руу мөнгөө хийх үү гэдэг ийм л асуудал. Тэгээд энэ нь бол өөрөө бизнесийн зарчмаар явах нь, тэр нь цаашидаа ер нь зөв.

Эрдэнэт үйлдвэрийн хувьд бол яах аргагүй энэ Ковидын хувьд бол ард иргэдийн болон аж ахуйн нэгжүүдийн эрчим хүчний үнийг зардаг, төлүүлэх ийм шийдвэр бол гаргаж явсан. Энэ бол цэвэр Ковидтой холбоотой түүнээс биш Эрдэнэт үйлдвэр өөрийнхөө үйл ажиллагаагаа тэлэхтэй холбоотой хөрөнгө оруулалт хийхэд нь болохгүй, одоо төсөв дээр авчирч бид нар хуваарилна гэж үздэг нь өөрөө бас энэ яг бизнесийнх нь зарчимтай зөрчилдөх ийм учир юм байгаа юм шүү. Тийм учраас бизнесийн зарчмаар хийгдэж явагдах ёстой хөрөнгө оруулалтын ажлууд нь тусдаа байгаа гэж байгаа юм.

Хоёрдугаарт нь бол улсын нууцад хэзээ орсон зүйлүүдийг гаргах вэ гэж. Энэ дээр бол Доржханд

гишүүнтэй би 100 хувь санал нэг байгаа. Энийг олон жил сонгогдсоноосоо хойш тасралтгүй ярьж байгаа. Ямар нэгэн төрийн мэдэлтэйгээр оролцсон, санхүүтэй холбоотой бүтээн байгуулалттай холбоотой нууц гэрээнүүд ил болго гэдэг зүйлийг та бол удаа дараа шахаж байгаа. Тэгээд 100 хувь санал нэг байгаа. Сая Засгийн газрын хуралдаан дээр ороод энэ улсын нууцтай холбоотой байгаа гэрээнүүдийг ил болгоно гэдэг шийдвэр, Засгийн газрын тогтоол бол гарчихсан байж байгаа.

Тэгээд үе шатаар дамжигдаад тэр бас тодорхой журмаар явагдаад хийгдэнэ. Ер нь цаашидаа Монгол Улсад бол аливаа бүтээн байгуулалтын ажлууд бол нууцаар хийгдэх учиргүй юм байгаа юм. Бүтээн байгуулалт л юм бол ард иргэдийн нүдэн дээр ил тод зарцуулж байгаа мөнгө нь тавьж байгаа зорилт, гарах, үр дүнг нь бол нийт ард иргэд мэдэж байх ёстой гэж бодож байгаа гэдгийг хэлье. Тэгэхээр тэр өмнөх ярьсан алдаануудын нэг л бол төслүүдээ эрэмбэлээгүй, бас нууцад оруулсан олон янзын хардлага дагуулж байгаа. Энийгээ бол цэгцэлнэ гээд Засгийн газар шийдвэр гаргачихсан байгаа гэдгээ хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Болдын Жавхлан сайд.

Б.Жавхлан: Доржханд гишүүний асуултад хариулья.

Бид ирэх жилийнхээ төсвийнхөө тэнцлийг 1.5 их наяд хасах буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь дээр барьж орж ирж байгаа. Энэ бол бидний байж болох хамгийн бага

алдагдлын түвшин гэж харж байгаа юм.

Дээрээс нь хэлэх юм бол бид 2020 оноос энэ ковидтой нүүр тулж эхэлснээс хойш төсвийн тусгай шаардлагуудаа 2 удаа хойшлуулсан. Өөрөөр хэлбэл 2 жилээр хойшлуулсан гэсэн үг. Ингээд ирэх оны 2.8 гэж бидний хүрч чадаж байгаа тоо маань уг нь бол 2024 онд хүрч болох ийм тоо юм байгаа юм. Тэгэхээр бид нар 2 жил алдсаныг ямар ч байсан энэ удаа 1 жил наашлуулж байгаа. 1 жилд нь нөхөж байгаа ийм алдагдлын түвшин юм. Тэгээд цаашидаа тантай бол санал 100 хувь нийлж байна. Шат дараатай нольлох чадвал 2024 онд, 2025 онд бол нольлох бүрэн боломж гарч ирнэ. Эдгээр төсвийн шинэчлэлүүдийг амжилттай үргэлжлүүлж чадвал ингэж харж байна.

Төр хувийн хэвшлийн түншлэлийн асуудлыг бол одоо энэ хууль өргөн баригдсан байгаа. Энэ дээр та дэмжээд явж байгаад бид их талархаж байна. Бид нэгжийн хуулиар нэлээдгүй ажлуудыг орон нутаг руу шилжүүлсэн байдаг. Орон нутаг харин эдгээр төрийн хэд, хэдэн төрлийн үйлчилгээ болон олон нийтэд үзүүлж болох хувийн хэвшлийн орон зайг энэ хуулийн хүрээнд хийж болох ийм эрх зүйн орчин үүссэн. Гэсэн хэдий ч энэ нь бас тийм төгс болж чадахгүй байгаа. Тэгэхээр энэ жил бид өргөн барьсан Төр хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг батлаад авчихвал 1 сарын 1-нээс энэ хуультайгаа харин хавсраад төрийн үзүүлж байгаа маш олон төрлийн төрийн үйлчилгээг бид худалдаж авах замаар хувийн хэвшлээр хийлгүүлэх ийм маш том эдийн засгийн орон зай үүсэх юм. Бид ийм замаар энэ ажлыг цаашидаа үргэлжлүүлж явна.

Дархан, Хэнтийн хувьд бид нийтлэг зарчмаар л явж байгаа. Нийтлэг зарчмаар. Ирэх жил нэг ч төгрөгийн шинэ хөрөнгө оруулалтууд байхгүй. Энэ бүх аймагт ижил үйлчилж байгаа. Ийм зарчмаар явж байгаа. Эцэст нь хэлэхэд төрийн бид *parliament.mn* дээр жишээ нь төсвийн хөрөнгө оруулалтууд бүх эдийн засгийн ангиллаар ширхэглэн байгаа учраас тэндээс олон нийт хэнийг харж давхар нягталж болно. Баярлалаа.

Г.Занданшатар: Аудитын дүгнэлт. 89.

Д.Энхболд: Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн Аудитын газрын захирал Энхболд байна. Гишүүний асуултад хариулъя.

Аудитын дүгнэлт дээр зарлагын бүтэц дэх халамжийн эзлэх хувь бол буурахгүй байна гэдэг ийм дүгнэлтийг хийж байгаа. Эндээс нөгөө талаас төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогыг бол өнгөрсөн 4 жилийн хугацаанд хийсэн. Энэ бодлогын хэрэгжилтэд бол аудит хийгдсэн. Тэгэхээр хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд нийгмийн бүлэг бүрт олон төслүүдийг хэрэгжүүлсэн хэдий ч энэ нь бол ихэвчлэн санхүүгийн дэмжлэг, нэг удаагийн эргэлтийн хөрөнгийн жижиг төслүүдэд зарцуулагдаад байгаа учраас энийг бодлогоороо энэ үйлдвэрлэлийн чиглэлд нь дотоодын үйлдвэрүүдтэй холбож ажлын байр бий болгох, хувиараа хөдөлмөр эрхлэх тэр идэвхжүүлэлтийг бий болгох тал дээр нь илүү анхаарч ажиллавал энэ ажлын байр нэмэгдэх үйл явц бол нэмэгдэж, ажлын байрны нэг тоо нэмэгдэж байна гэж бид нар хэлээд байгаа

боловч халамжийн зардал буурахгүй байгаа нь энэтэй холбоотой гэдэг ийм ерөнхий бодлогын дүгнэлтийг бас хийсэн байгаа.

Г.Занданшатар: Тогмидын Доржханд гишүүн 1 минут тодруулъя.

Т.Доржханд: Хүрэлбаатар сайдаа та ил болгоно гэж хэллээ. Тэрийг бол хүлээж байя.

Хоёрдугаарт, танаас нэг зүйл асуух хэрэгтэй байна. Яагаад Эдийн засгийн хөгжлийн яам бий болсон бэ гэхлээр энэ төсвийн бодлого, мөнгөний бодлогыг уялдуулах юм. Гэтэл ингээд төсөв чинь тэлчихлээ, мөнгөний бодлого чинь хатуураад байдаг, энэ чинь 2 тийшээ яваад байна. Үр дүн гарахгүй байна, нэг. Нөгөө талд өнөөдөр Сангийн яамныхан тухайлбал, олон улсын зах зээл дээр бондоо гаргаад арай гэж явж байсан ажлыг чинь мөнгөний бодлого нь нураачихлаа шүү дээ. Нөөцөө алдсанаас болоод ердөө 1.7 тэрбум долларыг он гарснаас хойш алдсанаас болоод бүх өглөгүүд чинь буурчихлаа шүү дээ. Бондууд чинь будаа болчихлоо шүү дээ. Зах зээл чинь байхгүй болчихлоо шүү дээ. Тэгээд бие биеэ ингээд хорлоод яваад байгаа байхгүй юу. Тэгээд хариуцлага тооцох юм уу? Монголбанкныхаа удирдлагуудтай та нар ер нь ийм байдлаар толгойг нь илээд яваад байх юм уу? Тэгээд ийм байдлаар цаашаага энэ төсвийнхөө уялдаа мөнгөнийхөө уялдааг 2 тийш нь аваад яваад байх юм уу? Тэгэх юм бол энэ инфляцын чинь зорилт биелэх боломж байхгүй. Ханшаа тогтворжуулах ямар ч боломж байхгүй.

Г.Занданшатар: Үг хэлчихлээ. Чимидийн Хүрэлбаатар сайд гүйцээж хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Ер нь бол Доржханд гишүүнтэй бол зарчмын хувьд бол санал нэг байна л даа. Доржханд гишүүн ч бас өөрөө энийг бол нэлээд удаан хугацаанд ярьж ирсэн. Эрсдэлүүд үнэ өсөх эрсдэл, инфляцын эрсдэлүүд байна. Ханшны эрсдэлүүд байна гэж хэлээд байхад тухайн үедээ бол мөнгөний бодлого дээр эрт арга хэмжээ авч чадаагүй л дээ. Тэгээд одоо өнгөрсөн хойно нь байдал ийм болж байгаа юм. Сая тэр манай бондууд хөдөлдөг үндсэн гол шалтгаан нь бол валют дээрээ капитал контрол тавьчихсан юм байна. Хоногийн 300 доллар билүү. Түүнээс илүү гүйлгээ хийхгүй гэдэг энэ мессеж л үндсэндээ манай бондын зах зээлийг бол савлуулсан. Эдийн засгийн хөгжлийн яам байгуулагдсан шалтгаан бол мэдэж байгаа. Тэгээд энэ бодлогыг уялдуулах чиглэл дээр нэлээн сайн анхаарч ярьж, эдийн засгийг тогтворжуулах бодлогоо нэг номерт нь оруулъя, төсвийн алдагдлыг буулгая гэж бас дотроо нэлээн сайн ярьж байж оруулж ирж байгаа зөв бодлого шүү гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа.

Нэгдүгээрт, өмнөх жилтэй харьцуулахад төсвийн алдагдал 800 тэрбумаар буурч орж ирсэн байна. Энэ бас болж байна. Энэ эдийн засгийн хүндрэлтэй үед харин ирэх жил энэ эдийн засгийн өсөлтөө 5 хувьд хүргэж, инфляцыг нэг оронтой тоо руу оруулах, 36 сая тонн нүүрс олборлох гээд энэ үзүүлэлтүүд чинь ер нь хэр

бодитой вэ, гадаад, дотоод улс төр, эдийн засгийн нөхцөл байдлаа хэр бодитой дүгнэсэн юм бэ, ирэх жил ахиад одоо төсвийн тодотгол хийхгүй байх баталгаа хэр байгаа вэ гэж асууя.

Хоёрдугаарт, Төрийн албан хаагчдын цалинг хэрхэн яаж яг бодитоор нэмэгдүүлэх юм. Энэ жилийнх шиг төрийн үйлчилгээний боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилтнуудын тэр цалингийн шатлалын 5 дугаар зэрэглэлээр нь тогтоосон шигээ ийм байдлаар нэмэгдүүлэх гэж байна уу, өөр бас арга хэлбэр байна уу? Энд хэдэн төгрөгийн төсөв тавьсан юм бэ? Төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдэлд.

Гуравдугаарт, хувь хүний орлогын албан татварыг шаталсан тогтолцоонд шилжүүлнэ гэж байна. Сарын орлого нь 10 сая төгрөг, жилийн орлого нь 120 сая төгрөг хүртэл хүмүүст бол хамаарахгүй юм байна. Тэрнээс дээш гарсан орлогод нь 5 хувиар нэмэгдүүлэхээр тооцоолж байгаа юм байна. Энэ нийт хүн амын хэдэн хувьд эзэлж байгаа юм, эндээс хэдэн төгрөгийн орлого орж ирнэ гэж төлөвлөсөн юм бэ. Мэргэжлийн хяналтын тогтолцоонд нэлээд хэдэн өөрчлөлт орох юм байна ирэх жил. Ямар байдлаар мэргэжлийн хяналтын тогтолцоог өөрчилж шинэчлэх гэж байна. Энэ чиг үүргийн давхардлыг арилгана гэсэн байна. Тэр дагасан хуулиудыг харахаар аймаг, нийслэлд гэсэн байсан, дүүргүүдийн мэргэжлийн хяналтын албанд өөрчлөлт орохгүй юм уу гэдэг ийм асуултыг асууя.

Хүүхдийн мөнгөний нийт 91 хувьд нь олгоно. 9 хувьд нь үндсэндээ тэгээд тэр дагасан тогтоолыг нь

харахаар бас 9 хувийнх нь эцэг эхчүүдэд нь уриалах юм шиг юм ярьсан. Тийм үг өгүүлбэр байсан. Тэгээд өөрсдөө татгалзаад тэр хүүхдийн мөнгөө авъя гэсэн өргөдөл хүсэлтээ гаргахгүй байх ийм асуудал руу хандах юм уу, яах юм. 9 хувийнх нь ямар хүүхдүүд нь энд орж чадахгүй юм бэ, хүүхдийн мөнгөнд хамрагдаж чадахгүй юм бэ гэдгийг асууя.

Ирэх жил хөрөнгө оруулалтын зураг төслүүдийг Эдийн засгийн хөгжлийн яаманд хариуцуулж байгаа юм байна гэж ойлголоо. 2024 оны хөрөнгө оруулалтын зураг төслүүдийг 2023 онд Эдийн засаг, хөгжлийн яам нэгдсэн байдлаар төвлөрүүлж хийж явах юм байна гэж ойлголоо, энэ зөв үү? Тэгэхгүй бол энэ орон нутагт бол яг ирэх жилийн хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөв хийх мөнгө байдаггүй юм л даа. Өнөөдрийн энэ хөрөнгө оруулалтын он дамжиж удааширч байгаа шалтгаануудын нэг шалтгаан нь бол ерөөсөө энэ шүү дээ. Зураг төсөвгүйгээс болоод баахан хөрөнгө оруулалтууд Их Хурлын гишүүд нь батлуулчихдаг, тэр дээрээ амьдрал дээрээ зураггүйгээс болоод ингээд явж байгаа. Энэ дээр нэг тодорхой мэдээлэл өгөөч.

Эрчим хүчний сайдаас энэ эрчим хүчний суурь үнийг нэмэгдүүлэх асуудал яригдаж байсан. Энэ жил энэ эрчим хүчний салбарынхан чинь ачааллаа даахгүй, өнөө өвөл ер нь энэ хэдэн станцууд чинь энэ хотыг нүүрсээр хангадаг нүүрсний уурхайнууд чинь ер нь гал алдахад бэлэн ойрхон байгаа. Эрчим хүчний үнэ тарифыг нэмэгдүүлэх асуудал дээр ямар бодлого ирэх жил барьж байгаа вэ? Хэвээрээ явахаар байгаа юу нэмэгдүүлэхээр байгаа юу? Айл өрх, аж ахуйн нэгж гэж өөрчлөн ялгаатай

байдлаар асуудалд хандах гэж байна уу? Ийм хэдэн асуултуудад хариулт өгөөч. Баярлалаа.

Г.Занданшатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна. Дараа нь сайд нар.

Л.Оюун-Эрдэнэ: Би үгэндээ хэлсэн. 2022 оны төсвийг хэлэлцээж байх үед бол манай эдийн засаг -5.3 хувь руу уначихсан. Улсын төсөв нь 23 орчим хувьтай тасарчихсан хатуу хөл хориотой, хичээл сургууль хичээллэхээ больчихсон ийм л цаг үе байсан. Вакцин байхгүй байсан. Вакцин тасраад юу болж байлаа. Бид нар мэдэж байгаа. Ингээд 2022 оны улсын төсөв батлагдсан. Өнөөдөр 2022 оны улсын төсвийн төгсгөлд -5.3 хувь байсан эдийн засаг юутай ч тогтворжоод 3 хувийн өсөлттэй гарах ийм тооцоолол гарч байгаа юм. Энэ бол бас ч гэж үр дүн. Ингээд вакцинжуулалт сайн яваад 2 сарын 14-нд бид нар цар тахлын хатуу хөл хориог чөлөөлсөн эхний улс орнуудын нэг болсон. Ингээд аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа идэвхжиж эхэлсэн, энгийн амьдралд орох ийм хэмнэл бага багаар явж тавигдаж эхэлсэн.

Тухайн үед нэлээдгүй эсэргүүцэлтэй тулж байсан. Гэхдээ энэ бодлого бол зөв. Нэг үгээр хэлбэл, эрүүл мэнд, эдийн засаг 2 бол нэг зүйл юм гэдэг энэ бодлого руу явсан. Харамсалтай нь яг эдийн засаг суллаад 10 хоногийн дараа ОХУ, Украйны дунд геополитикийн маш хурцадмал нөхцөл байдал үүссэн. Шулуухан хэлэхэд бараг цөмийн бөмбөг дээр л хүрэх хэмжээнд ийм хурцдаж байна. Бид байтугай дэлхийн томоохон олон улсын банк санхүүгийн байгууллагууд юу болох вэ гэдгийг бол урьдчилж тооцоолоход туйлын төвөгтэй ийм нөхцөл байдал

үргэлжилж байна. Өөрөөр хэлбэл Ковидын нөхцөл байдлаас дайны үе рүү шилжсэн дэлхий. Энэ агуулгаараа 2023 оны төсөв бол бид нар цар тахлын болон дайны шокоос гарах ийм л үндсэн зорилтыг дэвшүүлж байгаа. Анх удаа нэмэлт хөрөнгө оруулалтыг байхгүй байдлаар ингэж төсөв оруулж ирж байгаа. Ингээд оны эцэс гэхэд 1 жилийн дараа эдийн засаг 5 орчим хувьд хүрсэн байна гэдэг ийм том зорилтыг тавьж байгаа юм.

Мэдээж энэ амаргүй, гэхдээ энэний төлөө бүгдээрээ чадах бүх зүйлээ л хийж хичээх ёстой. Боомтын экспортын шинэ гарцууд ашиглалтад орно. Экспорт нэмэгдэнэ. Ер нь бол экспорт бас нэмэгдчихсэн байгаа. Зүгээр өмнөх онд зарсан нүүрснүүд гарч байгаа учраас ханиш дээр ийм бас дарамт өгөхөд ийм нэрмээс болоод байгаа. Энэ асуудлыг бас цэгцлэх ийм бодлого хийгээд, засаад явж байна гэж ойлгож болно. Инфляц 15-16 хувьтай байна. Үүнийг нэг оронтой тоонд барих бас л ийм томоохон зорилтыг дэвшүүлээд явж байгаа юм. Тэгэхээр мэдээж тухайн үед цар тахалтай холбоотой, бас вакцины олон асуудлууд яригдаж байхад амаргүй л ийм мэтгэлцээн өрнөж байсан. Гэхдээ Их Хурал дэмжээд, Засгийн газар хэрэгжүүлээд эргээд харахад 1 жилийн дараа бид нар үр дүнтэй л болчихсон сууж байгаа юм. Чуулган танхимаар хуралдаж чадахгүй л үед байсан. Одоо бид нар мартчихаад байгаа юм л даа энэ үеийг. Одоо хүнд байна гэхдээ мэдээж энэ дайны үеийг бид нар тааж мэдэхгүй. Нөхцөл байдал бол яаж ч хүндэрч болзошгүй. Гэхдээ бид ирэх жил эдийн засгийг бүрэн тогтворжуулах ийм л зорилтыг тавьж байгаа юм.

Тийм учраас Засгийн газраас оруулж ирсэн төсвийг Засгийн газраас орж ирсэн хувилбараар нь нэг их өөрчлөхгүй баталж өгөхийг Улсын Их Хурлаас Ерөнхий сайдын хувьд хичээнгүйлэн хүсье.

Ингээд 1 жилийн дараа хамтдаа үр дүнгээ 2024 оны улсын төсөв хэлэлцэх үед бид нар тэртээ тэргүй хамтдаа ярилцана. Ингээж л бид нар урагшлаад явах ёстой. Ер нь бол бид нар тойрог дээр төсвийг тэгшитгэн хуваагаад яваад байсан, тэгшитгэн хуваагаад үр дүн гардаггүй гэдгийг бидний өнгөрсөн хугацаа хангалттай харуулсан.

Г.Занданшатар: Эдийн засаг, хөгжлийн сайд.

Ч.Хүрэлбаатар: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Ингээд 5 хувийн өсөлт инфляцаа нэг оронтоо тоонд оруулахад ер нь чадах уу гээд. Ер нь бид нар нэг өөрсдөө сайн хичээгээд, тал талдаа сайн зорилго нэгтэй байвал энэ болчих болов уу гэж бодож байгаа. Яагаад вэ гэхээр бид нар чинь энэ 9 сарын эхээр л энэ ажлууддаа орсон санагдаж байна. Тэгээд валютын нөөц чинь 2.4 гаран тэрбум доллар байсан шүү дээ. Тэгээд оптекоор гарч байгаа нүүрсээ хязгаарлаад урьдчилгаа төлбөрөөр гарч байгаа нүүрсээ гаргахдаа бас бууруулаад, тэгээд зохицуулалт хийгээд эхлэхэд өнөөдөр валютын нөөц 9 сарын дүнгээр 2.8 тэрбум америк доллар болоод нөгөө уруудаж байсан хандлага нь ингээж тогтворжоод өсөх ийм дээшээгээ хандлага орчихсон байж байгаа. Тэгээд энэнд бас урамшаад байгаа л даа. Тийм учраас бид нар өөрсдөө хичээгээд зөв бодлого аваад явуулаад

байх юм бол 5 хувийнхаа өсөлтийг ч гаргачих байх. Инфляц нэг оронтоо тоонд оруулчих байх гэж бодож байна.

Зураг төсвийн хувьд бол Мөнхбаатар сайд бид 2 ярьсан. Уг нь зураг төсвийн мөнгөө энэ мэдээж мэргээжлийн байгууллага нь болох барилгын сайд дээрээ байлгаад бодлогын хувьд юун дээрээ ярих вэ гэдгээ одоо хоёулаа хамтарч яриад шийдээд явчихъя гээд тохирсны хувьд. Тэгээд бодвол тэр мөнгө нь Барилгын сайдын багц дотор байгаа байх. Хөгжлийн сайдын багц дээр ний нуугүй хэлэхэд бид нар зураг төсөв хийдэг, хариуцдаг хүмүүс биш учраас мэддэг чаддаг байгууллагад нь өгье гээд Мөнхбаатар сайдын багцад байгаа болов уу гэж бодож байгаа юм.

Гэхдээ Мөнхбаатар сайдтай манай яам 2 хоорондоо яриад хоорондоо чиглэлээ тогтоогоод явчихъя гээд тохиролцож Мөнхбаатар сайдын багц дээр тавиулна гэж бодож байгаа. Тэгээд орчихсон байх.

Г.Занданшатар: 18 цаг болсон байна. Жавхлан сайд хариулах юм уу тэ? Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Тодотгол бид аль болох хийхгүй. Мэдээж бас ирэх жил эдийн засгийн тодорхойгүй байдал, энэ хүндрэлүүд бол үргэлжилнэ. Гэхдээ тодотгол хийхгүй гэж зорьж орж байгаа юм. Бид орлогоо нэлээн дайчилж ингээж тавилаа, орлогоо л бид дайчилж олж чадвал тодотгол хийх шаардлага үүсэхгүй гэж ингээж харж байгаа юм. Цалингийн хувьд, ер нь сүүлийн

жилүүдэд 10 гаран жил энэ төрийн нэгдсэн цалингийн тогтолцоо, энэ систем бол бүрэн алдагдсан. Маш олон өөрийн бие даасан хуультай байгууллага, системүүд байгаа. Тэр болгон нь өөрсөд дотроо ингээд цалингийн тогтолцоотой системтэй яаж тогтоодог вэ? Ингээд бүр хуульчилчихсан. Тэр нь орж ирж Нийгмийн хамгааллын яам, Сангийн яаман дээр төсөвлөгддөг төсвийн тогтолцоогоор явах ёстой цалингийн тогтолцоогоо эвдээд байгаа юм. Тэгэхээр бид цалинг нэмж, хасах гэдэгтээ биш ер нь цалингийн тогтолцоогоо бид нэг мөсөн өөрчлөх шаардлага гарч ирж байгаа юм. Тэгэхээр төсвийн шинэчлэлийн хүрээнд бид өнгөрсөн 2 жилд энэ жил оролцоод ингээд бид нийгмийн 2 том салбар эрүүл мэндийн салбар, боловсролын салбар дээрээ томоохон төсвийн шинэчлэл хийж байгаа. Энэ дотор мөн цалингийн тогтолцооны бүрэн шинэчлэл хийгдэж байгаа. Эхнээсээ эрүүл мэндийн салбарынхан маань сайн үр дүн гарч байна.

Боловсролын салбарын ерөнхийдөө санхүүжилт авдаг тоолуурын систем нь эрүүл мэндийн салбар шиг өдөр бүрээр биш хагас жилээр жилээр дүгнэгддэг учраас тодорхой үр дүн гарах хугацаагаар бид хүлээх шаардлагатай байгаа. Ингээд энэ цалингийн тогтолцооны шинэчлэл үргэлжилнэ. Өөрөөр хэлбэл ажил хийж чадаж л байвал илүү үр дүн гаргаж, илүү төрийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй гүйцэтгэж чадаж байвал илүү санхүүжилт авч цалин нэмэгдэх боломжтой ийм систем рүүгээ маш тодорхой, бүрэн шилжинэ гэсэн үг. Энэ шилжилт үргэлжилнэ гэсэн үг. Салбарууд нь тэлнэ, ирэх жил соёл, шинжлэх ухаан, спортын салбарууд дээр энэ

гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн систем шинээр ороод ингээд тэлээд явах юм байгаа юм. Энэ шинэчлэлд зориулж нийтдээ 266 тэрбум төгрөг төсөвлөсөн байгаа. Ялангуяа бид нар хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэр гэсэн, мөн өөр ийм бодлоготойгоо энэ конценцоо бас уялдуулж явж байгаа.

Ингээд хөдөө орон нутаг дахь төрийн албан хаагч нарын цалинг суурийг нь 20 хувиар шууд нэмнэ. 165 ялгаатай цалингийн системээсээ бид ерөөсөө маш тодорхой, ойлгомжтой, 20 ялгаатай төрийн цалингийн систем рүү шилжчих юм байгаа юм. Төрийн алба хаагчийн 5 шатлалтай биш, зөвхөн нэг шатлалтай, доод суурь цалин. Дээр нь 10 зэрэглэлтэй ийм маш тодорхой 5. 5 зэрэглэлтэй. Ийм ойлгомжтой цалингийн систем рүү явж орно. Ингээд яг нөгөө ТЗ, ТТ, ТҮ гээд харах юм бол яг дунджаар ер нь нэг 20-25 хувиар цалингийн суурь зардал нь нэмэгдэх боломжтой. Энэ дээрээсээ нэмэх нь хэн сайн ажиллана, хэн чанартай үйлчилгээ үзүүлнэ, тэнд илүү цалин авах бүрэн боломж нээгдэж байгаа гэсэн үг.

Г.Занданшатар: Товч тодорхой хариулъя. Одоо нэг асуулт нь 3 хүн хариулаад 15 минут хариулах юм бол. Ингээд 18 цаг болсон байна. Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөлөө.

Маргааш 10 цагт чуулганы нэгдсэн хуралдаан асуулт хариулт үргэлжилнэ. Түрүүлээд Цэндийн Сандаг-Очир гишүүн өглөө асуулт асууна.

Тодруулж, асууна.

18.04 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*